



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-110
<hr/>	
<i>1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	<i>10-43 68-108</i>
<i>2.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл: Боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаар</i>	<i>43-68</i>
<i>3.“Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>108</i>
<i>4.“Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>108-109</i>
<i>5.Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох</i>	<i>109-110</i>

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын
ээлжит чуулганы 10 дугаар сарын 07-ны өдөр
/Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа, Х.Болорчулуун, Н.Ганибал, Г.Дамдинням, Х.Нямбаатар, Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат;

Тасалсан: Д.Ганбат;

Хоцорсон: С.Амарсайхан- 10 минут, С.Батболд- 2 цаг 22 минут, Д.Батлут- 12 минут, С.Ганбаатар- 1 цаг 51 минут, Т.Доржханд- 18 минут, С.Одонтуяа- 3 цаг 15 минут, Д.Сарангэрэл- 26 минут, Н.Энхболд- 30 минут, Т.Энхтүвшин- 21 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ж.Чинбүрэн нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Соёлын сайд Ч.Номин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулхар, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Отгонцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөгжлийн санхүүжилтийн

хэлтсийн дарга Б.Ганзориг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, мөн газрын Аудитын хоёрдугаар газрын захирал Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Д.Тогтохсүрэн, Н.Наранбаатар, Н.Алтанхуяг, Ш.Раднаасэд, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Ч.Ундрам, Т.Энхтүвшин, Т.Аубакир, Г.Мөнхцэцэг, Д.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр, Г.Амартүвшин, Б.Жаргалмаа, Н.Энхболд, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Батлут, П.Анужин, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, С.Ганбаатар, С.Чинзориг, Б.Бейсен, Ц.Туваан, А.Адъяасүрэн, Б.Баярсайхан, Х.Ганхуяг, Ц.Цэрэнпунцаг нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Соёлын сайд Ч.Номин, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Отгонцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 15 минут үргэлжилж, 13 цаг 17 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 10 минутад эхлэв.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаар/

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Х.Тамир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, референт Ж.Монголжсингоо нар байлцав.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаар мэдээлэл хийв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, С.Одонтуяа, С.Ганбаатар, Б.Бейсен, Ж.Батсуурь, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 16 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Г.Занданшатар: Төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу шаардлага хангасан талаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 20

Бүгд: 53

62.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус илжүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Уг асуудлыг 19 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданишатар төслийн талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданишатар: “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 13

Бүгд: 53

75.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 20 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданишатар: “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 12

Бүгд: 53

77.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 20 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Баталсан тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1. “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./20:07/

2. “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./20:07/

Уг асуудлыг 20 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Засгийн газрын гишүүнийг огцуруулах тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын ахлах референт Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүнийг огцуруулах талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүнийг огцуруулах талаар Улсын Их Хуралд танилцуулав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн, О.Цогтгэрэл нарын урилгаар Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн урилгаар Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Дорнод аймгийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазарын урилгаар Булган аймгийн Хутаг-Өндөр сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, мөн “Тариаланчдын холбоо” төрийн бус байгууллагын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ахмадууд, Сүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2001 оны төгсөгчид, Нийслэлийн 52 дугаар сургуулийн 1981 оны төгсөгчид, Улсын Их

Хурлын гишүүн Ч.Ундрэм, Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны сургуулийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг нарын урилгаар Архангай аймгийн Өндөр-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Д.Тогтохсүрэн, Г.Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Б.Саранчимэг, Ж.Чинбүрэн, Э.Бат-Амгалан, Б.Энхбаяр нарын урилгаар Баянзүрх дүүргийн Нийгмийн ардчилал, Монголын эмэгтэйчүүдийн холбооны гишүүд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 9 цаг 14 минут үргэлжилж, 76 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 89.5 хувийн ирцтэйгээр 20 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье.

52,6 хувийн ирцтэй өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Ингээд Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 4 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Гуравдугаарт, “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл. Боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаар танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаан дээр хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дарааллыг өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий бичгээ саналаар ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нараас албан бичгүүд ирүүлсэн байна.

Энэ бичгүүд нь хаана байна, нягталж шалгана.

Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Би энэ Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад 4 дүгээр сард нэг тогтоолын төсөл өргөн барьсан юм. Тэгээд тэр тогтоолын төсөл маань болтол

ингээд Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж өгдөггүй, тэгээд би та нарт зүгээр ер нь ямар процесс явдаг болдог юм байна гэдгийг бас нэг дуулгая гэж бодсон юм. 4 сард би энэ Эрдэнэт үйлдвэрийн төрийн өмчит үйлдвэрийн газрын технологид нь таарахгүй байгаа, өнөөдөртөө тохирохгүй байгаа л даа, тийм хүдрийн овоолгыг ашиглах тухай ийм тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн юм. Энэ тогтоолын санаа бол нөгөө Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр бол байгалийнхаа баялагтаа, баялагтаа эзэн болъё гэдэг энэ л том лоозонгийн дор би нэг бодитой юм хийчихье, түүнийгээ энэ Эрдэнэт үйлдвэр дээр жишиг болгоод хийчихье. Эрдэнэт үйлдвэр дээр жишиг болгоод цөөхөн хүн баялаг иддэг биш, Эрдэнэтийн ард иргэдэд тодорхой хэмжээгээр хувь хүртдэг болчих юм бол эндээс санаа аваад ер нь Монгол Улсад, энд тэнд босоож байгаа бүх ашигт малтмалтай газруудад тодорхой хувийг орон нутгийн иргэдэд хувь эзэмшүүлэх ийм боломж нээгдэх юм биш болов уу гэж, нээгдэх юм болов уу гэж бодож ингэж санаачилсан юм.

Тэгсэн нэг сонин юм би харж байна. Улсын Их Хурлын гишүүнд хууль, тогтоолын төсөл санаачлахад маш их олон саадтай гүйлтээр гүйдэг болсон юм байна, хэлэлцүүлэг гэж. Нэгдүгээрт би 4 сард өргөн барьсан чинь энэ Чойжилсүрэн Байнгын хорооны дарга байсан, одоо сайд болоод явчихсан. Энэ нөхөр 6 сарын 8-нд Байнгын хороогоо хуралдуулаад ийм, ийм бичиг явуулсан байх юм, би үүнийг сая л олж авлаа, ядаж надад энэ бичгээ өгөх хэрэгтэй шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч хэн билээ, нэгэн нөгөө хууль санаачлагч. Энэ хууль санаачлагчийн эрхэнд хэн ч халдаж болохгүй байхгүй юу. Их Хурлын гишүүн хууль санаачлаад байхад тэрний нь Байнгын хороо авч үзээд Монгол Улсын Их Хурлын ерөнхий нарийн бичгийн дарга Өлзийсайханд ийм бичиг явуулж байгаа юм, энэ Чойжилсүрэн. Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонх нь энэ Алтанхуягийн санаачилсан тогтоолын төсөл, Монгол Улсын Үндсэн хууль, та нар сонс доо, Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжсэн болно. Яах вэ, өнөөдөр манай нөгөө дэгийн хуулиар бол ийм заалт байна. Тэгэхдээ эрхэм гишүүд ээ, нэг юм бодмоор байна. Та жаран хэд маань ийм хүчингийн ажил хийгээд байж болохгүй шүү дээ, та нар л хуульд өөрчлөлт оруулдаг. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн хэнбугай ч гэсэн хууль, тогтоолын төсөл санаачлахад Их Хурлын Тамгын газар дээр очиж хянагддаг болох нь.

Үгүй ээ, Монгол Улсын ҮХЦ тэр нь дампуурчихсан л даа, тэр чинь л Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг ишиддэг болохоос биш хэн нэг гишүүний санаачилсан хуулийн төсөл нь

Үндсэн хууль зөрчсөн юм уу, бусад хууль зөрчсөн юм уу гээд ингэж юм хийдэг юм байхгүй шүү дээ. Энэ Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхэнд халдаад байна шүү дээ. Яах вэ гэж бодъё. 6 сарын 8-нд ийм бичиг өгөхөөр нь Их Хурлын Тамгын газар бол энэ дээр ажилласан юм байна, 6 сарын 27-нд Чойжилсүрэнг дарга байхад нь бичиг өгсөн юм байна. Ингээд 20 хоногийн дараа ингээд дүгнэлтээ өгсөн байна. Энэ дүгнэлтийг би өчигдөр олж авч байна шүү дээ. Яагаад энэ асуудал хэлэлцэхгүй байгаа юм бэ гэхээр үгүй ээ, энэ Чойжилсүрэн байхдаа нэг бичиг дээшээ явуулсан юм байна гээд хөөцөлдөж авч байна. Чойжилсүрэн ингэж болохгүй л дээ. Та нар жаахан ёс зүйтэй бай л даа, хэнбугай нь ч гэсэн. Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль ингэж дамнуурч болохгүй.

Энэ хуулийн амин чухал үндэс санааг би хэлээд өгөх үү. Эрдэнэтийн овоолго гэдэг нэрээр Эрдэнэтийн тэр баялгийг хаягдал гэдэг нэрээр завиж байгаа цөөхөн хүн байгаа шүү дээ. Та нар тэгээд тэр цөөн хүний эрх ашгийг хамгаалах юм уу, ард түмнийхээ ашгийг хамгаалах юм уу, өнөөдөр ард түмний ахуй, амьжиргаа ямар байна, нэг аймгийн ард иргэд ч болов 3 хүний иддэг юмыг 100000-уулаа бас нэг хүртэж болдоггүй юм уу? Одоо үндсэндээ ийм л тэмцэл явж байгаа гэж би ойлгож байна.

Тэгээд та нар маань Ардын намын бусад гишүүд минь ... /минут дуусав/

Г.Занданиатар: Хууль тогтоомжийн тухай хуулийг Улсын Их Хурлаар баталсан, та бүхэн маань л баталсан, энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бүх ард түмнээс сонгогдсон, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрх хүрээ хязгаарыг ч гэсэн тогтоосон. Энэ бүх нь бол бас Үндсэн хуулийн тэр хүний хувийн өмчийг шууд авах ч байдаг юм уу, Үндсэн хуультай зөрчилдсөн тийм заалтуудыг бол хууль бол бас байж болохгүй ээ гэсэн тийм агуулга санаатай юм байна лээ. Тэгэхээр тэр агуулгын хүрээнд л хууль зүйн лавлагаа дүгнэлт гаргахаар Үйлдвэржилтийн байнгын хороо шийдвэрлээд, түүнийг нь үзэж хянаад, тэгээд бас Үндсэн хуулийн зөрчилтэй байж болзошгүй байна гэсэн дүгнэлт гаргасан юм байна гэж ойлгосон.

Одоо эрхэм гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн үг хэлнэ.

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүддээ энэ өдрийн өглөөний мэнд хүргэе. Би эрүүл мэндийн салбарын эрүүл мэндийн төсвийн талаар хэдэн үг хэлбэ гэж зориуд цаг авлаа. Тэгэхээр эрхэм гишүүд та бүхэн нэг анхааралтай сонсож өгөөч ээ. Эрүүл мэндийн төсөв яг 2022 оныхоо төсвөөр 23 онд орж ирж байгаа. Тэгэхээр инфляц, долларын хани, өөрчлөлт их байна. Яг эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдийн үнэ хани 40-60

хувийн инфляцтай, үнэ нэмэгдэлтэй явж байгаа. Тэгэхээр өнөөдөр бид төсвийг нь нэмж өгөхгүй бол даатгалын сангаас эмнэлгүүдэд квот тогтоож байна. Квот гэдэг маань та сардаа зуун хүнийг эмчилнэ ээ, эс үгүй бол 150 хүнээс илүү эмчилж болохгүй ээ, энэ нь тухайн эмнэлгүүд иргэдийг өвчтэй хүмүүсээ хүлээж авах, үзэх, энэ дарааллыг хойшлуулж, сараар хойшлуулж, нөгөө квотдоо багтаагүй учраас төлбөр авч чадахгүй гэдэг утгаараа хойшлуулах, очер дарааллыг нэмэгдүүлэх, иргэдэд төвөгтэй болох энэ нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Өнгөрсөн 2 жилийн энэ ковидтой хүнд хэцүү үед бол бид, ялангуяа Засгийн газар бол үнэхээр сайн ажиллаж, энэ төсөв мөнгийг шийдэж чадсанаараа эрүүл мэндийн салбар энэ хүнд хэцүү үеийг даваад аваад гарсан. Энэ геополитик, инфляцын энэ хүнд үед энэ бүгдийг дахин 23 онд авч гарна гэхэд бол төвөгтэй байдал үүсэж байгаа учраас эрхэм гишүүд та бүхэн энэ дээр онцгой анхаарч, ялангуяа энэ хэлэлцэх асуудал дээр энэ эрүүл мэндийн салбарын нөхцөл байдал, тоо баримтуудыг анхааран үзэхийг бас хүсэж байна.

2 дахь асуудал бол энэ хөнгөлөлттэй эмийн асуудлыг бол зайлигүй ярих хэрэгтэй байна. 20 оны Засгийн газраас өргөн барьсан энэ даатгалын шинэчлэлийн хүрээнд бол гол шийдэж чадсан юм бол хөнгөлөлттэй эмийн асуудлыг бол асар зөв шийдэж өгч чадсан, тусгай зөвшөөрөл өгөхгүйгээр бүх аптекаар зарж борлуулах боломжийг нь олгоод, 2-т эмчлэх лицензтэй эмч болгон жороо бичих ийм боломжийг бүрдүүлсэн боловч энэ нь зохион байгуулалтын хувьд бол нэлээн тийм төвөгтэй болж, иргэд хөнгөлөлттэй эмээ төвөгтэй буцаад авдаг болсон явдал үүний бас нэг том, бидний анхаарлыг татах нэг асуудал болоод байгаа юм.

Мөн төсөв дээр нэг бид амжилттай хийсэн нэг зүйлийг бүр зориуд хаяад Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон нэг асуудал бол энэ “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр үргэлжлэх ёстой юм. Тухайлах юм бол D вирус тэй 10 гаруй мянган иргэд хэзээ Монгол Улсад D вирусийн эм орж, бид энэ өвчнөө эмчлүүлэх вэ гэдгээ хүлээгээд сууж байна. Тэр дотор нэн ялангуяа дөч гаруй мянган иргэн зайлигүй D вирусийн эмчилгээ хийлгэхгүй бол амь нас нь эрсдээд, эрсдэлтэй байгаа хүмүүс дөч гаруй мянган байна. Тийм учраас Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ороод байгаа D вирусийн эмчилгээний асуудал, энэ асуудал энэ төсөвт суулгаж өгөхгүй бол энэ 23 онд бол хэрэгжихгүй ээ. Та бид санаж байгаа, 2016-20 онд хийгдсэн “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр бол бараг дөч гаруй тэрбум төгрөгөөр жил болгон болгонд тусгаж байж, бид 1000200 иргэнээ В, С вирус байна уу гэж үзээд С вирус тэй хүмүүсийг бүрэн эмчлээд ямар том амжилтад хүрсэн билээ. Тэгэхээр энэ амжилттай явж

байгаа хөтөлбөрүүдийг бас үргэлжлүүлэх чиглэлд бас онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Тийм учраас энэ 23 оны төсөв дээр эрүүл мэндийн санхүүжилтийн төсөв дээр бол онцгой анхаарч бид хийсэн том шинэчлэл буюу одоо үр дүнгээр нь худалдан авах энэ тогтолцоогоо улам бэхжүүлж, улам сайжруулах чиглэл дээр анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Сайн зүйлүүд бий. Жишээлбэл, анхан шатны тусламж үйлчилгээний үнэ тарифыг 2 дахин бид 22 онд нэмсэн, 23 онд энэ үргэлжлээд явж байна. Ингэснээрээ сум, өрхийн эмнэлгүүдийн төсөв бол 2 дахин нэмэгдсэн байдлаараа явж байгаа. Гэхдээ энэ маань бол дөнгөж 22 оны 6, 7 сараас л жигдэрч эхэлсэн. Одоо 23 ондоо илүү сайн болж, тэгээд анхан шатны тусламж үйлчилгээгээ зөвхөн эмнэлгийн тусламж үйлчилгээ мөнгө олдог чиглэл биш, нийгмийн эрүүл мэндийн чиглэл рүү хандсан ийм тусламж үйлчилгээ нь илүү явах ёстой. Энд бол бүтэц зохион байгуулалт, чанарын шаардлагыг бол өндөр тавих ёстой юм.

Тийм учраас эрхэм гишүүддээ дахин хэлэхэд, эрүүл мэндийн санхүүжилтийг 3,5 сая иргэдийнхээ санхүүжилт дээр онцгой анхаарч, Төсвийн байнгын хороо, одоо байгуулагдах төсвийн Ажлын хэсэг энэ дээр онцгой анхаарч ажиллахыг эрхэм гишүүдээсээ хичээнгүйлэн хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Асуулт, хариулт явж байгаа.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатараас өөр сайд алга байх чинь. Сайд нарыг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар, Батлан хамгаалахын дэд сайд Баярмагнай тэнд сууж байсан. Ажлын хэсгийг оруулъя.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асуугаад дууссан, одоо тодруулж асууна. Гишүүд суудалдаа суугаарай. Сайд нар асуулт, хариултдаа бэлдээрэй.

Сандаг-Очир гишүүн ажлын хэсгийг оруулж ирэхээр асуух уу? Шууд асууж байх уу? Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

Ц.Сандаг-Очир: Өчигдөр асуултууддаа гүйцэд хариулт авч чадаагүй юм. Сангийн сайд 2 зүйл дээр нэмэлт тайлбар хийж өгөөч. ХХОАТ-ыг шаталсан тогтолцоонд шилжүүлнэ ээ гэж.

Нөгөө талаар зураг төсвийг цаашидаа ямар тогтолцоонд, ямар байдлаар хэлбэрт шилжүүлж байгаа юм бэ? Энэ дээр бас. Хүүхдийн мөнгийг бас 9 хувиа яаж тооцох гэж байгаа юм, хүн амын өрхийн бүртгэл мэдээллийн сангаасаа тооцох юм уу, эсвэл тэр 9 хувьд хамаарагдаж байгаа айл өрхийг уриалж, хүүхдийн мөнгөнөөсөө татгалзаач ээ гэсэн ийм уриалга гаргаж явах юм уу гэсэн ийм нэмэлт тодруулгыг авъя.

Эрчим хүчний сайдаас үнэ тарифтай холбоотой ирэх жил энэ дээр хариулт авч чадаагүй байгаа. МХЕГ-ын тогтолцоог өөрчлөхөөр ирэх жил нэлээд томоохон өөрчлөлт орохоор байгаа юм байна, энэ ер нь ямаршүүхан хэлбэрээр яаж бүтцийн өөрчлөлтийг хийх гэж байгаа юм бэ гэсэн ийм асуултууддаа хариулт авъя.

Г.Занданишатар: Эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан гүйцээж хариулна, дараа нь Эрчим хүчний сайд бэлдэж байгаарай. Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Шаталсан дотор бол ийм учиртай байгаа шүү. Энэ бол шинэ татвар биш ээ, бид нар бүр 2004 онд энэ тогтолцоонд анх байсан юм, тэгээд 14 онд буцаад гарсан юм байна лээ, 18 онд Засгийн газраас дахин өргөн барьсан боловч Их Хурал дээр буцаасан. Одоо бол хамрах хүрээ нь бол нэлээн бага байгаа, энэ арван сая сарын шүү, сарын арван саяас дээш 15 саяас дээш гээд ийм 3 шаталсан ийм татвартай болж ирж байгаа. Манайд нийтдээ нэг 817000 ХХОАТ татвар мэдүүлдэг ийм иргэд байдаг. Эндээс яг энэ шатлалд хамаарч байгаа нь бол 0,3 хувь буюу 1365 хувь хүнд оногдож байгаа л ийм татварын систем юм байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ маань эндээс орж ирэх орлого бол нэг 10 тэрбум ... /минут дуусав/

Г.Занданишатар: Жавхлан сайд товч тодорхой гүйцээгээд хариулчих.

Б.Жавхлан: Ийм байгаа. Тэгээд ингээд өргөн барьж байгаа маань бол ийм системээр өргөн барьж байна. Тэгэхээр орлого дайчлахаасаа илүү татварын системд орж байгаа томоохон реформын шинэчлэл юм гэж ингэж ойлгоорой. Ер нь бол энэ чинь 10-15 саяынхаа хооронд давсан хэсэг дээр нь 15 хувь, 15-аас дээш давсан хэсэг

дээр нь 20 хувь л ийм систем рүү шинэчилж орж байгаа гэсэн үг.

Зураг төсвийн хувьд бол ийм байгаа шүү. Ирэх жил бид энэ хөрөнгө оруулалтынхаа бодлого дээр томоохон өөрчлөлт хийж байна. Өөрөөр хэлбэл ингэж явах юм байгаа юм. Эдийн засгийн хөгжлийн яаман дээрээс бид Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиараа 4 жилийнхээ төлөвлөгөөг гаргаад хөрөнгө оруулалтынхаа ерөнхийдөө том зургаа гаргачихна гэсэн үг. Энэ хүрээнд жил бүр энэ хөрөнгө оруулалтын бодлогыг одоо байгаа ЗГ-ынхаа бүтэц, чиг үүргээрээ Сангийн яам авч явна, өөрөөр хэлбэл, дараа дараагийн жилүүд дээрээ хөрөнгө оруулалтын бодлого болж бүрээ төсөвт сууж өгөх бүтээн байгуулалт нь эхлэх ёстой тэр ажлуудын бэлтгэл ажлыг хангуулах яг ийм чиг үүргээр зураг төсвийг хийнэ. Түүнээс биш төсөвт цаашидаа суухгүй зүйлүүдийг зураг төсвөөсөө бэлтгэл ажил хангах, ийм илүү зардал гаргах ямар ч шаардлагагүй. Ийм зарчим барьж явах юм байгаа юм.

Харин захиалагч яамнууд захиалгаа өгөөд зураг төсвийнхөө яг худалдан авах ажиллагааг бол яамнууд өөрсдөө хийнэ, хуваарилалтаа Сангийн яаман дээрээ хийгээд явах юм. Ийм зарчмаар явна.

Хүүхдийн мөнгөн дээр бол ингэж байгаа. Нийгмийн халамжийн тухай хууль дээр хүүхдийн мөнгө гэж орж байгаа, өөрөөр хэлбэл халамжийн бодлогын хүрээнд халамж юм гэж. Тийм учраас илүү зорилтот бүлэг рүү чиглүүлье ээ гэдэг ийм бодлогыг цаашаагаа явна гэсэн үг. Ковидын хүнд үед хүүхдийн мөнгө маань өрхийн орлогыг дэмжих маш том ийм зорилго бол биелүүлсэн, цаашидаа бол өндөр орлоготой эсэх нь эндээс татгалзъя, илүү зорилтот бүлэг рүүгээ үүнийгээ чухал ач холбогдол өгч авч явъя гэдэг ийм бодлогоор орж ирж байгаа юм.

Тэр 91 хувь гэдэг хаанаас гарч ирсэн юм бэ гэхээр манай статистикийн хороо статистикаас гаргадаг, улирал бүрийн бюллетень дээрээс та бүхэн харж байгаа байх. Улаанбаатар хотод өрхийн орлого 1,9 сая, дундаж орлого, орон нутагт 1,5 сая байгаа юм. Ингээд дундажлах юм бол 1750000, үүнийгээ бид нар өндөр орлоготой хэсэг рүү нь дөхүүлээд 2 дахин ингэж аваад өсгөөд үзэхээр 3 сая 500-аас 3 сая 700-гийн хооронд байгаа. Ингээд тооцохоор нэг 90-91 хувь орчим байгаа юм. Ингээд 91 хувь дээр нь бид нар хангалттай төсөвлөөд орж байгаа юм.

Харин ирэх оны 1 сарын 1 хүртэл өрхийн орлогынхоо тооцдог энэ систем төрийн сангийн мэдээлэл дээрээ бид нар дахиж эргэж маш сайн тооллого бүртгэлээ сайжруулж ингэж явах шаардлага гарч ирж байгаа юм. Яг өнөө

маргаашгүй Засгийн газар дээр энэ ажлын хэсэг байгуулагдана. Энэ бол нэлээн тийм том ийм ажил болно. Гэхдээ бид 18 оноос хойш төрийн мэдээллийн сан маань бол ... /минут дуусав/

Г.Занданишатар: Ер нь тодорхой тас, тас, тас гээд л хариулчхаж баймаар байгаа юм. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн гишүүн хариулъя.

Б.Чойжилсүрэн: Гишүүдийнхээ өглөөний амрыг эрье. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбар хүнд, хүндэвтэр нөхцөлд байна л даа, хүнд гэж хэлж болно. Жишээлбэл, нүүрсний уурхайнууд дээр эргэлтийн хөрөнгийн дутагдал өнөөдрийн байдлаар 109,2 тэрбум төгрөг, үүн дотроос Багануурын уурхайд 61,3 тэрбум, Шивээгийн уурхайд 33,3 тэрбум, Шарын голын уурхай дээр 14,6 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэхгүй бол бүтээгдэхүүн үйлдвэрлэх санхүүгийн эх үүсвэрийн хомсдолд орсон ийм байдалтай байгаа юм.

Эрчим хүчний үйлдвэр компаниуд маань ялгаагүй яг ийм байдалд орсон. Галлагааны мазут, дизель түлш болон бусад шатахуун, сэлбэг хэрэгслийн материал үнэ, ковидын өмнөх буюу 2019 онтой харьцуулахад дунджаар 30-65 хувийн өсөлттэй байгаа ийм хүнд нөхцөл байдалд орсон байна.

Мөн ялгаагүй энэ ОХУ-аас худалдаж авах импортын цахилгааны эрчим хүчний үнийн ... /минут дуусав/

Г.Занданишатар: Чойжилсүрэн гишүүн гүйцээгээд хариулчих. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: ОХУ-аас бид нар оргил ачааллын цагт импорт юу, цахилгаан импортолдог ба төвийн бүсээрээ, баруун бүсээрээ 2 газраар импортолж байгаа нь нийтдээ зөвхөн 2022 онд хүлээгдэж байгаагүй гүйцэтгэлээр ханишийн алдагдал 37,8 тэрбум төгрөг гарах ийм нөхцөл байдал үүссэн гэх мэтээр эрчим хүчний салбарт яг өнөөдрийн байдлаар 432,8 тэрбум төгрөгийн онцгой шаардлага үүссэн гэдгийг хэлье ээ. Тийм учраас 2019 оны 2 дугаар улиралд нэг удаа үнийн тарифыг өөрчилсөн байгаа, одоо 2022 оны 11 дүгээр сарын 1-нээс үнэ тарифыг өөрчлөх ийм саналыг Эрчим хүчний зохицуулах хороон дээр ишидвэр гаргаад явж байна. Эхний ээлжид айл өрхүүдийн дулаан, цахилгааны үнийг бол цахилгаан эрчим хүчний үнийг, дулааны үнийг эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй байгаа учраас нэмэгдүүлэхгүй ээ. Цахилгаан эрчим хүчний тухайд аж ахуйн нэгжүүдийн хувьд 5000 киловатт хүртэлх хэрэглээтэй бол 14 хувь, 5000-ас дээш юу хэрэглээтэй бол 5000-аас дээших хэсэгт нь бол 28 хувиар нэмэгдүүлж тооцохоор ийм цахилгааны эрчим хүчний тариф гарч байгаа.

Уул уурхайн компаниуд болон банк, үүрэн телефон операторууд гэх мэт санхүүгийн ачааллыг дааж чадахуйц цөөн хэдэн юу, крипто валют олборлогч нар бол 28 хувь, 200000 киловатт хүртлээ бол 28 хувийн нэмэгдэлтэй байна, 200000-ас дээш мянган киловаттаас дээших хэрэглээнд нь бол 38 хувийн нэмэгдэл тооцохоор ингэж явж байгаа. Энэ тооцооллыг хийгээд нэмэгдүүлсэн тохиолдолд жилийн хугацаандаа нэг, 280 орчим тэрбум төгрөгийн нэмэлт орлого олох ийм бололцоо бий. Энэ бол нийт төсөвт борлуулж байгаа үнэ нь борлуулж байгаа өөрийнх нь бараа бүтээгдэхүүнийг өртгөөс нэг 28 орчим хувь дутуу байгаа, бүрэн гүйцэд хааж чадахгүй иймэрхүү байдалтай байгаа гэдгийг ойлгож байна.

Бид нар энэ цахилгаан үнэ тарифыг нэмэгдүүлэхэд бас тодорхой хэмжээний цаг нь мөн үү, биш үү гэдэг дээр судалгаа хийж үзсэн, одоо ингэж ойрын хугацаанд яаралтай нэмэгдүүлэхгүй бол гал алдах байдал үүссэн учраас аргагүйн эрхэнд ийм шийдвэр гаргаж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданиатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Мэргэжлийн хяналтыг нэгтгэх асуудлаар энэ Амарбаясгалан дарга л танилцах ёстой. Дагалдаж орж ирж байгаа бүх хуулиуд ирэх 7 хоногт Байнгын хороодоор хэлэлцээд, хэлэлцэх эсэх чуулганаар хэлэлцэнэ. Тэр үед мэргэжлийн хяналтад нийтдээ 107 хуульд өөрчлөлт орж ирж байгаа, 107 хуулиар бараг бүх Байнгын хороогоор бараг хэлэлцэх, 8 байнгын хороогоор хэлэлцэхээр байсан байх.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: 2023 оны улсын төсөв бас төсвийн реформ хийсэн бас төсвийн нэлээн хямгадсан, шинэ хөрөнгө оруулалтаа татсан, шинэчлэл хийсэн ийм төсөв орж ирж байна. Ерөнхийдөө бол бид Үндсэн хуульдаа Эдийн засгийн яамтай болж эдийн засгийнхаа асуудлыг бол бүхэлд нь энэ яам харж, тэгээд Сангийн яам бол хамтраад ингээд ажиллах ийм бүтцийг бий болгосон. Тэгээд энэ утгаараа бол бас нэлээдгүй аятайхан төсөв орж ирж байна гэж ерөнхийдөө бол зөвшөөрч байгаа юм. Дэмжиж байгаа юм.

Тэгээд энэ Болдын Жавхлан сайдаас нэг ганц 2 асуулт байна. Энэ орон нутгийн төсөвт энэ өргөн барьсан төсвийн 3 дугаар бүлэг гэж байгаа юм, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг гэж аймаг болгонд өгч байгаа, тийм үү? Хэд хэдэн аймаг бол авахгүй байгаа. Энэ ямар шалгуураар ийм хуваарилалт хийж байгаа вэ, хүн амд нь харьцуулж байна уу, хөгжилд нь харьцуулж байна уу, хүн амын амьдралын түвшинд нь харьцуулж байна уу? Үүнийг нэг тайлбарлаж өгөөч. Би энэ дотор харахаар Булган, Сүхбаатар гээд 2 аймаг бол нэг

8, наймхан тэрбум төгрөг тавьчихсан. Бусад нь бол нэлээн өндөр төсөв тавьчихсан байгаа. Тэгээд энэ ямар учиртай юм, эсвэл гайхалтай хөгжчихсөн ийм 2 аймаг болчихоод ингээд байгаа юм уу? Энэ дээр нэг сайхан нэг тайлбар хэлж өгөөч, ямар үндэслэлээр ийм ялгаатай байгаа юм бэ?

Хоёрдугаарт, энэ ард талд нь Орон нутгийн хөгжлийн дэмжих сан, Хөгжлийн дэмжих сан гэж байгаа юм. Мөн энэ дээр бас ялгаатай. Энэ дээр Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Булган гээд л 2 аймгаас, бас дахиад доошоо, бусад аймгууд нь бас нэлээн дээшээгээ ч байна. Үнэхээр орон нутгийн хөгжлийн дэм хөгжил нь гайхалтай хөгжчихсөн болоод энэ нутгууд аймгууд дээр ийм бага дүн тавиад байгаа юм уу? Энэ 2 дээр нэг сайн тайлбар хэлж өгөөч. Би тантай нэг зав зай гаргаад л 2-уулаа уулзаж байсан даа. Дундговь, Говь, Алтай, Завхан, Булган гэсэн нэг 4 аймаг дээр ер нь хөрөнгө оруулалтууд бол татуу яваад байдаг юм байна гээд бид 2 нэг ярьж байсан санагдах юм. Та бол үүнийг хүлээн зөвшөөрөөд л яаж байсан.

Хоёрдугаарт шинэ хөрөнгө оруулалтууд байхгүй гээд тэгсэн, энд нэг бас зам засварын ажлууд л байж байна. Баянхонгор дээр, Хэнтий дээр, Өвөрхангай, Өмнөговь гээд байж байх шиг байна. Энэ маань хаагуураа давхиад ороод ирсэн юм байгаа юм, энэ нь ямар учиртай юм байгаа юм? Ер нь бол жоохон шинэ хөрөнгө оруулалтыг нэг бага сага бол өөрчлөлт хийгээд оруулах боломж бололцоо байна уу, үгүй юу? Жишээ нь “шинэ хөдөө” гээд л маш олон гишүүд маань хийгээд явж байгаа ийм хөтөлбөр байгаа шүү дээ. Яг ард иргэд рүүгээ хандсан, ажлын байр бий болгосон, бизнесийг дэмжсэн ийм хөтөлбөр шүү дээ, тэр ажил хийе гээд байдаг, бизнес хийе гээд байдаг, ногоо цагаа тарья гээд байдаг, тэр аж ахуй нэгж явах гээд бүх зүйлээ төлөвлөхөөд байдаг мөнгө нь байдаггүй, мөнгө нь болохоор хаанаа байдаг, банкандаа байдаг, банк нь зээлээ өгдөггүй, эсвэл өндөр хүүтэй, тэгээд гар хоосон мухардаад байгаа шүү дээ. Тэд нарт дэмжлэг үзүүлээд л явж байгаа шүү дээ.

Өшөө нэг асуудал байна. Төрийн албан хаагчдын ялгавартай цалингийн болоод энэ төрийн албан хаагчдын энэ шатлал байгаа байна? Жишээ нь аймаг дээр яг таны яамны харьяа Төрийн сангийн мэргэжилтнүүд болохоор ТЗ-7-оор цалинжиж байна. Бусад нь бол ТЗ-5-аар цалинжаад байгаа юм. Суман дээр болохоор босоо тогтолцоотой нь болохоор ТЗ-5-аар цалинжаад, хамгийн бүх зүйлтэй нь ноцолдож байдаг хог шороо тэр бүхий л хагас сайн, бүтэн сайнгүй ажлаа хийгээд ингээд явж байдаг хэд нь болохоор ТЗ-3-аар. Тэгээд өнөөдөр яг үнэндээ бол сум болгон дээр зүгээр бусад сумд, аймгууд ямар байгааг мэдэхгүй, манай аймаг дээр бол нэг 4-5 орон тоо бол дандаа ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Шинэ ажлууд байхгүй байна, тэр зарчмаараа явсан нь дээр биз дээ тэрийг олонхоороо шийдээд л явах хэрэгтэй.

Тэр их засварын ажил бол шинэ ажил биш шүү, Бат Эрдэнэ сайд аа, энэ шинэ бүтээн байгуулалтын ажил биш. Зам, тээврийн хөгжлийн яамнаас таны байсан яамнаас энэ 4 том чиглэлийн энэ улсын зам, улсын чанартай энэ зам дээр засвар хийе ээ гэж их засвар шүү, их засвар хийе ээ гэж 186 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажил ийм санал ирсэн. Үүнийг бид хэсэгчилж оруулъя, 35 тэрбум төгрөгт л тааруулж их засвараа хийгээрэй гэж байгаа юм. Түүнээс биш шинэ зам, шинэ бүтээн байгуулалт огтоос биш ээ.

Цалингийн хувьд бид тогтолцооны томоохон шинэчлэл хийж байгаа. 2 салбар дээрээ хийгээд эхэлчихсэн, үлдсэн, ирэх жил бол ялангуяа орон нутаг руу чиглэсэн энэ цалингийн тогтолцооны шинэчлэл явна. Яг таны саяын хэлж байгаа тэр зэрэглэл шатлал байхгүй болно. Одоо бид 165 ялгаатай энэ цалингийн системтэй, энэ нь ерөөсөө 20 л болох юм байгаа юм, шатлал байхгүй, нэг цалингийн суурь системтэй тэр нь бол бүгд 1-5 руугаа очно гэсэн үг, нэг л суурь шаталтай.

Харин зэрэглэлийн хувьд бол ингээд 5. 5 ийм зэрэглэлтэй болоод явна, энэ бол томоохон шинэчлэл хийгдэнэ ээ гэсэн үг. Орон нутгийн хувьд бол орон нутгийн төсөв дэмжлэг бол орон нутгийн хөгжлийн сангаасаа бол ялгаатай шүү. Энэ 2 бол орон нутгийн хөгжлийн сан бол илүү алслал, хүн амынхаа тооноосоо шууд томъёогоор бодогддог, дэмжлэг бол орлого зарлагынхаа зөрүүнээс явдаг. Бид одоо 6 аймаг, нийслэл гээд 7 орон нутгийн төсөв маань улсад орлого төвлөрүүлдэг. Бусад нь бүгд дэмжлэг авч татаас авч явдаг ийм болж ирсэн. Өнгөрсөн жил мөн л энэ асуудал бас яригдаж байсан. Бид энэ дээр нэлээд тийм оновчтой хуулийн өөрчлөлт хийж, зохицуулалт хийгээд бид шинэ томъёололтой явж байгаа. Тэр талаар манай Төсвийн бодлогын газрын дарга Санжаадорж хуулийн заалтуудыг нь дахин танилцуулж өгч болно.

Түрүүн би Чинбүрэн гишүүний асуултад би тодорхой нэмж хэдэн зүйл хэлэх гэсэн юм. Өчигдөр бас хэлээд амжина лээ. Монгол Улс маань эрүүл мэндийн салбараас өөр их олон салбартай шүү дээ, Монгол Улс нэг төсөвтэй, энэ олон салбаруудыг бид багтаах гэж олон тоо бодож ингэж аль болох зөв зохицуулалтаа хийх гэж орж ирдэг юм байгаа юм. Эрүүл мэндийн салбар энэ төсвийн томоохон шинэчлэлийн үр

дүнд маш оновчтой ийм төсвийн хуваарилалтад орж ирж байгаа. Эрүүл мэндийн сайд нь ЭМДҮЗ-ийн дарга нь өөрөө энэ бүх тооцооллуудыг хийгээд ирэх жил Эрүүл мэндийн даатгалын сан дээр ямар нэг алдагдал үүсэхгүй, үйл ажиллагаа доголдохгүй, ингэж явна гэдгийг хариуцлагатай мэдэгдээд байгаа юм. Нэг их наяд 481 тэрбум гэдэг бол энэ жилийн түвшинд, энэ жилийн түвшинд. Энэ жилийн түвшин гэдэг маань бид өнгөрсөн жилийнхээс даруй 20 гаруй хувиар өсөж орж ирсэн тоо, өсөж орж ирсэн тоо.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас яах вэ, ирүүлсэн саналаасаа бол ингээд 8 хувийн ийм бага төсөв батлагдаж байгаа. Гэхдээ ийм бага хэмжээний төсвийн таналт дээр энэ салбар бүр тэр чигээрээ зогсох ийм аюул байна гэж тэгж хэлж, тэгж хамаагүй энэ том салбарын үйл ажиллагааг дүгнэж хэлж болохгүй шүү. Сүүлийн 2 жилийн хугацаанд энэ том салбар маш том, төсвийн шинэчлэлийг хийж маш том амжилт, үр дүн гаргаад явж байгаа. Ирэх жил ямар ч саадгүй энэ тогтолцоо, төсвийн шинэчлэлийг энэ салбар, төсвийн яам бүгд бид хамтраад явахад саадгүй явна гэж бодож байна.

Г.Занданишатар: Мижиддоржийн Санжаадорж 82. Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн газрын дарга.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр аймгуудын санхүүгийн дэмжлэг бол аймгуудын орлого, зарлагын зөрүүгээр Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасны дагуу л олгодог байгаа.

Харин Орон нутгийн хөгжлийн сан бол Төсвийн тухай хуулийн жардугаар зүйлд заасны дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ гэсэн 3 итгэлцүүрээр олгодог байгаа.

Г.Занданишатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Та нар нэг хувийн мөнгөө өөрсдөө өөрсдийнхөө хармаанаасаа аваад ингээд санхүүжүүлж байгаа юм шиг ингэж нэг хачин, хандлага гаргадагаа больцгоох хэрэгтэй шүү, Жавхаа сайд аа, энэ орон нутгийн хөгжлийн санд оруулж байгаа энэ доторх аймгуудынхаа ялгааг нэг хараадхаач, үнэн бодитоор нэг хараадхаач, тоог нь хараах л даа. Энэ дэмжлэг үзүүлж байгаа дэмжлэгийнхээ та нар тэгвэл тайлбараа олигтойхон шиг өгөөдөх л дөө, ямар учраас тэгвэл наймхан тэрбум төгрөг байгаад байгаа юм, ямар учраас зарим нь болохоор хорин тэрбум гараад явчихдаг юм. Энэ минийгээ тэгвэл нэг олигтойхон тайлбарлаад өгье л дөө, наадах аа.

Орон нутгийн хөгжлийн сан гэж байна тийм гайхалтай хөгжчихөөд байгаа юм уу, тэр улс аймгууд чинь. Тэгээд хөгжчихсэн болоод тэгвэл ийм бага мөнгө тавиад байгаа юм уу, хэчнээн олон жил ярих гэсэн юм үүнийг. Сүүлийн 2 жил ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулна. Хариулахад бэлтгэж байх хооронд очиж танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатар, Баттогтохын Чойжилсүрэн, Одонгийн Цогтгэрэл нарын урилгаар Увс аймгийн Улаангом сумын ЕБС-ийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ, та бүхэн төсөв хэлэлцэж байгаа үед орж ирж байна. Ди парламентаар нэвтэрч төсвийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож сайн ажиллаарай. Манай 2 сайд, танай тойргийн 2 сайд, сонгогч нар чинь энэ төсвийн ажлыг танилцуулж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэр өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе, ажлын амжилтыг хүсье.

Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүн ээ, энэ дээр бухимдаад байх юм байхгүй шүү. Бид нарын баримталж байгаа хууль нь өөрөө ийм юм, тэрнээс биш аймаг аймаг дээр үзэмжээрээ тавьдаг юм гэж байхгүй, байгаа нь л тэр, тэгвэл хуулиа өөрчлөхгүй юу, танд эрх чинь байгаа шүү дээ, өөрчлөөч тэгээд. Чи өөрчлөхгүй юу, тэгвэл. Наад засаг захиргааны нэгжийн тухай хууль дээр чинь заасан заалтын дагуу томъёогоор нь оруулж ирж байгаа юм.

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Жаахан чимээгүй байгаарай. Төсөв, мөнгөний бодлого хэлэлцэж байна. Энэ төсөв, мөнгөний бодлогыг ингээд харахаар тийм хүндрэл бэрхшээл гэхэд багадаа хямралын байдалтай ийм л тоонуудтай тулаад ажиллаж байна. Энэ мэргэжлийнхний хэлж байгаагаар болохоор төсвийн болоод төлбөрийн дансны хос алдагдал гэдэг зүйл болчихлоо гэж байгаа юм. Тогтох оо дарга аа, жаахан чимээгүй. Төсвийн болоод төлбөрийн дансны хос алдагдал гээд мэргэжлийн хэлээрээ, товчхондоо хэлэх юм бол төсвийн алдагдал гэдэг нь төр томроод байна. Монголын төр улам томроод байна. Төсвийн алдагдал их байна, төсөв тэлж байна гэсэн ийм л цаана нь энгийн утга л байгаа. Төлбөрийн дансны алдагдал гэдэг нь бид нар валют болж чадахгүй байна. Валютын орлого, зарлага нь тэнцэхгүй, зарлага нь ихэдчихээд байна. Валют болж чадахгүй байна гэдэг л хоёрхон зүйл л гэж ойлгож байгаа

юм. Тэгээд валютыг хэн олж ирдэг билээ. Экспорт хийдэг, гадаадын хөрөнгө оруулалтаар нэг бол орж ирдэг, нөгөө бол зээл авдаг. Тэгэхээр эхнийх нь буюу экспорт хийх ажлыг муу хийж байгаа, гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг маш муу хийж байгаа. Ганц ажлыг маш сайн хийж байгаа, тэр нь өр зээл тавих ажлыг маш сайн хийж байгаа. 16 оноос нааш Засгийн газрын өр 2 дахин л нэмэгдчихсэн л байгаа шүү дээ. 4 тэрбум байсан нь 8, 9 тэрбум болчихоод л явж байгаа шүү дээ. Тэгэхээр валют болж ирэх 3 ажлыг нь 2-ыг нь муу, нэгийг нь маш сайн хийж байгаа ийм л нөхцөл байдал.

Тэгээд Ерөнхий сайдаас уг нь нэг ганц 2 асуулт асууя гэж бодсон юм. Тэгээд холбогдох сайд нар нь хариулчих юм байгаа биз. Ер нь тэгээд яагаад Ерөнхий сайд бас их олон тийм дэвшилтэт зүйлүүд бас их ярьдаг. Гэтэл яг манай энэ сүүлийн засгийн үед яагаад энэ эдийн засаг, төр яагаад ингээд томроод байгаа юм бэ, улам. Төрийн оролцоо, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн оролцоо энэ эдийн засагт яагаад жилээс жилд ингээд томроод байгаа юм, дөчөөд хувь нь төсвийн төсөв нь эдийн засгийнхаа дөчөөд хувь боллоо. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн оролцоо, тэд нарын эдийн засагт эзэлж байгаа хувь хэмжээ чинь бүр болохоо байлаа. Бид нарын нөгөө тунхагласан зарчмаас чинь бүр эсрэг тийшээ яваад байгаа юм биш үү, төр улам томроод байдаг.

Дахиад нөгөө нэг асуулт нь төрөлжилт гэдэг зүйл бүр байхгүй болчихсон, эдийн засагт ганцхан салбар нь бараг 90, 100 хувийг нь ганцхан салбар нь экспортын орлогыг нь олдог, төсвийн орлогыг нь бүрдүүлдэг, үндсэндээ 2003, 4 оны тоо харж байхад уул уурхайн бусад салбарын экспорт гэдэг тоо эдийн засагт 43 хувь байсан байна лээ.

Одоо явсаар байгаад, тэгэхээр Ерөнхий сайдаас уг нь асуух гэсэн асуулт бол яагаад эдийн засаг төржөөд байгаа юм бэ? Яагаад эдийн засаг төрөлжихгүй, улам төрөлжилт нь улам муудаад ганц тулгуурт болоод байгаа юм бэ? Тэр зөв бодлогууд чинь үр дүн нь ярих биш, зөв бодлогуудын чинь үр дүн энэ 2 тоогоор илрэх ёстой л гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт нь, Сангийн сайдаас нэг асуулт асуух гэж байгаа юм, дээр бас нэг бүлэг дээр асуугаад гүйцэд хариулт авч чадаагүй. Энэ төсвийн зузаан номын 71 дүгээр хуудсан дээр байгаа. Засгийн газрын үүрэг гэдэг хэсэг. Энэ дээр 2022 оны 11 сар буюу өнөөдөр 23 оны 12 сар буюу төсөөлөл гэдэг хоёрын хооронд 28 их наядаас 39 их наяд буюу 11 их наядаар өр нэмэгдэнэ ээ гэсэн тоо байгаа. 11 их наядаар, энэ том тоонуудыг нь задлаад харах юм бол Засгийн газар дотоодоосоо 3 их наядыг авна, гадаадаас 5 их наядыг авна, Засгийн газрын өрийн баталгаа гээд 3,7 байна лээ. Шууд мөнгөөрөө бараг 8 их наядыг зээлж өр

үнэт цаас, дотоодоосоо үнэт цаас, гадаадаасаа зээл хэлбэрээр авна гээд энэ 71 дүгээр хуудсан дээр байгаа. Үүн дээр нэг тайлбар өгөөч.

Дараагийнх нь энэ юунаас статистикийн газрын даргаас асуух гэж бодож байна л даа. Манайх энэ ядуурлыг хэрхэн яаж тооцдог юм бэ? Сүүлд хэзээ тооцсон юм, одоо яг хэд байгаа юм, яг ямар аргачлалаар яаж тооцож байгаа юм? Энэ дээр нэг тодорхой, аргачлал болоод тоо баримт, сүүлд хэдэн онд тооцсон юм, хэдэн жилдээ нэг удаа тооцох ёстой байдаг юм. Энэ орлогын аргаар зарла ... /минут дуусав/

Г.Занданиатар: Болдын Жавхлан сайд, дараа нь Батдаваа дарга.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Би уг нь танд хариулсан шүү дээ, та ойлгоогүй л юм байна л даа. Наадах чинь хязгаарын тоо шүү дээ, хязгаарын тоо. Дээрээс нь ирэх жилүүдэд зээл авах төслүүд ч байгаа. Энэ дээр чинь бид дунд хугацааныхаа стратегийг Их Хурлаараа батлуулаад авчихсан, яг энэ хүрээндээ л явна. Бид аваад хэрэглэхэд бэлэн, Улсын Их Хурлаар ороод батлуулчихсан, дунд хугацааны хөгжлийн түншүүдээсээ авахаар бэлэн болчихсон, зээлийн үлдэгдлүүд ашиглаагүй байгаа зээлийн үлдэгдлүүд гээд энд чинь бараг хориод их наяд төгрөгийн ийм зээлийн гэрээнүүд байдаг юм. Эндээсээ шаардлагатай бөгөөд “шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд, мөн төсөв дээр зайлигүй шаардлагатай ийм зээлүүдээ бид аваад явна, аваад явна. Ханишийн зөрүү гээд тэр бүхнээс нэмэгдсэн зүйл нэмэгдэх тооцоолууд байгаа. Тэгэхдээ саяын таны хэлж байгаа тэр 39 бол хязгаар шүү, хязгаар. Гэхдээ бид төсвийн тусгай шаардлагынхаа хүрээнд ДНБ-ийхээ 50 хувиас хэтрүүлэхгүй л аваад явах юм байгаа юм, цаашаа.

Төсвийн алдагдлыг бол бид бууруулж ирж байгаа, шат дараатай бууруулж ирж байгаа. Энэ удаа бол бүр бид энэ оныхоос 800 гаруй тэрбум төгрөгөөр ингээд бууруулж байгаа. Энэ нь бол 2024 онд бүр хүрэх ийм алдагдлын хэмжээ байна шүү, шат дараатай бууруулаад. Тэрийг бид нар 1 жилээр нааш нь татаж, энэ ковидын үед алдсан 2 жилээ бид нөхөж байгаа гэсэн үг.

Төсөв нэлээн юм төржөөд байна. Төрөлжихгүй байна гэж байгаа, энэ шүүмжлэлтэй бол бас бид бодох ёстой зүйлээ. Үнэхээр сүүлийн жилүүдэд сүүлийн хорь гаран жил энэ төсөв маань дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх энэ төсвийн орон зай бол маш их тэлж байгаа, тэлж байгаа юм. Тэгэхээр бид цаашидаа энэ “шинэ сэргэлт”-ийн бодлого гэдэг маань төсөв дээрээ биш, харин ДНБ-ээ эдийн засгийнхаа суурийг тэлье гэдэг энэ бодлогыг л том бодлогоо бид авч явж, энэ рүүгээ бүх төсвийн шинэчлэл, төсвийн хөрөнгө

оруулалтууд, энэ бүх юм төр, хувийн хэвшлийн түншилэл, гадаадын хөрөнгө оруулалт, бүх юм энэ рүүгээ бид чиглэж байгаа. Түүний үр дүнд таны хэлж байгаа тэр хувийн эдийн засгийн хөрөнгө оруулагч нарын оролцоо эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь бол илүү их болж, төсвөөс хамаарал нь багасах учиртай. Энэ бол 1 жил, 2 жил хийгдэх асуудал биш, энэ бол дунд, урт хугацаанд хийгдэх ийм төлөвлөлт байх ёстой.

Г.Занданиатар: Статистик Батдаваа дарга нэг номер. Ядуурлыг яаж тооцож байгаа вэ гэсэн.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ядуурлын тооцоог ҮСХ Дэлхийн банкттай хамтраад 2 жил тутамдаа тооцдог байгаа. Тооцооны ерөнхий аргачлал бол хүн амын өрхийн хэрэглээн дээр нэг хүнд ноогдох хэрэглээ дээр үндэслэл тооцдог байгаа. Энэ хэрэглээний энэ түвшинг тооцохдоо хүнсний хэрэглээ гэхэд тухайн нэг хүнд ногдох хүнсний хэрэглээ маань тэр хүний өдөрт авах ёстой илчлэгийг хангаж чадаж байна уу гэдэг тэр үндэслэл дээр үндэслэж тооцдог байгаа. Тэгээд хоногийн сүүлийн үеийн ядуурлын тооцоо бол 2020 оны байдлаар тооцсон байгаа. Энэ тооцооллоор бол Монгол Улсын нийт хүн амын 27,8 хувь буюу нийтдээ 903,4 мянган иргэн ядуу амьдарч байна гэдэг ийм тооцоо гарсан байгаа. Энэ тооцоог бид нар Дэлхийн банкттай хамтраад 2 жил тутам тооцдог.

Энэ жил өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар бид нар авч байгаа. Тэгээд 23 оны эхний хагаст багтаагаад 22 оны тоог зарлахаар байгаа. Баярлалаа.

Г.Занданиатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Жавхлан сайд энэ 71 дүгээр хуудсан дээр байгаа Засгийн газрын өр гэсэн хэсгээ хэтэрхий их хязгаар гээд та нэг хэтэрхий зөөллөж л хэлээд байна л даа. Яг энд байгаагаар бол 23 оны төсөөлөл сая таны хэлснээс өөрөөр, одоо ДНБ-ий 50 хувьд байгаа өрийг 60 хувь болгоно оо, одоо төсөөлөл гээд энэ хүрээнд өр зээл авна гээд л энэ баримт бичиг дээр байж байна шүү дээ. Энэ хүртэл авна гээд л. Тэгэхээр та үүнийг хязгаар, ингээд өөр янзаар биш, энэ хүртэл бид нар өр зээл авна, энэ тоо чинь өөрөө 11 их наяд буюу бараг гурван тэрбум доллар гэсэн тоо л энд энэ хүрээнд бид нарт орон зай байна, үүнийг бид нар авна л гэж биччихсэн л байна шүү дээ. 50 хувийг 60 хувь болгоно оо гээд. Одоо 50,1 байгааг байгааг 60,1 хувь болгоно оо. Тэгэхээр үүнийг та нэг хязгаар энэ зүгээр нэг тийм төсвийн шалгуур үзүүлэлтүүдийн тоо юм гэж тайлбарлахад арай л худлаа л харагдаад байна л даа. Аль эсвэл энэ бичиг баримт чинь өөрөө өөр цаас юм уу?

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд, Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Уучлаарай, би ойлгуулж чадахгүй байгаа юм байгаа юм болов уу даа. Бид төсвийн тусгай шаардлагаа хуульчилчихсан байдаг, бид хуулийнхаа хүрээнд л ажиллана. Орон зай гарвал үүнийг ашиглах эрх нь, үүрэг нь Засгийн газарт байгаа. Ямар зээлүүдийг ашиглаж болох вэ гээд дунд хугацааныхаа бүх жагсаалтуудаа бид нар АХБ-аас, Дэлхийн банкаас ийм ийм төслүүд дээр ийм ийм зээлүүдийг авч болно оо гээд үүнийгээ Улсын Их Хурлаар батлуулчихсан, ингээд гэрийн даалгавраа авчихсан. Үүнийгээ бид гарч ирж байгаа ДНБ-ий өсөлт, төлөгдөж байгаа зээл гээд үүсэж байгаа орон зай нь дотроо хязгаарынхаа орон зайн дотроо Их Хурлаар батлуулсан тэр зээлүүдээ бид харж байгаад эрэмбэлж байгаад эдийн засгийн үр өгөөж, төлбөрийн тэнцэл дээр хийж байгаа үр өгөөж, энэ бүх зүйлээс нь харж байгаад ашиглаад явдаг ийм л зарчимтай, тэр зарчмаараа л явахыгаа хэлж байгаа юм. Тэр хэмжээндээ л зээл өсөж, буурна.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгэхээр бид 2023 оны төсвийн төслийг хэлэлцэж байна. Тэгэхээр сүүлийн энэ 21, 22 он гээд бид нар их хүнд нөхцөл байдал, томоохон сорилтуудтай тулгарч байгаа. 22 он бол үндсэндээ дэлхий нийтийн хэмжээнд дайн, ковидоос болоод инфляцын маш өндөр түвшинд, өндөр инфляцтай ийм нөхцөлд бид ажиллаж амьдарч байна. 23 онд дэлхийн эдийн засагчдын үзэж байгаагаар бол энэ инфляц бол нэг их буурахгүй гэж ингэж үзэж байгаа. Тэгэхээр бол нэлээн тийм хүндрэлтэй үед бид нар энэ төсвийг хэлэлцэж, ярилцаж, баталж бас хүндрэлтэй цаг үеийг бас туулах ийм шаардлага үүсэж байгаа юм. Тийм ч учраас өчигдөр Ерөнхий сайд үгэндээ 23 он бол макро эдийн засгийн тогтворжуулах, сэргээхэд чиглэгдсэн ийм л үйл ажиллагаа байна гэж тодорхойлсон. Тийм учраас бол энэ чиглэлээр бол УИХ онцгой анхаарал тавих ёстой гэж ингэж бодож байна.

Яах вэ, 23 оны төсвийн төсөл дээр өмнөх жилүүдээсээ давуу 2, 3 асуудлууд бий. Нэгдүгээрт нь, алдагдлаа бууруулсан, энэ бол их сайн үзүүлэлт гэж бид нар бодож байгаа. Өмнө нь бол бид нар нэг 2 орчим их наяд төгрөгийн алдагдалтай л төслүүдийг баталдаг байсан. Энэ удаа 1,5 руу оруулж ирж, ДНБ-ийгээ 2,8 хувь болгож оруулж ирсэн нь сайн үзүүлэлт.

Дээр нь хөрөнгө оруулалтыг эрс багасгасан. Ялангуяа шинэ хөрөнгө оруулалтаа зогсоосон. Энэ бол ханишийн эрсдэлтэй өнөөгийн

нөхцөлд бол маш чухал арга хэмжээ гэж бодож байгаа.

Халамжийн бодлоготой холбоотой нэлээн шүүмжлэл байдаг. Үүнийг бас аль болохоор орлогоос хамаарч авч үзэхээр эхний ийм анхны алхмууд хийж өгсөн гээд давуу талууд байна. Гэхдээ цаашид анхаарах ёстой хэд хэдэн асуудлууд байна. Манай Засгийн газар ч тэр, Их Хурал ч тэр.

Нэгдүгээр асуудал нь юу байна вэ гэхээр бидэнд хамгийн том 23 онд нэг номерын асуудал, инфляцын асуудал, инфляцын асуудал. Энэ өндөр инфляцтай үед бол бид нар томоохон хатуухан бодлого, төсвийн хатуу бодлого явуулахгүй бол бид нар гарахгүй ээ. Өчигдөр бид нар мөнгөний бодлогыг хэлэлцсэн, мөнгөний хатуу бодлого явуулна гээд шийдэж байгаа. Төсвийн ийм бодлогыг явуулах шаардлага байгаа. Ингэхгүйгээр нэг талаас нь харахад бид нар мөнгөний хатуу бодлого явуулаад, нөгөө талаасаа төсвийн тэлсэн бодлого явуулах юм бол бид цаашид инфляцаа дийлэхгүй байдал руу орох гээд байгаа юм. Тийм учраас Засгийн газар нэг номерт энэ инфляцыг 6 хувьд оруулна гэсэн асар том хүлээлт гаргасан байгаа, үүнийгээ чиглэлээр тодорхой ямар арга хэмжээ авч байгаа вэ гэж би авахаар төлөвлөж байна гэж асууж байгаа юм.

Нэгдүгээрт, хамгийн чухал юм импортын асуудал байгаа, импортыг валютын доллароос өөр хэлбэрээр явуулах чиглэлээр Засгийн газар яриа хэлэлцээр хийж тогтоож байгаа асуудал байна уу. Тухайлбал, нефть, нефтийн бүтээгдэхүүний асуудал байна, нэг номерт. Үүнийг би Засгийн газраас нэгдүгээрт асууя гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт нь, бид нар төсвийнхөө алдагдлыг бууруулж байгаа мөртөө төсвийн зарлагаа Засгийн газар их нэмэхээр орж ирж байгаа юм. Урсгал зардлыг 2,5 их наяд төгрөгөөр нэмчхэж байгаа юм. Төсвийн зарлагыг нэмнэ гэдэг бол бид нар инфляцын өндөр нөхцөлд буцаад инфляцаа дийлэхгүй байхгүй юу. Тэгэхээр заавал ингэж төсвийн зарлагыг нь нэмэх зайлигүй шаардлага байсан юм уу гэдгийг би хоёрдугаарт нь асуух гээд байгаа юм.

Гуравдугаарт нь, төсвийн алдагдлын асуудал. Бид нар төсвийг аль болохоор алдагдалгүй батлах ёстой, алдагдалгүй батлахгүй бол болохгүй нь ээ. Сүүлийн 5, 6 жил бид нар төсвийг алдагдалтай баталж байгаа. Энэ алдагдал маань өр болоод л яваад байгаа. Алдагдлаа нөхөхийн тулд зээл авч байгаа. Энэ жил дэлхий нийтийн хэмжээнд зээлийн эх үүсвэрүүд бүгдээрээ өндөр хүүтэй болчихсон, одоо 12 хувиас ... /минут дуусав/

Г.Занданишатар: Дараа нь тодруулна.

Зочид танилцуулъя. Сүхбаатар аймгийн Халзан сумын ЗДТГ-ын албан хаагчид болон Дорнод аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье. Ажлын өндөр амжилтыг хүсье. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягийн урилгаар зочилж байгаа юм байна.

Болдын Жавхлан сайд хариулъя, Болдын Жавхлан сайд хариулъя. Сангийн сайд хариулна.

Б.Жавхлан: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Тантай санал нийлж байна. Ер нь бол та яг бидний төсвийн шинэчлэлийн хүрээнд яригдаж байгаа асуудлуудыг, зорьж байгаа зүйлүүдийг хэллээ. Бид гэхдээ нэг 2 жил огцом бид зардлаа бууруулаад, шууд алдагдалгүй болоод, ингээд цоороод гараад ирэх боломж бол байхгүй, аажим аажмаар ингээд явна. Энэ жил ирэх жилийн хувьд бол бид зардлыг чадлынхаа хэрээр танаж орж ирж байгаа. Энэ нь ямар хэмжээ вэ гэхээр энэ онд бид 2 ч удаа тодотгол хийж, хөрөнгийн зардал дээр, урсгал зардал дээрээ нийт дээ 800 тэрбум төгрөгийн таналт хийсэн. Ялангуяа урсгал зардлын хувьд бол бид нар яг энэ 2 тодотголын дараах зардлын хэмжээнд оруулж ирж байгаа юм, оруулж ирж байгаа юм. Энэ бол ер нь төрийн үйл ажиллагаа, өмнө нь бид нар олон хөрөнгө оруулалтуудаар бий болсон энэ объектуудаар дамжиж энэ төрийн урсгал зардал маань өөрөө байнга ингээд тэлж байдаг. Үүнтэй харьцуулах юм бол бид зардлаа ингэж барьж орно гэдэг бол маш том хэмнэлт болж байгаа юм, хэмнэлт болж байгаа гэсэн үг. Үүнээс илүү механикаар зардал танагдах юм бол төрийн үйлчилгээ, зарим яамдын үйл ажиллагаа дээр бас доголдох ийм аюул эрсдэл гарах учраас бид энэ урсгал зардал дээр бол нэлээн болгоомжтой явна.

Өнгөрсөн жилүүдэд ковидын үед бид урсгал зардлыг бүр 15-30 хувь хүртэл яаж хэмнэж болохыг бол харсан. Яг энэ түвшинд хэмнэж чадаж оруулж ирж байгаа гэж болно.

Хөрөнгө оруулалтыг бол та сайн мэдэж байна. Бид ирэх жил олон жил хуримтлагдсан шилжих хөрөнгө оруулалтуудыг 86 хувьтай дуусгана, 86 хувьтай дуусгана. Тийм учраас энэ удаа шинэ хөрөнгө оруулалтуудаа хойш нь татаж байгаа. Мөн энэ хэмжээгээр бид нийт төсвийнхөө зардал тал дээрээ нэлээн тийм бас татаж орж ирж байгаа гэсэн үг.

Алдагдлын хувьд би хэд хэдэн гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Бид нар шат дараатайгаар ингээд бууруулж байгаа. Бид 24 онд хүрэх ёстой алдагдлынхаа бага түвшинийг 1 жилээр татаж, ирэх жил тавьж байгаа. Өөрөөр

хэлбэл өнгөрсөн 2 жил алдсан энэ цаг хугацаагаа 1 жилээр бид нааш нь татаж байна гэсэн үг.

Тэр бензин, шатахууны хувьд Уул уурхайн сайд хариулах байх.

Г.Занданишатар: Жамбалын Ганбаатар Уул уурхай, хунд үйлдвэрийн сайд хариулна.

Ж.Ганбаатар: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. 23 онд ер нь нийт шатахууны хувьд бол бид нар нэг 1,5 сая тонн шатахуун импортлохоор бол төлөвтэй байгаа. Нийт дүнгээрээ бол 1,8 тэрбум долларын асуудал бол байгаа. Хүмүүс бол яах вэ, рублиэр хийвэл дээр шүү дээ гэсэн ийм байр суурь бол илэрхийлдэг. Тэгэхдээ рубль, долларын хувьд бол өнөөдрийн байдал дээр бол нэг их том ялгаа бол их харагдахгүй ээ.

Монголбанк бол энэ свот хэлцлийг хийх талаар бол санаачилгатай ажиллаж байгаа. Цар тахлын өмнө бол бас нааштай зүйлүүд бол нэлээн байсан юм байна лээ, яах вэ. Өнөөдрийн цаг үед Тогтохсүрэн гишүүн сайн мэдэж байгаа. ОХУ-тай холбоотой энэ Украйнтай холбоотой асуудлаас болоод, энэ валютын хувьд бол ОХУ бол нэлээн чанга бодлого барьж байна. Тийм учраас энэ асуудлууд дууссаны дараа энэ хэлцлүүд нэлээн сайжрах байх гэж бодож байна. Бид энэ талаар дээшлүүлэх талаар УУЯ, Монголбанкттайгаа хамтраад бол ажиллаж байгаа. Орос, Украйнтай холбоотой асуудлууд, ер нь бол ойрын үед аль тал руугаа болох бол тэр тохиолдлоос шалтгаалаад манай ОХУ-тай хийж байгаа хэлцэл сайжирна гэж ойлгож болно. Баярлалаа.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн тодруулж асууна.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр төсвийн алдагдлыг л асуух гээд байна. Төсвийн алдагдал 2,8 хувь, ДНБ-ий 2,8 хувь болж, 1,5 их наяд төгрөгийн л төсвийн алдагдал гарч байгаа юм. Энэ бол өмнөхтэйгөө харьцуулах юм бол 900 тэрбум төгрөгөөр бууруулсан сайн үзүүлэлт байгаа. Гэхдээ яг өнөөдрийн нөхцөлд бол бид нар аль болохоор л тэглэчихээр байгаа юм, чадвал. Яагаад тэгж хэлж байна вэ гэхээр ирэх жил чинь энэ жил чинь юм байхгүй юу, инфляц өндөр учраас дэлхийн зах зээл дээрээс бид нар мэдээж энэ төсвийн алдагдлыг зээл л авна, тэр зээл чинь доод тал нь 12 хувийн хүүтэй олдох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр зарлагаа шахааж байгаад алдагдалгүй болох боломж байна уу л гэдгийг би Сангийн сайдаас асуух гээд байгаа юм. 3 дахь нь.

Г.Занданишатар: Болдын Жавхлан Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Тийм ээ, болдог бол үнэхээр л нойлчилчихмоор байна. Яг таны саяын ярьж

байгаа үнэн л дээ. Гадаад зах зээл дээр мөнгө их үнэтэй болж ирж байна, мэдээж алдагдлаа бид тийм үнэтэй эх үүсвэрээр л нөхөж таарна. Гэхдээ бид бас энэ төсөв гэдэг маань өөрөө төрийн үйлчилгээг санхүүжүүлэх, төрийн үйл ажиллагааг доголдуулахгүй явах ийм үндсэн үүрэгтэй юм байгаа юм. Үүнээс их бид нар, ялангуяа урсгал зардал талдаа танах юм бол ялангуяа нийгмийн 3 том салбар маань эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар гээд урсгал зардлын маань үндсэндээ энэ 3 салбар 70 хувь нь байдаг. Ингээд тасалдах бас аюул үүснэ ээ. Тийм учраас бид нар үнэхээр тултал танаж боож оруулж ирж байгаа төсөв маань ийм байгаа юм. Харин нольлох хэмжээнд бол бид 24 онд, 24 онд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Энэ өдрийн мэнд хүргэе ээ, та бүхэнд. Ганц 2 асуулт тодруулчихъя. Ирэх жил нүүрсийг 36,5 сая тонн гээд, үүн дотроо хэдэн хувь нь оптик гэрээ байгаа юм, яг бодитой төсөвт орж ирэх нь хэдэн тонн нь орж ирэх юм, нэг дотор нь ялгаад салгаадхаач. Тэгэхгүй бол экспорт нэмэгдээд л байдаг, нэмэгдээд л байдаг, орж ирж байгаа валют байхгүй, төгрөгийн хани чинь улам сулраад л. Ингээд л байна шүү дээ, үүнийгээ дагуу өчнөөн сөрөг асуудлууд байна. Тэгээд ирэх жил энэ төлөвлөгөөний чинь хэдэн хувь нь яг мөнгө нь орж ирэхээр байгаа юм гэсэн нэг асуулт байна.

Дараа нь энэ “шинэ сэргэлт”-ийн бодлогынхоо төслүүдийг явуулна, зураг төсвийг нь хийнэ гээд ингэсэн байгаа. Тэгээд энэ “хөх морь” төслийг нэг тодруулаадхаач. Ирэх жил юу хийгдэх юм бол оо? Төслийн нэгжийг нь байгуулаад Эрдэнэс Монгол компани дээр жишээ нь байгуулаад цааш нь явах бас боломж харагдаад байгаа. Төрийн өмчтүүдээс санхүүжүүлээд явах бас боломж байна, энэ дээр ер нь санхүү, зураг төсөв хийх ажлыг нь яаж хийе гэсэн төлөвлөгөөтэй байгаа юм гэдгийг бас Сангийн сайдаас асууя.

Нөгөө талаар Ерөнхий сайд 5 сард Өмнөговьд очихдоо иргэдэд нэлээд олон зүйлүүдийг хөрөнгө оруулалт хийнэ гэж амласан. Тэгээд энэ ажлуудыг бас яах нь тодорхойгүй байгаа учраас нэг тодруулаадхаач. Ирэх жилийн төсөв дээр лав алга, тэгээд энэ дотроо хамгийн гол нь бол энэ “хөх морь” төсөл, тэгээд 3 Тэс руу явсан зам, тэгээд дулааны станцын асуудал тулсан асуудлууд байгаа.

Дараа нь энэ орон нутаг руу чиглэсэн цалингийн арга хэмжээнд бол их талархалтай байгаа. Одоо нэмээд энэ дээрээ төрийн жинхэнэ захиргааны албан хаагчид дээрээ ТҮ-г нь нэмээд өгчихмөөр байна. Нөгөө сумын Тамгын газарт

ажиллаж байгаа үйлчлэгч, жижүүр, харуул, энэ хүмүүсийнхийг бичиг хэргийн ажилтнуудыг нэмчихмээр байх юм. Нэмэхдээ орон нутаг нь шийдэж болохоор байдлаар нэмчихвэл их сайн байх юм. Төсөвт ямар нэгэн дарамтгүйгээр орон нутаг нь өөрөө нэмэх эсэхээ шийдээд эрхийг нь олгочихвол, тийм, эрхийг нь олгочих юм бол бид нэмээд цаашаагаа явах асуудал алга. Үнэндээ сумын Тамгын газарт үйлчлэгч 420000 төгрөг аваад ажиллах уу, хажуу талын уурхайд очоод 4200000-г цуг аваад ажиллах уу гэдэг чинь тэгээд төрийн алба чинь ийм байдалтай л байна шүү дээ. Ажиллах хүн байхгүй болсон, төрийн үйлчилгээ доголдож эхэлсэн.

Дараагийн асуудал, ипотекийн зээлийн төлөлтийг дахиад 1 жил сунгачих боломж байна уу гэдэг зүйлийг бас иргэд ярьж байна. Зээлээ төлөх нь битгий хэл идэх уух хүнсээ авч чадахгүй байдал л орчхоод байна шүү дээ. Тэгээд эдийн засаг нь нэг арай гайгүй болоод эхлэхээр төлөвлөдөг юм уу, яадаг юм? ийм боломж байна уу?

Хүүхдийн мөнгөн дээр тэр 9 хувь дээр нь бас иргэд бухимдалтай байгаа. Тэр тал дээр бас тодруулчихна биз ээ.

Шилжих үлдэгдэл дээр яг одоо гэрээ байгуулагдаж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудынх ирэх жил байхгүй байгаад байгаа, энэ дээр яах вэ? Ирэх жил ингээд сох хаячих юм болов уу, яах юм бол? Энэ дээр нэг тодруулаадхаач. Яг одоо гэрээ байгуулах гэж байгаа ажлууд байх. Тэгээд энэ дээр тусгагдаагүй хаягдчихсан, тийм эд нарыг нэг эргэж харахгүй бол болохгүй болчихоод байгаа юм.

Мэргэжлийн хяналтыг татан буулгана гэж байгаа юм. Тэгээд ер нь яах вэ, орон нутагт ажиллаж байсан хүний хувьд бол мэргэжлийн хяналт зайлшгүй байх шаардлагатай л даа. Тэгээд өөрөө өөрөө, өөрөөсөө сан байгуулаад үйл ажиллагаагаа өөрөө хянадаг, лиценз өгчхөөд өөрөө араас нь хянадаг нэг ийм юм л байж болохгүй л дээ. Тэгээд яваандаа мэргэжлийн хяналт татан буугдлаа гэхэд хэдэн жилийн дараа болохгүй юм байна, буцаая гэдэг л юм руу л, бараг л эргээд л орох байх. Тэгээд татан буугдаад цаашаагаа ямар ч асуудал гарахыг мэдэхгүй, тэрийг урьдчилж мэдэх арга алга, үүнийг нэг үндэслэлийг нь хэлчихгүй юу, ямар ямар орнууд ер нь ийм байдаг юм, яагаад ер нь татан буулгах гээд байгаа юм гэдгийг нэг сонирхчихмоор байх юм.

Тэр Уул уурхайн сайдад хүсэлт тавихад тэр Цагаан дэлийн боомт руу явсан, концессын зам байгаад ... /минут дуусав/

Г.Занданишатар: Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

Ч.Хүрэлбаатар: Гишүүний асуултад хариулъя. Ер нь нийтдээ хэчнээн тонн нүүрс гарах юм, үүнээс хэчнээн нь оптик юм, хэчнээн нь урьдчилсан төлбөрөө авчихсан, нүүрс юм, Ер нь хэчнээн доллар орж ирэх юм бэ гэдэг ийм асуулт байгаа. Тэгэхээр энэ энэ 7 хоногийн 3 дахь өдөр Засгийн газар хуралдаад бас энэ нүүрсний борлуулалтыг ил тод болгох, нүүрсний борлуулалтаас орж ирж байгаа валют болгон Монголдоо орж ирэх чиглэлээр Засгийн газрын бол тогтоол гарсан. 2023 оны төсөв дээр бол нийтдээ 36,5 сая тонн нүүрс гарна гэж тооцсон. Энэ нь цар тахлын өмнөх үеийн хэмжээ буюу 2019 оны хэмжээнд хүргэх ийм зорилтыг тавьж байгаа. Өөрөөр хэлбэл ковидгүй, дайнгүй байх үеийнхээ хэмжээнд энэ экспортыг аваачна гэдэг ийм зорилт тавьж байгаа.

3 дахь өдөр гарсан Засгийн газрын тогтоолоор бол 2023 оны 1 сарын 1-нээс эхлээд бүх гэрээ цахим болно. Гэрээний дагуу бүх нүүрс гарна, хэрвээ гэрээ ороогүй бол тэр нүүрс хилээр гарахгүй гэсэн үг. Гэрээний загварыг шинэчилж баталж өгнө. Тэр гарсан доллар юу, оптикээр байна уу, урьдчилгаа төлбөрөөр байна уу, мөнгө нь Монголын банканд орж ирээд тэгээд буцаад гараад явах нь бол явна биз. Тэгэхээр бүх мөнгийг нь бол бид нар оруулж авна гэж үзэж байгаа. Оптик дээр бол нийтдээ нэг 2,3 тэрбум америк долларын оптикийн гэрээ хийгдсэн юм байна лээ. Үүнээс өглөг нь өр нь бол 1,8 тэрбум америк доллар байгаа. Тэгэхээр ер нь 2023 он хүртэл бол нэг 3 сарын зай байна, энэ хугацаандаа нүүрсний экспортыг цэгцлэх ажлууд бол хийгдэнэ. Тэгээд 2023 оны 1 сарын 1-нээс бүх зүйл бүртгэлтэй ном журмын дагуу гарна. Бүх орлого нь орж ирнэ ээ, орж ирээд гарна гэж үзэж байгаа юм.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. “хөх морь” төсөл маань ер нь Өмнөговийн 5 аймгийг хамарсан томоохон төсөл өө. Тэгэхээр энэ төслүүд нэлээн удаан яригдсан, ирэх жил ТЭЗҮ нь од гарах зардал нь бол бүрэн тавигдсан байгаа шүү. Тэгэхээр хойтон бол зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл дээрээ бүгдээрээ хамтарч сайн ажиллацгаая.

Ерөнхий сайд энэ жил 6 аймгаар явсан байгаа, ганц Өмнөговь ч биш 6 аймгаар явсан байгаа. Эдгээр аймгууд дээр явахдаа эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой бүтээн байгуулалтын ажлуудыг ард иргэдийн оролцоотойгоор ийм санал авч, жагсаалт гаргаж, эрэмбэлж ингэж явсан. Ингээд Засгийн газрын тогтоол гарч, эдгээр төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр үүрэгээ өгөгдсөн байгаа. Ингээд ирэх жил бид бүрэн бэлтгэл ажлыг нь хангана, бүрэн бэлтгэл ажлыг нь хангана. Ингээд тэр 80

тэрбум төгрөг бид нар зураг төсөв, бэлтгэл ажлаа хангах төсөв тавьсан байна, ер нь бол яг эдгээр ажлууд руу гол нь чиглэх юм байгаа юм. Ингээд сайтар бэлтгэл ажлаа хангаад, өөрөөр хэлбэл дахиж үнийн өсөлтөд нэрвэгдэхгүй байхаар шинэ индексээр, шинэ ТЭЗҮ-ээр хойтон хэдүүлээ бэлтгэл ажлаа хангаад 24 оноос шат дараатай, ингээд бүтээн байгуулалтын ажлуудаа эхлээд явах юм. Ийм байдлаар шийднэ.

ТҮ-ийн ТЗ, орон нутагт бол үнэхээр энэ ТЗ-ийн ажилтнууд бол олон жил орхигдсоныг та сая хэллээ, тийм ээ. Тухайлбал, боловсролын газар ажилладаг, ажилтан, мэргэжилтнүүд нь 500, 550000 төгрөг авдаг байх жишээтэй. Гэтэл багш нар хэдийг явдаг болчхов. Тийм учраас энэ олон жил хөндөгдөөгүй энэ цалингийн системдээ бид тогтолцоонд нь өөрчлөлт хийж байгаа. Мөн ТҮ-г ч нэмэгдүүлэх энэ боломж бол байгаа. Бид нар энэ төсвөө хэлэлцүүлэх шатанд, үүнийг дахиж бас өөрчилж, сайжруулж орж ирэх боломж ч байгаа. Ингээд орон нутагт нь боломжийг нь өгнө, хамгийн гол нь, тогтолцооны хувьд. Өмнөговь аймаг бол хамгийн боломжтой аймаг, ингээд л төсөв дээрээ хянаад, зардал дотроо суулгаад хорь битгий хэл нэмэгдүүлэх боломж нь Өмнөговь аймагт бол байгаа. Ийм учраас бусад аймаг ч гэсэндээ өөрсдөө бие дааж эдийн засгийн нөхцөл байдлаа сайжруулах, эдийн засгийнхаа суурийг тэлэх, баялаг бүтээгч нарыгаа дэмжих, татварын орлогоо нэмэгдүүлэх, ингэснээр энэ цалингийн тогтолцоогоо илүү их санхүүжүүлэх боломж гарч ирнэ ээ. Тийм учраас хөгжлийг орон нутаг руу чиглүүлэх, тэнд нь тогтвор суурьшилтай, боловсон хүчнүүдийг ажиллаж, амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэх энэ бодлогын хүрээнд энэ цалингийн томоохон тогтолцооны өөрчлөлтийг хийж байгаа юм шүү. Баярлалаа.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цогт-Очирын Анандбазарын урилгаар Булган аймгийн Хутаг-Өндөр сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе өө, Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс.

Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууна.

Н.Наранбаатар: Ипотекийн зээлийн төлөлтийг ер нь засаг дээр яригдаж байгаа юу, хойшлуулъя гэж яригдаж байгаа зүйл байна уу, үгүй юу. Ер нь яая гэсэн бодолтой байгаа юм. Тэгээд мэргэжлийн хяналтын татан буулгахтай холбоотой асуудал байна. Уул уурхайн яаманд хүсэлт тавихад тэр Цагаан дэлийн боомт руу тавигдах концессын замыг чинь дагаад 3 сумын нутагт 70 лиценз амилах гээд байж байгаа байхгүй юу. Тэгээд энэ 70 лицензийг нэг эхнээс нь

дахиад нэг үзэж шалгаад, гол нь малчдын дургүйцээд байгаа зүйл бол тэр л дээ, энэ 70 лиценз ашиглалтад орчих юм бол бид газар нутаггүй болно, газрын хөрс эргэнэ ээ л гэж л байгаа шүү дээ. Тийм учраас нэг сум, гуравхан суманд ийм 70 лиценз байх шаардлага байна уу, үгүй юу. Тэгээд энэ малчдын асуудал, орон нутгийн асуудал, сумдыг хооронд холбох асуудлыг нь шийдээд өгөх юм бол энэ дээр бол бас, бас нэг томоохон төсөл цаашаа явах бас боломжтой байгаа юм. Төрөөс ямар нэгэн зохицуулалт хийхгүй байгаа учраас л иргэд уурлаад бухимдаад тодорхойгүй, мэдээлэлгүй байгаа учраас л асуудал гараад байгаа шүү.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Ипотектэй холбоотой асуудал бол ер нь ийм шүү, үүнийг үргэлжлүүлэх нь бас их, цаад иргэддээ бас их эрсдэлтэй байгаа юм. Энэ чинь нөгөө төлбөрийг нь хүчингүй болж байгаа биш, хойшлуулах ийм боломжийг нь сонголтыг нь өгч байгаа юм, төлөөд явж болно, эсвэл хойшлуулж болно. Хойшлуулах тутам л улам л их эрсдэлтэй болж ингэж ирж байгаа. Тийм учраас мөн энэ сэдвийг хөндөх юм бол нэг ковидын хууль гэж бид нэрлээд байгаа. Энэ хуулиа ч бас сунгах ийм асуудлууд давхар давхар яригдаад явчихна. Зүгээр яах вэ, бидэнд хугацаа байна, зүгээр, үүнийг дахиж бас шаардлагатай бол ярилцах хэрэг гарах байх.

Мэргэжлийн хяналтын хувьд бол энэ дээр энэ томоохон тогтолцооны өөрчлөлт бас хийгдэж байгаа. Энэ талаар Засгийн газраас Засгийн газрын Хэрэг эрхлэхийн газраас нэлээд дэлгэрэнгүй тайлбаруудыг хийсэн. Төсвийг дагасан 108 хууль гээд байгаа, түүнээс чинь бараг наяд гаруй хууль ... /минут дуусаав/

Г.Занданишатар: Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Хэдүүлээ энэ 23 оны төсөв дээр би зарлагатай холбоотой энэ нэг хэдэн асуулт бас санал байгаа юм. Ингэхчээж болдоггүй юм уу гэсэн.

Би энэ үг хэлэхийн тулд ийм 2 материалыг ашиглалаа. Нэг нь бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 23 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн ийм зөвлөмж байна, нөгөөх нь бол аудитын дүгнэлт гэсэн ийм 2 материалыг би үндсэн материал болгож ашиглалаа. Тэгээд нэгдүгээрт, би аудитын нэг дүгнэлтийг та бүхэнд хэлж өгье өө. Энэ 2018-аас 20 оны хооронд Засгийн газрын гадаадаас авсан зээлийн 44,1 хувь нь төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулагдсан гэсэн. Тэгээд хэн Жавхлан сайд энэ дээр яг энэ олон нийт сонсож байгаа учраас та хариулт өгөх хэрэгтэй. Аудитын дүгнэлтийг та

нар шүүмжилнэ ч гэж байхгүй л дээ, энэ чинь нь мэдээж аудит гаргасан юм чинь. Тэгэхээр эндээс юу гэсэн үг гарч байна вэ гэхээр бид нар гадаадаас зээл аваад төсвийн алдагдал нөхөөд байна л гэж хэлж байгаа юм. 44 хувиар одоо төсвийн алдагдал нөхнө гэдэг бол маш аюултай ийм үзэгдэл рүү орж байна.

Үүнтэй уялдуулаад миний 2 дахь зүйл нь бол энэ жил одоо 1,5 их наядын алдагдалтай энэ төсөв батлах гэж байдаг. Тэгэхээр одоо би бас та нараас хүсмээр л байна л даа. Энэ төсвийн алдагдлыг энэ жил нойлилчихооч дээ, алдагдалгүй төсөв баталчихъя л даа, хэдүүлээ нэг удаа. Энэ өөрөө дахиад Монгол Улсын гадаад өрийг 600 сая доллароор нэмэгдүүлэх ийм төсвийг бид нар батлах гэж байна. Би одоо энэ Их Хуралд орж байгаад та бүхэнд 2 юмыг байнга гуйж, заримдаа үглэж байгаа юм. Нэгдүгээрт бол энэ улсын төсвийн хөрөнгө оруулалт энэ улсын төсвийн хэрэггүй, зарлагуудыг бол танаад өгөөч ээ. Би дахиад та нарт нэг тоо хэлье дээ. 2018 онд Монгол Улсын төсвийн зарлага 9,3 тэрбум төгрөг байсан, 18 онд. Өнөөдөр 22 онд 20 тэрбум, одоо 23 онд 20 тэрбум төгрөг болж байна, хорин тэрбум нь биш ээ, би тэрбум гээд буруу хэлээд, их наяд байсан, одоо 20 их наяд болчихоод байна. 4 жилийн дотор зарлага нь 2 дахин өсдөг улс гэж дэлхийд байхгүй. Энэ бол улсыг бид нар сүйрэл рүү авч явж байна, гадаадын өр зээлд барьж өгч байна л гэсэн үг.

Дахиад л энэ зөвлөмжийн дотор ийм өгүүлбэр байгаа, та нар сайн уншаарай. Төсвийн зарлага одоо өнөөдөр бол манай ДНБ-ий 37,6 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ жилийн төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд бол валютын нөөц чинь хүрэхгүй ээ гэж энэ шинжээчид энэ хүмүүс хэлсэн байгаа юм. Яагаад энэ төсөв хийгээд ийм ийм, одоо мэдлэг чадвартай, улс орноо гэж бодсон хүмүүсийг яагаад тооцохгүй байгаа юм бэ? Би заавал энэ иш үндэстэй ийм материалыг би ярьж хэлж байна шүү, та нар энэ бүхэн дээрээ нэг анхаарал тавиад өгөөч ээ.

Төгсгөлд нь, гадаад зээл. Сүүлийн 10 жилд манай гадаад зээл Засгийн газрын зээл бол 3,5 тэрбум америк доллароос 8 тэрбум болсон, 4,5 тэрбум америк доллараар 10 жилд гадаад зээл өсөж байна. Өсөж байгаагийн нэг шалтгаан нь төсвийн алдагдал. Нийт зээл бол 20 тэрбум байж байгаад 3,0 тэрбум болсон. Ингээд энэ тоон дээр маргахгүйгээр энэ одоо газруудын энэ гаргаж байгаа тоонууд нэг л тоо явж байгаа. Монголбанкны вэб сайт дээр байдаг ийм тоонууд.

Тэгэхээр ингээд би асуултаа дахиад хэлчихье. Нэгдүгээрт, энэ 44 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулагдсан нь үнэн байгаа биз дээ?

Хоёрдугаарт, 1,5 их наядынхаа алдагдлыг хаагаад, хэдүүлээ нэг алдагдалгүй төсөв баталчихвал яасан юм бэ? Юу нь бас болохгүй байгаа юм бэ? Энэ зөвлөмж дотор ийм ноцтой өгүүлбэр байгаа. Гадаадаас өндөр хүүтэй зээл авч, хөрөнгө оруулалт ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулъя. Сангийн сайд хариулна.

Б.Жавхлан: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Таны хэлсэн тэр хугацаа 18-аас 20 оноо нэг эргээд санацгаая. Энэ маань ОУВС-ийн хөтөлбөрт орсон байсан хугацаа юм байгаа юм. Ингээд бид ОУВС-ийн хөтөлбөрт ороходоо АХБ, Дэлхийн банк, ОУВС, Япон улсаас гээд ингээд нийтдээ бид чинь 1 тэрбум гаруй долларын зээл авсан шүү дээ. ОУВС-ийн одоо өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд яг таны хэлсэн хугацаанд 18-аас 20 онд энэ хэрэгжих үед одоо төсвийн алдагдлыг нөхөх ийм зорилгоор авсан байгаа юм, авсан. Яг энэ хэмжээ байхгүй юу. Тэгэхээр энэ тухайн үед одоо эдийн засгийн нөхцөл байдал, төлбөрийн тэнцэл бас л их хүндэрсэн байсан. Тэрийг одоо богино хугацаатай, өндөр хүүтэй элдэв янзын бонд байдаг юм уу, ийм зүйлээр нөхөх ямар ч боломж байхгүй. Урт хугацаатай, нэн хөнгөлөлттэй ийм зээлүүдээр төлбөрийн тэнцлийнхээ богино хугацааны шокийг одоо давж гарах, Төв банкныхаа валютын нөөцийг зузааруулж байж тэр хүнд үеийг давсан байдаг. Тэгэхээр энэ бол одоо түүх ээ, бодит түүх. Цаашидаа бид нар одоо ийм эдийн засгийн хүндрэлд орохгүй байх нь л ийм чухал юм байгаа юм. Тэгэхээр энэ түүхийг бол одоо нааш нь, цааш нь энэ тоог худлаа үнэн гэж ярих зүйл байхгүй. Гэхдээ ер нь урт хугацаанд энэ манай энэ өнөөдрийн үүссэн өр зээлийн асуудлыг ярих юм бол одоо их юм ярьж болно оо.

Зарлагын хувьд бол яах аргагүй ийм өндөр хүүтэй болж ирж байгаа. Сүүлийн жилүүдийн маань ер нь нэг сүүлийн 20 жилийн төсвийн болон ДНБ-ий харилцаа энэ хандлага ийм болоод байгаа. Эндээс бид нар бодлого маань аль болох төсвөө өсөлтийг нь хязгаарлаад, илүү их ДНБ-ийхээ эдийн засгийн суурь тэлэлтийг л дэмжих нь хамгийн чухал ийм бодлого. Түрүүн бас Тогтохсүрэн гишүүн яг энэ асуултыг асуусан, бид нар богино хугацаанд үүнийг бол бид нар шийдэж чадахгүй. Гэхдээ үүнд дөхөж очих томоохон шинэчлэл, реформыг хийж байгаа төсөв бол яах аргагүй 23 оны төсөв шүү. Та Ерөнхий сайд байсан хүн, энэ төсвийг бол маш сайн уншиж байгаа байх гэж ингэж харж байна. Дахиад бас нэг сайн хараадхаарай. Тэгэхээр 23 оны төсөв бол нэлээдгүй бас дэвшилттэй ийм төсөв болж орж ирж байгаа юм.

Алдагдлын хувьд үнэхээр болдог бол нойлилчихмоор байна, болдог бол үнэхээр нойлилчихмоор юм. Энэ оны 22 оныхоо төсвөөс

бид даруй найман тэрбум 850 тэрбум төгрөгийн алдагдлаа бууруулж ингэж орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө тусгай шаардлагуудаараа шат дараатай бууруулна гэж байгаа зорилтот түвшнийхээ 24 оныхоо түвшинг бид нар 23 онд хүрч байгаа гэсэн үг. 1 жилээр нь наашлуулж байгаа юм. Ковидын үед бид нар 2 жил алдсан, түүнийгээ 1 жил наашлуулж байгаа ийм алдагдлын түвшин. Тэгэхээр түрүүн бас гишүүний асуултад хариулахдаа бас л үүнийг би хэлсэн, давтаад л хэлье. Төсөв гэдэг бол төрийн үйлчилгээг санхүүжүүлэх үндсэн үүрэгтэй, үндсэн үүрэгтэй. Манай нийт урсгал зардлын 70 хувь нь манай нийгмийн 3 салбар дээр байдаг, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хамгааллын гээд. Эндээсээ танах юм бол төрийн үйлчилгээ өөрөө тасалдах, доголдох ийм эрсдэлтэй. Тийм учраас бид нар нэлээдгүй танаж ирсэн байгаа. Энэ жилийн 2 тодотголын дараах дүнгээр урсгал зардлаа бид нар өсгөхгүй барьж орж ирж байгаа, барьж орж ирж байгаа юм. Ийм төсвийг бид өргөн барьж байгаа. Тэгэхдээ ерөнхий зорилт конценцтой бол санал нийлж байгаа. Яг тэр лүү л чиглэсэн ийм төсөв өө гэдгийг дахиж хэлье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Норовын Алтанхуяг гишүүн тодруулж асууя.

Н.Алтанхуяг: Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг дотор нь хуучин нөгөө Сангийн сайд байсан Даваасамбуу, Бямбажав гуай энэ тэр гээд хүмүүс байлаа л даа, тэгээд та нар ийм хүмүүсийг жаахан сонсооч дээ л гэж би хэлж байгаа юм. Би дахин дахин хэлж байгаа шүү дээ, бид нэг л улстай, нэг л улсын хүмүүс шүү дээ. Тэгэхээр энэ дээр чинь ийм дүгнэлт өгөөд байна шүү дээ, та нарт. Өндөр хүүтэй зээл авч хөрөнгө оруулалт, халамжийг санхүүжүүлж болохгүй ээ гээд энэ зөвлөмжид чинь өгчхөөд байгаа юм. Тэгээд та нар юмаа үз л дээ л гэж би гуйгаад хүсээд, заримдаа уурлаад байгаа юм. Ганцхан Монгол Улстай байж түүнийгээ дампууруулчихмааргүй байна шүү дээ.

Энэ жишээ нь, Чингис бондын мөнгөн дээр бол Аюулгүйн зөвлөл дээр яриад 2 юмыг хатуу хаасан юм. Нэгд нь бол бондын мөнгөнөөс бол төсвийн алдагдал ерөөсөө нөхөхгүй, нөхөж болохгүй, хоёрдугаарт нь бол халамжид нэг ч төгрөг өгч болохгүй, үүнийг бол тэрнийхээ дагуу хийсэн ийм л зүйл л дээ. Тэгэхээр энэ сүүлийн үед авч байгаа энэ ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд асуултад хариулна.

Б.Жавхлан: Чингис бондыг ярих гэж байгаа бол ингэж ярина. Бид нар Чингис бондын үлдэгдэл 133 сая долларыг энэ жил төсөв дээрээс төлөөд ингээд Чингис бонд дуусаж байгаа юм. 10 онд авсан, 12 жилийн дараа бид нар ингээд

төлөөд дуусаж байгаа юм. Гэтэл Чингис бондын тал нь Хөгжлийн банк дээр чанаргүй зээл болоод хэвтэж байгаа юм. Үүнийг төлүүлэх гээд бид нар ядаж байгаа юм. Хэрвээ энэ Чингис бонд орж ирээд энэ богино хугацаатай валютын эх үүсвэрээр богино хугацаанд валют оруулж ирдэг төслүүдийг амжилттай санхүүжүүлсэн бол өнөөдөр энэ хүндрэлүүд ингэж овоорохгүй юм байгаа юм. Хэрвээ тэгсэн бол саяын таны яриад байгаа тэр богино хугацаатай, өндөр хүүтэй, ийм гадаад зээлээр алдагдлаа нөхөх ийм шаардлага үүсэхгүй байх байсан, үүсэхгүй байх байсан. Ийм л юм байгаа юм. Одоо бид нарын дунд хугацааны 3 жилийн стратегийг батлуулсан дотор яг ийм даалгавар бид нар Их Хурлаас авсан. Юу вэ гэвэл дахиж арилжааны зориулалттай ийм бонд гаргахгүй шүү ... /минут дуусав/

Г.Занданишатар: Норовын Алтанхуяг гишүүн 1 минут тодруулчих.

Н.Алтанхуяг: Та нар нэг инээдтэй юм ярих юм. Ингээд л нэг 10 хэд вэ, энэ чинь 22 гээд 10 жилийн өмнө авсан Чингис бонд дээр юу хийснийг Монголын ард түмэн сайн мэдэж байгаа. Жавхлан сайдтай би нэг юман дээр санал нэг байгаа, түүнийг төлүүлэх эсэх асуудал нь бол дараа дараачийн Засгийн газрын тэр банкны хүмүүсийн асуудал. Та нар тэр банк дээр хэчнээн мянган луйвар болсныг бүгдийг нь мэдэж байгаа. Түүнийгээ цэгцлэх нь та нарын асуудал. Тэгэхдээ яг өнөөдөр авчирсан бондын мөнгөөр 888 үйлдвэр маш их хэмжээний биз, тэгэхдээ дахиад нэг юм хэлчихье, яг маргааш мөнгө өгдөггүй юм руу орсон уу гэвэл орсон, яг маргааш мөнгө өгдөггүй зам руу орсон. Одоо Монгол Улсын арван хэдэн аймгийг хатуу хучилттай замаар холбосон нь буруу юу. Энэ 3, 4 дүгээр цахилгаан станцыг өвөл хөлдөх гээд байхад нь чадалгүй болчихсон байхад нь чадлыг нь нэмэгдүүлээд 200 орчим мегаваттаар нэмэгдүүлээд, тэгэхдээ хямдхан шүү, тэр ... /минут дуусав/

Г.Занданишатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЕБС-ийн багш, ажилчид, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Алтанхуяг гишүүн өөрөө нэгэнт энэ сэдвийг хөндсөн учраас би тайлбар хэлэх шаардлагатай. Энд Чингис бонд 18 төрлийн багц ийм төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлсэн байдаг юм. Төслийн орлогоос

эргэн төлөгдөх 36,6 хувьтай улсын төсөв рүү шилжүүлчихсэн, төсвийн шинэчлэлтэй үйл ажиллагааг санхүүжэсэн, өөрөөр хэлбэл тухайн үед ийм үнэтэй эх үүсвэрүүдийг оруулж ирээд санхүүжүүлэх төсөл хөтөлбөр байхгүй байсан учраас яах аргагүй ингээд төсөв рүү яваад орчихсон, нөгөө 2, 3 төсөвтэй яваад байсан гэдэг учир нь өөрөө энэ. Төслийн санхүүжилтүүд хийгдсэнээс одоо 53 хувь нь чанаргүй болчихсон байгаа юм. Яагаад гэвэл Алтанхуяг гишүүн ээ, ийм богино хугацаатай ийм үнэтэй мөнгөөр 20, 30, 40 жилийн өгөөжөө гэдэг зам руу хийж болохгүй ээ, болохгүй. Тэр зам руу, хэрвээ гаднын санхүүжилт хийе гэж байгаа бол 20, 30 жилийн нэн хөнгөлөлттэй дэд бүтцийн санхүүжилтүүдийг авч хийдэг болохоос биш богино хугацаанд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Шатарбалын Раднаасэд гишүүн асуулт асууна.

Ш.Раднаасэд: 2-3 асуулт байна. Багагүй хэмжээний барилгууд царцаагдах юм байна. Ялангуяа магадлал хийгдээгүй, нийтдээ хэдий тооны сургууль, цэцэрлэг байна. Ялангуяа орон нутаг, манай аймаг дээр гэхэд 2, 3 юм л лав харагдаж байна. Энэ 24 онд төсөвт суулгаад хийнэ гээд энэтэй холбоотой нэг асуудал байна, үүнийг төсвийн хууль дагасан энэ тогтоол дотор агуулгаар явж байгаа ч гэсэн жагсаалтыг нь гаргахаасаа өмнө энэ хуулиа салгаад аваад үлдчихмээр байх юм. Тухайлаа юм бол Завхан, Говь-Алтай хоёрын хооронд нэг агаарын шугам, цахилгааны шугам явдаг. Төсөв тавигдсанаас хойш 4 жил болж байна, ажил нь эхэлдэггүй, мөнгө нь өсөөд л ингээд төсөв дээр яваад байдаг. Ийм юм энэ дотор их байгаа. Тэгэхээр энэ Үндэсний аудитын газар орчихсон байгаа юм гэсэн, үүнийг нь Төсвийн байнгын хороон дээр авч үлдэж байгаад төсвийн хууль, энэ 23 оны төсөв батлагдсаны ар дээр тусгайлан дахиж энэ тогтоолд батлах нь зүйтэй юм болов уу гэсэн нэг ийм санал байна.

Энэ цалингийн нэмэгдлийн асуудал ярьж байна. Ялангуяа энэ бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, энэ Төрийн албаны хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр зөвхөн төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдэл өгнө гэсэн нэг ийм заалт шинээр нэмээд ороод ирсэн байгаа юм. Тэгээд тэнд ажиллаж байгаа багш, эмч нар яах юм, үйлчилгээний албанд ажиллаж байгаа, бүр захиргаанаасаа хэдэн 10 дахин олон тооны хүмүүс байгаа шүү дээ. Энэ төвлөрлийг сааруулъя гэж байгаа бол орон нутагт хөгжлийг хүн амын төвлөрлийг бий болгоё гэж байгаа бол энэ цалингийн нэмэгдэл зөв. Энэ бүсийн нэмэгдэл гэж маш олон жил ярьж байгаа, үүнийг хийх гэж байгаа бол ингэж алагчилж хийж ерөөсөө болохгүй байх. Ирэх жил тэгээд энэ дээр тодорхой тооны мөнгө байгаа болоод ингэж орж байгаа юм уу, зүгээр төрийн албаны хууль

дээр ямар зорилгоор энэ орсон юм бол. Ер нь энэ түгжрэл төвлөрлийг бууруулах юм уу, энэ Сүхбаатар сайд алга байх шиг байна, энэ хүн бол түгжрэлийн сайд биш болно, хөдөөг хөгжүүлэх сайд байхгүй юу. Хөдөөгийн хөгжлийг бий болгож байж энэ түгжрэл алга болно. Мааш олон юман дээр хүн амын орлогын албан татвар энэ дотор бас шатлалаар ингээд өсөөд ороод ирсэн байна лээ. Шатлалтай болгоод. Орон нутагт амьдарч байгаа ард иргэдийн хүн амын орлогын албан татварыг өшөө бараг энэ дотор нойлжих ёстой байхгүй юу. Ингээд гарч байгаа хууль болгон Засгийн газраас гарч байгаа бодлого болгон дээр энэ хот, хөдөө гэдэг юмыг эдийн засгийн хөшүүргүүдийг сууж явж байж бид нар энэ хотын түгжрэлийг бууруулна. Энэ бодлого чинь зүгээр зам барих хэдэн төгрөг тавьснаар асуудал шийдэгдэхгүй гэж хараад байгаа юм.

Энэ онгоцны билетийн асуудал байна. Орон нутагт нисэж байгаа. Одоо Говь-Алтай руу сая гаруй төгрөгөөр нисэж байна, тэгээд татаас гээд навигацийн орлогоос мөнгө өгдөг, тэрийг нь хүртэл болих. Орон нутгийн иргэд нисэж байгаа бол Говь-Алтай аймгийн иргэн Говь-Алтай аймаг руу нисэж байгаа бол 300000 төгрөгөөр нисэх, хотоос нисэж очиж байгаа албан томилолт, тэр аялал жуулчлалаар явж байгаа бол сая төгрөгөөр нис. Тэр 300000 төгрөгийн зөрүү 700000 төгрөгийн татаасыг нь навигацийн орлогоос өгдөг болмоор байна. Зүгээр Авиа компаниудад аваачиж ингээд бөөнөөр нь навигацийн орлого гэж нислэгийн тоогоор нь мөнгө өгөхөөр тэнд хэн хамрагдаад байгаа нь мэдэгдэхгүй, ялгаагүй, нөгөө л нислэг нь доголдоод л, тэнд амьдарч байгаа хүмүүс байнга нисэх боломж нь хүртэл бас хаагдсан байгаа. Энэ мэтчилэнгээр ингээд энэ хөдөө рүү чиглэсэн хөрөнгө оруулалт, энэ түгжрэлийн асуудлыг бууруулах юман дээр нэлээн юм ярих ёстой юм болов уу гэж хараад байна.

Бас нэг зүйл, энэ мэргэжлийн хяналттай холбоотой юм байна. Мэргэжлийн хяналтыг ингээд татан буулгаж болно оо, 17 яам байгаа. Дараа нь нэг үйлчилгээний газар юм уу, ямар нэгэн хувийн хэвшлийн байгууллага дээр ... /минут дуусав/

Г.Занданиатар: Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Цалин дээр бол хэдүүлээ нэг цалин нэмнэ гэж ярьмааргүй байгаа юм. Энэ цалингийн тогтолцооны л өөрчлөлтөө хийж байгаа бид нар. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбар дээр бол томоохон шинэчлэл хийж чадсан. Үүний хүрээнд та сая нэг зүйл жоохон зөрүүтэй хэлээд байна шүү. Эрүүл мэндийн салбар боловсролын салбар дээр хийсэн одоо энэ тогтолцооны шинэчлэлийн үр дүнд орон

нутагт байгаа багш, эмнэлгийн ажилтан, эмч, эмнэлгийн ажилтнууд бүгд цалингийн системд нь өөрчлөлт орсон. Энэ дээр нэмэгдлүүд нь тавигдаж байгаа. Дээрээс нь үр дүнгийнхээ урамшууллаар нэмэлтүүдээ аваад явах ийм боломж бүрдчихсэн байгаа, аль хэдийн. Харин орон нутагт байгаа ТЗ энгийн ТҮ-ийн ажилчдын хувьд ирэх жилийн шинэчлэлтүүд хамрагдаад явах юм байгаа, тийм юм байгаа шүү. Тэнд мөн одоо тэр бид нар 165 ялгаатай зэрэглэл шатлалаас хамаарсан ийм системтэй. Энэ маань бол мааш энгийн 10 болж байгаа, шатлал байхгүй, тус бүр ТЗ, ТҮ дээрээ ТТ дээрээ 5, 5 зэрэглэлтэй, ингээд нийтдээ 10 л ийм ялгаатай цалингийн системтэй болоод шатлал дотроо бүгдээрээ нэг ижил суурь цалингийн систем рүү очиж байгаа учраас таваас нэг рүүгээ бүгд иүүд шилжиж очиж, энэ дээр мөн бас цалингийн зөрүүнүүд өсөж, суурь цалин нь тогтоно оо гэсэн үг.

Хөрөнгө оруулалтын хувьд би дахиад хэлье. Ирэх онд тавигдаж байгаа 1064 төслөөс 914 буюу 86 хувь нь бүгд дуусна, бүгд дуусна. Царцаж байгаа гэж хэлмээргүй байна, царцаж байгаа гэж хэлмээргүй байна. Энэ үргэлжилж байгаад дуусаж байгаа дотор үнийн нэмэгдлээ аваад явж байгаа төслүүд ч байгаа, нийтдээ 303 тэрбум төгрөгийн үнийн нэмэгдлийг Их Хурлаас өмнө нь өгсөн үүрэг даалгаврын хүрээнд үзээд, нягтлаад магадлангаар оруулаад, ингээд Барилга, хот байгуулалтын яамнаас ирсэн Засгийн газраар орсон хэлбэрээр ирэх оны төсөвт орж байгаа.

Харин төсөвт өртгийн нэмэгдэл хийгээд мөн 300-аад тэрбум төгрөгийн ийм нэмэгдлүүд яригдаж байгаа. Үүнийг харин нягтлах аудитлах асуудлууд үүсэж байгаа учраас хойтон ирэх жил энэ бүгд дээр нь дахин аудит хийгдсэний үндсэн дээр филтердээд төрийн хэмнэлтийн хуулийнхаа хүрээнд бас шүүлтүүр хийгээд 24 оноос шат дараатайгаар үргэлжлүүлж тавих ийм бодлого барьсан байгаа шүү. Түүн дээр нэмэлт мэдээлэл, жагсаалтуудын талаар тоон мэдээллүүдийг манай Хөрөнгө оруулалтын газрын дарга Чимидсүрэн өгнө.

Г.Занданиатар: 84.

Ч.Чимидсүрэн: Сайдын хэлсэн дээр нэмэлт мэдээлэл хийхэд, төсөв өртгийн нэмэгдэл дээр бол өмнө нь олон жил үргэлжилсэн төслүүдийн нэмэлт өртөг, мөн үнэ өсөлтийн асуудлуудыг бол бүрэн шийдвэрлэсэн байгаа. Харин сүүлийн жилүүдэд буюу сүүлийн 2 жилд төсөвт өртөг нь нэмэгдчихсэн 226 төслийн мэдээлэл бол ирсэн. Тэгэхээр эдгээр бол уул нь нэмэлт шинэчилсэн төсвөөрөө магадлал хийгдээд ирсэн боловч тэгээд ингээд төсөвт өртөг нэмэгдэхээр ороод ирсэн юм. Тэгэхээр үүнийг бол зайлиггүй нягталж, аудитаар оруулж байж тусгах ёстой. Энэ талаар бол бид нар төсвийн төслийг энд дагалдуулсан Улсын Их Хурлын

тогтоол дээр бол бас тэмдэглэлийг нь бол оруулсан байгаа.

Г.Занданиатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууд та бүхэндээ эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Жамбын Батсуурь гишүүн. Шатарбалын Раднаасэд гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ш.Раднаасэд: 20 жилийн өмнө байгуулагдаж байсан энэ байгууллага ингээд энэ хуулиар ерөнхийдөө 2, 3 салаад алга болж байна л даа, энэ байгууллага. Энэ анх байгуулагдахдаа нэг компани, нэг үйл ажиллагаа явуулж байгаа ААН дээр маш олон хяналтууд давхардаж очиж байна. Энэ давхардсан олон хяналт, энэ асуудал чинь ерөөсөө өөрөө бизнес эрхлэхэд маш их хүндрэлтэй байна гэж анх энэ нэгтгэгдэж байсан юм. Яам болгон өөрөө дотроо дороо хяналтын газартай хяналт тавьдаг. Одоо энэ 17 яам 17-уулаа хяналт явуулна. Нэг хоолны газар ажиллуулдаг бол хүнсний хяналт, эрүүл ахуйн хяналт, цахилгаан эрчим хүч, дулаан тэгээд л ингээд л явна. Энэ уялдаа холбоогоо чухам яаж тооцож хийж байгаа юм бол. Зүгээр тухайн үеийг бодох юм бол бас нэг харьцангуй онлайн болох янз янзын юмнууд байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ хяналтын арга ажиллагаа дотор ... /минут дуусав/

Г.Занданиатар: Хэн хариулах уу, Баасандорж дарга хариулъя, мэргэжлийн хяналт 2 номер. 2.

Раднаасэд гишүүний асуултад хариулъя. МХЕГ Баасандорж. Өнгөрсөн намрын чуулганаар 2021 оны намрын чуулганаар “шинэ сэргэлт”-ийн бодлогын баримт бичгийг УИХ-аас баталсан байгаа. Энэ “шинэ сэргэлт”-ийн бодлогын баримт бичгийн 6 дахь шинэ сэргэлт буюу төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох талаарх асуудлууд туссан байгаа юм. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар дээр ер нь энэ өнгөрсөн сая Раднаасэд гишүүний хэлсэн 20 жилийн хугацаанд төрийн шинэчлэлийн тогтолцоо маань ямар амжилтад хүрсэн юм, бас бид нар юун дээр алдсан юм бэ гэдэг дээр нэлээдгүй өргөн дүн шинжилгээ хийсэн юм. Яг саяын гишүүний хэлсэнчлэн 2003 онд анх МХЕГ байгуулагдсан, тухайн үедээ мөн олон улсын туршлагыг судалж үзсэн байдаг, НҮБ-ын төсөлтэй хамтарч хэрэгжүүлсэн юм байна лээ. Дэлхий дээр ер нь яг манайх шиг нэгдсэн

тогтолцоотой 3 улс л байгаа юм. Босни, 2 дахь нь манай Монгол улс, 3 дахь нь Хорват гэсэн 3 улс байгаа. Яг өнөөдөр, 20 жилийн хугацаанд бид нар яг 2003-2010 он хүртэл Мэргэжлийн хяналт ... /минут дуусав/

Г.Занданиатар: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Өмнөх төсвийн бодлого өмнөх зарцсан хөрөнгө оруулалтууд, дуусаагүй хөрөнгө оруулалтуудыг 23 ондоо нэг бүрэн дуусгая гэж энэ санаа тавьж байгаа нь бол чухал юм байгаа юм. Гэхдээ бодит нөхцөл байдал энэ зүйлийг нэг анхаарч үзээч гэж би Жавхаа дарга, Сангийн яамныханд хэлэх гээд байгаа юм. 18, 19, 20, 21, 22 онд тавьсан төсөвт өртөг нь магадлаар өсчихсөн, тэгсэн мөртөө цаасан дээр бол дуусах гэж байгаа юм шиг байдлаар ингэж 84 хувь нь бүгдийг дуусгах гэж байгаа гэдэг байдлаар харагдаад байгаа юм. Учир нь хөдөөд жишээлэх юм бол Эрдэнэцагаан сумын сургууль, цэцэрлэг, Баяндэлгэр сумын цэцэрлэг гээд Энх-Амгалан сайд бол нэлээд анхаарал тавьсан. Ингээд анхаарал тавиад заримыг нь бол магадлалд оруулаад бүр хяналтаар ороод ингээд төсөвт өртөг нь шинээр бий болчихсон байгаа юм. Тэгтэл хуучин төсөвт өртгийнх нь үлдэгдлийг тавиад ингэнгүүт дуусаж байгаа юм шиг бүрэн дуусаж байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Гэтэл магадлал нь хийгдчихсэн байгаа, бодитоороо. Үүнийг анхаарч үзээч ээ. Нэгэнт л 23 онд энэ асуудлуудыг дуусгах бидний л хар биеэс гарахгүй ажил учраас тэр магадлалыг төсөвт өртөг дээр нь нэмж тавиад, зөрүүг нь тавиад, ирэх онд тодорхой сургууль, цэцэрлэгүүдийг дуусгамаар байна. Тэгэхгүйгээр цаасан дээр байгаа үлдэгдлийг нь тавьчихангуут дуусчхаж байна гэсэн байрнаас хандах юм бол дуусаагүй барилга ирэх жил бас байсаар л байх болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ажлыг цэгцлэх үүднээс яг магадлал нь гарчихсан, өөрөөр улаан тамга нь дарагдаад, бэлэн болчихсон энэ байгууллагад бол төсөвт өртгийг нь нэмэгдүүлээд үлдэгдэл жоохныг нь тавиад ингээд бүрэн дуусгамаар байна гэсэн ийм бодитой саналыг эхэлж байгаа юм. Ингэх юм бол бас сургууль, цэцэрлэгүүдийн хувьд бол 24 оныг хүлээхгүйгээр хэд хэдэн сургууль бодитоор ашиглалтад орох боломж бүрдэж байгаа юм, үүнийг 1 онцгой анхаарч үзээч ээ гэж хэлэх гэсэн юм.

Дараагийн асуудал бол ард иргэд бол хамгийн гол зүйл бол Засгийн газрын тэргүүний хэлж байгаа зүйлийг гэвэл хууль энэ болох юм байна гэсэн байдлаар ханддаг. Тэгээд орон нутагт ажиллахдаа жишээлэхийн бол Засгийн газрын тэргүүн 2022 оны 7 сарын 2-нд Сүхбаатар аймагт ажилласан. Тодорхой 5 зүйлийг ирэх оны төсөвт зайлиггүй оруулна гэж

алга ташуулаад, нутгийнхны гол сэтгэл санааг амраагаад ирсэн. Тэгтэл төсвийн тавьж байгаа илтгэлтэй байвал зураг төсөв нь хийгдээгүй учраас 24 он руу шилжүүлсэн гэж хэлж байгаа юм. Тэгвэл тэр хэлэлцээрээс хойш зураг төсөв нь хийгдчихсэн, магадлалаар орчихсон, баталгаажихсан төсвийг энэ жил оруулж өгөөч ээ, бодитоор нь. Тэгэхгүй бол ахиад дараагийн он энэ жил зураг төсөв нь хийгдээд магадлалаар орчихсон зүйлийг 24 он руу шилжүүлэх юм бол ахиад л биедээ тээр тавина, нөгөө үнийн өсөлт чинь ахиад дараагийн магадлалыг хийлгэх ч юм уу, ийм нөхцөл байдлууд үүсээд байна. Тийм учраас төсөвт өртгийн дүн нь магадлал нь хийгээд хяналт шалгалтын байгууллагуудаараа баталгаажихсан энэ төсөвт өртгийн дүнг нь нэмж өгөөч. Дээр нь бололцоотой байх юм бол зөрүүг нь хийгээд нэг ч гэсэн ажлыг гараас гаргамаар байна гэсэн ийм асуултыг асууж байна. Боломжтой гэвэл ийм зүйлүүд бол хэд хэд байгаа багахан л ажил орох гээд байгаа юм. Ингээд үүнийг тодруулсны дараа би дахиж асууя гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Болдын Жавхлан сайд Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Саяын таны ярьсан төслүүд чинь бүгд энэ жил дуусахаар байгаа шүү дээ. Бүгд энэ жил дуусахаар байгаа, 22 онд 23 биш, 22 онд. Таны тэр магадлан гээд байгаанууд чинь бол яг Барилга, хот байгуулалтын ямаар ороод ирсэн, үнийн нэмэгдлийн жагсаалтад бол байхгүй юм байна лээ. Дандаа төсөвт өртөг гэхчхэн байна лээ. Тэгээд төсөвт өртгийн нэмэгдэл гарч байгаа, тэр магадлангаар оруулсан зүйлүүд бол ер нь бол их зөрчилтэй зүйлүүд байгаа шүү, тэгээд нэг бүрчлэн ярих юм бол нөгөө ёстой далай далай гэдэг шиг л юм байгаа юм. Тэгэхээр ирэх жил аудит хийлгэнэ ээ, аудитаар оруулж байж ямар түвшинд эрэмбэлж байж оруулах вэ гэдгийг 24 онд шат дараатайгаар ингээд явуулах юм байгаа юм.

Ер нь дахин хэлэхэд ганцхан таны асуултад ч биш энэ төсөвт өртгийн талаар нэлээн юм яригдаад байгаа юм. Энэ бол өмнө нь ингээд хөрөнгө оруулалтуудын бодлого маань яаж их алдагдсан, энэ хөрөнгө оруулалтыг дамжсан ийм бүр нэг хонгил үүсчхээд байсны л илрэл байхгүй юу. Бэлтгэл ажил дутуу, зураг төсөв байхгүй, дэд бүтцийн холболт байхгүй, газар нь бэлэн биш, жишиг 6-аар гээд л тавьчихдаг, жишиг зураг нь амьдрал дээр очихоороо өөрчлөгддөг, багасдаг, намсдаг, өндөр болдог, гадна холболтууд нь дэд бүтцүүд нь нэмэгддэг, газрын асуудал гарч ирдэг гээд ийм зүйлүүдээсээ болоод ажлын обьём нь өөрчлөлт ороод, тэгээд төсөв өртөг нэмэгдсэн гэж яриад байдаг юм, магадлан хийгдсэн гээд яриад байдаг юм. Тэр чинь төсвийн хуулиар бол тэр

магадлалыг бид нар хүлээж авах ёсгүй байхгүй юу. Тендер нь зарлагдаад тухайн яг зарлагдсан ажлын объёмоороо гэрээгээ хийж явчхаад ийм дүнгээр ийм ажил хийж чадна гэж явчхаад дараа нь баахан ажил зураг нэмээд хүрээд ирдэг. Тэр болгоныг авахгүй ээ, авахгүй, түүн дээр аудит хийнэ, нэг бүрчлэн аудит хийгээд, тэгээд тэрийг эрэмбэлээд төсвийн хуулийнхаа шаардлагуудыг тавиад төрийн хэмнэлтийнхээ хуулийн шаардлагуудыг тавиад, ингээд 24 онд шат дараатайгаар үргэлжлүүлнэ ээ гэж байгаа юм. Дахиад хэлье, таны хэлсэн зүйлүүд хэлсэн саяын ажлууд чинь энэ онд дуусах ёстой ажлууд байгаа шүү. Энэ онд дуусгах ёстой ажлууд. Үнийн нэмэгдлийн тэр Барилга, хот байгуулалтын ямаар оруулж баталгаажсан тэр жагсаалтад бол байхгүй ажлууд байна.

Ерөнхий сайдын явсан аймгууд дээр ард иргэдээс, орон нутгийн удирдлагуудаас өгч байсан саналуудыг бид маш сайн боловсруулж судалсан. Тухайн үед орон нутагт яригдсан асуудлууд ч байгаа. Үүнийг дахин боловсруулаад бид орон нутагт шийдсэн жагсаалтын хэмжээнд Засгийн газрын тогтоол гарсан, бэлтгэл ажлыг хангах үе шаттайгаар, үүнийг төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх гээд. Тэгэхээр 23 оны хувьд бид том зарчмаа харж байх хэрэгтэй юм байгаа юм, эхлээд. Ер нь бол энэ олон шилжиж ирж байгаа ажлуудыг ирэх онд дуусгахгүй бол тэрнээс цааш ч бид нар ажлуудаа хийж чадахгүй болж ирнэ. Тийм учраас ирэх жил нэлээн том ийм тохиргоогоо хийж аваад, мөн зэрэгцээд 23 онд бүх бэлтгэл ажлаа хангаад, бүх бэлтгэл ажлаа хангаад, таны саяын тэр зураг төсөвтэй гэж байгаа юмнууд чинь үнэлгээ нь хийгдээгүй, магадлан хийгдээгүй юмнууд ч байгаа, бүх бэлтгэл ажлыг нь хангаад шинэ индексээр шинэ онд гарах шинэ индексээ дахиж боловсруулалт хийгээд дахиж үнийн өсөлтөд эрсдэл учрахгүйгээр 24 оноосоо ингээд шат дараатайгаар бүх ажлуудаа хийгээд явъя гэдгийг жагсаалтаар Улсын Их Хурлын тогтоолоор батлуулаад яг хууль болгоод ингээд аваад явах л ийм зүйл байгаа юм. Энэ дээр харин та том зарчим, энэ том бодлогоо хараад тэвчээртэй, бас энэ том энэ шилжилтийн тохируулуудаа том утгаар нь хараад хүндэтгээд явна байх гэж найдаж байна.

Г.Занданиатар: Батсуурь гишүүн асууя, 1 минут.

Ж.Батсуурь: Үгүй ээ, яг өөрийн чинь хэлснийг л би яг яриад байгаа юм л даа. Тэр жишээ нь би нэг минут ганцхан учраас жишээлэх юм бол Дарьганга сум дээр салбарын яам очоод царцагдсан барилгыг яг бодитоор нь шалдан барилга барьсан, тэгээд дэд бүтцэд бүх юмыг нь оруулаад зургийг нь үзүүлээд, яг мэргэжлийн байгууллагаар нь магадлалыг нь оруулаад төсөвт өртөг нь өсчихсөн. Тэгээд уул нь зөрүүг нь

тавьчих юм бол нэг цэцэрлэг ирэх жил ашиглалтад орох нь ээ. Тэгэхгүйгээр хуучин дүнгийнх нь зөрүүг тавьчихаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ямар ч үр дүн гарахгүй. Жишээлэх юм бол яг л хаагуур төсвөө хянуулах ёстой, тэр зургийн газрыг хаана батлуулах ёстой вэ? Эдгээр зүйлээр нь ороод улаан тамгатай, гар хөл үсгийг нь зураад ямаараа дамжаад Сангийн ямаараа дамжаад өргөн баригдаад энд хоцорчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр уул нь бол яг ийм бодитой зүйлүүдийг бол татан оруулаад нэг ажлыг ч гэсэн гүйцээмээр л байна л гэсэн санааг хэлэх гээд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя. Баттөмөр гишүүн ээ, цаг чинь яваад байна.

Б.Баттөмөр: Энэ чинь одоо минут явчихлаа шүү дээ. Энэ орж ирж байгаа төсөв бол яах вэ дээ, 1 жилийн 5 хувийн өсөлт, нэг татварын орлого нэг 3,5 их наяд төгрөгөөр тэлж байгаа мэт боловч нөгөө ханиийг нь уналтаараа тооцохоор 2021 оны 22 оны түвшинд л байгаа шүү дээ. Нийгмийн халамжаас авдаг улсын төсвөөс нэгэн халамжид 2 их наяд төгрөг гээд л ингээд байж л байна л даа. Үүнээс муу төлүүлнэ ч гэж байхгүй л дээ. Монгол Улсын хөгжлийн потенциал чинь бол асар өндөр байгаа шүү дээ. Дэлхийд бас л нэлээн дээгүүр бичигддэг. Тэгээд ер нь бид нар бол их том харж, улс эх орныхоо хөгжлийг том харах ёстой л гэсэн энэ санааг хэлэх гээд байгаа юм л даа.

Энд нэг асуудал байна л даа. Энэ 2021 онд экспортын хэмжээ нэмэгдэж 11 тэрбум долларын урсгал бий болно оо гээд 2019 оны түвшинд хүргэнэ ээ гээд. 2019 онд ямар байсан гэхээр нэг 7,1 тэрбум долларын худалдаа хийсэн байгаа. Тэгээд 19 оны түвшинд хүрнэ гэхээр ингээд буурчхаад байгаа ч юм шиг ингээд л харагдаад байгаа юм. Энэ тоон дэрээ та нар эргэж үзэх шаардлагатай байх. Хэрвээ 11 тэрбум доллар ингээд ороод ирэх юм бол Монгол Улсын эдийн засагт хов биш түүнээс илүү хувиар өсөх. Тэр хэмжээгээр их хэмжээний валют Монголд орж ирэх ийм л дүр зураг л харагдаад байгаа юм, тэгээд энэ бичиг баримтаа та нар сайн үзээрэй гэсэн ийм зүйлийг би хэлэх гэж байгаа юм.

Ер нь энэ Засгийн газрын хувьд бол хамгийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа. Бид 30 жилийн алдаа, хөгжлийн алдаа, бодлогын алдааг энэ өнөөдөр энэ хүмүүс үүрч явж байгаа. Тийм учраас бол бид нар энэ оруулж ирж байгаа зүйл дээр нь бас хүндэтгэлтэй хандах ёстой, хэлэх юмаа хэлэх ёстой гэж ингэж бодож байгаа юм. Орж ирж байгаа асуудал, энэ татварын шаталсан тогтолцоо, баялгийн менежмент, ялангуяа тэр сая өнгөрсөн Засгийн газрын хурлыг харсан, энэ нүүрс дээр авсан арга хэмжээг бол

алга ташиж хүлээж авч байгаа. Энэ бол зөвхөн эхлэл нь, ингээд цаашаа маш их олон арга хэмжээг авах ёстой, Жавхлан сайд аа, Хүрэлбаатар сайд аа. Энэ далд эдийн засгийг ил болгох чиглэлд бас тодорхой асуудлуудыг оруулж ирж байгаа нь бол маш сайн байна гэж ингэж үзэж байгаа юм. Тэгээд эдгээр асуудлуудыг та нар бас анхаарч ингэж ажиллах шаардлагатай гэж ингэж үзэж байна.

Энэ хэд хэдэн асуулт байна. Нэгдүгээрт нь бол юу вэ гэхээр энэ ипотекийн зээлээ яах гэж байна? Энэ чинь санхүүгийн зах зээлийн маш том салбар шүү дээ. Ипотекийн зээлээс болж 2008 оны 9 оны хямрал үүсэж байсан, 4,5 тэрбум төгрөгийн тийм 4,5 их наяд төгрөгийн ипотекийн зээлийг Монголбанк тийм, ер нь гаргачихсан байгаа юм. Үүнээс 3,5 их наяд төгрөгийг Монголбанк гаргачихсан байгаа юм. 2023 оноос ипотека бол Засгийн газарт шилжиж ирж байгаа. Ипотека бол Монголд бол маш чухал ажил. Ялангуяа энэ дунд давхарга, залуучуудыг дэмжих ийм арга хэмжээ шүү дээ. Тэгээд энэ дээр ямар арга хэмжээ авах гэж байна гэсэн нэг дэх асуулт байна.

2 дахь асуудал, манай энэ орон нутагт хэрэгтэй хэрэггүй, дутуу баригдсан янз бүрийн объектууд их байдаг. Энэ объектуудыг нэг хэсгийг нь зарвал яасан юм, нэг хэсгийг нь хувийн хэвшилд бас хөрөнгө оруулаад үргэлжлүүлээд баривал яасан юм гэсэн ийм санал байгаа, санал байна, асуулт байна.

Дараагийн асуудал бол юу вэ гэхээр энэ эрүүл мэндийн салбарт 166 тэрбум төгрөг төлөвлөсөн байна. Өнөөдөр ингээд эрх ашгийн эрэмбээрээ үзэх юм бол Монгол Улсад энэ Монголчуудын эрүүл мэндийг хамгаалах асуудал нь маш чухал байгаа ... /минут дуусав/

Г.Занданишатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн “Тариаланчдын холбоо” ТББ-ын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ сайн ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэлээ хангаж энэ ажил өндөр нь өндөр амжилттай байхыг хүсэн ерөөе, Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс. Сайн сайхныг хүсье.

Хэн харцулах уу, Болдын Жавхлан сайд, Сангийн сайд харцуулъя.

Б.Жавхлан: Баттөмөр гишүүнд баярлалаа. Яг тэр үнэхээр яг бид эдийн засгийнхаа бүрэн потенциалыг бүрэн зуун хувь ил болгож, энэ дээрээ эдийн засгийнхаа нөөц хуваарилалтыг зөв хийх нь л гол ач холбогдол, том зорилго юм гэдэгтэй би танил санал нийлж

байна. Өөрөөр хэлбэл бид маш том далд хэлбэрээр байгаа эдийн засгийг бид өөрсдөө удирдаж чадахгүй байгаа. Маш том потенциал маань өөрөө тэнд далд улс өөрөө удирдаж чадахгүй ингэж явж байгаа. Үүнтэй бол зуун хувь санал нийлж байна. Үүний эсрэг, бид Засгийн газар маань дуу нэгтэйгээр хатуу ч гэсэн бид богино хугацаанд хэд хэдэн арга хэмжээнүүдийг авахаар зорьж ингэж явж байгаа.

Ипотекийн зээлийг ирэх жилд бид яг бодлого бол үргэлжилнэ, бодлого бол үргэлжилнэ. Ер нь бол хэмжээний хувьд бол зах зээлээсээ шалтгаална, зах зээлээсээ шалтгаална. Мөн худалдан авах иргэдийн маань бодит эрэлт хэрэгцээ ямар байна вэ. Мөн банкнууд маань ямар хэмжээнд дамжуулж гаргаж чадах вэ. Өөрөөр хэлбэл яг МИК төвтэй энэ ипотекийнхээ системийг бол үргэлжлүүлнэ гэсэн ийм тодорхой бодлоготой байна.

Орон нутгуудад үнэхээр олон ийм дутуу объектууд их байгаа. Бүр харамсалтай нь 2010 оноос ч хойш бүр ирсэн, дуусаагүй хэд хэдэн объектууд байгаа юм. Энэ дээр нэлээн онцгой арга хэмжээ авч байгаа, ирэх жилд дуусгахаар ингэж төлөвлөж байна. Орон нутагт нэг 4 объект, Улаанбаатар хотод 2 объект байгаа. Улаанбаатар хотод байгаа тэр 2 спортын объектыг бол үндсэндээ зогсоож байгаа, зогсоож байгаа. Харин цаашидаа харин яг таны хэлж байгаачлан одоо байгаа хэлбэрээр нь болон эсвэл цаашиа ашиглаж болно оо гэвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр үргэлжлүүлэх ийм бодлогоор бол шилжинэ ээ гэж харж байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Баагаагийн Батмөнх гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Эрүүл мэндийн салбарт үнэхээр тулгамдсан асуудлууд их байгаа, маш их олон хүн Солонгос руу явж шинжилгээ хийлгэж байна шүү дээ. Тэгээд муу нэртэй, луу данстай социализмын үед байгуулчихсан 4, 5 том эмнэлэг байгаа. Үүнийгээ түшиглээд энэ оношилгоог Монголд хийдэг юмыг л зорих ёстой шүү Энхболд сайд аа, Засгийн газар. Эн утгаар хэлсэн юм.

Дараагийн асуудал бол энэ эрх ашгийн эрүү гэж байдаг бол энэ шинжлэх ухаанд зардаг мөнгө гэж, боловсрол шинжлэх ухаанд. Манай 2021, 22 онд бол ДНБ-ий 0,11 хувийг шинжлэх ухаанд зарж байсан бол энэ жил 0,2 болгож өсгөж ирж байгаа юм байна. Гэтэл энэ зарим орнууд бол 2 хүртэл хувийг өгч байна шүү дээ, ДНБ-ий. Тэгэхээр манайх 10 дахин бага байгаа юм. Одоо энд 2, 3 жишээ хэлье л дээ. Энэ Дарханы тэр нэг өр байгаа шүү дээ, нэг Дархан 144, Үр ашиг нь жил болгон 60 тэрбум төгрөгийн үр ашигтай. Нойр булчирхайг Монголд эмчлэх энэ технологи байна ... /минут дуусав/

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Уг нь энэ шинжлэх ухааны салбар тэр юмыг салбарынх нь сайд нь хариулбал их зүгээр байх юм. Асуултаа сонссон уу. Бид ямар нэг сайд хүсэлт тавьсан, бид тодорхой хэмжээнд бол нэмсэн. Харин яг юунд зарцуулах вэ, ямар хэсэг дээр үнэхээр оновчтой хуваарилалт хийх вэ гэдэг дээрээ Энх-Амгалан сайд хариулчихвал зүгээр байх юм.

Г.Занданишатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр бид нар сая Баттөмөр гишүүний яг хөндөж тавьж байгаатай адилхнаар, ер нь энэ шинжлэх ухаанд зарцуулж байгаа мөнгө энэ зарцуулсан, төсвөөс зарцуулж байгаа энэ мөнгөний буцааж Монголынхоо эдийн засагт өгч байгаа өгөөж гэдэг энэ талуудыг төсөвтэйгөө уялдуулдаг, төсвийн үр дүн, гүйцэтгэлтэйгээ уялдуулдаг нэг энэ тогтолцоо манайд ер нь бий болж чадаагүй юм байна лээ, Баттөмөр гишүүн ээ. Тийм учраас ингээд төсвөөс шинжлэх ухаан технологийн санд бол бас багагүй мөнгө зарцуулсан байгаа. Сүүлийн 10 жилээр авч үзэх юм бол үндсэндээ 180-аад тэрбум төгрөг зарцуулчихсан, 4200, 300 орчим судалгаа санхүүжүүлчихсэн. Тэгээд нөгөө хийсэн судалгаануудынх нь үр дүн, яг нөгөө эдийн засагтай улс орныхоо хөгжилд яг ямар хувь нэмэр оруулсан юм бэ гэдэг нэг энэ шинжлэх ухааны экономикс л гэж ярьдаг юм байна лээ л дээ. Тэгэхээр энэ зүйлүүдийг бид нар үндэслэлтэй гаргаж чаддаг нэг ийм тогтолцоо руу шилжих нь их зүйтэй юм байна гэж харж байна. Тэгээд энэ дээр бол би зөвхөн нэг жишээ дурдъя л даа, Баттөмөр гишүүн ээ. Дарханы 144 дүгээр сорт гэдэг нэг сорт ... /минут дуусав/

Г.Занданишатар: Энх-Амгалан сайд гүйцээгээд хариулъя.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр энэ 144 гэж энэ сортын судалгааг, энэ сортыг бий болгоход бол 10 жил зарцуулсан байгаа. Тэгсэн мөртөө тэрбум гаруй төгрөгийн судалгаанд зарцуулаад, одоо өнөөдөр тэр сортын Монголын ХАА-д өгч байгаа өгөөж нь жил бүхэн 10 тэрбум төгрөгийн нэмэгдэл юуг бий болгож байгаа, нэмүү өртөг бий болгожээ гэсэн үг. Сүүлийн 6 жил яг үндсэндээ манай газар тариалангийн компаниудын 40 хувь нь энэ сортыг үрийн сортоор ашигладаг болсноор сүүлийн 6 жил гэхэд 60 тэрбум төгрөгийн Монголын газар тариаланд нэмүү өртөг өгдөг нэг ийм шинжлэх ухааны үр өгөөжүүд гарчихсан байна. Тэгэхээр цаашидаа бол бид нар ерөөсөө энэ шинжлэх ухаанд гарч байгаа, нөгөө зарцуулж байгаа мөнгөнүүд нь эргээд тухайн салбарынхаа өрсөлдөх чадварыг

нэмэгдүүлдэг, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэдэг энэ чиглэл рүү бид нар тэрийгээ харж энэ мөнгөө тавьдаг нэг ийм тогтолцоо руу шилжих нь их зүйтэй юм байна гэж харж байгаа. Ерөнхийдөө товчхоноор хэлэхэд ДНБ-ий нэг хувьтай тэнцэх л хэмжээний мөнгийг бид нар зарцуулдаг болёо оо л гэж зориод байгаа шүү дээ. Хамгийн наана, хамгийн багадаа. Одоо бол 0,1 байгаа шүү дээ. 0,1 тийм ээ. Тэгэхээр нэг хувь тэр ДНБ-тэй тэнцэх нэг хувийг бид нар зарцуулаад байх юм бол эдийн засгийн өсөлтийг 0,7 хувиар дэмждэг, ийм шууд хамааралтай л хөрөнгө оруулалт байдаг юм байна лээ л дээ. Тэгэхдээ бид нар үүнийг ингээд цаашаа бол ер нь нэг ийм нөгөө шинжлэх ухаанд оруулж байгаа санхүүжилтийн үр өгөөжүүдээ эргээд тооцдог, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо руу шилжих эхний алхмуудыг энэ жилээс хийгээд зарим хүрээлэн дээр энэ жилээс хийгээд явчих нэг ийм ажлууд эхлэхээр төлөвлөж байгаа гэж хэлж болно.

Г.Занданиатар: Чинбатын Ундрэм гишүүн.

Ч.Ундрэм: Өчигдөр би нөгөө мөнгөний бодлогыг ярьж байх үеэр асуулт, энэ Засгийн газрын бондтой холбоотой асуулт асуугаад олигтой хариулт Монголбанкны Ерөнхийлөгчөөс авч чадаагүй. Энэ маш их санаа зовоож байгаа учраас дахиад асуумаар байна.

Манай Засгийн газрын баталгаатай бондын үнэ огцом буурч, өгөөж нь 35 хувьд хүрсэн гэдэг ийм мэдээ олон улсын орчинд яваад байна. Энэ бол бас нэлээн аюултай сонсогдоод байгаа юм. Тэгэхээр үүнийг яах ёстой юм бэ, дахин санхүүжүүлэх гэхээр дахиад 35 хувийн хүүтэй бонд гаргах юм уу, яах юм бэ гэдгийг Жавхлан сайдаас асуумаар байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, “шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд боомтын хөгжил, чөлөөт бүсийг хөгжүүлнэ гээд нэлээн яригдаж байгаа. Манай, миний тойрог Сэлэнгэ аймагт бол Алтанбулаг боомт, чөлөөт бүс гээд бүгдээрээ байж байгаа. Тэгээд энэ чөлөөт бүс боомт, мөн сумын хөгжил нь ингээд 3-уулаа тусдаа төлөвлөгөөгөөр яваад байгаа юм. Яг ингээд харахаар дэд бүтэц нь тусдаа, жишээлбэл дулаан гэхэд ингээд тусдаа 3 жишгжихэн уурын зуух барих гээд ч байгаа юм шиг ийм үр ашиггүй төсвийн хөрөнгийг зарцуулах байдал харагдаад байгаа юм. Нэг дор төвлөрсөн ийм 3 засаг захиргааны нэгж учраас нэгдсэн ийм дэд бүтцийн төлөвлөлт хийх талаар ер нь ярилцаж байгаа юу, Засаг дээр. Үүнийг Хүрэлбаатар сайдаас асуумаар байна.

Бас нэг санаа зовоож байгаа юм, энэ жил бол шинээр хөрөнгө оруулалт тавихгүй, гэхдээ баригдаж байгаа ажлуудаа дуусгана

гэсэн. Энэ гацсан ажлуудаа яах юм бэ? Маш олон, сургууль цэцэрлэгээс авхуулаад л Алтанбулаг боомтын бүтээн байгуулалт гээд хамаг ажил гацчихаад байна. Энэ дээр нэг ажлын хэсэг гаргаад ч юм уу ингээд шуурхай арга хэмжээ авахгүй бол маш олон хүмүүсийн эрх ашиг зөрчигдөж байна, үүнээс болоод. Мөн дээрээс нь энэ чинь ингээд л гацаад л, дараа дараа жил рүүгээ яваад байх юм бол эдийн засгийн хувьд ч гэсэн маш их алдагдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг яаралтай арга хэмжээ авах талаар ярьж байна уу, үгүй юу гэдэг ийм асуулт байна.

Энэ нийгмийн халамжийн сан 483 тэрбумаас 596 тэрбум болоод ингээд нэмэгдэж орж ирж байна. Бид нар чинь халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү гээд л зөндөө яриад л хэлэлцүүлэг хийгээд байгаа. Тэгэхээр яг энэ халамжийнхаа асуудлыг яаж цэгцэлье гэж байгаа юм. Би дээр Нийгмийн бодлогын байнгын хороон дээр холбогдох яамнаас нь асуусан, 2 буюу түүнээс дээш төрлийн халамж авч байгаа хүний тоо хэд вэ гэсэн чинь 800000 хүн байгаа, зарим нь тав хүртэлх төрлийн халамж авч байгаа гэсэн тийм аймшигтай тоо надад хэлж байна. Бизнес эрхлэгчид нөгөө талдаа бид нар цалин амлаад хүн авъя гэхээр хүн байхгүй, ажиллах хүчний хомсдол та нар халамжаа боль л доо, бид нарыг хорлоод байна, бид нар бүр ингээд яваандаа дампуурах нь байна шүү дээ гэдэг ийм асуудал тавьж байна. Тэгэхээр энэ халамжийг яаж цэгцлэх юм бэ?

Хүнсний аюулгүй байдал хангамжийн тухай Улсын Их Хурлын тогтоол гарсан. Энэ тогтоолын дагуу энэ ХАА-г дэмжих, ХАА-н боловсруулах үйлдвэрийг дэмжих талаар бол татварын бодлого явах юм байна. Энэ бол сайшаалтай байна. Үүнээс гадна бас ийм зээлийн асуудал яригдаж байсан дээр чуулганы нээлт дээр Их Хурлын дарга бас энэ хүнс эрхлэгчдэд чиглүүлсэн ийм зээл шинээр санаачилъя гэсэн. Тэгэхээр үүнтэй холбоотой ямар мэдээллүүд байна?

Эцэст нь их, дээд сургуулиудыг орон нутаг руу шилжүүлж, нүүлгээ гээд л нэлээн олон жил яригдаад л холбогдох бас тогтоолууд гараад байх шиг байсан. Тэгэхээр эндээ зориулж мөнгө төгрөг төлөвлөсөн юм уу? нөгөө төвлөрлийг сааруулахад бас нэг гол ажил дээрээс нь жишээлбэл ХАА-н сургуулийг Дархан, Сэлэнгийн бүс рүү нүүлгээд илүү практиктай нь ойртуулъя, хослуулъя гээд яриад байдаг. Тэгээд энэ чинь хэзээ нүүх юм бэ? Энд зориулсан мөнгө төгрөг тавьсан юм уу? бас нэг юм ... /минут дуусав/

Г.Занданиатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ундрэм гишүүний асуултад хариулъя. Тэр бондтой холбоотой асуудал яах аргагүй бас сэтгэл зовнисон асуудал бол мөн бол

мөн. Гэхдээ бид нар зохих арга хэмжээг шуурхай авч байгаа. 2 хоногийн өмнө Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуралдаад үүссэн нөхцөл байдал дээр анализ дүгнэлт хийгээд бид хариу арга хэмжээнүүдийг маш шуурхай, банкнуудтай хамтарч мөн манай дотоодын хөрөнгө оруулагч, бас бонд холдирууд, үндэсний банкнууд маань нэлээн том ийм хөрөнгө оруулагч болж чадсан байгаа юм. Манай нийт бондын бараг 10 гаруй хувийг манай дотоодын банкнууд эзэмшдэг ийм болсон байгаа юм. Энэ асуудал бол санаатай ч юм шиг, санамсаргүй ч юм шиг ийм зүйл болсон. Ер нь бол капитал контрол гэдэг үг хэрэглэснээс болоод тэр нэг Блүүмбергийн сэтгүүлч гаргасан аар текли дотроо. Үүнээс болоод манай хөрөнгө оруулагч нар дотор мөн богино хугацаанд ийм паник үүссэн байгаа юм, паник үүссэн. Тэгээд манай өгөөж нэлээн унаж, 30, 40 хувь хүртэл унасан юм байгаа. Түүнээс биш хүү, дараагийн санхүүжилтүүд дээрээ мэдээж хүү дээр нэлээд ийм цохилт болохоор ийм мэдээ мөн үү, мөн. Гэхдээ бид богино хугацаанд буцаагаад бондуудыг худалдаж авах арга хэмжээнүүдийг авснаар бас зах зээл тогтворжих ийм эхний сигналууд гарч байгаа юм. Зүгээр өчигдөр бас депольт гээд үг хэлчихнэ лээ, тэр бол ямар тохиолдол үүсдэг вэ гэхээр төлөх цаг хугацаа нь болчихсон түлж ирээд улс орон нэрээ төлж чадахгүй бол ийм асуудал үүсдэг. Энэ бол ийм зүйл байхгүй шүү. Энэ дээр бол санаа амар байж болно. Бид нарын хамгийн ойрын хугацааны төлбөр бол 12 сард Чингис бондын үлдэгдэл 133 сая доллар байгаа юм. Үүнийг бид нар энэ жилийнхээ төсөв дээр тавьчихсан, доллар нь бэлэн, ингээд хугацаа нь болохоор шууд төлөөд ингээд явах юм байгаа юм. Тийм учраас ер нь яах вэ, В зэрэглэлтэй улсуудын хувьд 2 дахь зах зээл дээр Засгийн газрын бондууд энэ арилжаалагдаж байх ийм хүнд цаг үед бол энэ, ер нь бол хөрөнгийн зах дээр байдаг л үзэгдэл дээ, байдаг л үзэгдэл. Бидэнд бас хатуу тусах ийм эрсдэл бол байгаа, гэхдээ бид үүнийг тогтворжуулах бүрэн ийм арга хэмжээнүүдийг авч байгаа. Ойрын хугацаанд зах зээл энэ дээр тогтворжино оо гэж бодож байгаа юм.

Сэлэнгэ аймгийн хувьд бол гацсан ажлууд бол байхгүй байгаа шүү. Боомт дээр Сэлэнгэ аймгийн хувьд 23 онд 95,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 35 төсөл хэрэгжихээр тусгагдсан. 23 онд санхүүжих дүн нь 39 тэрбум, гацсан ажил байхгүй ийм байна. Алтанбулаг боомт тэр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, гадаадын зээл тусламжаар 280 тэрбум төгрөгийн ажлууд 23 онд хийгдэнэ ээ. Энэ яг нөгөө боомтын бүтээн байгуулалттай холбоотой ийм асуудал.

Чөлөөт бүстэй холбоотой асуудлыг Хүрэлбаатар сайд хариулах болов уу гэж ингэж бодож байна.

Халамжаас хөдөлмөр лүү гэдгийг бид нар ер нь бодлогоо бол тодорхойлсон байдаг. Ер нь яг зорилтот түвшинд Нийгмийн халамжийн тухай хууль дээр их зөв тодорхойлолт оруулж, үүнийгээ харин хавтгайруулахгүй үүнээс гадуур халамжийг тэлж олгохгүйгээр байгаа хуулийнхаа түвшинд халамжаа цааш нь тэлэхгүй явах нь л их чухал юм байгаа юм. Дээрээс нь энэ жилийн хувьд бол хүүхдийн мөнгө, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмж орж ирж байгаа. Цаашидаа бид нар энэ хүүхдийн мөнгийг хүүхдийн мөнгө хэлбэрээр нь явуулах уу, эсвэл өөр нэршилээр илүү их шаардлагатай байгаа нийгмийн хэсэгт нь дүнг нь нэмэх илүү байх зорилт руу нь үр дүнтэй, хүртээмжтэй байдлаа чиглүүлэх ийм бодлого руугаа бол аажмаар шилжих учиртай юм байгаа юм.

Их, дээд сургуулиудыг нүүлгэх асуудлуудыг сайд нь байж байна, Энх-Амгалан сайд хариулаад явах байх.

Г.Занданишатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд. Энх-Амгалан сайд Энхтүвшин гишүүн дараа нь.

Л.Энх-Амгалан: Ундрам гишүүний энэ их, дээд сургуулиудыг хөдөө орон нутагт үе шаттайгаар шилжүүлэх ажлуудад ямархуу үр дүн гарах вэ, 23 оны төсөв дээр энэ дээр мөнгө тавигдсан уу гэж асууж байх шиг байна. Яах вэ, бид нар нэг судалгаа хийгдээд нэг 35-50 тэрбум орчим төгрөг эхний ээлжид шаардлагатай юм байна гэдэг нэг энэ тоог бас Сангийн яамтай ярилцсан. Гэхдээ яг 23 оны төсөв дээр бол яг энэ их, дээд сургуулиудыг хөдөө орноос шилжүүлэхтэй холбоотой зардлууд бол тавигдаагүй. Гэхдээ үүнийг заавал ч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар биш, ер нь өөр хэлбэрүүдээр хийгдэх ийм хэлбэрүүд бас байна. Сайн санал санаачилгууд бас байна. Яагаад би ингэж хэлэхийг хүсэж байна вэ гэхээр манай энэ Эрдэнэт, Дархан дээр байгаа их, дээд сургуулиудын энэ дотуур байр, хичээлийн байрны ашиглалтууд их муу байгаад байгаа юм. Тэгэхээр нэмэлт хөрөнгө оруулалт гэхгүйгээр өнгөрсөн 22 оны төсөв дээр бид нар энэ дотуур байр, хичээлийн байруудын нэмэгдэл дээр нэг 12 орчим тэрбум төгрөг тавьсан юм. Тэгээд үүнийхээ ажлын үр дүнг бид нар нэг, 23 онд бас үзэх нь зөв юм болов уу гэж харж байгаа. Тэгэхдээ үүнийг шууд их, дээд сургуулиудыг хөдөө орон нутаг руу ийм механик шилжилт хийнэ гэдэг бол их буруу, энэ их буруу. Өмнө нь ч гэсэн бид нар бас механикаар шилжүүлэх гэж ийм буруу харалган бодлого хийж байгаад, ингээд тэрнээсээ ч илүү их алдсан ийм гашиун туршилага бас байгаа. Тэгэхээр үүнийг бид нар бас их цогцоор нь хармаар юм байна лээ. Тэгэхээр яг үнэхээр ингээд энэ ХАА-н их сургуулиудын зарим сургуулиуд

нүүж байсан түүх байгаа шүү дээ. Тэгэнгүүт нөгөө хажууд нь байгаа хувийн сургуулиуд нь нүүсэн сургуулиудынхаа хөтөлбөрийг нээчихдэг, ингээд үр дүн муутай болсон ийм гишүүн туршилага байгаа. Тийм учраас эхний ээлжид бид нар ингээд үүнийгээ нэг бодлогыг бол цогцоор нь харж байж энэ яг үнэхээр сургууль нээвэл хөтөлбөр нь хамт нүүдэг, оюутнууд нь хамт нүүдэг, багш нь хамт нь нүүдэг, яг нэг ийм цогцоор нь, тэгээд хөдөө орон нутагт суралцаж байгаа оюутнууд дээр бид нар нэг оюутны зээл, хөнгөлөлт оюутны зээлийн сангаас бас 50 хувь хүртэл бүр хөнгөлөлтийн зээлээр зээл олгох гэх мэтчилэнгээр ингээд багийн асуудлууд, энэ оюутны асуудлууд, сурах орчны асуудлууд, энэ хөтөлбөрийн асуудлуудыг нь бас ингэж цэгцээр нь шийдэх ийм ажлуудыг бас бодитой ажлууд болж байгаа. Хамгийн амьд жишээ бол энэ жил бид нар Өмнөговь аймаг дээр ШУТИС уул уурхайн сургуулийг шинээр нээж хичээлийн шинэ жил нь эхэлсэн. Нийт 120 гаруй оюутнууд өнөөдөр ингээд Өмнөговь аймагт суралцаж байна. Энэ хөтөлбөр бол Монгол Улсад хэзээ ч давхцахгүй, зөвхөн тэр уул уурхайн энэ тодорхой 2, 3 мэргэжлээр бол зөвхөн тэр Өмнөговийн сургууль дээр л очиж суралцах ийм боломжуудыг бид нар олгож байгаа.

Энэ жил бол бид нар Ховдын их сургууль, Дорнодын их сургууль гээд тусдаа бие даасан Эрдэнэтийн их сургуулиудыг бол бид нар МУИС, Шинжлэх ухаан технологийн сургуулийн салбар сургууль болж зарлаж байгаа. Эхний ээлжид бид нар ирэх хичээлийн жилээс авхуулаад хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод орж ирж суралцаж байгаа 10000, 12000 орчим оюутнууд жил бүхэн ирдэг, үүнийг 1, 2 дугаар курс буюу үндсэн сургалтуудыг бол бид нар хөдөө орон нутагт нь сургаад, тэгээд 2 дээр нэмэх нь 2, 3 дээр нэмэх нь 1 ч гэдэг юм уу, ийм сандвич хөтөлбөрүүдээр сургах бас нэг ийм хөтөлбөрүүдийг бас туршилтаар хэрэгжүүлэх энэ ажлууд бас энэ шинэ хичээлийн жилээс эхлэж байгаа гэдгийг бас би онцолж хэлвэ гэж бодож байна.

Г.Занданиатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд хариулна. Төвлөрлийг сааруулах бодлого.

Ч.Хүрэлбаатар: Ундрэм гишүүний асуултад хариулъя. Энэ чөлөөт бүс бол Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяалах асуудалд бол байгаа. Тэгээд Алтанбулаг дээр хийгдэж байгаа тэр боомтын ажил, чөлөөт бүсийн цаашдын хөгжил, эдгээрийн ажлуудыг бол хооронд нь уялдуулж нэг цогц бодлогоор явуулна, явуулах хэрэгтэй гэдэгтэй бол санал нэг байгаа, энэ чиглэлээр бол хамтраад ажиллана гэж бодож байгаа.

Г.Занданиатар: ХАА-н яамнаас хэн байна. Намрын ургац хураалт, өвөлжилтийн

бэлтгэл, төсвийн хэлэлцүүлгийн үгээр ХАА-н сайд хайцсан. ХАА-н яамнаас чагаад хүн байхгүй байгаа юм.

82. Санжаадорж хариулъя. Сайд нь байхгүй юм аа гэхэд энэ дэд сайд хүмүүс нь байдаггүй юм уу. Төрийн нарийн бичгийн дарга нь.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2022 онд бол УИХ-аас бол хүнсний хангамж, аюулгүй байдлын хангах талаар бол зарим авах арга хэмжээний талаар 36 дугаар тогтоолыг бол баталсан байгаа. Уг тогтоолтой холбоотойгоор бол бид нар 2023 оны төсөв дээр бол нийтдээ 138 тэрбум төгрөгийн бол хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасыг бол бид нар оруулж ирсэн байгаа. Энэ маань өөрөө бол арилжааны банканд бол нэлээдгүй тийм боломжийг гаргаж өгч байгаа. Энэ үндэсний хангамжийн зээл маань бол өөрөө чиглэх зүйл нь бол өөрөө МАА, газар тариалан гэх мэт яг хүнсний аюулгүй байдалтай холбоотой ийм зээлүүдэд чиглэх юм байгаа юм.

Г.Занданиатар: Зочид танилцуулъя.

Монгол Улсын Волейболын холбооны Залуучуудын УАШТ-ний аварга багийн гишүүд, саяхан бас залуучуудын аварга шалгаруулах тэмцээний Алтан цомын эзэн, Баянхонгор клубийн баг тамирчдадаа баяр хүргэж амжилт хүсье. Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Спорт бол хүний тэсвэр хатуужил, хамтын амжилтын бүтээл, ялалт, ялагдлын амтыг мэдэрч, хүн болгонд сайн сайхан авчирдаг энэ багийн спортоор амжилттай оролцож, анх удаа орон нутгаас улсын аварга болсон явдалд баяр хүргэе. Энэ нийтийн биеийн тамир, олимпын спортын сайдтай болсон, тэгээд, тийм Алтайн барс багийнхан Мөнгөн медаль авсан. Монгол Улсын 5 удаагийн аваргыг ялж, эднийх аварга болсон юм байна, тийм ээ, баяр хүргэе, амжилт хүсье. Улам сайн тэмцээрэй, цаашидаа дээд лигийн тэмцээндээ амжилт гаргаж, залуу үеийнхнийхээ бахдал баярын эзэд болоорой гэж хүсэн ерөөе.

Чинбатын Ундрэм гишүүн тодруулж асууна, 1 минут.

Ч.Ундрэм: Энэ нөгөө гацсан ажлуудтай холбоотой Жавхлан сайд аа, надад жишээлбэл бичиг ирээд байна л даа. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургууль, Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3 дугаар сургууль маш олон жил гацаад, ирэх жилийн төсөвт бас би шалгасан, мөнгө тавигдаагүй байна лээ л дээ. Гэх мэтчилэн маш олон ийм бичгүүд бол ирээд байна. Тэгэхээр саяын 2 дээр жишээлбэл гацсан л байгаад байна даа. Тэгэхээр энэ дээр та дараа нь ч юм уу хараад надад хэлээд өгвөл зүгээр байна.

Энэ боловсролын салбартай холбоотой, бас энэ нөгөө шинжлэх ухаан технологийн сан маань өмнө нь нөгөө яригдаад байсан шинэчлэлүүд хийгдсэн үү? Нөгөө сангийнхаа мөнгийг улс орны энэ асуудлыг шийдэх чиглэлийн чиглэл рүү нь хандуулж, хэрэгцээ шаардлагатай судалгаанууд хийлгэж, энэ улс орны хөгжил, эдийн засгийн эргэлтэд оруулах тийм чиглэлийн ажлууд энэ сангийн мөнгө тийм зүйл рүү ... /минут дуусав/

Г.Занданиатар: Хэн хариулах уу. Болдын Жавхлан сайд, Сангийн сайд хариулъя. 84.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимидсүрэн гишүүний асуултад хариулъя. Түрүүний асуусан Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын сургууль 320 хүүхдийн суудалтай, энд бол өмнөх онуудад бол 1 тэрбум 100 сая төгрөгийн санхүүжилтийг бол авсан байна. 22 онд бол 1 тэрбум 290 сая төгрөгийн санхүүжилт бол батлагдсан байгаа. Санхүүжилтээ бол гүйцэтгэл нь хянагдаж ирээгүй байгаа учраас бол энэ юу нь гараагүй байна.

Мөн түрүүний хэлсэн Мандал сумын 3 дугаар сургуулийн төсөл арга хэмжээ байгаа. Өмнөх онуудад 1,6 тэрбумын санхүүжилтийг бол авсан, 22 онд 2,1 төгрөгийн бол бас санхүүжилт батлагдсан байгаа, мөн ялгаагүй гүйцэтгэл нь ирээгүй учраас санхүүжилт нь бол гараагүй байна. 23 онд бол төсвийн төсөлд бол нөгөө төсвийн төсөвт өртгийн нэмэгдлүүд бол суугаагүй учраас ... /минут дуусав/

Г.Занданиатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Яах вэ, Ундрэм гишүүн юу, 2 асуудал зүгээр ганихан би тойргийнхоо нүдээр харж яриагүй байх гэж бодоод байгаа юм. Юу вэ гэхээр энэ нөгөө олон жил төсөвт өртөг нь нэмэгдээд яваад байдаг, тэгээд дуусдаггүй объектуудын хувь заяаны тухай л асуудлууд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол энэ манай салбар дээр нэлээн ийм ужгирчихсан ийм асуудал байгаа юм. Тийм учраас бид нар ерөнхийдөө энэ нэг 23 оныг ингээд нэг шинэ хөрөнгө оруулалт тавихгүйгээр энэ өмнө нь эхлүүлсэн хөрөнгө оруулалтуудаа цэгцэлж авъя гэдэг энэ бодлогыг их зөв хэрэгжүүлээд, өмнө нь гарсан энэ алдаа дутагдлуудаа бүгдээрээ нэг амьсгаагаар нэг засаад авах нь зүйтэй юм болов уу гэж бодож байгаа юм. Гэхдээ яах вэ, энэ дээр нэг асуудал байгаа. Юу гэхээр одоо 23 он дээр үргэлжлээд явж байгаа нэг үнийн өсөлт тооцуулсан объектууд бол бүгдээрээ ороод тэгээд бид нар бол гүйцэтгэл бол үүгээр нэлээн өндөр шахна. Асуудал яг юун дээр үүсэж байна вэ гэхээр олон жил үргэлжилсэн, яг санаатай

санаагүйгээр ингээд төсөвт өртөг нь нэмэгдээд яваад байдаг нэг ийм нөгөө манай Жавхлан сайдын хэлдгээр нэг ... /минут дуусав/

Г.Занданиатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд гүйцээгээд хариулчихъя. Тэр их, дээд сургуулиудыг гаргах асуудлаар

Л.Энх-Амгалан: Үгүй ээ, тэрийг өгчихсөн, өгчихсөн хурлын дарга аа. Тэгэхээр тэр энэ олон жил ингээд ужгираад, тэгээд нөгөө зураг төсөлгүй эхлүүлчихсэн, тэгээд дураараа нөгөө нэг өөрийнхөө нэмэлт ажлуудыг ингээд орон нутаг нь нэмж гэрээ хийгээд ингээд тэгээд тэр нь ингээд хэзээ ч дуусдаггүй, ингээд олон жил үргэлжлүүлдэг нэг ийм, одоо жишээ нь 12 онд эхэлчихсэн объектууд хүртэл дуусаагүй. Тэгсэн мөртөө төсөвт өртөг нь нэмэгдээд байдаг нэг ийм асуудлууд байгаа байхгүй юу. Тэгээд тэрийгээ бид нар нэг мөсөн энэ 23 он дээр нэг тэр магадлан итгэмжлэх нь орсон бол дахиад түүн дээр нь энэ аудит оруулж яг үнэхээр тэр төсөвт өртөг нь нэмэгдсэн үү, нэмэгдээгүй юу гэдгийг нь тогтоодог тийм хэлбэр лүү орох нь зүйтэй юм болов уу гэж нэгдүгээрт бодож байгаа.

Хоёрдугаарт бол бид нар энэ 22 он дээр тавьчихсан байгаа, 21, 22 он дээр тавьчихсан байгаа энэ объектууд дээр нэг зүйл анхаарах ёстой юм байна лээ. Юу гэхээр 21, 22 оны төсвийг бид нар баталж өгөхдөө дандаа шинэчилсэн төсвөөр баталж өгсөн байгаа байхгүй юу, энэ объектуудыг. Тэгэнгүүт гүйцэтгэл гаргах гүйцэтгэл, нөгөө том гүйцэтгэл гаргаж байгаа компаниуд нь шинэчилсэн тэр төсвөөр гэрээ хийчихсэн мөртөө дахиад нэг ийм үнийн өсөлт, дахиад төсөвт өртөг нэмэгдсэн асуудлууд ингээд яриад байдаг нөгөө гээндээ ч бий, гоондоо ч бий гэдэг шиг нэг ийм компаниуд их байна, яг үнэхээр. Тэр тусмаа үндсэндээ зэрэг зэрэг энэ объектууд авч сургууль, цэцэрлэгүүд авч ингээд сэглэдэг ийм компаниуд байгаад байна шүү дээ. Бүгдээрээ дуусдаггүй, бүгдээрээ зэрэг эхэлчихдэг, тийм учраас ингээд зарим компаниудтай бид нар, ер нь энэ хар жагсаалт энэ тэрийг зарлаж байж нэг ийм хариуцлагын тогтолцоо руу орохгүй бол яг үндсэндээ ингээд ийм, нөгөө тендерийн хонгилоор явсаар байгаад сурчихсан ийм компаниуд ч гэсэн байгаа учраас үүнийг бид нар энэ 23 оныхоо төсвийн бодлого дээрээ бас нэлээн чангалж, хариуцлагын тогтолцоогоо сайжруулж явах ёстой гэж би ойлгож байгаа. Энэ бол бид нарт олдож байгаа их том боломж юм болов уу гэж нэгдүгээрт харж байгаа.

Хоёрдугаарт бол сая Ундрэм гишүүний хэлж байгаа нөгөө шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтүүд чинь ил болсон уу гэдэг асуудлууд яриад байна л даа. Тэгэхээр яг өнгөрсөн жил бид нар энэ шинжлэх ухаан технологийн сангийн нөгөө нэг судалгаа санхүүжүүлдэг,

сонгон шалгаруулдаг энэ зүйлүүдийг бол бид нар процессуудыг нь бүгдийг нь ил болгосон байгаа. Энэ бол нөгөө шинжлэх ухааны ЖДҮ байж болохгүй л гэж бид нар хэлж байгаа шүү дээ. Тэгэхээр цаашидаа бол бид нар энэ шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтийг олон хэлбэрүүдийн ийг бий болгох шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр хийж байгаа энэ судалгаа бол яг нөгөө цөм буюу тэргүүлэх чиглэлээр улс орны хөгжил дэвшилд хэрэгтэй байгаа, улс орны тулгамдсан асуудлаар шаардлагатай байгаа тэр суурь судалгаа буюу хэрэглээний судалгааны чиглэл рүү нь бид нар энэ санхүүжилтийг олгох зарчмыг барина, нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол бид нар их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн хамтарсан судалгааг хийх энэ чиглэл рүү бид нар дэмжих энэ зарчим барих ёстой юм байна лээ. Ер нь бол манай шинжлэх ухаан хөгжүүлнэ ээ гэх юм бол энэ их, дээд сургуулиуд дээр байж байгаа энэ мэдлэг, тийм ээ, энэ ноу хау, энэ инновац, энэ шинжлэх ухаан технологийн институт, хүрээлэнгүүд дээр байгаа энэ патентуудын энэ эрдэмтүүдийн хүчин чадлуудыг бид нар мэдлэг чадваруудыг ашиглаж байж улс орны өмнө тулгамдсан байгаа энэ шинжлэх ухааны судалгаа, суурь судалгаа, шаардлагатай байгаа асуудлуудаа шийдвэрлэдэг энэ тогтолцоо руу орох нь зүйтэй юм байна гэж харж байгаа, хоёрдугаарт.

3 дугаар асуудал бол бид нар ерөнхийдөө энэ шинжлэх ухаан технологийн энэ санхүүжилтийг илүү нөгөө цөм тэргүүлэгч технологи руу суурь буюу хэрэглээний судалгаа руу санхүүжүүлдэг бодлогыг барихгүй бол хувийн хэвшилүүд бол богино хугацаанд үнэ үр дүн гардаг, энэ инновацуудыг санхүүжүүлээд явдаг учраас бид нарын дунд болон урт хугацаанд энэ бодлогоо барих нь зүйтэй юм байна гэж зүйлийг гарна харна.

4 дүгээр асуудал бол бид нар ингэж хавтгайруулж хуваарилдаг. Жилд нэг 10-12 тэрбум санхүүжилт ирэхэд нэг төсөл дээр нэг хорьхон сая төгрөг хуваарилчхаад тэндээс үр дүн нэхээд ингээд сууна гэдэг бол энэ бол бие биеийгээ хуурсан асуудал болж байгаа юм байна лээ. Тийм учраас цаашидаа бид нар энэ эрэмбийн асуудал, судалгааны эрэмбийн асуудал, судалгааны ач холбогдлын асуудал, судалгааны өгөөжийн асуудлууд дээр бид нар нэлээн тийм үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх ийм алхмуудыг хийнэ ээ гэдгээ бас би онцолж хэлжэ гэж бодож байна.

Г.Занданшатар: Төмөртөгоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Баярлалаа. 2, 3 асуулт байж байна. 2023 оны орлогыг хараад байж байна. Энэ онцгой албан татвар, хөрөнгийн албан татвар 2 өмнөх оноосоо бас буугаад төлөвлөгдсөн байж байна. Онцгой албан татварыг бас ойлгож байна, дизель түли, бензин шатахуун гээд бас татвар буурсантай холбоотой байх. Хөрөнгийн зардал яагаад буурчхав? нэгдүгээр асуудал юм байж байна.

2 дугаар асуудал бол энэ Ирээдүйн өв сангийн тухай хууль гэж бий. Ирээдүйн өв санд жил болгон одоо юу гэдэг юм ашигт малтмалын нөөцөөс мөнгө төвлөрүүлж байх ёстой. 2022 онд огт төвлөрүүлээгүй, 2023 онд бас тэг гээд тавьчихсан байж байна. Одоо энэ ирээдүйн өв санд чинь ер нь мөнгө байгаа юм уу, байхгүй юм уу? Энэ яг хэдэн төгрөг байгаа гэдгийг надад нэг хэлж өгөөч, энэ телевиз үзэж байгаа олон хүн байгаа байх гэж бодож байна.

3 дахь асуудал энэ 2023 онд энэ МАА, газар тариалангийн салбар, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний хөгжүүлэх арга хэмжээнд ХХААЯ-ны багцад 228,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тавьж өгсөн юм байна. Үүний нэг задаргааг хэлж өгөөч. Энэ аймаг орон нутагт хүлэмжийн аж ахуй эрхэлж байгаа, газар тариалан эрхэлж байгаа ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ чиглэлд хамаарах юм уу, хуваарилагдах юм уу гэдэг дээр бас нэг хэлж өгөөч.

4 дэх асуудал бол энэ боомтын сэргэлт, боомтын хөгжлийн асуудлыг сүүлийн үед хүн болгон яриад байгаа юм. Тэгээд энэ боомт руугаа чиглэсэн хөрөнгө оруулалт ер нь тавьсан юм уу, тавиагүй юм уу. Ялангуяа Жавхлан сайд бол өөрөө мэдэж байгаа. Гашиун сухайт байна, эрчим хүчний хувьд бол Хятадаас хамааралтай. Ханги мандал байна, эрчим хүчний хувьд бол Хятадаас хамааралтай. Энэ эрчим хүчнийхээ асуудлыг шийдчихсэн юм уу, энэ хөрөнгө оруулалт дээрээ хамгийн гол асуудал энэ шүү дээ. Урд хөрш чинь тогоо тасалбал, Гашиун сухайт, Ханги мандал 2 чинь ажлаа ачааллаа дийлэхгүй, нүүрсээ гаргаж чадахгүй ийм байдалд хүрнэ. Тийм учраас эрчим хүчний боомтын сэргэлт, боомтын хөгжлийн асуудлыг тавьж байгаа бол энэ эрчим хүчнийхээ асуудлыг бас шийдэх ёстой гэдэг дээр байж байна.

Жил болгон энэ алдагдал буураад явж байна. Энэ бол маш зөв. Зээлийн энэ үйлчилгээний төлбөр чинь нэмэгдээд байх юм. Алдагдал буураад байгаа бол энэ зээлийн үйлчилгээний төлбөр бол тэр хэмжээгээр буураад явах ёстой юм болов уу гэж би бодоод байх юм. Тэгээд энэ бас нэмэгдээд ингээд тавигдчихсан байх юм, энэ дээр бас нэг хэлж өгөөч ээ.

Дээр нь Газрын тосны тухай хуулийг бид нар шинэчилсэн байж байгаа. Газрын тосны тухай хууль дээр бид нар өөрсдөө юу гэдэг юм, өрөмтэй өөрсдөө газрын тосныхоо хайгуулыг хийдэг болъё оо гээд ийм хууль гаргачихсан. Тэгээд газрын тосны хайгуулаа Монголчууд өөрсдөө хийхгүй бол хэзээ мөдгүй одоо газрын тосны үйлдвэр чинь ашиглалтад ороход хайгуулаа хийгээгүй ингээд өөрсдөө ч хайгуулаа хайгуулаа хийх өрөмгүй ингээд сууж байх юм биш биз дээ? Тийм учраас энэ газрын тосны хайгуул хийх энэ өрмийг нь худалдаж авах, энэ боловсон хүчнийг бэлтгэх тал дээр тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт, хөрөнгө мөнгө тавьж өгсөн юм уу гэдэг ийм 5 асуулыг хариулт авъя.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулъя. Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн зардал та буурсан гэх юм, хөрөнгийн зардал буурч байвал уг нь сайн юм байгаа юм. Гэхдээ бид нар ирэх жил хөрөнгийн зардлыг бууруулах боломж бидэнд гарахгүй. Яагаад гэхээр сүүлийн 6 жилийн хугацаанд бид нар жил бүр нэг их наяд төгрөг гарсан шинэ хөрөнгө оруулалтуудыг тавьж ирсэн байгаа юм. Үүний үргэлжлэх шилжиж ирж байгаа нийтдээ 2,5 их наяд төгрөгийн бөөгнөрөл төвлөрөл хойтон 23 онд таарч байгаа юм. Тэгэхээр бид нар цаашаага энэ том эрсдэлийг цасан нуранги шиг үргэлжлүүлэхгүй байхад нэг удаа энэ рүүгээ бид нэлээн том ороод үүнийгээ нэг дуусгах хэрэгтэй байгаа юм. Ингээд бид нар ирэх жил 86 хувьтай дуусгахаар ийм төсөв оруулж ирж байгаа юм. Ингээд шинэ хөрөнгө оруулалт дээр бид нар орон зай байхгүй. Үүнийгээ энэ удаа больё гэж байгаа юм, 23 онд. Тийм учраас хөрөнгө оруулалтын зардал өмнөх оныхоос 1,1 их наядар нэмэгдэж гарч ирж байгаа шүү. Энэ дээр бол үнийн өсөлт орж ирж байна, мөн концессын бид нар үлдэгдэл төлбөрүүдийн Засгийн газар энэ өрнөөсөө яаралтай салах хэрэгтэй байна. Мөн нийслэлийн түгжрэлийн эсрэг 339 тэрбум гээд ийм дүнгүүдээр нэмэгдэж орж ирж байгаа юм. Мөн олон улсын зээл тусламж дээр хийгдэж байгаа зүйлүүдээс Монголын талын хүлээсэн үүрэг 188 тэрбум төгрөгөөр нэмэгдэж орж ирж байгаа. Энэ дээр бол Мянганы сорилын сангийн Монголын талын хүлээсэн, хуримтлагдсан 49 сая долларын хөрөнгө оруулалтыг бид хийхгүй бол ирэх жилээс энэ том төсөл зогсох бас ийм эрсдэлд орж ирж байгаа юм. Ийм дүнгүүдээр нийтдээ ингээд 1,1 их наяд төгрөгөөр хөрөнгийн зардал нэмэгдэж байгаа юм шүү. Бид шинэ хөрөнгө оруулалтаа танаад, танаад заавал хүлээсэн үүрэг 1,1 их наядар нэмэгдэж байна гэсэн үг.

Ирээдүйн өв сан та их чухал асуулт асуулаа. Ирээдүй өв сан дээр бид нар 2 жил ийм

бодлого барьсан байгаа. 2021 оны төсөв хүртэл ирээдүйн өв санг данс дээр нь бол хуримтлуулж ирсэн, гэхдээ эх үүсвэр нь бол төрийн санд хэрэглэгдэж ирсэн гэсэн үг, данс дээрээ бичилт хийгдээд хуримтлагдаад байна гэсэн үг. Ер нь бол хуулиараа бид нар 25 онд тусад нь гаргаж эх үүсвэртэй нь энэ корпорацыг нь байгуулаад ингээд менежментийг нь өөрөө аваад явах ёстой юм байгаа юм. Харин 23 оны төсөв дээрээс дэвшилттэй зүйл нь бид юу хийж байгаа вэ гэхээр ирээдүйн өв сан дээрээс бол ирээдүйн сангийн орлогын тодорхой хэсэг нь бол хүүхдийн мөнгөнд л дахин зарцуулагдана. Гэхдээ цаана нь хуримтлал юу хэмнэгдэж үлдэж байгаа хэсэг, мөн нэмэлт орлого гээд нийтдээ 600 тэрбум төгрөгийг бид нар ирээдүйн өв сан дээр нэмж орлого төвлөрүүлж байгаа, төвлөрүүлнэ. Энэ нь гэхдээ төрийн сангаас мөн тусад нь гаргаад, эх үүсвэртэй нь цаашид нь баталгаажуулаад ингээд явах юм байгаа юм. Өнөөдрийг хүртэл хуримтлагдсан үлдэгдэл бол 2,5 их наяд байгаа, 2,5 их наяд. Ингээд бид нар 25, 6 оноос тусад нь гаргахдаа бол одоо ядаж бид нар талаас илүү хувийг нь яг эх үүсвэртэй мөнгөн хөрөнгөөр нь шилжүүлж өгөх ийм зорилго тавьж байгаа. Хэдийгээр ирэх жилүүдэд төрийн сан дээр маань нэлээн дарамт ирж байгаа ч гэсэн энэ ирээдүйн өв санг одоо төрийн сангаас тусад нь гаргах бас өөрсдөө ийм хатуу бөгөөд заавал хийх ёстой ийм зорилго тавьж байгаа гэсэн үг.

Боомт дээр та асуулаа. Ирэх жил төсөв дээр бид нийтдээ 668 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 132 тэрбум төгрөгийн ийм санхүүжих дүнтэй “шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд төслүүдээ тавьсан. Боомтын эрчим хүчний асуудлаар сайд нь ярих байх.

Газрын тос, хайгуулын бодлогыг Ганбаатар сайд ярих байх.

Алдагдлын хувьд алдагдал дээр байгаа тэр гадаадын тусламжийн хүүгийн зардал бол ер нь жил ирэх тусам л бага багаар нэмэгдээд байдаг. Өөрөөр хэлбэл нийт манай Засгийн газрын зээлийн өр хэмжээ, үндсэн өрүүд маань жил жилд бид одоо төсөвт даах хэмжээ гэдэг маань нэг 200 сая доллар орчим л үндсэн өрөө, одоо бид нар гараад ингээд явж байгаа. Тэгэхээр жил ирэх тусам одоо хани болон одоо нэмэгдэж байгаа гадаадын тусламжийн зардлаар ингээд өсөөд яваад байна. ... /минут дуусав/

Г.Занданишатар: Наадхаа микрофонд хэл, ХАА-н сайд нь байхгүй, дэд сайд нь байхгүй, Төрийн нарийн бичгийн дарга нь байхгүй, газрын дарга нь ч байхгүй. Яаж энэ хүнсний хувьсгал, намрын ургац хураалтын үеэр одоо ингээд төсөв хэлэлцэж байгаа үед ингэж яамаараа эзгүй байж болж байгаа юм байна. Энэ арай хэтэрч байна шүү.

Тлеуханы Аубакир.

Т.Аубакир: Баярлалаа. Жавхлан сайд аа, би аягүй товчхон асууна аа. Яагаад гэвэл одоо 2 дахь өдрөө бас хэлэлцэж байгаа юм чинь яг маш товч, тодорхой, ганц хоёрхон асуулт тавидагхья.

Үндсэндээ 23 оны төсвийг бол дэмжиж байгаа. Макро эдийн засгийг дэмжих, эдийн засгийн суурь тэлэлтийг дэмжих бодлого, тэгээд том зарчим, том бодлого ярьж байгаа учраас үндсэндээ бол дэмжиж байгаа. Гэхдээ одоо орон нутгууд дээр сая одоо ихэнх гишүүд ярьж л байна л даа, яах вэ, Засгийн газрын оруулж ирсэн, одоо төсөл хөтөлбөр ойлгож байгаа. Гэхдээ бид нар бас нэг тойрог тойргоос сонгогдсон гишүүд тухайн тойргийнхоо проблемыг, магадгүй Засгийн газраас ч илүү мэдэж байж бас магадгүй л дээ. Тийм учраас сая энэ орон нутагт үндсэндээ 2 сар орчим ажиллалаа. Энэ хугацаанд барилгын салбарынхантайгаа бид нар бол уулзсан, барилга барьж байгаа одоо компанийн захирлуудтай бид нар уулзалт хийсэн. Би бас тэд нарынхаа үгийг завал дамжуулах ёстой юм. Яагаад гэвэл яг одоо үйлдвэрлэл дээр аж ахуйгаа хийгээд явж байгаа сантехник, цахилгаан, цэвэр, бохир гээд дэд бүтэцтэй, нэг ширхэг тоосго өрхөтэй хүртэл шаврын зуураад бүх юман дээр байж байгаа хүмүүс учраас тэр барилгын салбарынхан маань та бүхэнд хэлж өгөөч ээ гээд саналуудаа хэлсэн юм. Би товчхон уншаад өгье.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний УИХ-аас баталсан төсөвт өртөг нь тухайн барилгын бодит төсөвт өртөхөөс дутдаг гэж байгаа юм. Шалтгаан нь тухайн барилга объектын зураг төсөл нь бүрэн хийгдэж, улсын экспертизээр баталгаажсаагүй байхад нь төсөв батлагдчихдаг. Зарим барилга объектуудын зураг төслийг гарснаас хойш 1-2 жил хойшлогдож хөрөнгө батлагддаг, ажил гүйцэтгэгчээр шалгарсан компани дахин зураг төсөл гаргуулах, экспертизээр батлуулах, улсын төсвийн тодотголд оруулах гээд бодит бэрхшээлүүд гэх зэргээр дээрээс нь хийгдсэн ажлын гүйцэтгэлийн баталгаажуулах шат дамжлага их хүнд сурталтай, санхүүжилт товлосон графикт хугацаанд орж ирдэггүй, нэг удаагийн гүйцэтгэл батлуулахад зохиогчийн хяналт хийлгэхэд 15-20 хоног гэж байгаа юм, Мөнхбаатар сайд аа, орон нутгийн захиалагчийн хяналтын төлөөлөгчөөр хянуулаад батлуулахад 7-10 хоног, хөгжлийн төвөөр хянан батлуулахад 7-14 хоног, ерөнхий захирагчийн хянуулан батлуулахад 40-50 хоног зарцуулдаг гэх зэрэг наад зах нь нэг объектоор хэчнээн шат дамжлагаар одоо хяналт тавиад байдаг юм. Тэр болгонд гарын үсэг цуглуулах гээд гүйдэг. Гэтэл манай улсын хугацаанд яг нэг барилгын сезон бол нэг хоёрхон сар байж байдаг, дээрээс нь энэ жил одоо ажиллах хүч дутагдалтай, бөөн бөөнөөрөө

Солонгос явсан, үлдсэн нь самарт яваад ажиллах хүн ч байхгүй, наад зах нь гэх зэрэг ийм бэрхшээлүүд байхад нь бид нар ядаж төр засгийн одоо зүгээс тэр аж ахуй эрхэлж байгаа хүмүүстээ тавих саад тотгорыг аягүй цомхон болгочихмоор байгаа юм. Нэг объектоор одоо нэг л байгууллага хяналт тавьчихдаг. Гэтэл одоо орон нутаг дээр барилгын сайдын тушаалаар татан буулгагдсан байгууллага нь хүртэл хяналт тавиад, ингээд нөгөө нэг барилга барьж байгаа хүмүүсийн хүндрүүлээд байгаа процессууд байна гэх зэргээр надад маш олон юм бичиж өгсөн л дөө. Мэдээж хэрэг Жавхлан сайдын баримталж байгаа бодлогыг би бол хувьдаа маш зөв гэж дэмжиж байгаа. Хэдүүлээ 23 онд шинэ хөрөнгө оруулалт явахаасаа илүү дуусаагүй байгаа хөрөнгө оруулалтуудаа дуусгачихъя гэж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ таны саяын хэлсэн, жишээлбэл магадлан хийлгээд ороод ирсэн төсөл хөтөлбөр болгон дээр нэг бүрчлэн аудит хийлгэнэ гэж байна л даа. Энэ хугацаанд нөгөө барилга барьж байгаа компаниуд маань амьдарч чадах уу? Одоо энэ банкных нь хүү нь яваад байдаг, ингээд өвөл болчихсон гэх зэргээр ингээд аж ахуйн чанартай юмнууд байгаа учраас аягүй түргэн шуурхай л шийдчихэж нэг болчихмоор л ажлууд байгаад байгаа юм. Зүгээр би өөрөө бол эдийн засагч хүн биш, аж ахуй дээр олон жил ажилласан учраас аж ахуйн чанартай юмнуудыг хийчих болмоор юмнууд байгаад байгаа юм. Энэ дээр тэгээд нэг анхаарах ёстой юм нь төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах тал дээр яг юу орж ирж байгаа вэ? Жишээлбэл, энэ Хөтөлийн цементийг хар л даа. Нэг энтертайнмент хүн авачаад тавьчихсан, үйлдвэрийг удирдуулчихсан. Гэтэл үйлдвэрийг инженер хүн л удирддаг шүү дээ гэх зэргээр ийм алдаанууд ингээд гараад байна, аягүй хурдан засчхаж болмоор.

Нүүрсний асуудал байж байна. Нүүрсний мөнгө оптик гэрээ гээд 3 юм уу, эсвэл 7 гэрээ байдаг юм уу? Нүүрсний мөнгө нь хаана яваад байгаа юм? Дахиад нэг улс дотор улс байгуулчихсан нэг хүн ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Аубакир гишүүний асуултад хариулъя. Тэр зарим барилга төлөвлөлтийн асуудлууд дээр Мөнхбаатар сайд хариулах байх, тийм ээ. Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд дээр бол Засгийн газар бодлоо маш тодорхой зарласан. Бид энэ оны эхний улиралд зарласан байгаа, юу вэ гэхээр ер нь орон нутаг болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гээд нийтдээ хяналтад байдаг 500 гаруй ААН байна, орон нутагтайгаа нийлээд хамтарсан гээд. Эндээс 108 ААН-үүд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын удирдлага хяналтад байдаг. Эдгээр ААН-үүдийг бид 3 ангилсан байгаа

юм. Үнэхээр стратегийн хувьд улс өөрөө цааш нь ингээд аваад явах ёстой, хувьчилж болохгүй ээ, ХК болгож болохгүй ээ гээд. Эдийн засаг, нийгмийн үнэхээр үр өгөөжгүй, байнга алдагдал үйлдвэрлэж байгаа ийм ААН-үүд гээд бас нэг жагсаалт гаргасан. Ингээд дундын зоонд байгаа ААН-үүдийг бүтцийн өөрчлөлт хийх, байгууллагын засаглалыг нь сайжруулах замаар, мөн нээлттэй ХК болгох замаар эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нь дээшлүүлж болно оо гэж ингэж үзсэн байгаа юм. Энэ дотор бол хувьчлал гэдэг зүйл ерөөсөө огт байхгүй. Хувьчлалын бодлого бол тэр өнгөрсөн, энэ тэр нэг цүнхтэй хувьчлалууд ийм юм болдог байсан. Тэр бүх юмыг бол зогсоосон, дахиж ийм юм байхгүй, ирэх онд хувьчлалын орлого гэж бол нэг төгрөг ч байхгүй. Ингээд бүтцийн өөрчлөлт хийгдэх компаниудын эхний ээлжид төрийн өмчийн үйлдвэрийн газруудаас Төрийн банк маань өнгөрсөн 7 хоногт ХК болгох ийм алхмаа хийсэн. 5 хувийн нэмэлт хувьцаа гаргасан, 20 тэрбум төгрөгийг цуглуулах ийм зорилготой гар нийтдээ 63 тэрбум төгрөг буюу захиалга нь 304 хувь давж биелүүлж, анхдагч арилжаагаа амжилттай дуусгасан байгаа. Олон нийт маш их хүлээлттэй байсан байна. Хөрөнгийн зах зээл дээр бол маш том, ийм бустер боллоо. Араас нь 4-5 банк ингээд гарах гээд хүлээж байна. Тэгэхээр энэ бол маш амжилттай ийм бүтцийн өөрчлөлт хийгдэж байна гэж хэлж болно.

Мөн энэ онд багтаад би яг нөгөө яамныхаа харьяанд байдгуудыг л эхэлж хэлж байна шүү, Хөрөнгийн бирж мөн ХК болно гэх мэтчилэн яг ийм жагсаалт гаргаад 33 компанийг бүтцийн өөрчлөлт ийм шинэчлэл хийж, засаглалыг нь сайжруулж, эдийн засгийн үр өгөөжийг нь нэмэгдүүлж, нийгмийн оролцоо, нийгмийн идэвхийг нь үр өгөөжийг нь сайжруулна гэж ингэж харж байгаа. Ингэснээр төрийн өмчийн үйлдвэрийн газрууд дээр бол бодитой, үр дүн гарна гэж харж байгаа юм.

Боловсон хүчний асуудлуудыг бол тусдаа ярих нь зөв байх. Яг нэр цохож хэлж байгаа бол.

Нүүрс, энэ оптекийн асуудлуудыг бол Засгийн газар нэлээн дорвитой арга хэмжээ авна. Сүүлийн жил хагасын хугацаанд бид ямар ч байсан хилийн боомтуудаараа нэлээдгүй чанга арга хэмжээнүүдийг авсны үр дүнд одоо биет хэмжээгээрээ экспорт маань 19 оныхоо хэмжээнээсээ бол давсан шүү, яг гарч байгаа, урд нь. Гэтэл орж ирж байгаа валютын урсгал байдаггүй. Энд л асуудал байгаад байгаа юм. Энэ талаар нэлээн дэлгэрэнгүй хэд хэдэн удаа ярьсан байгаа. Ирэх жил бол бид 19 оныхоо түвшинд ямар ч байсан биет хэмжээгээр гарна, гарч байгаа килограмм тонн нүүрс болгон зэсийн хүдэр бол зэс болгон төмрийн хүдэр болгон валют авчрах ёстой гэдэг дээр маш хатуу ажиллана.

Мөнхбаатар сайд зарим асуултад хариулах байх.

Г.Занданишатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн. Түр хүлээж байгаарай. Бэгзжавын Мөнхбаатар сайд хариулна. Барилга, хот байгуулалтын сайд 95.

Б.Мөнхбаатар: Аубакир гишүүний асуултад хариулъя. Та бас яг манай салбарт байгаа амьдрал дээр байгаа тулгамддаг асуудлыг бас хэлж байна. Тэгээд зураг бол ер нь бүх юмны үндэс нь зураг байгаад байгаа, зураг нь дутуу хийгдээд явц дундаа зурагт өөрчлөлт ороод нэг жишиг зургийг өөр газар аваачиж тавиад холболтын зургаас өгсүүлээд ингээд бидний энэ алдаа зургаасаа эхэлдэг учраас аль болох зургийг бол нэг болгож хийе ээ гэсэн бодлогыг бол Засгийн газар бол барьж байгаа. Тэгээд зургаас өгсүүлээд л нөгөө мөнгөнхийг нь дүнгүүд нь өөр болоод явчихдаг асуудлууд байдаг.

Хүнд суртлын асуудлаар бид нар аль болох цэгцлэх гэж ажиллаж байгаа, жишээ нь Барилгын хөгжлийн төвөөс бол манайхаас хяналт тавьж байгаа объектууд дээр бид нар бол нэг чиклис дээр нэг 7-10 хоногт хийгээд гаргадаг, тэгээд орон нутагт бол янз бүрийн бас асуудлууд байдаг. Тухайлбал, энэ 2 аймгийг бас дурдаж хэлэхийг хүсээд байгаа юм. Төв аймаг болон Хөвсгөл аймаг өөрсдөө төрийн орон нутгийн өмчит барилга захиалагчийн газар гаргаад ажиллуулж байгаа. Хөвсгөл аймаг сүүлийн үед олон газар хөдлөлт бий болсон, барилга захиалагчийн тэр орон нутгийн өмчит газраа тавиулаад байдаг, манай салбарын харьяа газар, хот байгуулалтын газар нь тавьж чаддаггүй, газар хөдлөлтэй холбоотой нэг баригдсан байшин нь газрууд хагалбар цууралт үүссэн асуудлаас болж бас бөөн асуудлууд үүсэж байсан. Тэгэхээр зарим орон нутгийн удирдлагууд үүнийгээ бас хуулийн дагуу л асуудлуудаар нь холбогдох яам дээр нь тавьж ажиллах, хамтарч ажиллах нь зайлигүй шаардлагатай байгаад байдаг. Тэгээд энэ асуудлуудыг бол холбогдох аймгууд нь бол би бас асуудлыг бол тавьсан байгаа. Олон хоног тавьдаг мөнгө, төсөв гүйцэтгэл, олон хоног авч чадахгүй байгаа асуудлуудыг бид нар бас аль болох л багасгахын тулд л энэ чинь орон нутгаасаа ирнэ, яамаар хянагдана, тэгээд л төсөв рүү очно, Сангийн яам гээд л олон юмнууд байдаг юм, бид нар аль болох л багасгах л чиглэлээр бол анхаарч бол ажиллаж байгаа. Тэгээд таны ажиллах хүчний асуудал, ер нь ерөнхийдөө салбарт бас маш хүнд болсон бол байгаа. Тэгээд энэ ажилладаг энэ хүн угаасаа л зөвхөн манай барилгын салбарт төдийгүй олон салбарт л бас ажиллах хүчний асуудал дутагдаж байгаа. Энэ дотор халамж, хөдөлмөр гээд л бид нарын ярьж байгаа асуудлууд бол байгаа. Тэгээд бидний зүгээс бол аль болох хүнд суртлыг нь

багасгаж, цаг хугацаанд хурдан шуурхай ажиллах талаар бол анхаарч ажиллана.

Г.Занданишатар: Гомшилдоогийн Мөнхцэцэг гишүүн.

Г.Мөнхцэцэг: Энэ 23 оны төсөв ер нь их чанга, ийм хатуу бас цаг үед өргөн баригдаж байна. Шинээр хөрөнгө оруулалтуудаас татгалзаж байгаа, үүнийг бол ойлгож байна. Гэхдээ бид жилээс жилд, жил жилийнхээ төсвөөсөө энэ соёл, спорт, шинжлэх ухаан, боловсролынхоо төсвөөс танасаар байгаад ингээд улам жижгээрүүлсээр байгаад л ингээд л яваад ирлээ. Тэгэхээр ер нь эдийн засаг сэргэхээр бол энэ салбаруудаа нэг босгоод ирнэ ээ л гэдэг нэг ийм л мөрөөдлөөр л жил жилийнхээ төсөвт ингээд нэг суугаад л ингээд л яваад ирлээ. Тэгээд ер нь өдийг хүртэл бид нар дэлхийд өнгөлчихөөр нэг ч том бүтээн байгуулалтыг энэ соёлын салбарт хийсэнгүй ээ. Боловсрол, шинжлэх ухааны салбарт бүтээн байгуулалтуудыг хийсэнгүй ээ. 20, 30 жил бас ярилаа. Өнөөдөр дэлхийн хэмжээний энэ олон улсын тэмцээн уралдаанд манай хүүхэд багачууд бол толгой цохиж байна, манай урлаг соёлынхон бол үнэхээр бас нэр нүүр болоод л, ингээд л яваад л ирдэг ээ. Тэгээд 23 оны төсөв дээр манай соёлын салбарт бол юу ч тусаагүйгээр барахгүй ер нь ямар нэгэн байдлаар гацаанаас гарчих тийм бүтээн байгуулалтын асуудал, ажлууд хийгдэхгүйгээр ингээд баригдаад өргөн баригдаад явж байна. Тэгэхээр энэ он дамжиж байгаа нь магадлалаар орох шаардлагатай байгаа барилга байгууламж, манай соёлын салбарт маш олон байгаад байгаа, тийм ээ. Тэгэхээр энэ Сангийн яамнаас энэ 640, боловсрол бас тийм, 644 төслийн магадлалаар болоод, ингээд үндсэндээ төсөвт бол нэг 303 тэрбум төгрөгийг суулгасан гээд ингээд байж байна. Энэ суулгаж авч үлдсэн, магадлалаар оруулсан энэ төсвөөс хэд нь энэ боловсрол, соёл, спорт, соёлын шинжлэх ухааны салбарт байна вэ гэдгийг ийм асуултыг нэгдүгээрт тавьчихъя.

Хоёрдугаарт, энэ Үндэсний номын сан гээд 10 жил ярьж байна, энэ байгууллагыг одоо. Гүйцэтгэл 80-90 хувьтай явагдаж байгаа гээд байгаа. Хөндий байшин бариад бид нар дотор нь тавигддаг стандартын шаардлага хангасан ийм тоног төхөөрөмж нь огт байхгүй. Тэгэхээр энэ удаагийн төсөвт бол ямар нэгэн байдлаар энэ боловсрол, соёл, спорт, шинжлэх ухааны энэ салбарт хөрөнгө оруулалт дээр дээр нь энэ яг стандартын шаардлага хангасан ийм тоног төхөөрөмжийн төсөв ер нь харагдахгүй байна, тийм. Тэгэхээр энэ номын сангийн нөгөө төсөв дээр энэ стандартынх нь тоног төхөөрөмжүүдийг тусгах ийм төсөв байна уу, байхгүй юу, тийм, хэзээ дуусах юм бэ номын сангаа гэдэг энэ асуултыг ер нь тавимаар байна.

Мөн манай боловсролын салбарт олон асуудал байгаа. Гэхдээ бид бас зарим нэг зэх хэмжээгээр зарим асуудлуудаас гарц гаргалгаагаа хайгаад гаргаж чадаж байгаа гэж бас ингэж харж байгаа, 2022 оны төсвөөр бол бид бас энэ цэцэрлэгт сугалаагаар ордог асуудлуудыг бол бас шийдэж чадсан, энэ бол тодорхой хэмжээгээр бас дэвшил болсон. Гэхдээ бид бас хүүхдийн үдийн хоолны асуудал гэдэг бол том асуудал болоод ингээд үлдсэн хэвээрээ байна.

Сургууль, цэцэрлэг, дотуур байр гэдэг бол яалт ч үгүй хүүхдийн 2 дахь гэр ээ. Тэгэхээр энэ хүүхэд энэ 2 дахь гэртээ сурч хүмүүжихээс гадна энэ хоол идэх хоол хүнснийхээ асуудлаар бас бүрэн дүүрэн хангагдсан байх ёстой, чанартай хоол гэж ярьж байна. Энэ шаардлагуудыг хангахуйц ийм хэмжээний үйлчилгээг бид нар бас хүүхдэдээ үзүүлэх ёстой гэдэг. Энэ дээр бол бас маш том хэмжээний доголдол үүсээд байгаа гэдгийг та бүхэн бүгдээрээ бас мэдэж байгаа. Өнөөдрийн байдлаар гэхэд л цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгө өдөрт бол 2100 төгрөг байна, сургуулийн үдийн хоолонд 1500 төгрөг байна, дотуур байрны хүүхдийн хоол өдөрт 375 төгрөг байна, МСҮТ-ийн дотуур байрны хоолны зардал 3000 төгрөг байгаа. Тэгэхээр ийм хэмжээний зардлаар хүнсээ хүүхэд авч чадах уу, тийм ээ, өдрийнхөө наян хувийн хүнсийг авч чадах уу гэдэг ийм хүндрэлтэй асуудлууд үүсээд байгаа.

Өнөөдөр төсөвт өргөн баригдсанаараа бол нэмэгдлээр бид нарт 310 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай байгаад байгаа. Энэ эх үүсвэрүүдийг хаанаас олж хийх вэ? Энэ дээр Засгийн газар ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа вэ гээд ингээд энэ шинжлэх ухааны тал дээр түрүүн бас тодорхой хэмжээний тайлбар хэлчихсэн учраас зөндөө олон асуудлууд энэ бас соёл, боловсрол, шинжлэх ухаан, спортын салбарт бол байна. Тэгэхээр миний тэр номын, ядаж бид нар Үндэсний номын сангаа гараас гаргачихмаар байна, тийм ээ. Тэгээд энэ дээр р холбогдох, салбаруудаас бас асуулт байгаад байгаа юм. Энэ дээр хариулт авъя.

Т.Аюурсайхан: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Мөнхцэцэг гишүүн БСШУСБХ-ны дарга, бас их азтай, ер нь бол энэ салбарын хөрөнгө оруулалтын хамгийн өндөр оргил үед нь та удирдаж байгаа, удирдаж байгаа шүү. Энэ ирэх жилийн хөрөнгө оруулалтын 18 хувь буюу бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын хамгийн өндөр хөрөнгө оруулалттай ийм салбар. Хөрөнгө оруулалт нь ч өндөр, урсгал зардал нь ч хамгийн өндөр, төсөв талдаа бас сахилгагүйтэж байгаа нь ч чамгүй өндөр байгаа. Одоо энэ гүйцэтгэл дутуу үргэлжилж байгаа зүйлүүдээс төсөвт өртөг нэхэгдэж байгаа үнийн

өсөлтөд бас орж байгаа гүйцэтгэл нь дутуу зарим нэг ажлууд нь бүр цаашаагаа үргэлжлэх эсэх нь ч эргэлзээтэй болж ирж байгаа ажлууд ч бас энэ салбартай хамааралтай байгаа. Тэгэхээр энэ төсвийн шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа, ялангуяа хөрөнгө оруулалтын чиглэлийн ажлууд дээр та их онцгой анхаарч, энэ салбартайгаа их сайн тулж ажиллаасай гэж бид хүсэж байна. Бүх талаар бид хамтарч ажиллахад ингээд бэлэн шүү.

Тэр тоног төхөөрөмж болон бусад зүйлүүд дээр Номин сайд нэмж хариулна биз. Ер нь соёлын салбарын хөрөнгө оруулалтын яг хамгийн өндөр хэрэгжилттэй, хамгийн өндөр санхүүжилттэй явж байгаа хүн шүү. Би томоохон төслүүдээсээ та сайн мэдэж байгаа тийм ээ, Чингис хаан музей энэ 7 хоногт ирэх 7 хоногт ашиглалтад орох гэж байна. Байгалийн түүхийн музейний ерөнхийдөө хөрөнгө оруулалт хийх концепц нь бол бид нар батлагдсан, яг тэрнийхээ төлөө бүгдээрээ ингээд явж байгаа. Үндэсний номын сан, театрууд ингээд ашиглалтад орох шатандаа явж байгаа. Зарим нэг орон нутагт баригдсан 10 жил явж байгаа дутуу театруудыг бид нар ирэх жил гүйцээж ашиглалтад оруулахаар ингэж төлөвлөж орж ирж байгаа. Ийм ажлууд нэлээд хийгдсэн байгаа шүү.

Тэр хүүхдийн мөнгөний биш ээ, хүүхдийн хоолны мөнгөний асуудлаар Энх-Амгалан сайд бас тодорхой хэлэх байх. Зүгээр би төсвийн бодлогын хүрээнд хэлэхэд энэ хүүхдийн хоолны мөнгө гэж яриад буруу нэрлээд байгаа юм шүү. Энэ чинь ингээд тэр энэ мөнгөөр хоол худалдаж авчраад бүтэн хоол ингээд явж байгаа зүйл биш байхгүй юу. Энэ чинь хоолны материалын зардал юм байгаа юм. Хэрвээ яг бүтэн хоолны өртөг гэх юм бол тэр тухайн сургууль дээр ажиллаж байгаа тэр хоолны газар ажиллаж байгаа ажилчдын цалин хөлс, цахилгаан, дулаан гээд бусад урсгал зардлууд нь бол тухайн сургуулийнхаа, байгууламжийнхаа төсвийн зардал дотор нь суугаад явж байгаа, суугаад явж байгаа. Тэгэхээр энэ хоолны зардал гэж ойлгоорой, материалын үнэ байхгүй юу, тийм, материалын үнэ. Өөрөөр хэлбэл хоолны орцонд орж байгаа материалын үнэ ээ гэж ойлгоорой. Энэ зүйлүүдийг хэлье, тэгээд Номин сайд, Энх-Амгалан сайд нар дэлгэрэнгүй тоонууд хэлэх байх.

Г.Занданишатар: Соёлын сайд Чинбатын Номин, 94.

Ч.Номин: Сайн байцаана уу. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт бол соёлын салбарт 2023 оны төсвийн тухай хуульд заасан дүнгээс яг нийтдээ 1,3 хувь нь соёлын төсөвт зарцуулагдаж байгаа. Тэгэхээр бидний хувьд бол яг тодорхой хэмжээнд авч байгаа төсөв бол 1,3 хувь байгаа. Нийт соёлын салбарт

зарцуулж байгаа хөрөнгө оруулалт бол 143 тэрбум төгрөг буюу сүүлийн 10-аад жилийн хугацаанд тавигдсан төсвийн хувьд бол яах аргагүй тодорхой хэмжээнд өндөр байгаа. Энэ нь бол дийлэнх нь эхэлсэн барилгуудаа, эхэлсэн хөрөнгө оруулалтуудаа дуусгах чиглэлд хандаж байгаа. Жавхлан сайдын хэлсэнчлэн энэ 7 хоногт буюу 10 сарын 11-нд бол Монгол Улсын хэмжээнд сүүлийн гучаад жилийн хугацаанд хийгдсэн хамгийн том бүтээн байгуулалтуудын нэг болох Чингис хааны соёлын хувьд бол хамгийн том бүтээн байгуулалтын нэг болох Чингис хааны музей маань ашиглалтад орж байгаа.

Дараагийн том бүтээн байгуулалтын нэг бол яах аргагүй Үндэсний төв номын сан маань байгаа. Үндэсний төв номын сангийн хувьд бол ажлын гүйцэтгэл бол ер нь бол ерээд хувьтай байгаа. Хэдий тийм боловч энэхүү байгууламж нь анх бий болохдоо анх төсөвт тавигдахдаа 2011 оноос эхэлж тавигдсан, тэгэхдээ ерөөсөө ямар нэгэн дотоод интерьерийн зураггүй хийгдсэн. Тэгээд бидний хувьд бол өнгөрсөн жилийн хугацааны 22 оны хувьд бол энэ интерьерийн зургийг нь төсвөөс гадуур санхүүжилтээр хийлгээд Сая санаа гэдэг компаниар хийлгээд дотор энэ интерьер зураг нь бол гарч байгаа. Энэ нь бол яг одоогийн байдлаар бол магадлалаар яг орж амжаагүй хэмжээнд явж байгаа. Яг барилгын хувьд бол үнийн өсөлтөөс нөлөөлөлтэйгөөр орж ирсэн, төсвийн өсөлт нь бол төсөвт тавигдсан байгаа. Түүнээс гадна энэхүү барилга нь өөрөө бас гүйцэтгэгчийн хувьд бол асуудалтай байгаа, гүйцэтгэгчийн байгууллагын эзэмшигч нь нас барсан, цаашидаа өвлүүлэгчийн асуудал үүссэн ийм нөхцөлтэй байгаа. Үүнийг бол бид нар яамны зүгээс шийдээд явж байгаа, энэ ондоо шийдвэрлэгдээд гарна гэж үзэж байгаа.

Тоног төхөөрөмжийн хувьд бол Үндэсний номын сангийн хувьд бол бид нар 22 онд тоног төхөөрөмжийн төсөв суулгасан байгаа. Тэгээд энэхүү ажлын хувьд бол жигд ямар нэгэн асуудалгүй явж байгаа бөгөөд гүйцэтгэгч шалгарсан байдалтай байгаа. Тэгээд энэ 23 онд бол 6,2 тэрбум төгрөгийн санхүүжилт тавигдсан байгаа.

Г.Занданишатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд. Үдийн хоолны асуудал.

Л.Энх-Амгалан: Бид нэг зүйлийг, ер нь энэ эцэг эхчүүд, асран хамгаалагч нар, ер нь нэг тоо, ер нь ямархуу хэмжээний мөнгийг, энэ ковидын хямралтай үед, төсвийн энэ алдагдалтай энэ үед, ер нь ингээд төр яг энэ үдийн хоол хөтөлбөрийг эхлүүлснээрээ ямар мөнгө зараад эхлэв гэдгээ бас бас бид нар их сайн хэлж мэдэж, хаана хаанаа нэг их тийм зөв ойлголттой байх ёстой гэж би ойлгож байгаа. Тэгэхээр үндсэндээ бол хуучин бол бид нар ерөөсөө ганцхан цэцэрлэгийн хоолны мөнгийг төр

эцэг эхчүүдтэй нь уг нь хамтарч таадаг байсан, саяхныг хүртэл, саяхныг хүртэл. Тэгээд эргээд нөгөө нэг халамжийн бодлого хавтгайрснаас үүдэж, ингээд бид нар ингээд төр 100 хувь даадаг нэг ийм тогтолцоо руу орсон байгаа юм. Тэгээд цаашидаа бол төр 100 хувь, энэ цэцэрлэг хүүхдүүдийн хоолны мөнгийг яг нуруун дээрээ авч явна гэдэг их хүндрэлтэй. Тэгж нөгөө нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг шиг иймэрхүү хэлбэрээр явахад бол асар их тийм төр дээр их том ачаалал ирэх юм байна лээ. Тэгэхээр бол асуудал бол юундаа байна вэ гэхээр яг хүүхэд өөрийнхөө өдөрт авах ёстой илчлэгийг өнөөдрийн тарифаар авч чадаж байна уу л гэдэг асуудал байгаад байгаа юм. Цэцэрлэгийн хувьд ч, сургуулийн хувьд ч, дотуур байрны хувьд ч, МСҮТ-ийн хувьд ч гэсэн.

Тэгээд ингээд үндсэндээ ингээд тооцоо судалгаа хийгээд өнөөдрийн ингээд үнийн өсөлтийг хараад, ингээд үзэхээр үндсэндээ бол яг өнөөдрийн энэ тарифаар бол энэ хоолны материалын тарифаар бол хүүхэд авах ёстой илчлэгийнхээ 50 хувийг л авч байгаа байхгүй юу, бараг хүрэх ч үгүй байгаа юм. Тэгэхээр цаашидаа ийм байдлаар нөгөө хоол өгч байгаа нь сайн, тэгэхдээ дахиад хагас өлсгөлөн байдалтай ингээд байгаад байх асуудал дээр бид нар ямар шийдэл гаргах ёстой юм бэ л гэдэг нэг үүнийг л бид нар хамтарч шийдэх нэг ийм улс төрийн буюу нийгмийн ийм дэмжлэг авч шийдэх ийм зайлиггүй шаардлага байна л гэж харж байгаа юм.

Зөвхөн өнгөрсөн жил ковидын жилүүдэд бол боловсролын салбарын мөнгө хасагдаагүй нэмэгдсэн шүү дээ, Мөнхцэцэг сайд аа, Мөнхцэцэг дарга аа. Тийм учраас бол энэ дээр болбол, тэр тусмаа нөгөө үдийн цайг бол бид нар үдийн хоол болгосон, энэ бол маш том өртөг зардалтай ийм шийдэл байсан. Өнөөдөр 1-5 дугаар ангийн 371480 хүүхэд өнөөдөр үдийн хоолоор халуун хоолоор үйлчлүүлж байгаа. Гэхдээ асуудал гал тогооны хувьд гэдэг юм уу, хоолны чанарын хувьд гэдэг юм уу, хоолны илчлэгийн хувьд асуудал байгаа юу гэвэл байгаа. Өнөөдрийн байдлаар ямар ч байсан 21 аймгийн 488 ЕБС дээр энэ хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын орчин бүрдэж чадахгүй байгаа нэг ийм бодитой эрсдэл бас бид нарт байна. Гэхдээ үүнийг дан ганц удаа бид нар энэ төсвийн эх үүсвэрээр шийдэх биш, ерөнхийдөө энэ АХБ, Дэлхийн банк, боловсролын төлөөх олон улсын байгууллагууд, Жайка, Койка гэсэн олон улсын байгууллагуудын бас дэмжлэгтэйгээр тусалцаатайгаар энэ сургуулиудын гал тогоогоо шинэчлээд явж байгаа ийм сайн жишиг, сайн санаачилгууд бас байгаа юм. Тэгэхээр эхлээд бид нар яг ингээд ерөнхий одоо нэгэнт хууль байгаа учраас хувийн гал тогоо бол ажиллуулах бид нарт эрх зүйн үндэслэл байхгүй. Тийм учраас ямар ч байсан эхний ээлжид энэ сургууль дээр цэцэрлэгийнхээ орчинд энэ гал

тогооныхоо стандартын асуудлуудыг зайлиггүй мэдэж хийх ёстой.

2 дугаар асуудал бол ер нь цаашидаа бид нар энэ үдийн хоол, ингээд 1-5 дугаар анги, 5-9 дүгээр анги, 9-12 дугаар ангийн юун дээр ингээд өгөөд явах тохиолдолд бол ер нь энэ төр, хувийн хэвшлийн түншилэлийн хамгийн зөв, моделиуд ямар хэлбэрүүд байх ёстой юм бэ гэдэг энэ бизнесийнхээ моделиудыг хамтын ажиллагаа, моделиудыг их зөв болгохгүй бол төр дангаараа ингээд нуруун дээрээ энэ бүх асуудлуудыг авч явна гэдэг бол бас их хүндрэлтэй. Төсөв зардлын хувьд ч гэсэн бас их хүндрэл ачаалал үүсгэх ийм нөхцөл байдал үүсчээд байгаа юм. Зөвхөн энэ жил гэхэд бид нар жил бүхэн энэ ерөнхий боловсролын салбар чинь 50000 хүүхэд нэмэгдэж байгаа шүү дээ, 50000 хүүхэд. Тэгэхэд 50000 хүүхэд нэмэгдэхэд л зөвхөн хоолных нь зардал гээд бараг 40 хэдэн тэрбум төгрөгийн нэмэгдэл зардал төсөв дээр ачаалал ирж байгаа. 90 тэрбум төгрөг зараад байдаг, яг жил бүхэн хүүхэд нэмэгдэхэд дахиад 40-50 тэрбум гэдэг зуун ... /минут дуусав/

Г.Занданишатар: Бат-Эрдэнэ сайд, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би Мөнхцэцэг даргын асуусан асуултад товч хариулъя. Энэ жил манай төсөв шилжиж ирсэн барилга, объектыг гүйцээхэд зориулаад 41,4 тэрбум төгрөг тавигдсан байгаа. Энэ нэлээн олон сумдад, аймгийн төвүүдэд спортын ордон, спортын цогцолбор барихаар ингэж төсөвлөгдсөн байгаа. Тэгээд энэ маань бол зарим нь арваад жил он дамжиж цаг хугацаа их алдсан ийм барилга объектын ийм бас зүйлүүд бий. Тэгээд үүнийг гүйцээнэ ээ гээд Биеийн тамир, спортын хорооноос ажлын хэсэг яваад 8 аймагт энэ бүх ажлуудтай нь танилцсан. Яг энэ асуудлаа дагнаж хариуцахаар болсон учраас бас тодорхой үр дүн гарч эхэлж байна гэж ингэж ойлгож болно оо.

Та Байнгын хорооны даргаар сонгосныхоо дараа хамгийн түрүүнд манай биеийн тамир, спортын салбарын ажил байдалтай танилцсан. Олимп хаяанд тулсан байгаа учраас энэ олимпын бэлтгэл сургалтын төв дээр очиж ажилласан, энэ их үр дүнтэй болсон. Тэгээд энэ хүрээндээ ажил хийж байна. Ер нь бол биеийн тамир, спортын асуудлыг бусад улс орнуудын жишиг ч тийм байдаг. Төр төсөөрөө дангаараа аваад явах бололцоо байхгүй, гэхдээ төр тодорхой хэмжээгээр ялангуяа манай орны нөхцөлд бол дэмжлэг үзүүлэхээс өөр арга байхгүй. Тэгээд энэ дэмжлэг бол тодорхой үр дүнгээ өгч байгаа, үүний жишиг хэлэх юм бол энэ хувийн хэвшлийнхэн, биеийн тамир, спортын цогцолбор, энэ томоохон барилга объектуудыг барьж, менежментийнх нь

үйл ажиллагааг өөрсдөө авч явж, энэ үр ашигтай ажиллуулж байгаа юм жишээг хэлж болно. Мөнхийн үсэг компани байна. Энэ мөсөн өвлийн олимпын энэ томоохон цогцолборыг хэлж болно. Ган хийц гээд тэр компани томоохон цогцолбор барьж байгуулсан байна. Ийм олон компаниуд ингээд ажиллаж байгаа юм.

Хамгийн гол нь үүнтэй холбоотойгоор энэ Биеийн тамир, спортын хуулийн хэрэгжилтийг хангаж, Биеийн тамир, спортын хуулийн энэ 25.2-т бол ААНБ-ын спортын заал, талбай, түүний дэд бүтцийг барих, спортын хэрэглэл, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд төрөөс татварын бодлогоор дэмжлэг үзүүлэхээр ингээд заачихсан. Энэ бол бодитойгоор хэрэгжиж чадахгүй ийм зүйл байгаа юм, дандаа улс хийгээд байна гэхээсээ илүү энэ хувийн хэвшлийнхэн бололцооны хэмжээгээр хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах, эрүүл эхтэй амьдралын хэв маягийг нь бий болгох энэ бололцоог гаргаж өгье гэж байхад энд төр бас тодорхой дэмжлэг үзүүлэх ийм шаардлага бол байгаа. Үүнийг манай эрхэм гишүүд анхаарч үзэх байх. Энэ улс орон даяар сумдад хийж байгаа энэ спортын цогцолбор, заал, танхимуудыг барьж байгуулах энэ санаачилгыг бол манай үе үеийн парламентын Их Хурлын гишүүд маань л үүнийг санаачилдаг. Та бүхэн маань бүгдээрээ, өөрийнхөө сонгогдсон тойргуудад олон бүтээлч энэ спортын барилга байгууламжийг хийж байгаа. Түүнд бол бид баяр талархалтай байгаа.

Зарим талаар бол бид бас хүрсэн, үр дүнгээсээ ухарч байгаа ийм зүйлүүд бий. Тухайлах юм бол энэ биеийн тамирын хуулийн 9.4-т Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ ээ гээд 9.4.1-д Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтад хамрагдах магадлан итгэмжлэгдсэн спортын клубийн нэрсийг хүргүүлэх гээд ингээд нэг үеэр бол энэ ЭМД-аас эрүүл мэндээ хамгаалж байгаа, өвчлөлөөс урьдчилан сэргийлж байгаа энэ иргэддээ дэмжих энэ бусад улс орнуудын жишээг бид нар жишгийн дагуу бид нар энэ нэг ахиц дэвшил гарсан. Үүнээсээ бол энэ ковидын үеэр бол төсөв дагасан хуулиар үүнийгээ хүчингүй болгочихсон байгаа. Тэр үеэр ярьж байсан яриа бол ингээд ковидын нөхцөл байдал өөрчлөгдсөн үед эргүүлээд хуулийн энэ заалтыг сэргээхээр ингээд ярьж байсан нэг ийм зүйлийг би бас хэлэх нь зөв байх гэж бодож байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна, алга байна, хаслаа. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн. Мөнхцэцэг гишүүн.

Д.Бат-Эрдэнэ: Төсөв улсынхаа эдийн засгийг тогтворжуулах концепцтой орж ирж байгаа. Цаашидаа бол мэдээж эдийн засгийг тэлэх бодлогыг бол дандаа агуулж явах ёстой. Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулах, тэлэхэд бол тодорхой нэг хэдхэн л асуудал байгаа л даа. Нэгдүгээрт экспортоо яаж, хэрхэн нэмэгдүүлэх вэ гэж. Тэгэхээр экспортоо нэмэгдүүлэх өнөөдөр бол гол нь бид нар, манай гишүүд маань их бас их цөмөөрөө ингэж нүүрс их чухал юм гэдгийг ойлгосон. Энэ дээр их анхаарч байгаад баяртай байгаа. Тэгэхээр нүүрсээ олборлоод зөөгөөд байж чадаж байх шиг байгаа юм. Хил гарах дээр асуудал байна. Тэгэхээр хилийнхээ одоо 2 дахин даблдаж, нүүрс гарах боломж нь өнөөдөр нөгөө төмөр замыгаа л цаашаагаа шууд гаргах ёстой. Энэ асуудлыгаа Зам тээврийн сайд онцгой анхаарах юм бол бид нар эдийн засаг дээрх дэмжих, экспортыг 2 дахин нэмэгдүүлэх боломж байгаа, даблдах боломж байгаа шүү, үүнийг бас хэрхэн анхаарч байна вэ, Засаг үүн дээр ямар бодолтой байгааг сонсмоор байгаа.

Гаднын хөрөнгө оруулалтгүйгээр ямарваа улс орон хурдтай хөгжих асуудал байдаггүй л дээ. Тэгэхээр мэдээж ковидын дараа бол хүндрэлтэй асуудлууд байгаа. Гэхдээ Монголд өнөөдөр жижиг эдийн засагтай цөөхөн хүн амтай учраас бид нар асар зөв бодлогыг богино хугацаанд явуулах юм бол хурдан босох боломж хамгийн түрүүнд цөөн хүн амтай улсад байдаг. Жижиг эдийн засагт байдаг. Тэгэхээр энд Монголд бол боломжит байгаа том 3 салбар байгаа. Уул уурхайн салбар байна, эрчим хүчний салбар байна, дэд бүтцийн салбар байгаа. Тэгэхээр яг энэ эрчим хүч, дэд бүтэц, зам тээврийнхээ салбарт бас Ардын нам маань ингэж бизнесийн дадлага туршилагатай, ийм сайн боловсон хүчнүүдээ сайдаар дээр тавьсныг бас их дэмжиж байгаа. Эндээс их юм хүлээж байгаа гэдгийг бас энд онцлон хэлье. Уул уурхайн салбарт хайгуулаа жосоохон чөлөөлж өгөх хэрэгтэй байна, ингэснээр хөрөнгө оруулалт орно оо, тусгай зөвшөөрлөө цаашидаа яах гэж байна вэ.

Эрчим хүчин дээр гаднын ямар хөрөнгө оруулалтуудыг татах гэж байна, Чойжоо сайд аа.

Мөн 3 дахь нь бол хувийн хэвилээ дэмжих ёстой юм. Өнөөдөр далд эдийн засгийнхаа мөнгийг койнд 2 юм уу, 3 их наяд мөнгө орчихсон байна л гэсэн тооцоо байгаа. Тэгэхээр бид нар энэ мөнгөө яаж наашаагаа эдийн засгийнхаа эргэлтэд зөв оруулах юм бэ? Төр, хувийн хэвшлийн түшиглэлийн ажил хэрхэн явагдах юм бэ? Төр өөрийнхөө бүх өөрсдөө мундаг бизнесменүүд шиг бүх хувийн хэвшлийнхнийг хааж, энэ бизнесийг татаад байх юм бол хувийн хэвшлийнхнийгээ яаж энэ зөв хамтарч ажиллах юм, зүгээр дарга болж гишүүн

болж, дарга ажил бизнес хийе гэсэн тэр тенденц Монгол Улсад цаашидаа үргэлжлэн явагдах болно оо. Энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий сайд 2022 оны 5 сарын 27-нд Өмнөговь аймагт 8 сайдтайгаа очиж уулзалт хийсэн юм. Өчигдөр хүртэл хэлсэн, бид нар бүгдээрээ ойлгодог, Өмнөговь аймаг Монгол Улсын эдийн засгийн дийлэнх эхийг нуруундаа үүрч явдаг. Төсвийн хөрөнгө оруулалтуудыг тойргуудад тэгишгэхгүй ээ гэж ярьдаг. Бид нар сүү авахын тулд хаана аль сүү ихтэй, үнээндээ л илүү их ус өгч, илүү тэрийг ашиглах ёстой байдаг. Тийм учраас Өмнөговийн хэд хэдэн асуудлуудыг шийдэхээр бүх сайдуудтайгаа очиж амласан юм. Энэ амлалтууд нь хэрхэн туссан бэ? Үүнийг харахад 24 он руу хойшоо тавьсан. Дараа гэсэн асуудлууд байна. Энэ дээр нэгдүгээрт нь тэр Улаанбаатар руу нүүрс зөөдөг замыг янзальга гэсэн, энэ 12-14 онд 1,6 жилд Алтанхуягийн Засгийн газрын үед Засгийн газрын гишүүд нь зогсож байгаад бид нар 550 километр замыг тавиулж байсан юм. Энэ зам өнөөдөр эвдрээд дууслаа. Гэтэл өнөөдөр урдуур тэрийг зөөх ёстой нөгөө төмөр замаа их хурдан ашиглаач ээ, хувийн хэвшилүүдийнх шигээ хийсэн юмаа хурдан дуусгаад явахгүй бол салан баавгай шиг бид нар ингээд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ерөнхий сайд энэ жил б аймгаар бид хамтдаа явсан. Ингээд ард иргэдийн оролцоотой, тухайн орон нутгийн удирдлагуудын оролцоотой, ингээд нэн шаардлагатай эдийн засаг, нийгмийн өндөр ач холбогдолтой төслүүдийг ойрын хугацаанд хийж хэрэгжүүлж эхлүүлэх, үргэлжлүүлэх, ингэж ач холбогдол өгсөн. Үүний дагуу Засгийн газрын шийдвэр тогтоол ч гарсан байгаа. Тэгэхээр одоо хойш нь шийдэж байгаа асуудал биш шүү, Бат-Эрдэнэ гишүүн ээ. Төсвийн нөхцөл байдал өөрөө ийм зүйлийг шаардаж байгаа юм, зөв хуваарилалтуудаа хийх. Ингээд ТЭЗҮ нь болон бусад бэлтгэл ажил нь хангагдаагүй бүх төслүүдээ ирэх онд энэ бэлтгэл ажлуудыг нь хангана. Энэ бол төсвийн хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалтынхаа бид зарчмын дагуу шат дараатай явдаг асуудал. Өнөөдөр хэрэгжүүлж дуусаагүй олон үнийн өсөлтөд өртчихөөд дуусаж чадахгүй байгаа асуудлууд бүгд л эндээс эхэлсэн байдаг, бэлтгэл ажил хангаагүй, зураг төсөвгүй эхлүүлчээд дараа нь ингээд төсөвт өртөг нь нэмэгдээд ингээд явчихдаг. Тэгээд энэ бүх зүйлээс эрсдэлгүйгээр найдвартай, баталгаатай эхлээд дуусах ийм замаар бүх зүйлүүдийг шийдэх хэрэгтэй юм байгаа юм. Тэгэхээр энд хойшоо урагшаа болсон зүйл ерөөсөө огтоос байхгүй, Төсвийн хуулийнхаа дагуу хөрөнгө оруулалтынхаа зарчмын дагуу бэлтгэл ажлаа бүрэн хангаад,

ингээд 1-2 жилийн дотор бүрэн дуусах хэмжээнд авчраад, ингээд 24 оноос яг бүтээн байгуулалтын ажлуудыг нь шат дараатай эхлүүлэх ийм тогтоол төсөв дагаж гарах юм байгаа юм, бүр нэг бүрчлэн төслүүдийнх нь нэрийг нь зоогоод ийм байдлаар бид өргөн барьсан байгаа.

Тийм учраас Өмнөговьчуудад, Өмнөговийн ард түмэнд амласан зүйлүүд бүгд бүрэн дүүрэн, баталгаатай хэрэгжинэ ээ гэж албан ёсоор хэлье. Ингээд төсвийн хуулиа дагаад ч энэ тогтоол болж орж байгаа гэж ойлгоорой. Бусад асуудлуудыг нь чиглэлийн яамд хариулах байх, тийм.

Г.Занданишатар: Жамбалын Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Гаднын хөрөнгө оруулалтуудын хувьд бол Оюутолгойг эс тооцвол хөрөнгө оруулалт буусан гэдгийг бол та мэдэж байгаа. Тэгэхээр гаднын хөрөнгө оруулалтын хувьд бол уул уурхайн салбар бол хайгуулын болоод олборлолтын, хувьд бид гаднын хөрөнгө оруулалтыг татах гол салбар гэдэгтэй санал нэг бол байна.

Хайгуулын хувьд бол улс бол ер нь өөрийнхөө мөнгөөр хайгуулаа бол хийж байгаа. 23 онд нэг 21 тэрбум төгрөг суулгасан, түүний 3 тэрбум төгрөг нь бол бас шинэлэг технологиудаар хайгуулаа хийнэ ээ гэсэн, зүгээр ер нь туршиж үзье ээ гэсэн ийм байдалтай Сангийн яамтай бас ярилцсан зүйлүүд байгаа. Хайгуулын ажлын хувьд бол, ер нь бол гаднын хөрөнгө оруулалтыг татдаг гол зүйл ээ гэдгийг бол та бас мэдэж байгаа. Хайгуулыг бид нар өнөөдөр геологийн суурь судалгаа, эрэл, эрэл, үнэлгээ гэсэн 3 чиглэлээр бол хийж байгаа. Энэ хийж байгаа хэлбэрт бас асуудлууд бол маш их байна. Үүнийг харин яаж өөрчилж, яаж ил тод болгох вэ гэдэг дээр УУЯ бодлого боловсруулж байгаа. Удахгүй бид бас танилцуулна.

Тусгай зөвшөөрлийн хувьд бол одоогоор олгогдохгүй байгаа, хайгуулын тусгай зөвшөөрөл. Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох талаар Засгийн газрын тэмдэглэл саяхан гарсан. Тийм ч учраас УУЯ энэ талаар бол эрчтэй ажиллаж байна. Ойрын хугацаанд бид газар нутгийн, зарим сумдын газар нутгийн хэмжээ бараг 20-оос дээш хувь нь лиценз хэлбэртэй болсон байгаа. Эдгээр сумдыг бид бол олгохгүй гэсэн бодлого бол барьж байгаа. Тийм сумдаа бид нар бол ерөнхийд нь хасаад, олгох боломжтой Монголын газар нутгийн 78 хувь нь тусгай хэрэгцээнд байдаг, үлдсэн 22 хувь дээр нь хайгуул хийх бололцоотой байгаа. Тэндээс мөн хайгуулын одоо сумдын тэр газар нутгийн хэмжээгээр нь харж байгаад ойрын хугацаанд олгож эхэлнэ ээ гэдгийг бас танд хэлье. Баярлалаа, дууслаа.

Г.Занданиатар: Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд.

С.Бямбацогт: Бат-Эрдэнэ гишүүн бас нэлээн чухал асуудал хөндөж байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “шинэ сэргэлт”-ийн бодлогод энэ боомтын сэргэлт гээд бас томоохон бодлого суусан байгаа. Энэ боомтын сэргэлтийн хүрээнд бид нар үндсэндээ бол энэ боомтуудад чиглэсэн төмөр зам, авто замуудыг хурдан хугацаанд барьж байгуулах энэ ажлуудыг бол онцгой ач холбогдолтой гэж үзэж нэгдүгээрт эрэмбэлж байгаа. Ер нь ковидын бас сүүлийн 2, 3 жилийн хугацаанд Монголын ард иргэд бүгдээрээ л энэ ачаа тээвэрлэх ямар чухлыг, тээвэр ложистик ямар чухлыг ойлгосон. Нүүрсээ байгалийн баялгаа гаргаж чадахгүй, түүнээсээ болоод төсвийн орлого тасалддаг, эдийн засагт нөлөөлдөг, импортоор орж ирэх өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, барилгын материал оруулж ирж чаддаггүй. Үүнээсээ болоод үндсэндээ бол энэ боомт чухал юм байна, боомтын тээвэр гэдэг чухал юм гэдгийг ойлгосон. Тийм болохоор үндсэндээ бол ямар нэгэн саад тотгоргүйгээр үндсэндээ бид энэ төмөр зам болон авто замуудыг боомтын чиглэлд барьж байгуулах ажлаа эрчимтэй явуулах ийм бодлого барьж байгаа.

Өмнөговь аймгийн тухайд гэж ярих юм бол төмөр замын Гашиун сухайт чиглэсэн төмөр замыг барьж байгуулан ашиглалтад хүлээж авлаа. Цааш нь бас Хятад улстай бас өргөн нарийн царигаар терминал байгуулах холболтын цэг байгуулах ажлыг 2 жилийн хугацаанд бас хурдан хугацаанд хийж хэрэгжүүлж байж жилдээ бас нэг 50 орчим сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай болно. Одоо бол нэг 20 орчим сая тонн ачааг бас хил дээр аваачих ийм бололцоотой болж байгаа гэж харж байгаа.

Дараагийн нэг асуудал бол бид нар Шивээ хүрэн, Арц суурь чиглэлд баруун босоо чиглэлийн төмөр замыг бас барьж байгуулж, үүгээр бас зөвхөн авто тээврийн нүүрс тээвэрлэхээс гадна төмөр замаар нүүрс тээвэрлэх ийм бас бололцоо боломжийг бий болгох энэ ажил хийгдэж байгаа. Тэгээд төсөл сонгон шалгаруулалт явагдаж байна, үндсэндээ бол бас тун энэ ондоо багтаад гүйцэтгэгч компанитай бас гэрээ хийчих болов уу гэсэн тийм бодолтой ажиллаж байгаа. Мөн Цагаан дэл уулын боомт авто замын концессын гэрээ 2018 онд гэрээ хийгдсэн боловч одоо болтол ажил нь эхэлдэггүй ийм ажил байгаа. Орон нутгийн иргэд нь эсэргүүцдэг, энэ ажлыг хурдан эхлүүлэх шаардлага байгаа. Хятад улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрууд хамтраад хоорондоо тохиролцоод гэрээ хийчихсэн. Хятадын галаас бол боомт дээр үндсэндээ боомтоо байгуулчихсан, замаа аваад ирчихсэн.

Монголын тал бас ажлаа хийж үүргээ биелүүлэхгүй байгаад байгаа юм. Энэ тал дээр бас манай Өмнөговь аймгаас сонгогдсон гишүүд бас Засгийн газартай хамтарч ажиллаж, энэ бас ажлыг хурдан эхлүүлэх нь зөв байх. Ингэх юм бол бас тодорхой хэмжээнд Таван толгойгоос Цагаан дэл уулыг чиглэсэн боомтыг чиглэсэн 240 километр зам баригдвал энэ чиглэлдээ бас импортын болон экспортын ачаа бараа эргэлтэд орох бас томоохон боломж бүрдэнэ ээ.

Зүүн чиглэлдээ бид нар зүүн босоо тэнхлэгийн төмөр замыг барьж байгуулах, Чойбалсан, Хөөт бичиг чиглэлийн төмөр замын сонгон шалгаруулалтын ажлыг бас хийж хэрэгжүүлэхээр ажлууд сонгон шалгаруулах ажил явж байгаа. Энэ хүрээндээ бас энэ ондоо багтаад бид нар энэ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад үндсэндээ би өө ти буюу барих, ашиглах, шилжүүлэх нөхцөлөөр зураг төслөө боловсруулаад ингээд үндсэндээ энэ дээр бол ямар нэгэн Монгол Улсын Засгийн газарт Монгол Улсын төсөвт ямар нэг дарамт болохгүй байдлаар төмөр замаа барьж байгуулъя гэдэг энэ бас бодлого зорилтыг хийж байгаа. Ингэх юм бол бас үндсэндээ Бат-Эрдэнэ гишүүний асууж байгаа төмөр замын Замын-Үүд-Улаанбаатар гэсэн ганцхан Улаанбаатар-Алтанбулаг гэсэн ганцхан чиглэлд төмөр замтай байсан бол Ханги Мандал баруун босоо, зүүн босоо гэсэн үндсэндээ 4 чиглэлтэй, төмөр зам барьж байгуулах ийм бас Засгийн газрын бодлого бас хэрэгжинэ ээ гэж ойлгож болно.

Г.Занданиатар: Даидэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна.

Д.Бат-Эрдэнэ: Тэгэхээр тэр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал дээрээ нэлээн анхаарч ажиллах ёстой байх, Жавхлан сайд энэ дээр бас дутуу хариулах шиг боллоо. Сая Төрийн банкны нөгөө ай ни өө гараад маш амжилттай, тэр захиалга нь 3, 4 дахин илүү тийм захиалга ирж байгаа, хангагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр цаана иргэдэд байгаа хувийн хэвшлийнхэнд байгаа энэ боломж энэ эдийн засгийг Монголынхоо энэ эдийн засгийн эргэлтэд оруулаач ээ. Эрдэнэс тавантолгой, тэр Оюутолгойгийн 34 хувь, Эрдэнэтийн тодорхой хувиудыг хувийнхаа хэвшлийнхэнд, ард түмэндээ нээлттэйгээр хөрөнгийн биржээр ингэж зарж борлуулах нь өөрөө зайлшгүй хэрэгтэй болчиход байгааг анзаарч харах хэрэгтэй.

Цагаан дэл уул, Өлзийтийн асуудлыг Монгол Улсын Засгийн газар, Их Хурлын гишүүд та нар Засгийн газрын 8 сайд очоод түдгэлзүүлсэн, түдгэлзүүлсэн. Тиймээс энэ бүх ажил өнөөдөр зогсонги байдалтай байгаа. Энэ дээрээ нэг тодорхой байр сууриа гаргаад ... /минут дуусав/

Г.Занданишатар: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Салбартаа ямар гадаадын хөрөнгө татах вэ гэсэн ийм асуулт тавилаа. Бат-Эрдэнэ гишүүн ээ, яг өнөөдрийн байдлаар манай салбар ийм ийм байна. Өөрийнхөө үндсэн хөрөнгүүдийг социализмаас дамжиж ирсэн учраас үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнүүд хийгдээгүй, салбар дээр нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн стандарт нэгдүгээрт гүйцэд хийгдээгүй байгаа юм байна. Үүнийг 2022 оны 4 дүгээр улирлын баланс гаргахдаа зохицуулаад энэ ажлыг зохицуулахаар нэг ажил хийж байгаа.

Ер нь бол хоёрдугаарт өнөөдрийн байдлаар 1,6 их наяд төгрөгийн өр төлбөр байна, зээл авчихсан байна. Хүүд нь жилдээ 70 тэрбум төгрөг төлж байгаа, борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг 1,9 их наяд төгрөг, борлуулж байгаа үнээрээ бол 1,6 их наяд төгрөг ийм байна. Тэгэхээр энэ үнэ либералчилж, чөлөөлж чадаагүйгээс шалтгаалаад гаднын шууд хөрөнгө оруулалт, хувийн хөрөнгө оруулалтыг татах бололцоо эрчим хүчний салбар дээр өнөөдөртөө хомс байна. Тийм учраас 2000 ... /минут дуусав/

Г.Занданишатар: Гүйцээгээд хариулчих, Чойжилсүрэн гишүүн Эрчим хүчний сайд гүйцээгээд хариулчих.

Б.Чойжилсүрэн: Тийм учраас 2022 оны 11 сарын 1-нээс эрчим хүчний үнийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж, өртөгт нь хүргэх ийм ажлууд хийгдэнэ. Дунджаар нэг, 28 хувь нэмэх шаардлагатай байгаа, өртгөөсөө борлуулж байгаа үнэ маань 28 хувь доогуур байгаа ийм ажлууд байна.

Хоёрдугаарт, салбарын хувьд бол техникийн бэлэн байдал, мөн санхүүгийн тогтвортой байдал, дампуурахгүй байх байдал, өртгөө нэмэгдүүлэхгүй байх байдлыг 2 талаас нь тийм 2 шинжилгээ хийж байгаа юм. Англиар sustainability гэдэг дээ, тогтвортой байдал гээд техникийн хувьд, санхүүгийн хувьд. Энэ судалгааны дүн 10 дугаар сарын сүүл, 11 дүгээр сарын дунд ихэд гарна, энэ талаар та бүхэнд танилцуулъя.

Яг өнөөдрийн байдлаар гэрээ нь хийгдчихсэн Эрдэнэбүрэнгийн УЦС гэх мэтийг оруулаад 9 төсөл арга хэмжээ байна. Төсөвт өртгийн дүн 750 сая америк долларын хэмжээтэй ийм төслүүд 9 төсөл, арга хэмжээ явж байна.

Дээр нь нэмээд энэ дээрээс одоо дээд хурыг 3 хувийн өргөтгөл байна, үнийн санал ТЭЗҮ дууссан, үнийн санал ирчихсэн. Бид нар одоо

ингээд түүн дээр ажиллаж байна, ОХУ-д ажиллана. Таван толгой цахилгаан станцыг 2 удаа зарласан, оролцогч оролцоогүй, шаардлага хангасан оролцогч оролцоогүй байгаа, энэ асуудлыг бас энэ ондоо багтаад нэг талдаа гаргана. Гэхдээ энэ бол үнэ ингээд юм тохируулгатай, зардал нь зах зээлийн үнэд байсан тохиолдолд бол хувийн хөрөнгө оруулалтыг оруулах бол бололцоо муутай байна. Энэ үнийг доошоо байнга тогтвортой доор байх юм бол энэ бүх зах зээлийн үнийн татаасыг төр өөр дээрээ бүх зүйлийг одоо санхүүжилтийг босгох гэх мэт энэ бүх эрсдэлийг авах ийм шаардлага байгаа учраас энэ эхний либералчлалын анхны одоо санхүү бүртгэлээ нэгдсэн стандартад оруулах, үнийг одоо чөлөөлж эхлэх алхмын нэгдүгээр алхмыг хийнэ. 2, 3 үе шаттай, 4, 5 үе шаттай ч явж чадах байх, эдийн засаг хямралтай байгаа учраас. Хэрэглэгчийн түрийвч бас резин шиг сунаж томорч өгөхгүй байгаа учраас энэ тал дээр бол бас тодорхой хэмжээний бэрхшээл бий. Шинэчлэлийн ажлыг бол эхлүүлж байгаа.

Г.Занданишатар: Бат-Эрдэнэ гишүүн тэгээд ажлын хэсэгт орж ажиллаад энэ юмнуудаа сайн яагаарай.

Завсарлах цаг болчихсон байна, сунгаж хуралдах уу, 2 цагаас та үргэлжлүүлж асуух уу.

1 минут Дагдэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн.

Д.Бат-Эрдэнэ: Цаг багтахгүй байна. Тэгэхээр нөгөө цаашидаа Монгол Улсын эдийн засаг тэлэхэд, мөн том төслүүд тасралтгүй явахад говь руу ус аваачих асуудал зайлшгүй чухал байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр яг бид нар цөмөөрөө сонгуулийн өмнөх төсөв хэлэлцэж байгаа учраас энэ асуудлыг битгий орхигдуулаарай гэж хүсээд хүсээд байгаа юм. Тэгэхээр энэ асуудал маань Эрдэс таван толгой дээр бас нэг асуудал яригддаг. Байгаль орчны яам гэж байдаг, гадна талын одоо ОУБ шийднэ ээ гээд ийш тийшээ ингээд түлхээд байдаг. Тэгэхээр энэ асуудлыг Засгийн газар, Байгаль орчны сайд энэ асуудлыг барьж аваад тодорхой хүмүүсийг нэгтгээд ажиллахгүй бол энэ дээр хүч сарниад байна аа. Энд цаашидаа өнөөдөр бид нар ойрын 24, 28 ондоо энэ сонгуулиа давах байх. Цаашидаа Монгол Улсын эдийн засаг энэ газрын доорх баялаг үнэ босгох асуудал байхгүй болно оо, Айна улам үнэгүй болно оо, энэ дээр онцгой анхаараач ээ, Байгаль орчны сайд юу гэж бодож байна вэ гэж.

Г.Занданишатар: 92. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд.

Б.Бат-Эрдэнэ: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. “Хөх морь” төслийн хүрээнд ялангуяа Орхон, Хэрлэн тооно гэсэн 2 томоохон

төсөл явж байгаа. Бид нар сая усны хэлэлцээрийг хийсэн. Усны хэлэлцээрээр бол одоо бид нар “хөх морь” төсөлтэй холбоо бүхий асуудлуудаа бүгдийг нь хөндсөн. Ялангуяа тухайн төслийн хүрээнд бол Орхон онги дээр бол бид нар ОХУ-ын талтай хамтарч энэ биологийн олон янз байдлын нөлөөллийн асуудлууд, Хэрлэн тооно дээр бол бид нар БНХАУ-ын талтай хамтраад, бас энэ биологийн олон янз байдлын нөлөөллийн асуудлуудыг бол бид нар судалгаа шинжилгээний ажлын багийг нь гаргаад бол бид нар ажиллуулаад явж байгаа. БНХАУ-ын пор чэйна гэдэг компаниас бол Орхон онги төсөл дээр түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр эхний ээлжид бол нэн шаардлагатай байгаа 6,8 тэрбум төгрөгийг гаргаж, цаашидаа үргэлжлүүлээд хийе ээ гэдэг ийм саналыг бол Монгол Улсын талд хэрэг ирүүлээд байгаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бол усны газар дээр ... /минут дуусав/

Г.Занданиатар: 13 цаг болсон байна. Энэ ажлын хэсэгт олон хүн ажиллаж байгаа учраас бас завсарлах нь зөв байх.

Гишүүд бол орж гараад үдийн цайгаа зохицуулж болох байх.

Ингээд үдээс өмнөх хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

2 цагт 14 цагаас Ерөнхий сайдын асуултад хариулна. Шинэ дэгээр явна.

Одоо Даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай. Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд Даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай.

ЗАВСАРЛАГА

13.17 цаг

Г.Занданиатар: Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 07-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Сая Даргын дэргэдэх зөвлөлөөр хурлаар хуралдаад хэлэлцэх асуудал дээр яаралтай зайлиггүй хэлэлцэхээр хүсэлт гаргасныг харгалзан Ерөнхий сайдын танилцуулгыг нэмэхээр өнөөдрийн хуралдааны явц “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэмж, хэлэлцэж байгаа асуудлуудын явц, цагийн байдлаас шалтгаалан “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулсан болохыг мэдэгдье. Хэлэлцэх асуудлын дараалалд ингэж өөрчлөлт орлоо.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаар/

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанд боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаар Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн мэдээллийг сонсох гэж байна. Мэдээллийг Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2022 оны 7дугаар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хийх Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэд өөрсдийн мэдэхийг хүссэн асуултаа D Parliament.mn цахим хуудсаар дамжуулан асуухад асуух боломжийг олгосон. Өөрөөр хэлбэл ард иргэдийнхээ оролцоог хангасан. Ингээд сар бүрийн 1 болон 3 дахь 7 хоногийн нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоог. Энэхүү мэдээллийг чуулганы хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газар хүлээн авч, D Parliament.mn цахим хуудсанд байршуулах ёстой. Ингэснээр иргэд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулж 5 хоногийн туршид асуух асуултаа оруулах боломж нээгдсэн. Иргэд уг мэдээллийн сэдвийн дор байрлах асуулт асуух гэсэн цэс рүү нэвтэрч хүссэн асуултуудаа тавих боломжтой. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуулийн гурвын нэгд заасан ард түмний засаглах эрхийг эдлүүлэх, иргэний мэдэх эрхийг хангах, парламент, ЗГ-ын үйл ажиллагаа, ард түмэндээ нээлттэй байх, иргэдтэйгээ хамтран төрийн бодлого, шийдвэр, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд чиглэсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ гэж үзэж байгаа. Ингэснээрээ иргэдийн асууж мэдэх эрхийг хангаж байгаа.

Энэ хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүнгийн талаарх мэдээллийг D Parliament.mn цахим хуудсанд байршуулж, мэдээллийг авлаа. Мэдээлэлтэй холбогдуулж иргэдээс 12 асуулт ирсэн байна. Хуулийн дагуу Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдэд Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх асуултыг нэгтгэж хүргүүлсэн. Иргэдээс ирүүлсэн асуултуудыг нам, эвслийн бүлгүүд нэгтгэж, чуулганы нэгдсэн хуралдаанд 20 минутад багтаан асуулт асуух дэгтэй, асуулт асууж хариулах зарчмаар явах дэгтэй. Мөн бүлэг тус бүр асуулт асуух гишүүдээ томилсон байх ёстой.

Ийнхүү Ерөнхий сайдын мэдээллийг сонсож, Монгол Улсын парламентын түүхэнд анх удаа ард иргэдийнхээ асуултад хариулах гэж байна. 20 минутын хугацаанд бол зөвхөн ингээд яриад байх биш бүлгийг төлөөлж асуулт асууж байгаа гишүүн бол 20 минутын хугацаанд хариулагч талтайгаа харилцан ярилцах буюу мэтгэлцэх хэлбэрээр асуултуудыг асууж тодруулж, асуудлын мөн чанарыг товойлгож, ил гаргахад чиглэгдэнэ ээ гэдгийг бас тодруулж хэлэхийг хүсэж байна.

Ингээд Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан таныг мэдээллээ хийхийг, иргэдийнхээ асуултад хариулахыг урьж байна.

Л.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас боловсролын салбарын хөгжлийн дунд болон урт хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэхээс гадна цар тахлаас үүдсэн бэрхшээл, саадыг даван туулах, хоцрогдлыг нөхөх амаргүй нөхцөл байдалд боловсролыг бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

Нэг. Боловсролын чанар, үр дүнд чиглэсэн, иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжсэн боловсролын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдан хэрэгжиж эхэлсэн. Уг бодлогын үргэлжлэл болох “Монгол Улсыг 21-25 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Засгийн газрын 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршийн суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх” зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас Боловсролын багц хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлж эхлээд байна.

Уг хуулийн төсөлд боловсролын салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, чанарыг сайжруулах, суралцагчдад тэгш боломж олгох, Монгол хүний насан туршийн хөгжлийг хангах, боловсролын нийгэм, эдийн засгийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг тусгасан. Тухайлбал:

- Бүх түвшний боловсролын зорилгыг шинэчилж, суралцагчийн цогц хөгжлийг

хангах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил, зан үйлийг тусгах;

- Боловсролын түвшин, шатлалыг олон улсын жишигт нийцүүлэх;
- Боловсролын удирдлагын тогтолцоог шинэчлэх;
- Иргэд насан туршидаа суралцах тэгш боломж сонголтуудыг тодорхой болгож, амьдрах орчны суралцахуйг боловсролын тогтолцооны салшгүй нэг хэсэг гэж үзэх;
- Иргэний эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх, чанарын баталгаажуулалт хийх, мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийг төлөвшүүлэх;
- Монгол Улсын үндсэн хуульд бүх нийтийн ерөнхий боловсрол гэж заасны дагуу заавал эзэмших боловсролыг 12 жил байхаар;
- Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь англи хэл болсноор Монгол хүнийг дэлхийд ур чадвараар өрсөлдөх боломжийг олгох;
- Бүх шатны боловсролын чанарын үнэлгээ баталгаажуулалтыг боловсронгуй болгох;
- Боловсролын сургалтын байгууллагын бүтэц, статус, чиг үүрэг, тэдэнд тавигдах шаардлагыг оновчтой болгон боловсролын байгууллагын удирдлага, засаглалын тогтолцоог шинэчлэх;
- Чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг тусгалаа.

Хоёр. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр

Монгол Улсын хүн амын 31,3 хувь нь залуучууд бөгөөд жилд 16,118 залуучууд гэр бүл болж байна. Улсын хэмжээнд жилд дунджаар 70 мянга гаруй хүүхэд шинээр мэндэлдэг. Залуу гэр бүл болон залуу ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цаашид халамжаас хөдөлмөрт шилжих боломжоор хангахад бага насны хүүхдийг нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах асуудал нэн тэргүүнд тавигдаж байна.

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж, улс орны эдийн засгийн нөхцөл байдал амаргүй байгаа энэ үед Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар түүхэн шийдвэр гаргаж цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай 100 тэрбум төгрөгийг баталж өгсөн нь сугалааны цэцэрлэгийн тогтолцоог халсан үр дүнд хүрсэн арга хэмжээ байлаа. Нэн тэргүүнд хүн ам ихээр төвлөрсөн зайлшгүй зохицуулах шаардлагатай аймаг, сум, нийслэлийн дүүргийн судалгааны дүнгээс харахад нийслэлийн хэмжээнд 2-5 насны нийт 141 мянган хүүхэд

байгаа бөгөөд цэцэрлэгүүдийн хүчин чадал сургах боломжтой хүүхдийн тоо зэргийг тооцоолон үзэхэд нийслэлийн хэмжээнд 34486 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдахгүй сугалааны цэцэрлэгийн тогтолцоо саяхныг хүртэл байсан. Иймд Монгол Улсын Их Хурлын 22 оны 17 дугаар тогтоол, Засгийн газрын 22 оны 218 дугаар тогтоолоор нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг төлөвлөж, 22-23 оны хичээлийн жилээс эхлүүлэн хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Ингэхдээ цэцэрлэгийн зориулалтаар ашиглах байр түрээслэх, төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлж, хоолны зардлын хамт санхүүжүүлэх замаар хувийн цэцэрлэгт нэмэлт элсэлт авах, байгууллагын цэцэрлэг байгуулахад аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, цэцэрлэгийн хүртээмж бага, ачаалал ихтэй ажилд орон сууцны хороолол, хотхоны доод давхарт цэцэрлэгийн зориулалттай тохижуулсан болон засварлан тохижуулсан боломжтой барилгуудыг худалдан авалт хийх, орчин үеийн дэвшилтэт технологи, хийц гэр цэцэрлэгийн зураг төслийг боловсруулж, цомцог гэр цэцэрлэгийг ажиллуулж эхлээд байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд 22 оны 09 дүгээр сарын 01-ний байдлаар 26.643 хүүхэд, 22 оны 12 сарын 31-ний хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нэмэлт 7.755 хүүхдийг цэцэрлэгт хамруулснаар урьдчилсан байдлаар сургуулийн өмнөх боловсролын хамрагдаж чадаагүй байсан 34.486 хүүхдээс 34.398 хүүхэд буюу 99,4%-тайгаар цэцэрлэгт хамруулах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Цогц арга хэмжээний хүрээнд СӨБ-ын сургалт үйл ажиллагаа явуулах материаллаг орчныг нэмэгдүүлэхийн зэрэгцээ багийн хэрэгцээг судалж, шийдвэрлэхээр ажиллаж байна. Урьдчилсан байдлаар нийслэлд 978 багийн хэрэгцээ үүсэж байна. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор цэцэрлэгийн 1000 туслах багийг цахим, танхимаар хослуулсан 2 үе шаттай бэлдэж 1000 гаруй багш нар ажлын байртай боллоо.

Нийслэлд хэрэгжүүлж байгаа энэхүү арга хэмжээ нь хүн ам ихээр төвлөрсөн аймаг, Дархан, Эрдэнэт зэрэг хот, суурин газруудад сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтын асуудлыг шийдвэрлэх туршилага болно гэж үзэж байна.

Энэ хичээлийн жилээс эхлэн хамран сургах тойргийн зарчмаар сургууль, цэцэрлэгийн бүртгэлийг и-монгол цахим системээр зохион байгуулсан нь түгжрэлийг бууруулахад тодорхой нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Гурав. Боловсролын чанар, үйлчилгээний чиглэлээр

Монгол Улсын боловсролын чанарыг дэлхийн улстай харьцуулах, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор олон улсын PISA үнэлгээнд 22 онд хамрагдлаа. Тус үнэлгээнд хот, хөдөөгийн 195 сургуулийн 7300 суралцагчийг түүврийн аргаар сонгон хамруулсан болно.

Энэ удаагийн судалгаанд Монгол Улс анх удаа оролцож байгаа бөгөөд 15 настай суралцагчдын математик, байгалийн ухаан, уншиж ойлгох чадвар болон бүтээлч сэтгэлгээний мэдлэг, чадварыг үнэлэх шалгалт, судалгааг компьютерт суурилсан хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Олон улсын байгууллагаас судалгааны нэгдсэн үр дүнгийн тайланг 23 оны 12 дугаар сард багтаан нийтэд танилцуулна.

Мөн сургалтын чанарыг сайжруулж, тэгш хамран сургах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор багийн цахим хэрэглээний зардал, хичээл практикийн нийт хувьсах зардлын тодорхой хувиар тооцож олгох, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, малчин өрхийн хүүхдэд итгэлцүүрээр тооцож нэмэгдүүлж олгох зохицуулалтыг хувьсах зардалд тусгасан болно. Энэ нь боловсролын чанар тэгш хүртээмжтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдэх боломжийг бүрдүүлж байна.

Сургалтын чанарт бодитой ахиц гарч ЕБС-ийн суралцагчийн сурлагын амжилтыг 2021 оны 9 дүгээр сарын амжилттай харьцуулахад 30 хүртэлх хувиар нэмэгдсэн үр дүнтэй байна.

Аж үйлдвэрийн 4-р хувьсгал, боловсролын цахим шилжилт зэрэг дэлхий нийтэд нийтлэг олон сорилт шийдлээ хүлээж байна. Тэдний дотор бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийн чанарыг сайжруулах асуудал зүй ёсоор багтдаг.

1998 оноос хойш бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр богино хугацаанд 5 удаа өөрчлөгдөж ирсэн нь агуулгын маш их давхцал, төөрөгдөл үүсгэсэн. Үүнийгээ дагаад сурах бичиг ч богино хугацаанд шинэчлэгдэж ирсэн нь багш, эцэг эхийн зүгээс олон шүүмжлэлийг дагуулж байна. Нөгөөтэйгөөр сургалтын хөтөлбөр, сурах бичгээр дамжуулан бид XXI зуунд шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагатай иргэнийг бэлдэж чадаж байна уу гэдэг асуудлыг бид тавих ёстой.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас бага боловсролын 13 хөтөлбөр, суурь боловсролын 22 сургалтын хөтөлбөр, бүрэн дунд боловсролын 30 сургалтын хөтөлбөрийн

хэрэгжилт өнөөдрийн сургалтад ашиглагдаж байгаа 145 сурах бичигт дүн шинжилгээ хийж ажиллалаа.

Боловсролын түвшин, анги хоорондын агуулгын уялдаа холбоо хангалтгүй байгаа. Агуулга, арга зүй нь амьдралд нийцтэй байдалд учир дутагдалтай, үнэлгээ нь хөтөлбөрт туссан шинэлэг агуулгатай зөрчилддөг зэрэг агуулгын болон арга зүйн зөрчил дутагдлууд их байна.

Хөтөлбөрийн арга зүйд сэргээн санах, ойлгох, хэрэглэх түвшний буюу доод эрэмбийн ур чадварыг түлхүү дэмждэг, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх түвшний чадвар буюу дээд эрэмбийн чадварыг дэмжсэн дасгал даалгавар цөөн боловсруулсан байгаа нь үнэлгээгээр тогтоогдоод байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан боловсролын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, үзэл баримтлал боловсруулан түүнийг сургалтын хөтөлбөрт тусгах арга хэмжээний хүрээнд 22 онд сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг шинэчлэх, 24 оноос суралцагчийн нас, хөгжлийн онцлог, авьяас, сонирхол, хувь хүний болон нийгмийн хэрэгцээ, үндэсний соёл, өв уламжлал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг эхлүүлж, цаашид судалгаа, шинжилгээнд суурилан боловсруулж, тогтвортой хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Дөрөв. Хүртээмжээс чанарт чиглэсэн боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын хүрээнд

Төсвийн шинэчлэлийг боловсролын чанарыг хэмжиж, гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоогоор дамжуулан цахим шилжилттэй хослуулан хэрэгжүүлж байна. Хувьсах зардлын санхүүжилтийн зарчмыг шинэчлэн сургалтын үйл ажиллагаанд шууд хамааралгүй зардлыг хасаж, хувьсах зардлын нормативын бүрэлдэхүүнд багшийн хөгжил, танхимаас гадуурх сургалт, судлагдахуун тус бүрээр тооцсон хичээл практикийн зардал, ажил олгогчоос хариуцах эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал, цахим хэрэглээний зардал зэргийг нэмэлтээр тооцож, санхүүжүүлж эхэлсэн.

Багш нарын цалингийн зэрэглэл, шатлалд өөрчлөлт орууллаа. Багш нар ажилласан жилээс үл шалтгаалан цалинжих болсноор суурь цалин 34 хувиар нэмэгдэж, багш мэргэжлийн нэр

хүндийг өсгөх, нийгмийн баталгааг нь хангах нөхцөл бүрдэж эхэлж байна.

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны шинэчлэлийг хэрэгжүүлж байна. Үнэлгээний үр дүнд үндэслэн багшийн гүйцэтгэл сул эсвэл хангалтгүй байгаа үзүүлэлтийг тодорхойлж түүнд чиглэсэн мэргэжил дээшлүүлэх хөгжүүлэх сургалтыг үндэсний, орон нутгийн болон сургуулийн түвшинд зохион байгуулж эхлээд байна. Багшийн хөгжилд багш бэлтгэх их, дээд сургууль, ахмад багш нар, багш нарын мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагад олон талын оролцоог хангаж байна. Түүнчлэн багшийн мэргэжлийн хөгжлийн зардлаа хэрэгцээндээ нийцүүлэн өөрөө зарцуулдаг, сонгож суралцаж болсон бөгөөд 22-23 оны хичээлийн жилд хувьсах зардлын тодорхой хувийг багшийн мэргэжлийн хөгжилд зориулан зарцуулах боломж бүрдлээ.

Багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах, ажлын ачааллыг гүйцэтгэлд тооцох, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахын тулд хувьсах зардлын бүрэлдэхүүнд ангийн хүүхдийн тооноос хамаарсан нэмэгдлийг шинээр тусгаж, багшийн хөгжлийн зардлыг багш бүрээр тооцон олгодог боллоо.

Хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн эрт илрүүлгийн шинжилгээний багцад ороогүй, багшийн ажлын онцлогоос хамаарсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг баталж хэрэгжүүлснээр өнөөдрийн байдлаар 40,000 гаруй багш нар хамрагдаад байна.

Боловсрол, шинжлэх ухааны салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 22 оны төсвийн жилд нийт 1,4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн жилд санхүүжих 356 тэрбум төгрөгийн өртөг бүхий 430 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Эдгээрээс ерөнхий боловсролын сургуулийн барилга, байгууламжийн 124, цэцэрлэгийн барилга, байгууламжийн 154 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, дундаж гүйцэтгэл 58.2-62.4 хувьтай байна.

Нийт 4 жилийн хугацаанд 200 сургууль, 273 цэцэрлэг ашиглалтад оруулах зорилт тавьсан бөгөөд 20-22 онд 100 сургууль, 123 цэцэрлэг ашиглалтад орох боломж бүрдэж байгаа бөгөөд ирэх 23-24 онд он дамжин хэрэгжиж дуусгахаар төлөвлөж буй 94 сургууль, 128 цэцэрлэгийг байнгын ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Хүн амын өсөлтийг дагаад ерөнхий боловсролын 41 сургуулийн ачаалал эрс өсөж, нийт 261 бүлгийн 12163 хүүхэд 3 ээлжид хичээллэх эрсдэл үүсэж байснаас 12 сургуулийн

169 бүлгийн 6510 хүүхдийн хичээл сургалтыг хувийн хэвшилтэй хамтран сургуулийн байр түрээслэн зохион байгуулж байна.

Иймд цаашид улсын хөгжлийн болон бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлт, газар зүйн байриил болон Засгийн газраас тогтоосон нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх жишиг нормативыг үндэслэн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ачаалал, нягтралтай холбоотой газарзүйн мэдээллийн систем дээр суурилсан скүүл майфинг системийг хөгжүүлж, шинжилгээ хийн хөрөнгө оруулалтыг оновчтой болгох ажлыг эхлүүлж байна. Энэхүү системийн тусламжтайгаар нэгдүгээр ангид элсэгчдийн хамран сургах тойргийг хүн амын төвлөрөл, сургууль, гэр хоорондын зай, нийслэлийн замын хөдөлгөөний нягтаршилтай уялдуулан тогтоож байна.

Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн санаачилсан орон нутгийн сургууль, цэцэрлэгийг цэвэр, тохилог ариун цэврийн байгууламжтай болгох санал, санаачилгыг дэмжин хэрэгжүүлж ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хамтран аймгуудаас ирүүлсэн саналуудыг боловсруулан 4 үе шаттайгаар нийт 21 аймгийн 330 сумын 819 төсөл, арга хэмжээ сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг халж, зориулалтын ариун цэврийн байгууламжаар хангах ажлыг Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд 100 тэрбум төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэхээр ажиллаж байна.

Тав. “Үдийн хоол” хөтөлбөрийг “үдийн хоол” хөтөлбөр” болгох чиглэлээр

Ерөнхий боловсролын суралцагчийн оюуны болон бие бялорын өсөлт хөгжлийг дэмжих, хооллох зөв дадал төлөвшүүлэх, тухайн орон нутгийн мал аж ахуй, газар шороонд тарьж ургуулсан болон боловсруулсан хүнсний түүхий эдээр хангах, эрүүл аюулгүй шим тэжээллэг хоол хүнсээр хүртээмжтэй хангах, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог хангах, тэдэнд хоол шим тэжээлийн боловсрол олгох, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан шаардлага хангасан зориулалтын орчинд үйлдвэрлэсэн хоолоор суралцагчдыг тэгш хамруулах зорилгоор Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.

Үдийн хоол хөтөлбөрт ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн суралцагчид үе шаттайгаар хамрагдах ёстой болов чиг ковид цар тахлаас үүдсэн эдийн засгийн

нөхцөл байдлаас шалтгаалан бага ангийн сурагчдыг хамруулж эхлээд байна.

ЕБС-ийн бага ангийн сурагчдад 2006 оноос эхлэн Үдийн цайны үйлчилгээг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 21 оны хичээлийн жилээс Үдийн хоолны үйлчилгээнд шилжүүлсэн. Өнгөрсөн хичээлийн жилд ЕБС-ийн 1-5 дугаар ангийн 371480 хүүхэд улсын төсвөөс Үдийн хоолны үйлчилгээг тэгш хүргэсэн. Гэсэн хэдий ч 21 аймгийн 488 ЕБС-д хоол үйлдвэрлэх үйлчилгээний стандартын орчин бүрдэж чадахгүй байна.

Мөн хоолны газаргүй, сургуулийн барилга дахин баригдаж буй гэсэн нөхцөл шалтгаанаас үүдэн 5 аймгийн 11 сургууль, нийслэлийн 17 сургуулийн 27094 сурагч Үдийн хоолны үйлчилгээнд бас бэлэн бүтээгдэхүүн буюу Үдийн цайны үйлчилгээг авсаар байна.

Түүнчлэн цэцэрлэг, сургууль, дотуур байрын нэг хүүхдэд ногдох хоолны норматив зардал нь авах шаардлагатай илчлэг, шим тэжээлийнхээ 50 орчим хувийг хангаж байгаа нь хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр хангах, тэдний эрүүл мэндийг дэмжих замаар сурч боловсрох эрхийг хамгаалахад эрсдэл учруулж байна.

Цаашид хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хоол хүнсээр хангах орчин нөхцөлийг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тодорхой түвшинд шийдвэрлэх, хүнсний хангамж, худалдан авалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, эцэг эх асран хамгаалагчдын оролцоог хангах зэрэг асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Мэргэжлийн болон дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлага, нийлүүлэлт тэр дундаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах хүчин мэргэжилтнийг бэлтгэх зайлиггүй шаардлага үүсэж байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагыг хөдөө орон нутагт төрөлжүүлж, хөдөө орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Энэ хүрээнд Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Технологийн дээд сургуулийг байгуулсан бол Дархан-Уул, Орхон, Ховд, Завхан, Дорнод аймгуудад төрийн өмчийн их, дээд

сургуулиудыг өөрчлөн зохион байгуулалтад оруулсан. Мөн орон нутаг дахь төрийн өмчийн сургуулиудын суралцагчид сургалтын төлбөрийн 50 хүртэл хувийн тэтгэлэг, зээл олгох, ажиллаж байгаа багш, ажилтны нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэхээр болж байна.

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлтэд нийцүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн индексийг нэвтрүүлээ. Хөтөлбөрийн индексийн шинэчлэлтэй уялдуулан хийсэн судалгаагаар өдөр, эчнээ, экстернат хэлбэрийн 1095 хөтөлбөрийн тусгай зөвшөөрлийг цуцалж, холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангаагүй 13 сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Засгийн газраас дээд боловсролын чанарыг сайжруулах, судалгааны их сургуулийг хөгжүүлэх чиглэлээр төрийн өмчийн 6 их, дээд сургуулийг нэгдсэн удирдах зөвлөлтэй болгож, дундын удирдах зөвлөлийг байгуулаа. Энэ зөвлөл нь их, дээд сургуулийн сургалтын чанар, эрэмбийг олон улсын түвшинд хүргэх, олон улсад өрсөлдөх чадамжтай мэргэжилтнийг бэлтгэхэд төрийн өмчийн их, дээд сургуулиудын стратеги, бодлого, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй юм.

Түүнчлэн мэргэжлийн боловсрол, сургалтын хуулийн төслийг шинэчлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Энэхүү хуулийн шинэчлэл нь мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог бүтээн байгуулалтын томоохон зорилттой уялдуулах, олон улсын жишигт нийцүүлэх, салбар дундын зохицуулалтын олон талын оролцоотой хангах удирдлагын оновчтой бүтэц, чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэ механизмыг бий болгох, сургалтын байгууллагын ангилал, хэв шинжийг оновчтой, үр ашигтай байдлаар тодорхойлох, сургалтын уян хатан хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, сургалтад ажил олгогчийн оролцоог бодитойгоор нэмэгдүүлэхэд чиглэх юм.

Долоо. Боловсролын салбарын цахим шилжилт

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч бие даан суралцах, мэдлэг чадвараа бататгах үйлийг дэмжих, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын тасралтгүй байдлыг хангах, багш хичээл, сургалтыг зайнаас зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ сурах үйлийг дэмжихэд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршидаа суралцах, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий MEDLE.MN сургалтын

нэгдсэн платформыг боловсруулж, 21 онд үйл ажиллагааг нь эхлүүлсэн. 22 оны 9 сарын байдлаар 5017 багш холбогдож, 3642 контент боловсруулах санал ирүүлснээс 1780 хичээл боловсруулалтын үе шатанд байгаа бол 1862 хичээлийг шалгаруулан байршуулсан ба нэг сая гаруй хэрэглэгч хандсан байна.

Боловсролын цахим шилжилтийн хүрээнд салбарын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ЕБС-ийн хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүнд анх удаа цахим хэрэглээний болон тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг тусгаснаар багшийн хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглах Дата хэрэглээний зардал, боловсрол, сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын систем зэрэг сургалтын зориулалттай программ хангамж, системийн эрх, лицензийг хэрэглэндээ нийцүүлэн эрхлэх эрх зүйн болон санхүүгийн зохицуулалтыг бий болгож, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Одоогоор 1153 боловсрол сургалтын байгууллагын багш нар цахим хэрэглээний зардлыг зардлыг ашиглаж эхлээд байна.

Дэлхий нийтээр технологийн дэвшлийг ашиглах сургалтын байгууллагын хэв шинж өөрчлөгдөж байна. Энэ хүрээнд Монгол Улсад анх удаа ерөнхий боловсролын үндэсний цахим сургуулийг хөгжүүлэх эхлэлийг тавилаа. 22 оны 2 дугаар сараас цахим сургуулийг хөгжүүлэх туршилтыг эхлүүлж, 22-23 оны хичээлийн жилд хот, хөдөөгийн 15,000 орчим 10 дугаар ангийн суралцагч ирээдүйд эзэмших ажил, мэргэжлийн дагуу хичээлээ сонгон цахимаар судлах боломж бүрдлээ.

Түүнчлэн цахим сургуульд гадаадад оршин суугаа Монгол хүүхдүүд эх хэлээ сурах, түүх, зан заншил, соёлоо уламжлан өвлөх, ерөнхий боловсрол дүйцүүлэн эзэмших боломжтой байна. Өөрөөр хэлбэл, цахим сургууль нь ирээдүйн сургалтын байгууллагын шинэ хэв шинж, загвар болон хөгжих юм.

Боловсролын салбарын цахим шилжилтийн туршилагаа олон улсад таниулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 22 оны 9 сарын 16-19-ний өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан Нэгдсэн үндэстний байгууллагын “Хувьсаж буй боловсрол” чуулганы үеэр тусгай арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Чуулганы 9 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанд Монгол Улс боловсролын цахим шилжилт, суралцагчдад тэгш боломж олгосон сайн туршилагаараа дэлхийн “Champion” орнуудын нэг болсныг Нэгдсэн үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас албан ёсоор зарласан болно.

Дээрх шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлөө Монгол Улсын Засгийн газар цаашид хичээн ажиллах болно.

Анхаарал тавьсанд маш их баярлалаа.

Г.Занданишатар: Мэдээлэлтэй холбогдуулж цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлж, асуулт асууна.

Үүний өмнө байж байгаарай, түр.

Зочдоо танилцуулчихъя.

Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2001 оны төгсөгчид, 52 дугаар сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг хүчээ ерөөе. Эргэн дурсах уулзалтад нь их амжилт хүсэн ерөөе.

О.Цогтгэрэл: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн боловсролын салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, үр дүн сэдвээр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хийсэн мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс хийсэн дүгнэлтийг танилцуулж байна.

Боловсролын салбар болбол тоон үзүүлэлт талаасаа нэг сая илүү суралцагч, 100000 багш, ажилтантай буюу хүн амын гуравны нэг нь шууд оролцдог. ДНБ-ий 4 хувь, улсын төсвийн зардлын зургааны нэгийг эзэлдэг том салбар. Нөгөө талаасаа ирээдүйд бид тусгаар байж, дэлхийн газрын зурагт тэмдэглэгддэг бодлогыг тодорхойлдог улс байх эсэхийг Монгол хүн дэлхий дахинтай хүн төрөлхтөнтэй хэрхэн өрсөлдөж, хөдөлмөрийн хуваарийнх нь хаана байриших өрсөлдөөнийг заадаг чухал салбар. Гэвч ийм чухал ач холбогдолтой салбарт сүүлийн 30 жилийн дийлэнхэд нь бодлого хэрэгжүүлсэн, түүний сүүлийн 6 жилд нь үнэмлэхүй олгохоор эрх барьсан Засгийн газруудын хэрэгжүүлсэн шинэчлэл, түүний үр дүн нь бас туйлын хангалтгүй байна. Хүртээмжийг сайжруулах буюу хөрөнгө санхүүг нэмэгдүүлэх, тууз хайчлах, алга ташуулахад л анхаарснаас биш боловсрол, сургалтын чанарыг ахиулах, бодит үр дүн гаргах, шинэчлэл хийх талаар олигтой ахиц гарахад анхаараагүй байна гэж бид үзэж байгаа.

Мянган жилийн өмнө сайн эрийн булчин шандаст морины хүчээр дэлхийн дайдыг эзэлж болдог байсныг бид мэднэ ээ. Харин өнөө цагт дэлхий дахин аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал, автоматажсан үйлдвэрлэл, технологи, инноваци буюу оюун ухаанаар эрдэм боловсролоор л өрсөлддөг цаг ирсэн. Хүн ам ихтэй улс оронд масс үйлдвэрлэлийг хөгжүүлбэл хэрхэн хөгжиж болдгийн жишээг бид өмнөд хөршөөсөө харж болно. 2020 оны байдлаар тэдний нэг хүнд ногдох дотоодын нийт нийт бүтээгдэхүүн 10000 долларыг давсан статистик байгаа. Гэтэл биднийх 4000 доллар. Тэд тэрбум хүнтэй, бид гурван сая хүнтэй. Нийт экспортын маань ер гаруй хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн, улс орнуудын эдийн засаг, үйлдвэрлэлд мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувь, үнэ цэнэ, өдөр өдрөөр бол үлэм нэмэгдсээр байхад биднийх улам бүр уруудаж, уул уурхай, нүүрс, зэсээс хамааралтай болсоор байна. Энэ бол бид хөршүүдээсээ хэд дахин илүү бага мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн ганцхан тоо жишээ.

Хүн ам цөөтэй, улс орон, оюун ухаан, эрдэм боловсролыг л дэмжиж байж сая хөгжиж болдгийг хөгжссөн орнуудын олон жишээнээс бид бэлхнээ харна, харж болно.

Монголчууд бид цөөхүүлээ. Ийм учраас бид цаашид амьд үлдэж, улмаар дэлхийн бодлогод бас тодорхойлолтод нь оролцохын тулд булчингаа биш тархиа хөгжүүлэх нь зүйн хэрэг ээ. Энэ эдийн засгийн гажгийг засах хүч, үүрэг зөвхөн бараг боловсролын салбарт л ноогдож байна. Гэтэл хангалттай хугацаанд үнэмлэхүй засаглаж буй эрх баригчдын боловсролын салбарт хийж буй шинэчлэл, бүтэлгүйтлийн тод жишээ бараг л алдарт Дархны замыг барьж буй хурднаас ч удаан байна.

Улаанбаатарын түгжрэлээс ч илүү түгжээ боловсролын салбарт бас хуримтлагджээ. Эдийн засгийн бүтцээ эрүүлжүүлж, мэдлэг оюун технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шинжлэх ухаан, технологийн оновчтой бүтэц нэн чухал үүрэгтэй. Гэтэл ШУА-ийн шинэчлэл, тогтолцооны өөрчлөлтөөс Засгийн газар тойрч бултсаар одоо ч бас зугтаасаар л байна. ШУА-уудыг судалгааны их сургууль болгох, либералчлах, бие даалгах тэргүүтэй шинэчлэлт өөрчлөлт хийж, олон улсын жишиг, сайн туршилагыг судлан хэрэгжүүлэх ажлыг салбарын яам мартаад 6 жил өнгөрлөө. Ахиад мартаж болох бараг ганц ч өдөр үлдээгүй ээ.

Үйлдвэрлэлд нэвтрэх үнэ цэнээ өсгөх, шинжлэх ухааны туршилт, инновац технологиор Монголын бизнесүүд үүнийг нь бүтээх боломжоор эрдэмтэд өсөж байна. Академи тойрсон хэдэн эрдэмтэд ажиллах, бүтээх

боломж өгдөггүй багахан төсвөөр алийн болгон аргалж, эрдэмтдээ, ШУА-ийн салбараа ч, бизнесүүдээ ч бид одоо авсаар байх вэ.

Уул уурхайгаас олсон мөнгөө уралдаж тараадаг халамждаа идүүлж буй эдийн засгийн бүтэц бол дараагийн сонгуульд яаж ялах вэ, улс төрийнхөө насыг яаж уртасгах вэ гэдэг урхагтай бодлогын л үр дүн. Яг энэ бодлогыг их дээд сургуулиуд дээр бас тасралтгүй бид явуулсан, үр дүнд нь бүгд диплом цуглуулсан ч хөдөлмөрийн зах зээл дээр гараад өрсөлдөх чадваргүй байгааг олон нийт хэлдэг. Ажилд авсан газар нь ахин мэргэшүүлдэг, зарим нь гадаад руу явж дахин сурдаг, ихэнх нь тэс өөр, дээд боловсрол шаардлагагүй ажил хийдэг нийтлэг дүр төрх бий болоод багагүй хугацаа өнгөрлөө.

Халамж чанаргүй, дээд боловсролтой нийлснээр бий болсон хөдөлмөрийн зах зээлийн бүхий л салбарт хүндрэл бэрхшээлийг дагуулж байна. Энэ бол улс төрчдийн гар хөл болсон агентлаг, яамны дарга гэх мэт амьгүй албатуудын төрийн өмчийн их, дээд сургуулиудын ТУЗ-д оруулж, дээд боловсролыг зах зээлийн механизм руу нь шилжүүлэхгүй бол либералчлахгүй удсаны гор оо. Төрийн оролцоо багассан цагт дэлхийн өнцөг булан бүрээс эрдэмтэн профессоруд ирж багшилдаг, оюутнууд ирж суралцдаг болж, их дээд сургуулиудын эрэмбэ жагсаалтад Монголын сургуулиуд багтдаг болно оо.

Дунд сургуулиудын орчин, хичээлийн болон дотуур байр, ариун цэврийн асуудал зэрэг материаллаг асуудлууд руу энэ ЗГ-ын хичээл зүтгэл бас гаргаж байгаа. Гэвч сургалтын хөтөлбөр, арга зүй, мэргэжлийн багшийн хангалт зэрэг дээр туйлын хангалтгүй байна. Тархи бол мэдлэг үйлдвэрлэх машин, боловсрол бол мэдлэгийг үйлдвэрлэхэд шаардлагатай оюуны үйлдлүүдийг алдаа мадаггүй, ажиллуулах чадвар гэж үзэх хандлага дэлхий нийтэд ноёлж эхэллээ. 30 жилийн өмнө сурсан мэдлэгээрээ нэг насаараа ажиллаж, хөдөлмөрлөж болдог байсан бол хувьсал өөрчлөлтийн хурд асар их өнөө цагт суралцах арга зүйг системтэй олж авах нь нэн чухлаар тавигдаж байна аа.

Бүх хүүхдэд ижил мэдлэг олгож, адил шалгуур тавьж шалгадаг хуучны социалист маягийн боловсролын хэв маягаас татгалзаж, хувь хүүхэд бүрийн онцлог ялгааг хөгжүүлэхэд чиглэдэг, боловсролын тогтолцоо руу бүх нийтээрээ шилжиж, хүн ам цөөн улсын иргэн бүр хөри болоод дэлхийн улсуудаас илүүгээр ур чадвараа хөгжүүлэх суурийг тавихад анхаарах шаардлага нэн ихээр тавигдаж байна.

СӨБ-ын байгууллагуудын хүртээмжийг нэмэх сугалаагаар биш цэцэрлэгт орох боломжийг бүрдүүлэх гэх мэтээр суурь ажлуудад

идэвх санаачилга ажиллаж буйг сайшаах нь зүйн хэрэг ээ. Хүүхдийн сурлагын амжилт, орчин нөхцөлд сайн багш, асран хамгаалагчийн дэмжлэг, сайн хөтөлбөрийн огтлолцол дээр л явагддаг. Иймээс багш мэргэжлийн үнэлэмж, үнэ цэнийг өсгөх сайн хөтөлбөр, арга зүйг сонгож, тууштай хэрэгжүүлэхэд улам их анхаарах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Чуулганы хуралдааныг сонсон суугаа Монгол Улсын иргэд ээ, эрчим хүч, зам тээвэр, эрүүл мэнд, эдийн засаг, уул уурхайн салбаруудад урхаг болсон олон асуудлууд буйг бусдаар хэлүүлэлтгүй бид бүгд мэднэ ээ. Тэр болбол даваад гарах, туулаад өнгөрч чадах өнөө цагийн өнөөдрийн асуудлууд аа. Харин тэднээс хэд дахин илүү том асуудал, тогтолцооны дампуурал, боловсролын салбарт байгаа. Үүнийг шийдэлгүйгээр шинэчлэл, өөрчлөлт, тогтолцооны шинэчлэл хийлгүйгээр Монголчууд бидний өмнө гэгээлэг, ирээдүй, итгэлтэй маргааши гэж байх боломжгүй гэдгийг бас дахин сануулья.

Ганц хоёрхон ажил хийгээд өргөс авсан юм шиг өөгүй болчихдог, өнөөдөр хийгээд маргааши сайхан болчихдог тийм салбар бас өөрөө боловсролын салбар биш. Харин ийм мэтээр нийгэмд ойлгуулж, дараагийн сайд, засаг нам нь өмнөхөөсөө илүү олны таашаалд нийцэхүйц шийдэл санаачилгуудыг гаргахгүй бол болдоггүй жишээг эвдэж урт хугацааны тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх үүрэг энэ Их Хуралд бас ноогдож буйг бас сануулья.

Эдийн засгаа эрүүлжүүлэх, эрчимжүүлэх, шинэ сэргэлтийг жинхэнээсээ эхлүүлэх, улс орны тусгаар тогтнолыг улам бүр баталгаажуулах хүч ганц боловсролын салбарт, магадгүй бий. Сайд нь явсан ч сайн ажил шинэчлэл нь үлддэг, нам нь солигдсон ч бодлого нь солигддоггүй, аргалж гал унтраасан, алга ташилтаар ажил нь үнэлэгддэг биш, чигээ болгон барьж буй бодлогыг хэрхэн хэрэгжүүлснээрээ хэмжигддэг, тийм жишгийг тогтооход санал санаачилга гарган ажиллаасай гэж салбарын сайд, Ерөнхий сайд, Засгийн газар, эрх баригчдаас бид хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинэжлэх ухааны сайд, БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Лхагвын Цэдэвсүрэн, БШУЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга Бандийн Гантулга, БШУЯ-ны Дээд болон Мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга Хөжөөгийн Тамир, БШУЯ-ны Санхүү хөрөнгө

оруулалтын газрын дарга Огноогийн Хуягцогт, Боловсролын ерөнхий газрын дарга Төмөр Очирын Ням Очир.

Мэдээлэлтэй холбогдуулж шууд бүлгүүдээс асуулт асууж, үгийг хамт явуулах уу тиймээ.

Тэгээд Ганбаатар гишүүнтэй асууж болох байх, бүлэггүй гишүүдээс.

Асуулт асуух гишүүд байна уу? Цөөнхийн Ганбаатар гишүүн асууна.

Ингэвэл цөөнхийн бүлгийг төлөөлж хүн асуухгүй нь байна шүү.

Цэвэгдоржийн Туваан гишүүн. Пүрэвдорж гишүүн асуухгүй боллоо шүү.

Ц.Туваан: Энэ дээр тодорхой хэдэн зүйлийг хэлээд асуултаа асууя. Боловсролын тухай хууль багц хууль ингээд явагдаж байгаа, хэлэлцүүлгийнхээ шатанд парламентаар орж ирчихсэн явж байгаа, тийм ээ. Багц хууль түүн дотроо энэ СӨБ, ерөнхий боловсрол, тусгай мэргэжил, их, дээд гээд ингээд явж байгаа байх. Тэгэхээр энэ хуулийг нэлээн сайн судалгаатай, бас бүх асуудлуудаа аль болох оруулсан байдлаар батлах нь ингэж чухал гэж ингэж харж байгаа. Орон нутагт ажиллаж байхад бол энэ боловсролын салбартай холбоотой бол маш олон асуудлуудыг тавьж байгаа, оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгүүд дээр бас орж саналуудаа хэлсэн. Үүн дээр тодруулж асуухад энэ ерөнхий боловсрол дээр энэ, ялангуяа хөдөө орон нутагт ажиллаж байгаа энэ ХАА-н салбарт ажиллагсдын хүүхдийг 7 настайгаас нь эхэлж, сургуульд хамруулах, энэ асуудлыг бас тусгах саналыг тавьсан. Үүнийг ажлын хэсэг дээр орж хэлсэн байгаа, энэ саналаа. Тэгээд энэ санал бас яг хуульдаа тусгагдаж өгсөн үү гэдэг ийм асуултыг асууя.

Хоёрдугаарт нь, энэ их, дээд боловсрол дээр одоо бид нар энэ их, дээд сургууль дээр бол маш олон залуучууд их, дээд сургуульд элсэн суралцаж байна. Их, дээд сургуулийн тоо хэдийгээр бас 2 дахин буурсан байгаа ч гэсэн бас 90 гаран их, дээд сургууль энэ хичээлийн жилд нээлтээ хийгээд ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ дотор энэ чухал шаардлагатай мэргэжил, ялангуяа Монгол Улс ХАА-н орон, тэгэхээр энэ дээр энэ ХАА-н салбарт ажиллах мэргэжилтэй малын эмч, зоотехник, агрономи гээд энэ хүмүүсийн асуудал нэлээн хүндэрч байгаа. Энэ мэргэжлээр ажиллаж байгаа хүмүүсийн дундаж нас, тэтгэврийн насны доод хэмжээнд хүрээд ирчихсэн. Тэгэхээр энэ чиглэл дээр энэ хууль дээр дэмжлэг үзүүлэх бодлогын асуудал ямар асуудлууд орж ирж байна? Малын эмч, зоотехник, энэ агроном хүмүүсийг бас нэлээн

ээж аав нь энэ салбарт ажилладаг ч юм уу, ийм хүмүүсийг, дээрээс нь тэр Боловсролын зээлийн сангаас тодорхой дэмжлэг үзүүлж, өөрөөр хэлбэл сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байдлаар энэ сувилагч нарыг сургаж байгаа шиг ийм бодлогын байдлаар оруулах ийм асуудал энэ хуульд орсон уу гэдэг ийм асуултыг тавья.

Дээрээс нь энэ сурах бичгийн асуудлыг сая сайдын үгэнд гарч байна. Маш олон төрлийн хоорондоо зөрөөтэй маш олон, 1 жилд мэдэхгүй хэдэн ч янзын сурах бичиг хэрэглэдэг юм. Бид нарыг бол бага сургуульд сурч байхад бараг нэг сурах бичгийг бараг ах дүү нар үеэрээ ингээд л яг адилхан хэрэглээд л ингээд л болдог байсан. Одоо болохоор ингээд жилд болгон ингээд өөрчлөгдөөд, тэгээд ингээд зөрүүтэй сурах бичгүүд гараад байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг бас яаж шийдсэн бэ гэдэг ийм асуулт байна.

Дараагаар нь энэ инфляц, юмны үнийн өсөлт, валютын ханишийн өсөлт чинь шууд энэ сургууль дээр явж байгаа энэ Үдийн хоол хөтөлбөр, дотуур байрны хүүхдийн хоолонд цэцэрлэгийн хоолны хүүхдийн өмнө нь үнэ гайгүй байхад дөнгөн ядаа хүрч байсан энэ асуудал одоо бүр хүндэрсэн. Тэгэхээр яг энэ асуудал улсын төсөв дээр ямар байдлаар хэдэн төгрөгөөр, тодорхой хэлэх юм бол цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгө 2450 гээд л, дотуур байрны хүүхдийн хоолны мөнгө 3450, 3500 орчим гээд ингээд эд нар чинь ялангуяа ахлах ангийн 11, 2 дугаар ангийн том хүүхдүүд дээр энэ хоолны хангамж чинь юу хүрэхгүй байгаа шүү дээ, илчлэг чанар нь. Тэгэхээр энэ асуудлууд төсөв дээр яаж туссан бэ гэдэг асуултад хариулт авъя.

Сургууль гэхээр ганцхан сургуулийн багш нар байдаггүй ээ, энэ дотор үйлчилгээний ажилчид, боловсролын салбарын хамаг хүндийг нуруундаа үүрдэг энэ үйлчилгээний ажилтнууд олон байдаг. Тэгэхээр энэ хүмүүсийн асуудал бол ноднингийн төсөв дээр нэг их эвгүй болж ирээд энэ жил бас гайгүй байрандаа орсон байгаа байх. Тэгэхээр энэ хүмүүсийн нийгмийн асуудал дээр бас ямар бодлого явж байна? Эд нараас гадна нэг хүн үлддэг, тэр нь нийгмийн ажилтан гээд, багш биш, үйлчилгээний ажилтан биш, тэгээд нөгөө нэг цалин авахаар цалин нь бага, нөгөө орон нутгийн нэмэгдэл энэ тэрд хамрагддаггүй үлдчихдэг. Тэгэхээр энэ хүн нийгмийн ажилтнуудын асуудал энэ жилийн төсөв дээр орж ирж байгаа юу гэсэн асуултуудад ... /минут дуусав/

Г.Занданиатар: Энх-Амгалан сайд хариулъя. Лувсанцэрэнгийн Эн-Амгалан.

Л.Энх-Амгалан: Туваан гишүүний асуултад хариулъя. Бас АН-ын саяын унисан дүгнэлт дээр ч гэсэн гол энэ боловсролын салбарын тогтолцооны гажуудал хэзээ, яаж

үүссэн юм, энэ гажуудлаас болж өнөөдөр нийгэм, Монгол Улс ер нь ямархуу хохирол учирч байгаа вэ гэдгийг бас нэлээн тод томруун хэллээ гэж бодож байна, бас олзуурхаж байна. Юунд нь олзуурхаж байна вэ гэхээр бас энэ боловсролыг бид нар нийгмийн үйлчилгээ гэхээсээ илүү энэ эдийн засгийн агуулгаар нь нэг харах байх, одоо цаг нь болчихсон юм байна. Улс орнууд ч ер нь тэгж хардаг боллоо.

Тэгэхээр эрүүл мэнд, боловсрол бол нийгмийн үйлчилгээ биш боловсрол болбол яг цаашаа Монгол Улсын хөгжил дэвшил, эдийн засгаа хөгжүүлэх гол суурь нь болбол энэ боловсрол юм байна гэж харж байгаа. Тэгэхээр өнөөдөр яах вэ, зүгээр ДНБ-ий нэг 4,5 хувь боловсролд зарцуулж байгаа. Энэ жил 23 оны улсын төсвөөр бол урсгал зардлын нэг 14 орчим хувийг зарж байгаа гээд бид нар ингээд ийм тоо яриад байгаа юм. Энэ тоо болбол үндсэндээ болбол бусад улсуудын тийм боловсролоороо тэргүүлдэг улсуудын юунд жишигт хүрчихсэн. Гэхдээ бид нар нэг үзүүлэлтийг харах ёстой, ямар үзүүлэлтийг харах ёстой вэ гэхээр нэг хүнд ноогдож байгаа нэг хүүхэд ноогдож байгаа зардал гэж байгаа юм. Нөгөө нэг хүнд ноогдох ДНБ гэдэгтэй адилхан нэг хүнд ноогдож байгаа боловсролын зардал. Энэ дээрээ бид нар 490000 төгрөг байгаа, долларт шилжүүлэх юм болбол энэ болбол 180 орчим доллар байгаа юм. Тэгэхээр 1 хүнд ноогдож байгаа боловсрол 180 доллар зарж байгаа улс орон болбол хамгийн ядуу улсуудын тоонд ордог юм байна лээ. Гэтэл нөгөө яг эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлж байгаа улсууд чинь нэг хүнд ноогдож байгаа боловсролын зардал нь 8000 доллар хүрчихсэн байгаа байхгүй юу, 8000 доллар. Ингэхээр бид нарын нөгөө нэг Жи Ти Пи ДНБ чинь хэтэрхий бага байгаа учраас бол нөгөө бялуу маань хэтэрхий бага байгаа учраас хэдийгээр боловсролд зарж байгаа мөнгө нь ДНБ-ийхээ 4,5-д хүрчихсэн, урсгал зардлын 13 хувьд хүрчихсэн гээд байгаа мөртөө яг бодитойгоор нөгөө боловсролын чанарыг бий болгодог, нэг хүнд ноогддог зарцуулагдаг тэр боловсролын юу маань, төсөвт мөнгө маань хөрөнгө маань бол ийм ядуу буурай орнуудын түвшинд байгаа шүү гэдгийг бас бид нар нэг тодорхой ойлгож, мэдэрч, энэ дээрээ нэг дүгнэлт хийх ёстой болов уу гэж бодож байна.

Туваан гишүүн ээ, 7 насны хувилбар болбол одоо ч гэсэн хуулиараа эрх зүйгээрээ нээлттэй байгаа, малчны хүүхдүүд 7 насанд орох. Гэхдээ бид нар болбол аль болохоор дэлхийн улс орнууд хүүхдүүдээ сургуулийн насаа аль болохоор доошлуулж байгаа шүү дээ. Одоо бид нар чинь 6 болголоо, бусад улс орнууд бүр 5 болгож байна. Тэгэхээр хүн нэг сургуульд, нэг хүүхэд 1 жилд сургуульд сурсан хэмжээнээс хугацаанаасаа шалтгаалаад ирээдүйн мэргэжлийн сонголт, ирээдүйн амьдралынх нь орлого нэмэгддэг ээ гэдгийг бол дэлхий нийтээрээ

хүлээн зөвшөөрчихсөн. Ер нь Хүний хөгжлийн индексийн гол 3 үзүүлэлт нь эрүүл мэндийн индексийн үзүүлэлт, боловсролын индексийн үзүүлэлт, нэг хүнд ноогдож байгаа ДНБ-ий индексийн хамгийн гол үзүүлэлт буюу боловсролын индексийн гол үзүүлэлт болбол тухайн улс оронд хүүхэд дунд сургуульдаа хэдэн жил сурч байна вэ. Тэр жилийг бид нар нэмж чадаж байна уу, чадахгүй байна уу гэдгээр хамгийн том үзүүлэлтүүд явдаг ийм тогтолцоотой юм байна. Тийм учраас бид нар аль болохоор хүүхдүүдийг бол болбол, бид нар нөгөө 12 жилийн тогтолцоог заавал 12 жилийн тогтолцоонд оруулна гэж зүтгээд байгаа нь бас ийм учиртай юм байгаа юм. Тэгээд цахим бид нарт маш том боломж олгосон, Туваан гишүүн ээ. Тийм учраас болбол бид нар, ер нь энэ танхимын болон танхимын бус сургалт гэдэг энэ сургалтууд боловсролын салбарт шинэ зүйл биш боллоо. Цаашдын чиг хандлага ч гэсэн энэ байх болов уу гэж бодож байна. Тэгээд яг малчдын хүүхдүүд гэдэг юм уу, эсхүл одоо үндэсний цөөнх гэдэг юм уу, эс үгүй бол хөгжлийн бэрхшиэлтэй гэдэг юм уу сурах өөр хэрэгцээ шаардлагатай хүүхдэд зориулсан, яг ийм сурах онцлогт нь зориулсан ийм боловсролын хувилбарт сургалтуудыг гаргаж ирэх ийм боломжууд нь байгаа. Үүнийг бол бид нар үүгээр шийдчих ийм бүрэн боломжууд байх болов уу гэж харж байна.

Их, дээд сургуулиудын өөрчлөлтийн хувьд болбол хэдийгээр хууль нь батлагдаагүй байгаа ч гэсэн бид нар энэ өнгөрсөн 1 жилийн хугацаанд, ер нь яг энэ Монголын их, дээд сургуулиудын тогтолцоонд яг ямар гажуудал гарсан юм бэ гэдгийг нэг ийм зөв оношилъя гэж бодсон. Тэгээд үндсэндээ 8 ажлын хэсэг гарч энэ их, дээд сургуулиудын төгсөгчдийн ажлын байрны асуудлууд, хөдөлмөрийн зах зээлийн асуудлууд, ажил олгогчид ер нь ямар ур чадварууд хүсээд байгаа юм, тэрийг манай их, дээд сургууль төгсөж байгаа төгсөгч нартаа бид нар энэ хөтөлбөрөөрөө, мэргэжлийн индексээрээ, багийнхаа ур чадвараар дамжуулж хүргэж чадаж байна уу гэдэг нэг ийм үнэлгээ, дүгнэлтүүдийг хийсэн. Энэ дээр болбол үнэхээр харамсалтай үр дүн гарсан байна. Одоо их, дээд сургууль төгссөн 6 хүүхдийн дунд нэг л ажлын байр оногдож байгаа шүү дээ. Гэтэл мэргэжлийн боловсрол төгссөн, коллеж төгссөн 2 хүүхдийн дунд нэг ажлын байр оногдож байгаа юм. Яг ингэхээр нөгөө манай их, дээд сургууль чинь өөрөө дипломгүй ажилгүйчүүдийн армийг бэлддэг ийм тогтолцоо болсон. Үүнийг бид нар хүлээн зөвшөөрөх ёстой, хүлээн зөвшөөрөх ёстой.

Тэгэхээр бид нар болбол зайлиггүйгээр нэг хэдэн их, дээд сургуулиудыг нийлүүлээд эс үгүй бол хэдэн их, дээд сургуулиудын лицензийг цуцлаад ингээд их, дээд сургуулиудын реформ гэж ... /минут дуусав/

Г.Занданишатар: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ жил бол цэцэрлэгийн асуудлыг бол шийдсэн байгаа, энд бол бас сайн шийдсэн гэж үзэж байна. Тэгэхээр иргэдээс болбол ирсэн гомдол бол эрс багассан.

Одоо сургуулийн бага сургууль дээр нэг том санал байна. Үүнийг яамныхан сайн хамтарч ажиллаад дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна. Энэ юу вэ гэвэл бид нар 100 жилийн өмнө, 50 жилийн өмнөх энэ бага сургуулийн боловсролыг харах өнцгөөсөө жосоохон өөрөөр хандмаар байна л даа. Нэг газар нэг юм сургууль барьчихаад л тэр нь бүх хүн энэ хотын хэдэн талаас л хүүхдээ зөөдөг энэ асуудлыг жосоохон өөрчлөөд энэ Улаанбаатар хотод нэгдүгээрт түгжэрэл маш их байна. Зам тээврийн осол маш их байна. Ялангуяа бага ангийн хүүхдүүд их өртөгдөж байгаа. Тэгэхээр манай БГД дээр гэхэд маш олон том том хорооллууд бий болчихсон нэг ч сургууль байхгүй. Тэгэхээр эд нар сургууль барих асуудлыг бол бид нар хувийн хэвшилтэй яриад хөөцөлдөж байна. Тэр сургуультай болтол энэ бага ангийн хүүхдийг аль болохоор хотхонд нь тэр байрыг нь түрээслээд сургадаг энэ тогтолцоог жосоохон нэвтрүүлэх гэж оролдооч ээ л гэж би бас хүсээд байгаа юм. Өөрөөр хэлбэл манай Алтай хотхоны нэг 100, 200 хүүхэд энэ хэдэн гудамж өнгөрөөд л хэчнээн бараг гүүр гараад л өөр сургуулиудад явж байхын оронд ч маш их түгжэрэл үүсгэж байгаа юм. Түүний оронд тэнд харин багш нь нүүж очоод, тэр сургуулийнх нь салбар нь нүүж очоод, тэгээд хотхонд нь тэр бага ангийн хүүхдүүдийг сургачихмаар байна. Бага ангид бол ерөөсөө нэг багш л зааж байгаа, тэгэхгүй бол эцэг эхчүүдийн өнөөдөр гол стресс юу гэхээр өглөө яаж хүүхдээ зөөх вэ? Өдөр яаж хүүхдээ авах вэ? Ингээд ажлын бүтээмж нь муу. Хотхон дотроо байх юм бол энэ чинь шал өөр. Тэгэхээр энэ бага сургууль, цэцэрлэгийн цогцолборыг ер нь энэ хотхонд нь шийддэг асуудлыг нэг хамтарч ажлын хэсэг гаргаж сайхан шийдэж өгөөч ээ.

Гэр хороололд бол бас энэ асуудал нэлээд байдаг юм. Сургуулиасаа хол, тэгээд л тэр муу б настай амьтны чинь л хар үүрээр л харанхуйд чирээд л сургууль руу нь аваачдаг. Энэ өөрөө их тийм түгжэрэл ихтэй үед бол их төвөгтэй асуудал. Тэгэхээр энэ стресс бухимдал, хүмүүсийн амьдралын чанар буурч байгаа асуудал чинь ерөөсөө л энэ шүү дээ. Тийм учраас үүнийг нэг сайхан хамтраад шийдэх гэж оролдоё оо, стандарт гаргая, хамаагүй хотхонд нь тэр эцэг эхчүүдийг нь хуралдуулаад санал авъя. Үгүй ээ, тэгээд тэр 30, 40 хүүхдийг заавал зөөж байхаар л тэр нэг багш нь ирээд л тэр хотхоны багш юм уу ирээд л зааг л даа. Энэ чинь хамаагүй их амар болчихоод байгаа юм аа. Үүнийг судалж өгөөч ээ.

2 дахь асуудал бол энэ сая МУИС чинь ойгоо хийлээ шүү дээ. Тэгэхээр ер нь дэлхийн их, дээд сургуулиудын жагсаалтад яг хаана явдаг юм бэ? Жишээлэхэд, бид нар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны судалгаа гарсан байна л даа. Та нарын дээд боловсролд авч байгаа зүйл чинь ажлын шаардлага хэр хангаж байна вэ? гэхэд АНУ, Английн сургуулиудыг төгсөгчид бол маш сайн хангаж байна гэдэг нь 60 хувь хариулж байгаа. Солонгосынх, Японых нэг 30 хувьтай. Тэгэхээр өнөөдөр Монголд энэ сургууль төгсөөд ажлын байранд очиж байгаа хүмүүсийн шаардлага нь хэр хангаж байгаа юм бэ? Энэ дээр судалгаа байна уу? Нөгөө хуурамч дипломын асуудал та бас нэлээд ярьсан. Тэгэхээр энэ хуурамч дипломын асуудал чинь ер нь юу болоод цаашидаа яах гэж байна вэ? Өөрөөр хэлбэл бага ангийн багшийн, цэцэрлэгийн багшийн, яслийн багшийн орон тоо чинь бас их дутмаг байдаг шүү дээ. Тэгэхээр энд зарим хүмүүс бас нэлээн шүүмжилчихсэн л байсан л даа. Энэ чинь маш их ачаалалтай ажил, тэгээд хүн олон жил заачихсан энэ сайн заачихсан багш нараа ингээд яах юм уу гэдэг ч юм уу? Тэгэхээр энэ дээр ер нь ямар бодлого баримтлах гэж байна вэ?

Дээрээс нь энэ сургуулиудад интернэт сүлжээ энэ цахимжлал дижитал орчин чинь ер нь хэр хөрөнгө оруулалт хийгдэх гэж байна? Хэр явж байна вэ? Бид нар яг өнгөрсөн зууныхаа л юугаар ингээд л нэг хуучин арга барилаасаа л салмаар байх юм. Энэ дээр ямаршүү харцултыг өгөх вэ? Ийм 3 асуулт байна.

Г.Занданишатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Одонтуяа гишүүн их тийм зөв санаачилга гаргаад байгаа юм. Тэгээд энэ Одонтуяа гишүүний санаачилгыг бас бид нар энэ жил энэ шинэ хичээлийн жилд бас нэг туршиж үзье, бас нэг зөв жишиг гарах юм байна гэж хараад байгаа юм. Юу вэ гэхээр энэ цэцэрлэг, бага сургууль хоёрын цогцолбор хэлбэрээр, ер нь цаашидаа бид нар авч явах нь их зүйтэй юм байна гэж. Тэгэхээр яагаад ингэж байна вэ гэхээр мэдээж олон шалтгаан байгаа. Гэхдээ ерөнхийдөө энэ цэцэрлэг, бага сургуулийн хүүхдүүд чинь гэрийнхээ ойр тойрноос 700 метрээс 1,5 километрээс хэтрэхгүй байх нь аль ч улсад нэг ийм хамран сургах тойргийн зарчим үйлддэг юм байна лээ. Тэгэхээр бид нар энэ жил цэцэрлэг дээр их тодорхой, манай Улсын Их хурал, ЗГ-ын дэмжлэгтэйгээр хийсэн энэ цэцэрлэгийн хүртээмжийн асуудал дээр бид нар ихэд маш том, туршилага хуримтлууллаа, маш том сургамж авлаа, маш том боломж байгааг бид нар харлаа. Тийм учраас цаашидаа бид нар ерөнхийдөө энэ цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор хэлбэрээр ингэж хөгжүүлж, сургуулийнхаа хэв шинжийг нэг зайлигүй харах

ийм зайлиггүй шаардлага байна гэж харж байгаа юм.

Энэ ганцхан Улаанбаатар хотод ч биш, ерөнхийдөө бид нар энэ 330 сум дээр 12 жилийн тогтолцоотой, ингээд ийм үргүй зардалтай, тэгсэн мөртөө нэг ангидаа нэг, 4 тавхан хүүхэдтэй, ингээд тэгсэн мөртөө сурлагын чанар хүсээд байдаг эцэг эхчүүд, асран хамгаалагч нар нь. Нэг ийм асуудлуудыг үнэхээр бид нар чанартай боловсролын тогтолцоог үр ашигтай боловсролын тогтолцоог бий болгохыг хүсэж байгаа болбол бид нар энэ сургуулийн хэв шинжээ ер нь эргэж харах цаг болчихсон юм байна лээ, Одонтуяа гишүүн ээ. Тийм учраас бид нар энэ Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа боловсролын хууль дээр энэ сургуулийн хэв шинжийн асуудлуудыг бид нар хөндөж тавьж байгаа. Ийм эрх зүйн шинэчлэл зайлиггүй хийх шаардлагатай байгаад байгаа юм.

Яах вэ, энэ гэр хорооллууд дээр ч гэсэн энэ жил бид нарын хийж хэрэгжүүлж эхэлсэн та бүхэн бас нэг очоод үзчихээрэй, энэ цомцог гэр гэж нэг яриад байгаа шүү дээ. Энэ чинь гэр биш байхгүй юу. Энэ чинь ерөөсөө орчин үеийн технологитой гэр хэлбэрийн байшин сууц, арай жаахан хялбар хийцээр барьсан байшин гэж хэлж болох юм уу, тийм ээ. Ийм хэлбэрийн байшин юм. Тэгэхээр энэ нь байшин бол маш их үр дүнгээ өгч байна. Одоо бид нар зөвхөн 150 хүүхдийн цэцэрлэгийг 460 сая төгрөгөөр барьж болдог юм байна гэдгийг бид нар үүгээр үзүүлж байна шүү дээ. Тэгэхэд та хотоос сонгогдсон гишүүн, зуун хүүхдийн цэцэрлэгийг хэрэв төсөв дээр тавих юм бол хамгийн багадаа газрын үнэ нь ороод бараг 2,5-3 тэрбум төгрөг, тэгээд 3 жил барина тийм ээ. Тэгэхээр бид нарт ийм шинэ технологи, ийм шинэ боломжууд гарч ирж байгаа учраас нөгөө талаасаа хөрөнгө оруулалтын үр ашгаа ч гэсэн бид нар хармаар юм байна лээ, хөрөнгө оруулалтын үр ашгаа. Тэгэхээр бид нар нэгэнт энэ цомцог гэрийг, цэцэрлэгийн хүртээмжийн хэлбэрээр ингээд шийдэж болж байгаа учраас цаашидаа ер нь цомцог гэрээ үргэлжлүүлээд ингээд гэр хороолол болон энэ төвлөрсөн хорооллуудын нэг давхарт хийж байгаа цэцэрлэгүүдийг бага сургууль хэлбэрээр ингэж хийх ийм бүрэн боломж байна, ийм хэрэгцээ шаардлага ч байна гэж харж байгаа. Энэ дээр тантай хамтарч ямар ч байсан энэ жишиг цэцэрлэг, бага сургуулийн цогцолборыг бас нэг ажиллуулж үзье ээ гэсэн ийм туршилтыг бас энэ намар эхлүүлье гэж ярьж байгаа. Үүнийг та бид 2 ярьсан.

2 дугаар асуудал болбол энэ МУИС-ийн рейтинг эрэмбэ чансаа хаана явна вэ гэж. Энэ сая дэлхий нийтээрээ нэг ойлгосон зүйл болбол ерөөсөө энэ их, дээд сургуулиудын энэ эрэмбэ чансаа гэдэг чинь хэтэрхий их тийм мөнгөний араас хөөцөлдсөн ийм арилжааны тогтолцоо

болчихсон юм байна. Тэр Таймс, QS энэ тэр гээд ангилдаг эрэмбэ ийм бизнес болчихсон юм байна гэж харж байгаа юм. Тэгэхээр ерөөсөө их, дээд сургуулиудыг бид нар энэ эрэмбэ чансаагаар нь эрэмбэлэгддэг биш, их, дээд сургуулиуд, үндэсний их, дээд сургуулиуд яг тухайн улсынхаа хөгжилд яг ямар хувь нэмэр оруулж байгаа юм бэ? Нөгөө ганцхан Ти чин одоо нөгөө зөвхөн оюутны төлбөрөөр амьдардаг, их, дээд сургууль биш, судалгаа шинжилгээ хийдэг, аж үйлдвэртэйгээ энэ нь холбогддог, сургалт судалгаа, аж үйлдвэрийн гуравласан холбоон дээр явагддаг энэ тогтолцоо руу шийдэх нь чухал юм байна. Тийм учраас МУИС өнөөдөр 3600-д өнөөдөр эрэмбэлэгдэх нь бид нарын юу биш, өндөр зорилго эрэмбэ биш, тэрийг бид нар 1000 руу оруулах, 1500 руу оруулах өнөөдөр тийм тулгамдсан асуудал би биш гэж бодож байгаа юм. Өнөөдөр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Санхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энх-Амгалан сайдад нэг 2 гол асуулт байгаа. Түүний өмнө ярихад бол яах вэ боловсролын салбараараа бид 30 жил тоглосон улсууд. Үе үеийн сайд нарт бас сайн ч юм бий, муу ч юм бий. Зүгээр ерөнхий дүгнэлтээрээ бол аль ч улс боловсролын салбараараа л гаднынхнаар тоглуулж болохгүй. Бид бол ёстой зүгээр хүүхдийн тоглоом шиг тоглуулсан улсууд. Бид ирээдүйгээрээ тоглуулчихсан. Тэгээд энэ салбар дээр Энх-Амгалан сайдын нэг сайн зүйл бол реформ хийх гэж оролдож байгаа. Энэ хүүхдүүдийн мөрөөдлөөр ээж, аавын сэтгэл мөрөөдлөөр залуучуудын ирээдүйгээ сайхан болгоё гэсэн мөрөөдлөөр мөнгө хийдэг энэ аймшигтай тогтолцоо болчихсоныг засах гэж оролдож байгаа. Энэ бол аймшигтай хэцүү. ЕБС хувийн ЕБС гэж Англи 7 жилийн өмнө тэрийгээ халчихсан. 2 жилийн өмнө Энэтхэг түүнийгээ зогсоож байна. Боловсрол бол хэн аав нь хэнд, хэр зэрэг мөнгөтэй вэ гэдгээс хэр боловсрол эзэмших вэ гэж шалтгаалдаг биш, тэр хүүхэд авьяастай юу, тэр хүүхэд хичээл зүтгэлтэй юу гэдгийг боловсрол дэмждэг тийм тогтолцоо руу бид орох ёстой. Одоо бол аавынх нь данс дахь мөнгө өнөөдөр Монголын боловсролын тогтолцооны шалгуур болчихсон. Оролдлого хийж байна. Аймшигтай мөнгөний улайрсан, өмнөх 30 жилийн Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ хувийн сургуультай, хувийн ЕБС-тай, хувийн их, дээд сургуультай, нүдний булай. Өөр орон ийм байвал ичиж үхмээр байдал орно.

Тэгээд миний хүүхдүүд бүгд улсын сургуульд явдаг, Их Хурлын гишүүдийн, нийгмийн зүтгэлтнүүдийн хүүхдүүд улсын сургуульд явдаг байгаасай гэж би хүсэж байна. Энэ улсын сургуулийн зовлонг зүрхэндээ ойрхон авч байх ёстой. Тэгэхээр миний хэлэх гээд байгаа хэдэн зүйл бол нэгдүгээрт энэ асуудлыг сайн уншлаа.

Энэ 23 онд боловсролын салбарын ажилтнуудын цалин нэмэгдэх үү? Одоо наана чинь ажиллах хүнгүй боллоо. Намайг үйлдвэрчний ерөнхийлөгч байхад багш, эмч нарын цалинг нэмсэнээс болж юмны үнэ өсчихлөө гэж дандаа зовоодог байсан, одоо юмны үнэ чинь талийчихсан, та нар зүгээр ЕБС-ийн цэцэрлэгийн ЕБС-ийн тогооч нарын цалин 528520 төгрөг, 400 гаран мянган төгрөгийг нь гар дээрээ авч байгаа. Энэ хүнийг яаж сар ажиллуулах вэ, ямар сайн хоол өгөх вэ, бидэнд ямар баталгаа байна. Тэгэхээр би сайдаас асуух гэж байгаа юм гэвэл яг хэдэн төгрөгөөр нэмэгдэх юм, тогоочийн цалин 528-аасаа яг хэд болох юм. Одоо энэ төсөв дээр орж ирж байгаа, авч болохгүй, хаяж болохгүй худлаа заалтууд байгаа. 20-80 хувиар нэмэгдэх боломжтой, үгүй ээ, мөн худлаа ярьж байгаа юм шүү. Ирэх жил ч гэсэн ингэж ярьж байсан.

Тэгээд тэр багшийн гүйцэтгэлийн үр дүнг хэчнээн үзүүлэлтээр яаж тодорхойлох юм бэ? Дандаа багш нар дээр очих дарамтууд яг хэдэн төгрөгөөр нэмэгдэх юм бэ? Боловсролын салбарын ажилтнуудын цалин. Нэмэгдэх биш шүү дээ, энэ Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн энэ ЗГ-ын эрх баригчдын гайхамшигтай Монголыг будаа болгосны буянаар 30-40 хувийн цалинг нь хулгайлагдчихсан. Тэр 30-40 хувийн карман дотроо байхдаа цалин нь хулгайлагдсан мөнгийг буцааж өгөх үү л гэж асууж байгаа шүү дээ. Цалин нэмэх тухай биш, цалингийн алдагдсан боломжийг нь буцааж Засгийн газар өгөх үү? Миний нэгдүгээр асуулт.

2 дугаар асуулт. Сургуулийн энэ хүүхдийн, би гол юм руугаа орчихёе, цаг явах гээд байна. Одоо боловсролын багц хууль орж ирж байгаа. Энэ хэдэн олигархуудын гараас мөнгө хийдэг, энэ хүүхдүүдийг мөнгөний нүдээр хардаг ЕБС-ийн байна уу их, дээд сургуулийн энэ аймшигтай тогтолцоог болиод нэг улс байна даа, боловсролоо хүүхдүүддээ ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийдэг энэ яг үзэл баримтлал Ундрам гишүүн, 2 Мөнхцэцэг гишүүн эд нар их дэмжиж орж ирж байгаа. Энэ ... /минут дуусав/

Г.Занданиатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Боловсрол бол үндэсний аюулгүй байдлын асуудал гэдэгтэй тантай санал нэг байна аа. Тэгээд үндсэндээ бол энэ боловсрол чинь өөрөө угаасаа хүний, нөгөө төрмөл эрх гэдэг ийм ойлголттой, хүн төрж л байгаа болбол яг сурах боловсрох эрх нь ингээд энэ Үндсэн хуулиараа төрмөл эрх гэж ойлгодог, ийм болсон учраас бид нарын энэ боловсролын салбарын шинэчлэл дээр Оюун-Эрдэнийн ЗГ-ын шинэчлэлээр хийх гээд оролдоод байгаа нэг асуудал болбол ерөөсөө л хүүхэд бүрд тийм чанартай боловсрол олгох ийм тэгш боломжийг л бид нар олгоё оо. Өнөөдөр Кембрижийн төрийн

өмчийн төсвийн зардлаар Кембрижийн сургуулийн тоог нэмэх нь өнөөдөр бид нар чухал уу, эс үгүй бол нийт 680 сургуулийнхаа төрийн өмчийн сургуулийнхаа боловсролын чанарыг тэгш хүртээмжтэйгээр бид нар дээшлүүлэх нь чухал уу гэдэг л ийм л асуудлын өмнө бид нар тулгараад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас бид нар жаахан яг жаахан ялгаатай харьцаар, ялгаатай ойлгомсоор байгаа юм. Одоо ингээд энэ Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн өндөр төлбөртэй, ерөнхий боловсролын сургуулиудыг бид нар бас ад үзэж болохгүй ээ. Энэ болбол боловсролын салбарын тодорхой ачаалал хуваалцаж байгаа, боловсролын салбарын бас чанарт бас тодорхой нөлөөлөл хийж байгаа ийм тодорхой үүрэг хүлээж байгаа, ачаа үүрч байгаа ийм хүмүүс. Өнөөдөр боловсролын салбарын экспорт Ганбаатар гишүүн ээ, боловсрол хэрэв өнөөдөр, хэрэв өнөөдөр ийм олон улсын хөтөлбөртэй сургуулиуд Монгол Улсад байхгүй байсан болбол өнөөдөр энэ сургуулиудад хувийн сургуулиудад сурч байгаа 40000 хүүхэд өнөөдөр хилийн гадна сурна, хилийн гадна. Өнөөдөр жил бүхэн өнөөдөр бид нар валютын хани ярьж байна, валютын хани бид нар валютын нөөц ярьж байна. Тэгэхэд жил бүхэн, жил бүхэн өнөөдөр Монголчууд хүүхдүүдээ хилийн гадна сурахад 400 сая доллар зарцуулж байгаа юм. 40 сая биш шүү, 400 сая доллар. Тийм учраас бид нар энэ эдийн засгийн өнцөг талаас нь нийгэмд үзүүлж байгаа нөлөө талаас нь бид нар харуулах ёстой.

Би тантай нэг зүйл дээр юу байна, өндөр төлбөртэй их дээд сургууль, өндөр төлбөртэй ЕБС дээр хүүхдийн хувьсах зардлыг бид нар зогсоосон, өнгөрсөн жилээс. 10 сая төгрөгөөс дээшээ төлбөртэй байгаа хувийн ерөнхий боловсролын сургуулиуд дээр хувьсах зардлыг зогсоосон, зогсоосон. Тэгээд энэ хэлбэрээр бид нар бас нэг тийм наанатай, цаанатайхан хандахгүй болбол энэ Англи чинь та хувийн сургуулийн дунд сургуулиудын тогтолцоогоо халчихсан гэж бас ийм иргэдэд ийм буруу мэдээлэл өгөхөө боль оо, боль, тийм ээ. Одоо ингэж, одоо ингээд бидний өмнө бүгдэд нь микрофон байгаа. Тэгэхдээ ард иргэддээ цөмөөрөө зөв мэдээлэл өгдөг больё, ард иргэддээ. Өнөөдөр нэг өдрийн пи ар бид нар чухал биш шүү, нэг өдрийн тийм ээ. Тийм учраас Монгол Улсын боловсролын тогтолцоонд тулгамдаж байгаа асуудлуудаа цөмөөрөө эрүүл саруул мэтгэлцээн л хийе. Эндээс хэн хожих нь өнөөдрийн хэн пи арынхаа оноог цуглуулж авах нь надад 300 дахь 400 дэх асуудал, мэдэв үү, Ганбаатар гишүүн ээ. Үүнийгээ товч ойлго.

Одоо цалин гэж хаширдгаа боль, цалин гэж хаширдгаа. Одоо бид нар үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжиж байгаа.

Чадварлаг багш нар өндөр цалин авна, чадварлаг хамт олон өндөр цалин авна. Бид нар хамгийн багадаа бид нар энэ өнөө энэ жил үр дүнгийн гүйцэтгэл гарах юм бол нийт авч байгаа цалингийнх нь 60 хүртэлх хувь дээр бид нар үр дүнгийн урамшуулал бодож олгох энэ тогтолцоо руу бид нар шилжүүлж байна. Одоо цөмөөрөө ард түмэндээ бүтээмж ярьж л даа. Яагаад Монголын ард түмэн ер нь цагт 1, 2 долларын ийм бүтээмж бий болгодог ийм бага цалинтай ард түмэн болчихсон юм. Яагаад ийм болчихсон юм. Гэтэл бид нар яагаад цагийн 15 доллар, 18 долларын бүтээмж бий болгодог энэ боловсон хүчин, энэ ард түмэн, энэ хүүхдүүдийг бид нар яагаад сургаж чадахгүй байгаа юм. Яагаад ийм тогтолцоог бид нар бий болгож чадахгүй байгаа юм. Ингээд нэг ийм төсөв ярихаар ингээд нэг ийм цалин нэмэхийн төлөө ингээд нэг ийм цээжээ уралдуулж ингэж бие биетэйгээ уралддагаа больё л доо, одоо цөмөөрөө зөв юм руу нь ингээд зөв хийж байгаа юмнуудыг ингээд нэг дэмжээд үр дүн гарч байгаа гээд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Сүмбэр сумын ЕБС-ийн багш, ажилчид, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багш нар та бүхэндээ сурган хүмүүжүүлэх их үйлсэд нь өндөр амжилт хүсье. Боловсролын багц хуулийг сайд өргөн бариад боловсролын шинэчлэл хийхээр ажиллаж байна. Боловсролын асуудлаар бас мэтгэлцээн өрнөж байгаа үед таарлаа. Асуулт, хариултын цаг явж байгаа. Та бүхэндээ сайн сайхныг бас хүсэн ерөөе, Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс.

Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Энэ дэлхийн хөгжилтэй улс орнууд боловсролын салбартаа хөрөнгө сайн зарж, иргэдээ хөгжүүлж чадаж байна л даа. Боловсруулсан, хөгжсөн иргэнтэй улс орон мөн сайхан хөгжиж чадаж байна. Бид боловсролдоо хангалттай хөрөнгө зарцуулж чадахгүй байна. Багш нарт амьдрал нь хүрэлцэх хэмжээний цалин олгож чадахгүй байгаа зэрэг асуудлууд байж байна. Үүнээс зэрэгцээд бас том асуудал бол сурагчдын гол хэрэглээ, сурах бичгийн хүртээмж муу, агуулгын алдаатай байгаа талаараа эцэг эхчүүдээс байнга гомдол ирдэг. Үүнтэй холбоотой нэг 3 асуулт асууя.

Ямар учраас агуулгын болоод хэл найруулгын алдаатай сурах бичиг батлаад хэвлүүлээд байдаг юм бэ? Хэн сурах бичиг агуулгыг баталдаг юм. Илэрхий алдаатай сурагч бичиг хэвлүүлж, сургалтад ашиглаад байгаагийн шалтгаан нь юу юм, хариуцлагыг хэн хүлээх вэ. Сурах бичгийн агуулгын хяналт шинжилгээ хийдэг газар байна уу? Цаашид хэвлэгдээд л

ингээд гарчихсан сурагч бичгээр хичээллээд байх уу, эсвэл солих юм уу. Төсвийн үргүй зарцуулалтын хариуцлагыг хэн хүлээх вэ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хөдөө орон нутагт хамгийн ихээр тулгамддаг асуудал, малчдын хүүхдүүдийн сурах боловсрох орчин нэлээн тааруухан, сурах бичгийн хүрэлцээ муу байгаа. Энэ талаар ямар бодлого барим ажиллаж байна вэ? Бас Улаанбаатар хотод сурах бичгийн хүрэлцээ муу байгаа, энэ талаар бас эцэг эхчүүдээс гомдол ирдэг. Хүртээмжийг нэмэгдүүлэх талаар энэ сурах бичгийн, ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ, сайд аа.

Гуравдугаарт, ковидын цар тахлын үед үүссэн сурлагын хоцрогдлыг арилгах талаар мөн нөхөх арга хэмжээ, үр дүн хэр байна вэ? Хоцрогдлыг арилгаж чадсан уу? Сая бид хөдөө явж байхад ер нь ноднин ковидод бас компьютер, интернэтийн хүртээмж муугаас болоод сурлагын чанар муу болсон гээд л багш нар бас ярьж байна. Энэ талаар бас ямар арга хэмжээ авч ажиллах вэ?

Таныг сүүлд 1 жил ажиллаж байхад бас боловсролын салбарт реформ хийж сайн ажиллаж байгааг бид мэдэж байна, бас ажлыг дэмжиж байгаа. Хөдөөнийхөн ч бас таны ажлыг дэмжиж байна. Тэгээд багш нарын бас нэг сая аймгийн бүх сургуулиудаар орсон. Нийгмийн ажилтан, менежерүүдийн цалин нэмэгдээгүй байна, үүнийг нэмэх талаар ямар бодлого барьж ажиллаж байна вэ? Энэ талаар хариулт авъя.

Г.Занданишатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Бейсен гишүүн ээ, өнөөдрийн нөгөө энэ чуулган дээр хийж байгаа мэдээллээр бид нар энэ сурах бичгийнхээ агуулга, арга зүй дээр ер нь яг ямар асуудлууд үүсчихсэн юм бэ гэдгээ бас энэ танилцуулга дээр бас нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн байгаа. Үгүй ээ, яах вэ, өнгөрсөн хугацаанд энэ сурах бичгийн алдаа дутагдлууд яагаад үүсчихсэн юм бэ гэдгийг бид нар их оношоо их зөв тавих ёстой юм байна гэж харж байгаа юм. Юу вэ гэхээр их ойрхон, ойрхон хөтөлбөр шинэчлэгдсэн байхгүй юу. Нөгөө Засгийн газар бүхэн гарч ирэхэд сайд бүхэн ирэхэд дандаа хөтөлбөрийн шинэчлэл ярьдаг. Үүнээс үүдэлтэй, ингээд энэ сүүлийн бараг үндсэндээ 20 хүрэхгүй жилд 5 удаагийн хөтөлбөрийн шинэчлэл хийчихсэн улс орон их цөөхөн л юм байна лээ. Тийм ч учраас бид нар цаашидаа ер нь хөтөлбөрийн шинэчлэл хийж байгаа болбол нэг шинэчлэл нь нэг, 10 жилийн хугацаатай хүчин төгөлдөр явж байж тогтвортой явж байж дараагийнхаа хөтөлбөрийн шинэчлэл рүү шилждэг нэг ийм эрх зүйн шинэчлэлийг хийе ээ гээд бид нар Улсын Их

Хурал дээр өргөн барьчихсан байгаа, хууль дээрээ зааж байгаа. Ингээж чадах юм болбол бид нар энэ хөтөлбөрийн шинэчлэлтийн асуудал хөтөлбөртэй холбоотой, энэ сурах бичгүүд хөтөлбөр амархан ойрхон ойрхон шинэчлэгдээд байгаа учраас л сурах бичгүүд шинэчлэгдэхээс өөр аргагүй болж байгаа байхгүй юу. Тэгээд маш их нөгөө энэ хөтөлбөр чинь 10 жилийн хөтөлбөр чинь маш их судалгаа туршилт дээр суурилж хийгдэх ёстой, сурах бичиг ч гэсэн ингээд нэг сурах бичгийг зохиоход нэг хоёрхон жилийн дотор зохиогоод хэвлээд түгээчихдэг нэг ийм улс орон манайхаас өөр бараг байхгүй болов уу даа. Тэгэхээр бид нар энэ зүйл дээрээ энэ хөтөлбөрийн асуудлууд, хөтөлбөрийн боловсруулалтын асуудлууд, хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлууд, эргээд хөтөлбөрийнхөө үр дүнг тооцох, үнэлгээ хийх энэ асуудлуудыгаа нэг ийм бусад улс орнуудад энэ менежментийн цикл гэж хэлдэг юм байна лээ, энэ хөтөлбөрийн удирдлагын цикл гэх юм уу даа. Тэгээд энэ циклүүд дээр явдаг нэг ийм хэлбэр лүү зөв хэлбэр лүүгээ голдирол руугаа орох нь зүйтэй болов уу гэж бас харж бид нар бодож байгаа. Яах вэ, та мэдэж байгаа, 1-5 дугаар анги болбол бүх сурах бичиг үнэгүй төр даадаг, дунд, ахлах анги нөгөө 6 дугаар ангиас эхлээд ингээд энэ түрээсийн сурах бичгийн түрээсийн сурах бичгээр бид нар хангаж байгаа.

Яах вэ, сурах бичиг дээр би түрүүний нөгөө үнэлсэн дүгнэлт дээр нэг ийм асуудал гарсан, алдаанууд маш их байгаа, агуулгын алдаанууд байна, арга зүйн алдаанууд байна, буруу жишээ авсан гэдэг юм уу янз бүрийн нөгөө дизайнер гэдэг юмыг авхуулаад одоо яг ашиглагдаж байгаа 3 сурах бичиг, 3 төрлийн сурах, нөгөө 3 өөр онд бичигдсэн ийм 3 өөр төрлийн сурах бичиг байсан юм байна лээ. Тэгээд 3-уулаа алдаатай. Тэгэхээр энэ 3 сурах бичгийг өнөөдөр явж байгаа энэ 3 сурах бичгийг бид нар гурвууланг нь нэг амьсгаагаар засаад залруулаад бүх хүүхдүүдэд алдаагүй сурах бичгийг хангана гэдэг болбол энэ болбол асар их хэмжээний мөнгө шаардагдах юм байна лээ 30 хэдэн тэрбум байхаа, урьдчилсан тооцоогоор. Тэгэхээр бид нар нэг хүрэхгүй, жилийн дараа ингээд дараагийн хөтөлбөрийн шилжилт рүү гулсаж орох гэж байна, ийм өндөр өртөг зардалтайгаар сурах бичгийн шинэчлэл хийнэ гэдэг хэцүү. Гэхдээ бид нар нэг зүйлийг хийж чадсан. Юуг хийж чадсан гэхээр бид нар энэ сурах бичгээ цахим болгосон, тийм учраас цахим дээр тавьсан сурах бичиг болбол алдаагүй сурах бичиг гэж ойлгож болно. Тийм учраас багш нь нэг сурах бичигтэй, хүүхэд нь нэг сурах бичигтэй ингэж ийм хичээл, тэгэхдээ хүүхдийнхээ сурах бичиг нь алдаатай сурах бичигтэй ийм тохиолдолд бид нар боловсролын чанарын асуудал яриад ямар ч утга учиргүй.

Тэгэхээр цаашидаа бид нар цахим ийм том боломж олгож байгаа учраас болбол энэ

цахимаар дамжиж сурах бичгийнхээ хүрэлцээг ер нь нөгөө нэг кендл гэж нэрлэдэг, ингээд энэ электрон номын энэ хэлбэрүүд чинь бүх улс оронд бол нэвтрээд эхэлчихсэн шүү дээ. Үүнтэй уялдуулаад нөгөө бага ангийн хүүхдүүд, нэг цүнхэндээ их олон сурах бичгүүд үүрч явдаг, бас энэ ингээд тодорхой эрүүл мэндийн юунууд сөрөг үр дагаврууд үүсэж байна гэж эцэг эх, хамгаалагч нар ч гэсэн ийм зүйл гардаг. Энэ дижитал сурах бичиг, электрон сурах бичгийн хэлбэрээр бид нар явж, үүнийг хэрэглээ болж чадах юм болбол төсөв дээр ч гэсэн тодорхой хэмжээний хөнгөлөлт юу, тодорхой төсвийн зөв хэмнэлтүүдтэй гарах ийм боломжууд байгаа юм байна гэж харж байгаа. Тэгэхдээ хүүхдүүдээсээ бид нар сурах бичиг, тэр мөнгө яаж байгаа хэлбэр биш, харамлаж байгаа хэлбэр биш. Энэ сурах бичгийн энэ түрээсийн тогтолцоонд шилжүүлсэн, энэ Баатарбилэг сайдын үед хийсэн их сайн тогтолцоо гэж харж байгаа. Одоо нэг сурах бичиг болбол нөгөө багцаар нь авахад ... /минут дуусав/

Г.Занданишатар: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Баярлалаа. Сайдын түрүүний ярианд 6 настай хүүхдийг бол олон улс дэлхийн нийтийн жишгийн дагуу сургахаас өөр аргагүй гэсэн зүйл ярьж байна. Энэ өөрөө нүүдэлчин Монголчуудад бол нэг хүндрэлийг авчирч байна. Хөдөөд өг 9 сарын 1-нээс хойш бол малчин айл бол 2, 3 салж байна. Хүүхдээ дагаад сумын төв, аймгийн төв бараадаг, амьжиргааны эх үүсвэр болсон мал хөсөө дагаад аавууд, эрчүүд үлдчихдэг. Энэ нөхцөл байдлыг Монгол орны түвшинд цаашид ер нь яаж зохицууля гэж боддог юм бэ? Үнэхээр бусад яамдтайгаа, Нийгмийн хамгааллын яам бусад энэ төрийн бодлоготой ер нь яаж зохицогдож явах ёстой юм бэ гэсэн.

Тэгээд жаахан дээшлээд ирэхээрээ дунд сургуулийн хүүхдүүд сайн багш дээр гайгүй сургууль төгсгөнө гээд аймгийн төв бараадаж байна. Ингээд сум, аймаг гээд салчхаж байна. Аймагт юм уу, төвлөрсөн газруудад сурахын тулд аль нэгэн асран хамгаалагч нь тухайн хаяг дээр байх ёстой гээд ингээд гэр бүл автоматаар салж байна. Мянгат малчин уу, мянгат малчин, боломжтой юу боломжтой, гэхдээ хүүхдээ сургахын тулд тусгай өрх бий болчхож байна. Монгол Улсын өрхийн тоо бол сүүлийн жилүүдэд автоматаар ихээр нэмэгдэж байгаа, бүр цаашилах юм бол арай ухаан мөчит хүн бол өрх толгойлсон эмэгтэй болж, өрх толгойлсон эцэг болж, халамж авах бүр хүсээгүй ийм салалтууд бий болоод байгаа байхгүй юу. Одоо хөдөөгүүр тойроход ерөөсөө ярьж байгаа зовлон бол үүнд л байгаа юм. Бид бүхэн энд чадах ядахаараа сумын сургуулийг нь гайгүй болоод, дотуур байрыг нь гайгүй болгоод янз бүрээр үзээд байнгуут ард нь

тийм нөхцөл байдлууд бий болж байгаа. Үүнийг Монгол Улсын хэмжээнд Монгол төрийн бодлогын хэмжээнд яаж зохицуулъя гэсэн алсын хараа байна аа. Дунд хугацааны ямар бодлого байна. Ойрын хугацаанд ямар асуудлуудыг авч хэлэлцэх гэж байна гэсэн нэгдүгээр асуудал.

2-т нь энэ төвлөрөл үнэхээр ихсэж байна. Энэ түгжэрэл, бухимдал. Төрийн өмчийн их, дээд сургуулиудаа гадагшаа хотоос гаргаж болдоггүй юм уу? Энд тэнд явж байхад том, том сургуулиуд дээр явж байхад том том цогцолборууд бий болж байгаа. Одоо Алс Дорнодын их сургууль ч гэдэг юм уу, тэгээд том том нэртэй сургуулиуд бол хотоосоо гадагш, сургалтын байр нь, дотуур байр нь, багш нарын байр нь гээд тэгэхээр энэ олон их төсвийн алдагдал, энэ их мөнгийг үрэн тарангүй одоо ковид, их наядын хөтөлбөр гэж байхын оронд МУИС-ийг ч гэдэг юм уу, Технологийн их сургуулийг, ХААИС-ийг хотоос гаргаж туршиж боломж байна уу? Үнэхээр тавь жараад онд байгуулагдчихсан, байришл нь ч гэсэн, байрууд нь ч гэсэн муудчихсан. Нэг иж бүрэн сургууль цогцолбор бариад оюутнуудтай нь гаргаад ингээд тэрний мөнгө төгрөг ч гэсэн өөрөө олдоно шүү дээ. Жишээлэхэд МУИС-ийг үнэхээр орчин цагийн дэлхий нийтийн сургууль болгоод хотоос гаргачихлаа гэхэд байгаа энэ нөхцөл байдлыг нь дуудлага худалдаанд орохоор бараг тэр мөнгөө олчих хэмжээний, дээр нь төсвөөс доохон жаахан дэмжлэг өгөөд ингээд дэлхий нийтийн олон улсын зэрэглэлтэй сургууль байгуулаад ингээд төвлөрлөө ч сааруулаад, төрийн бодлогоо ч хэрэгжүүлээд ингээд явах боломж нь байдаггүй юм уу гэсэн. Асуувал олон зүйл байна. Тэгээд би хөдөө тулгамдаа суугаад нэг зүйл, хотод ишидвэрлэж болох дотор бодогддог энэ зүйл асуулаа. Энэ 2 дээр нэг тодорхой хариултыг ойрын хугацаанд, дунд хугацаанд, алс хэтдээ ямар байна гэсэн хариултыг өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Батсуурь гишүүн ээ, одоо яах вэ, би сая энэ тоо аваад сууж байна л даа. Нийт малчдын хүүхэд, ерөнхий боловсролын хөдөөгийн сургуульд сурч байгаа 124000 хүүхэд байна, одоогоор 124000 тийм, тэндээс нэг дотуур байранд амьдарч байгаа нь 36000 орчим дотуур байранд амьдарч байгаа нэг ийм тоо байна. Тэгээд ерөнхийдөө бид нар яах вэ, энэ 6 настай хүүхдийн асуудлууд дээр болбол бас их олон жил ярьсан шинэ сэдэв биш л дээ. Би бас хөдөө аймгаас 3 удаа, 3 дахь удаагаа сонгогдож байгаа. Тэгээд яг үнэхээр энэ дээр асуудал бий юу гэвэл бий, яг Монголд байдаг л ийм онцлог. Тэгээд яг хүүхдээ дагаад ээж нь голцуу сумын төв дээр ороод ирдэг, ингээд нэг залуу гэр бүл 2 талд, нөгөө нэг яндан, 2 яндан болчихлоо л гэж яриад

байгаа шүү дээ, бид нар. Тэгээд үүнээс үүдэлтэй нийгмийн болон ингээд янз бүрийн сөрөг үр дагаврууд гарч байгаа энэ дээр бид нар бүгд ойлгож байгааг мэдэрч байгаа. Бас хийж байгаа судалгаанууд ч бас байна. Ерөнхийдөө энэ ерөнхий боловсролын дотуур байранд амьдарч байгаа 6 настай хүүхэд голцуу малчдын хүүхдэд зориулаад ямар ч байсан нэг туслах багш, дотуур байрны багш бол ажиллуулж эхэлсэн нь тодорхой үр дүн хүрсэн. Тэгээд нэгэнт зуны цэцэрлэгийн тогтолцоо гэж бас байгаа шүү дээ, Монгол Улсад тийм ээ. Тэгэхээр магадгүй бид нар 1, 2 дугаар ангийн сургалтыг, магадгүй тэр зуных нь зуслан дээр нь зохион байгуулж үзээд энэ нь тодорхой үр дүн хүрэх юм болбол магадгүй цаашидаа энэ тогтолцоо руу шилжихэд болохгүй юм байхгүй гэж харж байгаа нэгд.

2-т болбол нөгөө сая энэ цахим шилжилттэй холбоотойгоор үндсэндээ бол танхимын болон танхимын бус сургалт гэж хосолмол сургалт явагдах учраас яг аль аль сургалтаа танхимын бусаар аваад явах вэ, аль аль сургалтуудаа нөгөө танхимаар аваад явах уу гэдэг ийм хувилбарт сургалтуудыг ч бас санал болгоход болохгүй зүйл гэж байхгүй гэж би бодож байгаа юм. Тэгэхээр ийм хэлбэрээр ерөнхийдөө ийм хувилбар, сургалтын хэлбэрүүдийг хийх нь илүү дээр юм болов уу даа гэж харж байна. Энэ чиглэлийн бас зохицуулалтууд, бас боловсролынхоо ерөнхий хууль дээр ороод явж байгаа.

Их, дээд сургуулиудыг хотоос гаргана гээд ийм сэтгэлийн хөөрлөөр их бид нар их олон жил ярьсан юм байна лээ. Тэгээд нэг сэтгэлийн хөөрлөөр юм уу, захиргаадалтын аргаар үүнийг ишиддэг ажил бас биш юм байна гэдэг нь сүүлийн 1 жилийн хийсэн судалгаа тооцоогоор бас харагдаж байна. Өнөөдөр хуучин 88 байсан, 66 их, дээд сургууль дээр 150000 гаруй оюутнууд байна. Жил бүхэн 12-14 мянга орчим оюутнууд хөдөө орон нутгаас ирж Улаанбаатар хотод суралцдаг юм байна лээ. Тэгэхээр бид нар төрөлжүүлбэ л гэж байгаа юм, төрөлжүүлбэ. Дархан дээр, Эрдэнэт дээр, одоо Өмнөговь дээр бид нар ШУТИС-ийн салбар сургуулийг, тэгэхдээ Монгол Улсад хөтөлбөр нь давхцахгүй, тэр яг Даланзадгад дээр байгуулагдаж байгаа ШУТИС-ийн сургуулийн хөтөлбөр бол Монгол улсад ганцхан Даланзадгад дээр л байна. Тийм учраас тэр мэргэжил маркшедр мэргэжлийг эзэмшиж байгаа хүүхэд бол зөвхөн Даланзадгадад л сурна, тийм ээ. Жишээ нь ХААИС-ийн юу гэдэг юм, агро экономын ангид олгож байгаа тэр юунууд нь болбол зөвхөн Дарханы тэр ХААИС дээр хөтөлбөрийн давхацлаа, бид нар эхлээд арилгамаар юм байна лээ, тийм ээ. Тэгээд мэдээж багшийн асуудлууд, хөдөө орон нутагт суралцаж байгаа энэ оюутнуудын нөгөө сургалтын тэтгэлгээс өгч байгаа хөнгөлөлтийн асуудлууд гээд, ингээд цогцоор нь энэ асуудалд

бас хандаж байж бид нар тодорхой үр дүн гарах юм байна гэж бодож байгаа. Бид нар энэ жил Өмнөговь дээр бид нар ШУТИС-ийн салбар сургууль давхцалгүй хөтөлбөртэйгөөр нээж 120 хүүхэдтэй хичээлээ эхлээд явж байна. Үр дүнд бас хурч байгаа, ОТ компани хөрөнгө оруулалтууд хийгээд яг жинхэнэ утгаар нь уул уурхай, ложистикийн их сургуулийн кампус барих энэ ажлууд бас хийгдэж, ТЭЗҮ-үүд нь зургууд нь бас хийгдээд явж байна, бодитой ирэх намраас бол би бодитой ажил болох болов уу гэж бодож байгаа.

Сая та бүхэн анзаарсан байх. Дорнодод байгаа, Ховдод байсан их сургуулиудыг бид нар Эрдэнэтэд байсан их сургуулиудыг бид нар МУИС, Монгол Улсын ШУТИС-ийн шүүд харьяа сургууль болгосон. Үүний гол цаана хүлээгдэж байгаа юу болбол бид нар үүсэж байгаа зүйл болбол ер нь нэгдүгээр курст хүүхэд орж ирэх гэж Улаанбаатар хот руу, Ховдоос хүүхэд орж ирж, өнөөдөр ингээд эцэг эхчүүдээ малчны зээл, тэтгэврийн зээл авхуулж ингэж суралцах ийм хэрэгцээ шаардлага өнөөдөр байна уу. Эс үгүй бол нэгдүгээр курсээ Ховдоо суралцаад ... /минут дуусав/

Г.Занданиатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны сургуулийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний сурган хүмүүжүүлэх, соён гэгээрүүлэх ариун үйлст чинь өндөрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. Удахгүй Боловсролын багц хуулийг хэлэлцэнэ. Манай энэ Ундрэм гишүүн их идэвхтэй оролцож байгаа. Боловсролын асуудлаар шинэчлэл хийх гээд л загнуулаад сууж байгаа, байцаагдаж байна, мэтгэлцээн өрнөж байна.

Ингээд Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Сая дүгнэлт дээр бас олон зүйл ярьсан болохоор зөвхөн их, дээд сургуулийн талаар Боловсролын сайдаас нэг ганц 2 зүйл асууя.

Түрүүн бас бус Боловсролын сайдын үгэнд гарч байна лээ. Ер нь болбол ажилгүйчүүдийн армид бас хувь нэмрээ оруулж дипломтнуудаар хувь нэмрээ оруулдаг болчихсон үнэн гэдэг. Тэгэхээр яг үүний яг үндсэн шалтгааныг ер нь та яг юу гэж боддог вэ, үндсэн шалтгааныг. Хөдөлмөрийн зах зээл дээр ажлын байр байдаг гэдэг, байна гэдэг. Нөгөө талд нь баахан дипломтой нөхөд байдаг. Энэ 2 нь нь огтлолцдоггүй. Тэгэхээр бодит байдал дээр нөгөө

ажил олгогч нар чинь дахин сургалт явуулдаг, нэг ийм үйлдвэрээр болбол хөдөлмөрийн зах зээл, бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа үйлдвэр гээд бодох юм бол энэ боловсролын салбар чинь өөрөө чанаргүй бүтээгдэхүүн, гологдол бүтээгдэхүүнийг нь дараагийн салбартаа нийлүүлэх гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ яаж явал, яагаад чанаргүй болчихож байгаа юм? Тэгвэл яаж чанартай болгох юм гэдэг дээр.

Зүгээр энэ дээр нэг, миний танаас асуух гээд байгаа нь энд бид нар хэчнээн гоё олон зүйлийг ярьж болох байх, бүр чанаргүй гэж байгаа хувийн 10 сургуулийг хаачихаар үлдсэн нь механикаар хаачихаар тэгээд үлдсэн чанартай болчих юм уу? Чанартай бол болохгүй байх л гэж би бодож байна. Үүний цаана чинь угаасаа л тогтсон ойлголт байгаа. Аливаа бараа бүтээгдэхүүн чанартай болохын тулд өрсөлдөөнтэй байх ёстой, өрсөлдөөн байхын тулд үнэ чөлөөтэй байх ёстой гэдэг энэ үндсэн зарчим. Сургалтын төлбөрийг нь аваачаад хүчээр улсын их дээд сургуулиуд дээр бүгдийг нь барьчихдаг, засаглалын хувьд цаанаа ТУЗ гээд нэг гоё газартай, ТУЗ шийддэг нэртэй. ТУЗ-ыг нь дээрээс Боловсролын сайд, Засгийн газраас чиглэл өгдөг, тэд нар нь тэр чиглэлийн дагуу үнээ тогтоодог. Үнэ хатуу, тэнд зах зээл тэгвэл үнэ хөдлөхгүй учраас зах зээлд өрсөлдөөн байхгүй, өрсөлдөөн байхгүй учраас чанаргүй бүтээгдэхүүнийг зах зээл, боловсролын салбар нийлүүлээд байна. Тэгэхээр үүн дээр жишээ нь та яг энэ яагаад их, дээд сургууль дээр байгаа энэ үнэ дээр тодорхой хэмжээний чөлөөлөлт либералчлал гэдэг зүйл яагаад ер нь хийгдэж болдоггүй юм бэ? Энэ системийг энэ цикл энэ чигээрээ ингээд цааш ингээд эргээд авах ёстой юу?

Тэгэхээр үүн дээр тэр чанаргүй бараа бүтээгдэхүүн нийлүүлээд байгаа ажилгүйчүүдийн арми, дипломтнуудаар хувь нэмрээ оруулаад байгаа чинь энд нэг том зүйл байгаад байх шиг. Та үүн дээр бас нэг хариулт хэлээч, тэгээд би тодруулах зүйл байна.

Г.Занданиатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Дээд боловсролын тогтолцоо яагаад нурчихсан юм бэ, дампуурал нь хаана байна вэ, та ер нь оношоо зөв тавьж чадаж байгаа юм уу л гэж асуугаад байх шиг байна л даа. Оношоо зөв тавьчихаж байгаа болов уу гэж найдаж байна. Би яагаад ингэж хэлж байна вэ гэхээр ерөөсөө энэ Монголын дээд боловсролын тогтолцоо чинь ерөөсөө яг үндэснийхээ энэ мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоогоо залгичихсан юм байна лээ шүү дээ, ер нь. Яг ингээд яг техникийн болон мэргэжлийн боловсролын тогтолцоо оршин тогтнох энэ орон зайг их, дээд сургуулиуд нь

залгичихсан байхгүй юу, залгичихсан. Тийм учраас нөгөө нэг их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн хоорондын бараг үндсэндээ ялгаа байхгүй болчихсон гэж ойлгож болно. Манай их, дээд сургуулиудын багш нар энэ хоцрогдол нөхөх дамжаа гэж нэгдүгээр курсээ нэрлэдэг юм байна лээ, нэрлэдэг. Тийм учраас энэ ахлах сургууль одоо 11, 12-дугаар анги, мэргэжлийн боловсролын тогтолцоо, дээд боловсролын тогтолцоо нь ингээд том циклээрээ явж байсан энэ тогтолцоог 12 онд би одоо улс төржүүлмээргүй байна, 12 онд Боловсролын яамнаас аваад Хөдөлмөрийн яаманд өгчихсөн, мэргэжлийн боловсролыг. Ингээд боловсролын систем алдагдчихсан байхгүй юу. Энэ бол нэг шалтгаан. Энэ, тэгэхдээ улс төрийн шалтгаан биш, энэ болбол тогтолцоонд хамгийн их нөлөө үзүүлсэн ийм нэг шалтгаан байгаа юм, нэгдүгээр асуудал.

2 дугаар асуудал, манай Монгол Улс бид нар өнгөрсөн 30 жилд энэ дээд боловсролын тогтолцооны амин сүнс болсон мэргэжлийн үндэсний шаталсан бүдүүвч буюу *national codification primo* гэдэг энэ зүйлээ бид нар ойлгоогүй, ойлгоогүй учраас хийж чадаагүй. Энэ мэргэжлийн үндэсний шаталсан бүдүүвчээ бид нар боловсролынхоо тогтолцоотой хамтруулж хийж байж яг аль түвшинд нь ямар ур чадвар өгч, яаж баталгаажуулж, ахисан шатны сургалт руу дамжуулж явдаг юм бэ, яг ямар мэргэжлийн индексүүдийг яг зах зээлд эрэлт нийлүүлэлт дээр авч явах ёстой юм бэ гэдэг ийм тогтолцооны зүйлүүдийг бид нар олж харж чадаагүй, хийж чадаагүй учраас л өнөөдөр энэ дээд боловсролын дампуурал үүсчихсэн юм байна л гэж харж байгаа юм. Энэ нэг 2 жилийн дотор үүсчихсэн асуудал бол биш, тийм ээ, нэгд.

Хоёрдугаарт нь, өнөөдөр ингээд жил бүхэн манай Хөдөлмөрийн яамнаас гаргадаг энэ хөдөлмөрийн зах зээлийн тайлан гэж байгаа. Та ч гэсэн том баялаг бүтээгч хүн, үүнийг уншидаг байх. Яг энэ тайланг уншихаар өнөөдөр их, дээд сургууль төгсөөд очиж байгаа хүүхдүүдийн нөгөө ур чадвар, эзэмисэн ур чадвар, ажил олгогчдын хүсэж байгаа ур чадвар хоорондоо зөрчөж байгаа байхгүй юу. Яг эрэлт нийлүүлэлт зөрөхөөс гадна ур чадварын эрэлт нийлүүлэлт ингээд зөрчөж байгаа юм байна лээ. Тэгэхээр үүнийгээ ингээд бид нар энэ их, дээд сургуулиудынхаа хөтөлбөрөөр их, дээд сургуулиудынхаа энэ мэргэжлийн индексүүдээр янзалж авахгүй болбол цаашидаа ингээд л энэ тогтолцоо байгаад л байна. Би тантай санал нэг. 10 сургуулийг хаагаад 20 сургуулиудыг хаагаад, ингээд нэг тийм, боловсрол дээр тэр цоо шинэ реформ хийчихлээ гэж бид нар харахгүй. Энэ болбол хөтөлбөрийн шинэчлэлийн асуудлууд явагдана, тийм ээ. Багшийн чадварын ур чадварын асуудлууд яригдана, үнэлгээний зөв тогтолцооны тогтолцооны асуудлууд яригдана, магадлалын одоо итгэмжлэлийн магадлангийн

асуудлууд яригдана, чанарын үнэлгээний асуудлууд яригдана.

Ингээд тогтолцооны хувьд бид нар харж байгаа учраас бид нар үүнийгээ ерөөсөө энэ, бид нар чинь Их Хурал дээр өргөн барьчихсан байж байгаа энэ Боловсролын хууль чинь багц хууль шүү дээ. Боловсролын ерөнхий хууль, СӨБ, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол гэж ерөөсөө бүхэл бүтэн боловсролынхоо системийн энэ багц хуулийг яг нэг удаа ингэж ярьж байсан, аль ч Улсын Их Хурал байхгүй юм байна лээ. Аль ч Их Хурал. Энэ магадгүй бид нар түүхэн боломж олдож байгаа. Энэ Их Хурал бид нар яг энэ боловсролын багц хуулиа бүх боловсролынхоо системд уяулсан хоорондын интеграц буюу энэ боловсролын хоорондын уялдааг хангасан энэ хуулийг баталж гаргаж чадах юм болбол бид нар СӨБ-ын түвшинд ч, ерөнхий боловсролын түвшинд ч, мэргэжлийн боловсролын түвшин ч, дээд боловсролын түвшин ч гэсэн өнгөрсөн 30 жил үүссэн энэ алдаа завхралуудыг засах ийм л эрх зүйн шинэчлэлийг хийх магадгүй түүхэн ховор боломж бид нарын өмнө байна л гэж харж байгаа. Би алдаа дутагдал нь энд л байгаа гэж харж байгаа юм.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Улсын Их Хуралд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ард иргэдийн оролцоог хангах зорилгоор энэ хяналт шалгалтын зорилгоор болон мэдээллээр ирүүлсэн, Ди парламентад цахим хэлэлцүүлгийн платформ дээр тав хоногийн хугацаанд байрцуулж, иргэдээс санал авсан. Иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэж, нам, эвслийн бүлгүүд хүргүүлсэн. Энэ асуултууд дээр дүн шинжилгээ хийгээд нам, эвслийн бүлгүүд ангилан багцлаад бүлгээсээ тус бүр нэг гишүүнийг төлөөлж ЗГ-ын гишүүнээс асуулт асууж, хариулт авахаар зохицуулсан.

Ингээд энэ дэгийн дагуу Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг болон АН-ын бүлгийг төлөөлж тус бүр нэг гишүүн мэдээлэлтэй холбогдуулж ЗГ-ын гишүүнээс асуулт асууна.

Ингээд энэ нийт асуулт хариултын хугацаа 20 хүртэл минут байна. Энэ хугацаанд хэдэн ч асуулт асууж, хариултыг явуулна. Ингээд асуулт хариултыг эхлүүлэе.

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн ЗГ-ын гишүүнээс асуулт асууна.

Ё.Баатарбилэг: Баярлалаа. Тэгэхээр шинэ дэгээр бас энэ Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой олонхын бүлэг Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой асуулт асууж болдоггүй

тийм дэгтэй байсан. Шинэ дэгээр бас энэ боломж бүрдэж, бүлгийн төлөөлөл болж асуулт асуух боломжтой болсонд бол туйлын их талархалтай байгаа.

Тэгэхээр яг энэ шинэ дэгээр явж байгаа Ерөнхий сайдын эхний энэ мэдээлэл боловсролын асуудлаар, ялангуяа энэ боловсролын тогтолцооны шинэчлэл, боловсролын энэ салбарын санхүүжилт гээд маш олон шинэчлэлийн ажлууд ид явагдаж байгаа үед энэ боловсролын асуудлаар мэдээлэл сонсож байгаа нь их чухал ач холбогдолтой болж байна гэж үзэж байна.

Тэгээд Пүрэвдорж оо, би асуултаа асууя, Пүрэвдорж оо. Энэ манай бүлгийн асуулт, манай бүлгийн асуултын цаг, Пүрэвдорж оо, чиний цаг байгаа, ингээд Ди парламент дээр хэд хэдэн хүний асуултууд ирсэн юм байна. Бадамсүрэн гэдэг хүн Болдбаатар, Батсолонго, Төртөгтох, Батцэрэн гээд нэр бүхий хүмүүсээс хэд хэдэн асуудлууд ирсэн. Энэ дэгийн дагуу энэ асуултуудыг багцлаад агуулгаар нь тодорхой асуултууд болгож, олон нийтэд мэдээлэл хүргэх, бас дээр нь энэ асуусан хүмүүсийн асуултад нь хариулт өгөх ийм дэгтэй. Үүний дагуу би асуултаа асуух гэж байна.

Нэгдүгээрт, энэ боловсролын салбарын төсвийн шинэчлэл хийгдэж байгаа, Энх-Амгалан сайд бол энэ төсвийн шинэчлэлийг бол сүүлийн 1 жил гаруй хугацаанд хийгээд энэ багш нарын, ялангуяа энэ ерөнхий боловсролын салбарын багш нарын багш, ажилтнуудын цалингийн шинэчлэл хийж, цалин тодорхой хувиар бас нэлээд нэмэгдчихээд явж байгаа. Энэ цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг олон жил ярьсан. Тэгэхээр энэ маш хүнд нөхцөлд гэдэг юм уу даа, яг ялангуяа хөдөө орон нутагт ажиллаж байгаа багш, боловсролын салбарын ажилтан, албан хаагчид нэг үндсэндээ бол нэг 300 орчим долларын цалин аваад хүнд нөхцөлд ажиллаж байна. Тэднээсээ бид нар дэлхийн боловсрол нэхэж байгаа юм, дэлхийн боловсрол нэхэж байгаа юм. Дандаа өндөр хөгжилтэй орнууд ийм байна, тэгэхэд манайх ямар байна. Үүнийгээ сайжруулаач ээ гэдэг юм.

Дээр нь энэ Боловсролын багц хууль явж байгаа, үүнтэй холбоотой багш нарын нийгмийн баталгаа, цалин хөлс, тэтгэврийн насны асуудал хүртэл яригдаж байгаа юм. Тэгэхээр үүн дээр яг энэ салбарын шинэчлэлийн энэ санхүүжилтийн шинэчлэлтэй холбоотой, энэ боловсролын салбарын бусад ажилтан, албан хаагчдын цалин хөлсний асуудал дээр юу гэж харж байгаа вэ? Энэ тэтгэврийн насны асуудал, нийгмийн баталгааны асуудал дээр яг маш тодорхой 1, 2, 3, 4 гэсэн нэг ийм маягаар хариулт өгмөөр байгаа юм. Энэ бол яг салбарынхан бол бүгд харж байгаа асуудал юм байгаа юм.

Хоёрдугаарт, энэ сая сайд нэг асуултдаа хариулчихлаа. Тогтолцооны шинэчлэлийн асуудал байгаа. Сая тэр мэргэжлийн боловсролыг оруулж ирснээр манай боловсролын тогтолцоо нэг иж бүрэн болж байгаа юм. Яагаад гэвэл 10 дугаар анги төгсөөд энэ олон дээд сургууль бий болоод байгаагийн чинь нэг юм нь бол шууд дээд сургуульд орохоос өөр аргагүй, эсвэл ажилгүйчүүдийн эгнээнд орох гээд байдаг ийм л нэг тогтолцооны сонголт руу оруулчихсан шүү дээ. Мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн байгууллага болгоод Хөдөлмөрийн яаманд харьяалуулчихсан. Мэргэжлийн боловсрол бол сургалтын боловсролын байгууллага байхгүй юу. Тэгээд сая бол энэ Засгийн газар шийдвэр гаргаад Боловсролын яаманд харьяалуулсан байж байгаа. Тэгэхээр энэ мэргэжлийн боловсролын тухай хууль өргөн барьсан гэж сонссон, удахгүй Их Хурлаар орж ирэх байх. Тэгэхээр энэ мэргэжлийн боловсрол дээр чинь яг энэ тогтолцооныхоо шинэчлэлийн хүрээнд энэ ерөнхий боловсрол, дээд боловсролынхоо залгамжийг яаж тусгаж оруулж ирж байгаа гэдэг нэг ийм юман дээр нэг мэдээлэл өгөөдхөөч гэж нэг ийм асуулт байна.

Дараагийн нэг нь бас иргэдээс ирсэн, энэ асуултууд дотор байгаа. Энэ төрийн өмчийн болон энэ хувийн хэвшлийн сургуулиудын нэг ийм баахан статусын асуудлууд байгаад байна. ТӨК гээд л нэг хэсэг нь, нэг хэсэг нь төрийн өмчит УҮГ, тэгээд нэг ийм хувийн сургуулиуд нь хувийн компани, эсвэл сургууль, боловсролын байгууллага энэ нөгөө татвартайгаа холбоотой нэг ийм баахан статус хөндөгдсөн юм байгаад байгаа байхгүй юу. Зарим нь компани ААН-ийн бүтцээр явахаар татвар төлөөд явдаг, тэгж байтал боловсролын байгууллага татвар төлөхгүй гэдгээрээ явахаар нөгөө ТББ-ын статусаар яваад байдаг. Тэгэхээр үүн дээр энэ нэг статусыг нь нэг жигдлэх юм уу, хууль, эрх зүйн орчны шинэчлэл хийх юм байна уу, үгүй юу. Үүн дээр нэг та энэ дээд боловсролын шинэчлэлтэй холбоотой ямархуу асуултууд байна гээд.

Эхлээд нэг энэ 3 дээр хариултаа аваадахъя, тэгээд дараагийн асуултууд дээр асууна.

Г.Занданишатар: 5 минут асуулаа. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Яах вэ, энэ боловсролын салбарын ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудал гээд ингээд яахаар дан ганцаараа ингээд энэ тогтолцоогоо гэдгээр нь авч явахад их хэцүү л дээ Тэгээд яах вэ, энэ манай Засгийн газар дээр ерөнхийдөө яриад ерөнхий, тэр цаашидаа ер нь Монголын төрийн алба гэж байх болбол төрийн алба, төрийн үйлчилгээний алба, төрийн нөгөө онцгой гээд ингээд нэг баахан дотроо ингээд хуваагдчихсан, тэгээд салбарын хууль бүхэн гарах бүрд ингээд нэг ийм цалингийнх

нь шатлал нь, цалингийнх нь тогтолцоо нь, нийгмийн баталгааны тогтолцоонууд нь ингээд өөр өөр байдаг, хот, хөдөөгийн нэмэгдэл гэх мэтчилэнгээр ингээд ийм алаг цоог их тийм цалин хөлсний тогтолцоотой болчихсон юм байна лээ.

Манай Монголын төрийн албанд ажиллаж байгаа энэ хүмүүсийн дотор байгаа цалингийн юу чинь бараг 170 гаруй ийм өөр цалингийн тогтолцоотой улс болчихсон юм байна лээ шүү дээ бид нар чинь. Ийм, одоо нөгөө юу гэж хэлэх юм, тэгээд энэ чинь болбол ингээд адилхан нэг төр, Монголын төр нэг л төр байгаа. Төрийн үйлчилгээний албан хаагчид нь гэдэг нь нэг өөр, төрийн албан хаагчид нь гэдэг нэг өөр, төрийн захиргааны албан хаагчид нь гэдэг нь нэг өөрөөр нэг ийм хэлбэрээр явах нь болбол их буруу тогтолцоо юм байна. Ерөнхийдөө болбол энэ төрийн албаныхан, ажилтнуудын ангилал зэрэглэлийн асуудлууд, үүн дээр үндэслэсэн туршлага, мэдлэг тэр мерит зарчим дээр үндэслэсэн цалин хөлсний шударга тогтолцоо руу шилжих нь зүйтэй гэдэг дээр үндэслэж энэ 23 оны төсөв дээр бас тодорхой төрийн албан хаагчдын цалин урамшуулал, нийгмийн баталгааны асуудал дээр бол тодорхой шинэ дэвшил гарах нэг ийм зүйлүүд бас орж байгаа. Зүгээр ер нь яг энэ боловсролын салбарынхаа хүлээгдэж байгаа хуулиар болбол шууд багш нарынхаа тэтгэврийн насыг бид нар ингээд багасгаад явчихна гэсэн ийм тогтолцоо байхгүй ээ, байхгүй. Ерөнхийдөө цаашидаа болбол энэ тэтгэврийн тогтолцооны шинэчлэл хийх хүрээнд энэ асуудлууд яригдъя гэдэг нэг ийм тооцоо судалгаанууд бас хийгдэж байгаа гэдгийг бас хэлье. Бас баахан хий дэмий бас хүлээлтүүд үүсгээд нийгэмд ийм хүлээлтүүд ингээд үүсгэж, бас ер нь болохгүй юм байна гэж харж байгаа. Нэг хэсэг нь эрт тэтгэвэртээ гаръя гэдэг, нэг хэсэг нь болохоор тэтгэврийн насыг уртасгаж өгөөч гэсэн нэг ийм зүйлүүд яваад байдаг учраас болбол энэ нийгмийн өмнө тулгамдаж байгаа гол чухал асуудал учраас энэ нэлээн тооцоо судалгаа нотолгоо дээр үндэслэгдсэн ийм шинэчлэлтүүд явагдах болов уу гэж харж байна.

2 дахь асуудал болбол энэ мэргэжлийн боловсрол ирснээр болбол нэлээн боловсролын салбарын тогтолцоо их зөв болсон. Тэгээд яг тантай санал нэг байна, нөгөө шууд 12 дугаар ангиа төгсөөд шууд их, дээд сургууль бараг үндсэндээ 12 дугаар анги төгсөгчдийн бараг наяд гаруй хувь нь 85, 6 хувь нь шууд их, дээд сургууль руугаа ордог ийм тогтолцоотой улс орон бараг манайх байгаа байх даа, их ховор юм байна лээ. Уг нь бол энэ чинь эсрэгээрээ 30, 40 хувь нь дээд сургууль руугаа бусад нь болбол нөгөө мэргэжлийн техникийн боловсролынхоо тогтолцоо руу шилждэг, ийм ахиад ахисан шатных нь сургалтууд руугаа явдаг нэг ийм тогтолцоо байх ёстой юм байна. Тэгээд мэргэжлийн боловсрол ирснээрээ болбол энд

байсан энэ алдаа гажуудал, тогтолцооны алдаа гажуудлыг засах ийм боломжууд бас гарч ирж байгаа. Тэгээд болбол нөгөө мэргэжлийн боловсрол дээр чинь хүүхдүүд чинь 2,5 жил сураад яг гарах гэхээр хөдөлмөрийн зах зээл дээр гарах гэхээр нь 16 насанд хүрдэггүй, нэг 18 нас нь хүрдэггүй, нэг ийм, 6 сар, 1 жил хүлээх нэг ийм гэж тогтолцоо байсан. Тийм учраас болбол нэг мэргэжлийн боловсролын 2,5 жилийг бид нар 3 жил болгож энэ хуулиараа засаж байгаа. Тийм учраас бид нар ер нь ахлах сургууль, мэргэжлийн боловсрол, ингээд дээд боловсролын, нөгөө боловсролын түвшний уялдаа интеграцийг хангаж агсан шатны, ахиад дэвшээд суралцдаг, кредитээ тооцоод суралцдаг, энэ тогтолцоо руу шилжүүлэх ийм тогтолцооны шинэчлэлүүдийг бас хийж байгаа. Манайх шиг ер нь энэ их сургууль гэхээд дахиад дээд сургууль гэсэн ийм тогтолцоотой улс байхгүй шүү дээ, энэ чинь англиар орчуулахад ч гэсэн хэцүү юм байна лээ. Яг университет, тэгээд коллеж, graduate, undergraduate гэдэг нэг ийм тогтолцоогоор л явдаг. Тийм учраас цаашидаа бид нар энэ их, дээд сургуулиуд, энэ дээд боловсролын тухай хуулиуд хэлэлцэх гэж байгаа, энэ үе дээр ч гэсэн цаашидаа бид нар энэ их, дээд сургуулиудынхаа ангилал, зэрэглэлийн асуудлууд, эрэмбэ чансааны асуудлуудыг ч гэсэн ингээд энэ эрх зүйн шинэчлэлүүдээ хийх маягаар хийж явах боломжууд нь байгаа болов уу гэж харж байна.

Статусын асуудал яах вэ дээ, энэ төрийн өмчит их, дээд сургуулиудын гэрчилгээг аваад үзэхээр янз янзын юм байна лээ, төсөвт УУГ гээд ингээд нэг ийм юм байна, тэгээд бид нар энэ шинэ хуулиараа, ер нь болбол их сургууль гэсэн ийм статусуудыг нээгээд ингээд л явах л тэгж байж нөгөө нэг гэрчилгээнүүд нь энэ байгууллагуудын бүртгэлийн гэрчилгээнүүд нь зөв хийгддэг байхгүй болбол одоо их дээд сургуулиуд нь зарим их, дээд сургуулиуд чинь ТББ маягтай ч гэсэн байж байгаа шүү дээ, ТББ. Тэгээд үндсэндээ болбол тавь жархан оюутантай байгаа тэр их, дээд сургуулиуд би мөнгө хийгээд тэр амьдраад байх тийм их, дээд сургуульд нэг өөрийнх нь үйл ажиллагааныхаа зардлаа нөхөж байна гэж би ерөөсөө харахгүй байгаа юм. Хамгийн багадаа нэг, 600 оюутантай байж байж л нөгөө Брикин гэдэг чинь нөгөө ашиг зардлаа ашиг, орлогоо нөхдөг нэг ийм л тогтолцоо байгаа юм байна лээ шүү дээ, цэвэр одоо юугаар үзэхэд. Үүний чинь цаана юу яваад байна вэ гэхээр ерөөсөө татвараас зугтдаг л тогтолцоо юм байна лээ шүү дээ. Татвараас зугтдаг тогтолцоо. ТББ-аар бүртгүүлчхээд ТББ-ынхаа нэр дээр хэдэн га газруудад ийм олон үл хөдлөх хөрөнгүүд авчхаад боловсролын байгууллага гээд татвараас зугтдаг л нэг ийм тогтолцоог л одоо тодорхой бус, нөгөө байгууллагын статусын тодорхой бус нөхцөл байдлуудыг нөгөө хуулийн хийдэл гэдэг шиг ашигладаг ийм л гажуудал болчихсон юм байна. Үүнийг энэ шинэ хуулиар

засах, залруулах зайлиггүй ийм шаардлага байна л гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Баатарбилэг гишүүн.

Ё.Баатарбилэг: Дараагийн нэг багц асуудлууд байгаа юм. Энд бол яах вэ, тэр сургуулийн автобусны хүртээмж нэмэгдүүлмээр байна, энэ багшийн хөгжил залгамж халаа, багш нарын дутагдлын асуудлууд байгаа юм байна лээ. Ялангуяа энэ нийслэл, орон нутагт багшийн дутагдал их байна гэдэг ийм асуудал энэ багш нарын ЕБС-ийн шүү, ерөнхий боловсролын сургуулиуд багш нар дутагдалтай байна гээд. Тэгэхээр яг энэ нөхцөл улсын хэмжээнд ямархуу нөхцөл байдалтай байгаад байгаа юм, үүнийг ойрын хугацаанд яаж багш нарынхаа нөхөн хангалтыг хийх бодлого яваад байгаа юм. Ялангуяа түрүүн бас Их Хурлын гишүүд намайг нөгөө бүлгээс төлөөлж асууна гэсэн болохоор энэ Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд үүнийг асууж өгөөрэй гэсэн. Нийслэлийн захын хорооллын сургуулиуд багш нарын хомсдолтой байна. Хөдөө орон нутгаас багш нарыг авчирч ажиллуулж байна, нөгөө сайн багш нарыг урьж авчруулж байна, ажиллуулж байна. Тэгэхээр нөгөө хөдөө орон нутгаас ирж ажиллаж байгаа багш нарын нийгмийн асуудал, гэр орон, байрнаас өгсүүлээд хүндрэлтэй асуудлууд гарч байна гэж. Тэгэхээр үүн дээр та бүхэн яг тооцоо судалгаа юмнууд байна уу, ойрын хугацаанд юм уу, ямар хугацаанд энэ багш нарынхаа нөхөн хангалтыг хийх юм бэ гэдэг энэ дээр нэг мэдээлэл юмнууд өгөөдхөөч.

Дараагийн асуудал, энэ жорлонгийн асуудал. Энэ жорлон ер нь модон жорлонгоос салъя гэдэг энэ юмыг бол Их Хурал дээр маш хүчтэй яриад, миний үед яаман дээр бол энэ Баярсайхан гишүүн бид нар модон жорлонгийн асуудлыг анх ярьж хөндөж гаргаж байсан. Энэ дээр улсын төсвөөс тодорхой юм гаргаад нэг, 2 дахь жилдээ явж байна. Энэ жилийн нөхцөл байдал ямар байна, уг нь бол энэ 22 оноор дуусаад бүх сургууль, цэцэрлэгүүд модон жорлонгоос салах л ёстой л доо. Тэгэхээр одоо яг хамгийн сүүлийн үеийн мэдээллүүд ямар байна, энэ талаар нэг мэдээлэл өгөөдхөөч ээ гэж.

Энэ цэцэрлэгийн хүртээмжийн асуудал, энэ улсын төсөв орж ирсэнтэй холбоотой би ярьж байгаа юм шүү. Одоо шинээр нэг ч хөрөнгө оруулалт тавихгүй гэгчихсэн. Улаанбаатар хот яг та ингэж санаачлаад цэцэрлэгийн хүртээмжийг ингээд ерэн хэдэн он хүртэл шийдчихсэн гээд сая мэдээлэл гарлаа. Тэгж байтал орон нутагт цэцэрлэгийн асуудлууд хүндрэлтэй газрууд хэвээрээ байгаад байдаг, бид нар шинэ юм, шинэ юм төсөвт тавихгүй гээд ингээд бас хүлээгдэх болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ хөдөө орон нутгийн цэцэрлэгийнхээ асуудлуудыг та нар яг яаж судалж байгаа юм, бүрэн шийдэгдчихсэн юм

шиг ийм маягтай юм мэдээлэл явуулаад байгаа бол буруу гэж би харж байгаа юм. Тэгэхээр үүн дээр сайдын байр суурь одоо энэ төсөв дээр ямар боломж гаргах боломж байна, орон нутаг руу цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр гэж ийм юм.

Багш нарыг компьютержуулах асуудал 4 дэх асуудал нь. Яг ЕБС, цэцэрлэгийн багш нарын хэдэн хувь компьютертой байна. Та сая хэллээ, Нэгдсэн үндэсний байгууллагын тэр олон улсын хурал дээр Монгол улс цахим шилжилтийг ингээд маш өндөр түвшинд хийсэн улс боллоо гэж бүх цахим юм чинь багш нарын энэ компьютер дээр явна. Тэгж байтал нөгөө багш нар маань компьютерын яг хувийн нөүтбүүкний хангамж ямар байгаа юм, яг тэр нь хүртээмжтэй болгоход ямар арга замууд байна гэдэг дээр нэг ийм ийм нэг хэдэн багц асуудлуудаар энэ иргэдийн Ди парламент дээр ирсэн юмыг бол хааж байна.

Хамгийн сүүлд бол энэ боловсролын асуудлаар Энх-Амгалан сайдад өөрт нь даатгаа аа, тэр сайд өөрөө хийчхэж чадна гэдэг ийм юм хүртэл нэг юун дээр орж ирсэн байна шүү дээ. Ийм хэдэн асуултад хариулт өгчхөөч.

Л.Энх-Амгалан: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Багш нарын дутагдлын асуудал. Багш нар дутагдалтай байгаа юу гэвэл дутагдалтай байгаа. Бид нар сая шинэ хичээлийн жил эхлэхэд бас нэг судалгаа авсан, яг улсын хэмжээнд бид нарын ЕБС-ийн нэг 860 гаруй, 65 сургууль дээр 1171 багш дутагдалтай байна гэдэг нэг ийм судалгаа гарсан байна. Бага ангийн багш, математикийн багш, гадаад хэлний багш, байгалийн ухааны багш гэсэн ийм 4 чиглэлээр багш нар дутагдалтай байгаа. Тэгэхдээ бид нар яг энэ багш нарыг бэлтгэх асуудал дээр, ер нь энэ багш бэлтгэх тогтолцоогоо ер нь нэг эргэж харъя гэдгээ бид нар энэ боловсролынхоо багц хууль дээр бас нэлээн эрх зүйн шинэчлэлийн асуудлууд хийхээр ингэж ажиллаж байгаа. Дунд хугацаанд ер нь ойрхон хугацаанд энэ багшийн дутагдлыг нөхөх асуудал болбол энэ танхимын болон танхимын бус сургалтын энэ хосмог сургалтын арга л юм байна гэж харж байгаа юм. Тэгэхээр та бүхэн анзаарсан байх, энэ жил бид нар 9 сарын 1-нээс авхуулаад энэ Мэдлээ.мн гэдэг анхны Үндэсний цахим сургууль болж нээсэн. Ингэхээр энэ жил бол 12 дугаар ангийн биш ээ, 10 дугаар ангид орж байгаа хүүхдүүд болбол нөгөө тухайн сургууль дээрээ сонгосон, дуртай хичээлээ сонгохоор нөгөө бүлэг бүрддэггүй, дор хаяж 15-20 хүүхэд нэг адилхан хичээл сонгож байж бүлэг бүрддэг, ингэж байж хүүхэд нь өөрийнхөө нөгөө сонгосон хичээлээрээ суралцдаг, ЭИШ-ээ өгдөг нэг ийм тогтолцоо байгаа. Гэтэл харамсалтай нь нөгөө бүлэг бүрддэггүйгээс болоод өөрийнхөө дуртай хичээлийг сонгож авдаггүй, ЭИШ-ийнхээ шалгалтыг өгч чаддаггүй, дуртай мэргэжлээ эзэмшиж чаддаггүй нэг ийм асуудал үүссэн

учраас бид нар энэ жил улсын хэмжээнд 10 дугаар ангийн хүүхдүүдийг сонгоны хичээлийг бид нар цахимаар хийнэ. Ирэх жил бид нар 11, 12 дугаар ангийг энэ дээр шилжүүлнэ. Ийм хэлбэрээр Монголын хамгийн сайн багш нарын хичээлийг, хамгийн сайн багш нараар хаана амьдарч байна, хаана нь сурч байна гэдгээсээ үл шалтгаалж энэ хүүхдүүдэд бид нар энэ боломж өгөх ёстой юм байна гэж харж байгаа юм. Үүнийг л бид нар тэгсхэн гэж харж байгаа. Чанартай боловсрол олгох тэгш боломж энэ байна гэж нэгдүгээр асуудал.

2 дугаар асуудал бол бид нар ерөнхийдөө энэ МУИС буюу МУИС-ийн физик, математикийн юугаар төгсөж байгаа багш нарыг богино хугацаанд дүйцүүлэн сургаж, багш болгох хөтөлбөрүүдийг бас бид нар энэ МУБИС. МУИС-тай хамтарч бас хийхээр ингэж бэлдэж байна. Энэ зун ч гэсэн бид нар, энэ цэцэрлэгийн багш нарын мянга орчим багш нарын хэрэгцээг бол яг энэ хэлбэрээр шийдсэн. Тэгэхээр энэ хэлбэрээр бол бид нар шийдээд явчих энэ бололцоонууд нь байгаа болов уу гэж харж байна.

Маш сайхан санал, санаачилгууд гарч байгаа, манай Цогтгэрэл гишүүн бас Увс аймагт энэ “боловсролд гэрэл нэмье” гэдэг энэ арга хэмжээг бол хийсэн. Үүнийг ер нь цаашидаа ч гэсэн бусад аймгуудад хийх ийм шаардлага байна гэж бодож байгаа. Яг МУИС-д багшилдаг, чадварлаг багш нарыг хөдөө орон нутагт аваачиж богино хугацаагаар тэр багш нарын болон хүүхдийн тэр мэдлэг, ур чадваруудыг дээшлүүлсэн ийм сайн аргууд бас гарч ирж байна, сайн санаачилгууд. Тэгэхээр үүнийг ч гэсэн бид нар бусад хэлбэрээр ингэж явуулах. Ер нь их, дээд сургуулиудын багш нар, энэ хотод байгаа сургуулиудын багш нарыг бид нар сэлгэн ажиллуулах ер нь зайлиггүй шаардлага байна, сэлгэн ажиллуулах. Манай гадаадад их, дээд сургууль төгссөн 20 гаруй залуучууд санаачилгаараа хөдөө суманд очиж ажиллах Teach mongolia гэдэг энэ санаачилгуудыг бас нэвтрүүлж ажиллаж байна. Гэх мэтчилэнгээр ингээд бид нар өөрт байгаа бололцоогоо ашиглаж энэ дутагдалтай байгаа багш нарынхаа асуудлыг шийдчих энэ боломжууд нь байгаад байгаа юм болов уу гэж харж байгаа.

2 дугаар асуудал нь цэцэрлэгийн хүртээмжийг Улаанбаатар хотод шийдчихлээ. Цаашидаа энэ хөдөө орон нутагт цэцэрлэг шаардлагатай байгаа аймаг, сумд дээр яаж шийдэх вэ гэж. Ер нь Улаанбаатарт хэрэгжүүлсэн энэ туршилагаа л хэрэгжүүлбэ гэж бодож байгаа. Тийм учраас төр өөрөө ингээд заавал ч үгүй цэцэрлэг бариад, тэгэхдээ маш их өндөр өртөгтэйгөөр 2-3 жил ингээд цэцэрлэг барьдаг энэ тогтолцооноосоо ер нь салъя. Цэцэрлэгийг ер нь хувийн хэвшил дээр ер нь тодорхой ачааллуудаа хийвэл яасан юм бэ. Тэгээд хувийн хэвшилээ яг нөгөө хувьсах зардлыг нь 2

дахин үржүүлж өгнө гэдэгтэй адилхнаар ингээд үүнийг бид нар энэ тогтолцоог санхүүгийн тогтолцоог нэвтрүүлж чадах юм болбол Улаанбаатар хотод ч адилхан, хүн ам төвлөрсөн Дархан, Эрдэнэт, Мөрөн, Архангайн аймгийн төвүүд ч гэдэг юм уу, ийм томоохон аймгийн төвүүд дээр болбол хувийн хэвшил дээр байгаа энэ цэцэрлэгийнхээ багтаамжийг ашиглах энэ боломжууд нь байх юм байна. Энэ нь болбол санхүүгийн ийм зөв хөшүүрэг хийх юм байна гэж бодож байгаа.

Ер нь цаашидаа энэ цомцог гэр гэдэг маш бага өртөгтэй барьж байгаа энэ цэцэрлэгийг ч гэсэн аймгуудын төвд, сумдын төвүүд дээр ч барих нь илүү их өртөг зардал багатай ийм зөв шийдэл байх юм болов уу гэж харж байна.

3 дугаар асуудал, багш нарын компьютерын асуудал. Хэрэв төр өөрөө багш нарын компьютерыг зуун хувь шийднэ ээ гэх юм болбол энэ бол хэзээ ч шийдэгдэхгүй. Энэ 180 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа. Тэгэхээр ингээд 180 тэрбум төгрөгийг нэг амьсгаагаар улсын төсөв дээр тавина гэдэг бол энэ нэлээн том хэмжээний мөнгө, гэлээ гэхдээ бид нар багш нарын энэ компьютерын хангалт дээр бид нар 2 хэлбэрээр нэг зөв арга зам олъё гэж бодож байгаа. Нэгдүгээрт нь болбол энэ Улсын Их Хурал дээр хэлэлцэх гэж байгаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль гарахаар бид нар энэ хардвар нийлүүлдэг буюу компьютер нийлүүлдэг компанитай санхүүгийн түрээс хийж болох юм байна лээ, санхүүгийн түрээс. Яагаад гэвэл компьютер өөрөө хурдан хоцрогддог элэгддэг учраас 3-4 жилд бид нар санхүүгийн лизинг буюу санхүүгийн түрээс хийгээд, тэгээд тэр компаниуд нь багш нар дээр нь нийлүүлдэг бид нар зөвхөн түрээснийхээ зардлыг төлдөг. Энэ түрээсийн зардлыг нь бид нар нэг хүүхдийг сургах, хувьсах зардлынх нь зардалд оруулах нэг ийм шийдэл байна. 2 дахь шийдэл болбол Говь-Алтай аймгийн Засаг даргаас эхлүүлсэн маш зөв шийдэл байгаа. Сум бүр дээр жил бүхэн хуваарилагддаг сумын хөгжлийн мөнгөнөөс яг тухайн сум дээр байгаа багш нартаа жаран багш байхад нэг багш дээр нэг сая төгрөг гээд жаран сая төгрөгийн эх үүсвэр шийдээд, аймаг нь нэг сая төгрөгийн эх үүсвэр шийдээд ингээд аймаг, сумынхаа орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдэж байгаа. Одоо бараг үндсэндээ Монгол Улсын хэмжээнд 6 аймаг яг нэг энэ хэлбэрээр шийдээд явчхаж байгаа нэг ийм зөв санал санаачилгууд байна. 1 жил жаран сая төгрөгийн өртөгтэй нэг худаг шийдэх үү, эс үгүй бол суман дээрээ байгаа жаран багшийнхаа компьютерыг 1 жил нэг сая төгрөг шийдээд явах уу гэдэг энэ сонголтыг л манай сумынхан хийх ёстой. Сум дээр, аймгууд дээр аймгууд ... /минут дуусах/

Г.Занданшатар: Баатарбилэг гишүүний хугацаа дууссан байна.

Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуулт асууж, хариулт авна. Асуулт, хариулт 20 минут үргэлжилнэ. 20 минут болоод л хугацаа дуусаж байгаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Тэгэхээр мэдээж боловсролын салбарт болж байгаа юмнуудаа манай сайд хамгийн түрүүн хэлэлгүй яах вэ. Түүнийгээ хэлчихсэн. Болохгүй байгаа юмнуудаа ярьцгаая.

Цэцэрлэгээс эхэлье. Цэцэрлэгийн багш нар бол ингээд 50 настай тэтгэвэрт гармаар байна гэж. Яагаад гэвэл тэр хүмүүс чинь олон жил хүүхдийн шугуан дотор чих нь хатуурдаг, дээрээс нь 50 гараад 55 хүрээд л тэр хүүхдүүдийн өмнө дуулж бүжиглээд л, үсрээд цов

Л.Энх-Амгалан: Энэ тэтгэврийн насны тогтолцоог би түрүүн тайлбарласан даа. Ер нь салбар салбараар ингэж онцолж шийдэх, тэгээд хөдөө хотоор нь онцолж, ингэж шийдэх болбол бас их буруу тогтолцоо руу шилжчихсэн юм байна гэж. Одоо ингээд бид нар, хэрэв сая нөгөө малчдын тэтгэврийн насыг чинь нэг 5 насаар багасгасантай адилаар л яг л ингээд нийгэмд ийм барьцдаг юу үүсчихсэн байхгүй юу. Ерөнхийдөө Монгол хүний дундаж наслалт чинь нэмэгдэж байгаа шүү дээ, Пүрэвдорж шиг ээ, тийм ээ. Сүүлийн 10 жилд бол 10 хүрэхгүй жилд болбол бараг үндсэндээ 7, 8 насаар нэмэгдчихлээ. Цаашидаа ер нь улс орнууд болбол аль болохоор ингээд энэ иргэдээ эрүүл чийрэг, урт удаан хугацаанд ажиллах энэ боломжоор нь хангах ёстой юм байна. Ер нь хүний хөгжлийн индекс ч гэсэн энэ хэлбэрээр ингэж гол үзүүлэлтүүд явж байгаа. Би нэг их бөөрөнхийлөөд байгаа юм алга, ерөнхийдөө цэцэрлэгийн багш нар дээр ачаалал бол байгаа. Тийм учраас бид нар Улаанбаатар хотоос эхэлж өндөр их ачаалалтай байгаа цэцэрлэгүүд дээр бид нар туслах багш, ээлжийн багш ажиллуулж эхэлсэн. Тодорхой үр дүн хүрч байгаа. Тийм учраас тэтгэврийн насыг шууд өөрчилж богино болгоно гэдгээсээ илүү цэцэрлэгийн багш, бага ангийн багш нар дээр байгаа ачааллуудыг бид нар хэрхэн зөв хуваарилж, тэр хүний ачаалал багатай, эрүүл урт наслах энэ боломжуудыг нь бүтээмж өндөртэй ажиллах энэ боломжуудыг л бид нар хийж өгөх нь зөв шийдэл болов уу гэж харж байна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр улсын цэцэрлэг дээр бол анги дүүргэлтийг 30-аас дээш хэтрүүлмээргүй байна гэж ихэнх цэцэрлэгийн багш нар ярьдаг. Дээрээс нь ээлжийн багшийг бол яг таны хэлж байснаар бүр багш нар чинь эсэргүүцээд байгаа шүү дээ, яагаад гэвэл

нэгдүгээрт ихэнх цагийг нь тэр нөгөө үндсэн багш нь заадаг, тэгээд нэг жоохон хугацаанд оройтсон хүүхдүүдийг хүргэж өгөх, эцэг эхэд нь өгөх тэр ажлуудыг л энэ туслах багш нь хийдэг. Тэгээд тэр туслах багш нь тэр нөгөө үндсэн багшийнхаа илүү цагийн хөлсийг нь авчихдаг. Тийм учраас нөгөө үндсэн багш нар чинь энд нь жоохон дургүй байгаад байгаа шүү дээ. Энэ талаар ямар, та шал ондоо нь тайлбарлах юм. Багш нар чинь бол өөр байгаа.

Л.Энх-Амгалан: Одоо цөмөөрөө ингэнэ ээ, бид нар хүртээмж гэж их олон жил ярилаа. Ямар ч байсан нэг хүртээмжийг бид нар ингээд энэ цэцэрлэгийн СӨБ-ын насны хүртээмж, энэ жилийн түвшинд болбол бид нар яг 90 хувь гэдэг их өндөр тоо л доо, бас энэ тоог үргэлж хадгалж явна гэдэг ч гэсэн бас нэлээн өндөр зардалтай ийм асуудлууд. Тийм учраас бид нар чанарын асуудал яригдана, СӨБ дээр ч гэсэн чанарын асуудал. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ гэж хийгддэг. Тийм учраас өнөөдөр хүүхэд чинь энэ СӨБ-ын боловсрол чинь өөрөө хамгийн чухал ийм салбар гэдэг дэлхий нийт ингээд анхаараад эхэллээ л дээ. Тэгэхээр яагаад ингэж анхаараад эхлэх вэ гэхээр ерөөсөө энэ хүүхдийн тархины хөгжлийн бараг үндсэндээ 70 хувь нь бараг 6 нас хүртлээ бойжчихдог, 7 наснаас цаашаа бараг үндсэндээ 50 хувь нь ингээд нөгөө хөгжил нь саардаг. СӨБ-д оруулж байгаа нэг доллар буцаад 12 доллар буцаж ирдэг, хамгийн их өндөр өгөөжтэй энэ салбар болбол СӨБ-ын салбар гэдгийг дэлхий нийтээрээ өнөөдөр хүлээн зөвшөөрчихлөө. Тийм учраас бид нар энэ багш нарын ачааллыг одоо бид нар яг жинхэнэ цэцэрлэгийн багш гэдэг ажлын ачааллаа яг нөгөө хөтөлбөр илүү хөтөлбөр тал руу нь бид нар энэ багш нараа бэлдэнэ ээ, сургана. Одоо байгаа бид нарын багш нарын ачааллуудаа бид нар илүү үндсэн ажил руу нь, тэр хүүхдийг сургах, хүүхдэд чадвар эзэмшүүлэх тэр чиглэл рүү нь бид нар ажиллах тэр боломжуудыг нь хангаж ажиллана гэдэг нэг ийм ажлын байрны зураг авалтуудыг хийж л энэ зөв зохицуулалтуудыг л хийе ээ л гэж бодож байгаа. Бид нар хамгийн түрүүнд бид нар энэ хичээлийн жилээс авхуулаад бид нар СӨБ болон ЕБС-ийн багш нарынхаа ачааллыг нэг 30-40 хувь бууруулах бас ийм зорилтууд тавьж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ бид нар энэ яг үндсэн багш нь яг ямар ажлын хуваарьтай байх юм, туслах багш нь яг ямар ажлын хуваарьтай байх юм, үнэлэмж нь ямар байх юм бэ гэдэг үүнийгээ бол үр дүнд суурилсан санхүүжилтийнхээ хэлбэрээр хийж явах нь зүйтэй юм болов уу гэж харж байна.

Б.Пүрэвдорж: Энэ жилийн тэр цэцэрлэгийн бүртгэл бол яах вэ, болсон, тэгэхдээ мэдээж алдаа байгаа. Тэгэхээр энэ дээр хамгийн гол нь юу байдаг юм, ипотекийн зээлд хамрагдсан залуу өрхүүд нөгөө нэг байрныхаа гэрчилгээ

аваагүй ч байдаг юм уу, аль эсвэл түрээсийн байранд амьдарч байгаа хүмүүс болон аль эсвэл хороо нь том нэг нь өнцөгтөө хажуухандаа байгаа цэцэрлэгтээ хамрагдаж чадахгүй и-монголиа-аар бүртгэгдэж байгаа учраас бүр алс хэсэгтээ очоод бүртгүүлдэг ийм алдаанууд сая гарсан, үүнийгээ бас засаарай гэж хэлье.

Дараагийн асуулт бол сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сумын дарга, дүүргийн дарга томилж байгаа. Тэгээд ингээд тэр сумын дарга томилдог учраас тийм улс төрийн томилгоо маягтай болчихсон. Тэгэнгүүт багш нар бүгдээрээ тэр нэг сургуулийнхаа захирлыг дагаад нэг тийм улс төржсөн, намжсан маягтай болоод байгаа юм. Энэ дээр ямар арга хэмжээ яаж цаашидаа авах юм бэ, яаж томилоогоо зөв болгох юм.

Л.Энх-Амгалан: Сургууль, цэцэрлэгийн томилгоо бол улс төрийн томилгоо байж болохгүй ээ. Энэ бол цэвэр мэргэжлийн томилгоо байх ёстой. Тийм учраас бид нар энэ Улсын Их Хурал дээр хэлэлцэх гэж байгаа Боловсролын багц хууль дээр бид нар сургууль, цэцэрлэгийн томилгоог бид нар босоо тогтолцоотой болгох ийм л хувилбарыг бид нар хэлэлцэж байгаа. Тийм учраас сумын Засаг дарга нь тийм ээ, юуны дүүргийн Засаг дарга нь энэ сургууль, цэцэрлэгийн удирдлагуудыг томилдог, энэ томилгоо болбол буруу томилгоо. Тийм учраас үүнийг бид нар энэ хуулиараа засах ийм боломжууд нь байгаа болов уу гэж харж байна.

Б.Пүрэвдорж: Зарим Их Хурлын гишүүд бол малчдын хүүхдийг 7 настай оруулна, сургуульд оруулна гэж ярьдаг, энэ бол буруу. Малчдын хүүхэд 7 настай орчихдог, сумын төвийн хүүхдүүд 6 настай орчихдог, тэгэнгүүт тэр хүүхдийн боловсролын мэдлэгийн зөрүү гарч ирдэг. Тийм учраас ингэж ярьж байгаа хүмүүс бол энэ малчдын хүүхдийг малчнаар нь л байлгах бодлоготой л бодлого гэсэн үг. Тийм учраас энэ бүх хүүхдийг 7 настай оруулах, тэгэхдээ энэ 6 насанд нь заавал 12-оор төгс төгсгөнө гэж үзэж байгаа бол 6 насанд нь насан туршийн боловсролын төвийн багш нар яваад хичээл зааж болно. Дээрээс нь цахимаар хичээл зааж болно, бас яг тийм айхтар ачаалал авхуулахгүйгээр 6 настан нь танхимаар оруулахгүйгээр төгсгөх ийм бол ямар боломжийг хайж байгаа вэ.

Л.Энх-Амгалан: Тантай яг санал нэг байна. Та наад тайлбараа Туваан гишүүнд нэг сайн тайлбарлаад өгчхөөрэй. Яагаад, ямар үндэслэлээр бид нар 6 настайд нь сургуульд хамруулах ёстой вэ гэдгийг, тийм. Танд их талархаж байна, тийм. Тэгээд бид нар ерөнхийдөө нөгөө түрүүн би бас тайлбарласан даа, нөгөө хувилбарт сургалтуудыг л бид нар энэ 6 насанд нь өгчихье. Яагаад гэвэл ийм боломж бид нарт байна. Тийм учраас бол бид нар зуны

сургалт, танхимын болон танхимын бус сургалтууд, зайн сургалтууд, сая таны дурдсан насан туршийн боловсролын багш нараа ашиглаад ингээд ийм хувилбарт гэрийн сургалтууд хийчих энэ боломжууд нь байгаа гэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Үнэлгээний шалгуурууд чинь буруу яваад байна. Санамсаргүй түүврийн аргаар ингээд явуулах дээр зарим муу хүүхдүүд нь ингээд тэнд нь хамрагдаад түүнээсээ болоод багшийн үнэлгээ унадаг, тэгээд түүнээсээ хамгийн гол нь багш яадаг вэ гэхээр сэтгэл гутралд ордог, өөрийнхөө нэр хүндээ алддаг, цалин нь багасдаг ийм зүйлүүд гараад байна. Тэгээд энэ нь өөрөө бас тэр сургуулийн захиралд ч бараг мэдэгдэхгүй, дээрээс нь багш ч өөрөө юунаас болоод муу болсон гэдэг нь мэдэгдэхгүй ийм шалгуур байгаад байна. Үүнийгээ яаж зөв болгох юм бэ?

Л.Энх-Амгалан: Пүрэвдорж гишүүн ээ, бид нар муу хүүхдүүд, сайн хүүхдүүд, муу багш, сайн багш гэж ялгаж болохгүй ээ, энэ алдаа шүү, Пүрэвдорж гишүүн ээ, дахиж битгий муу хүүхэд, муу багш гэж ярьж байгаарай. Одоо бид нарын энэ үнэлгээний гол юу болбол ингээд багшийг багшид нь биш хүүхдийг хүүхэдтэй нь өрсөлдүүлэх биш, ерөөсөө ахиц дэвшлийн л үнэлгээ бид нар хийж байгаа юм, ахиц дэвшлийн үнэлгээ хийж байгаа юм. Тэгэхээр бид нарт нөгөө гарааны тэгш байдал л гэж яриад байна шүү дээ, одоо хүүхэд 9 сарын 1-нд хичээлээс эхлэхэд 1-12 дугаар ангийн хүүхэд яг гарааны ямар түвшинээс эхэлж байна вэ? Бариад хавар төгсөхдөө ямар барианд орж байна вэ гэдэг энэ үнэлгээний тогтолцоо. Энэ чинь бид нарын нөгөө яриад маргалдаад байдаг нөгөө кембриж гээд яриад байдаг юмны чинь амин сүнс нь энэ байхгүй юу, амин сүнс нь. Бид нар ерөөсөө үнэлгээнийхээ тогтолцоог зөв хийж байж л үр дүнд суурилсан санхүүжилт, чанартай боловсролын асуудлууд л ярих ёстой юм байна лээ.

Тэгэхээр энэ саяын харин ч манай багш нар, сурган хүмүүжүүлэгч нар, эцэг эхчүүд болбол энэ Монгол Улсад анх удаа хийж байгаа үнэлгээ шүү дээ. Тэгэхэд 35000 багшийг оролцуулсан эцэг эх, сурган хүмүүжүүлэгч нар нийт давхардсан тоогоор бол энэ чинь 1200000 хүн, хүүхдүүд, 480 гаруй мянган хүүхдүүд, 500 гаруй мянган эцэг эхчүүд, сурган хүмүүжүүлэгч нар, асран хамгаалагч нар оролцсон үндэсний хэмжээний маш том үнэлгээ хийгдсэн. Мэдээж анх удаа хийсэн учраас энэ дээр алдаа ч бий, оноо ч бий. Тийм учраас цаашидаа бид нар үүнийгээ сайжруулаад явах ёстой.

Гэхдээ бид нар нэг зүйлийг ойлгох ёстой. Энэ үнэлгээг бид нар багшийг багштай нь өрсөлдүүлж, хүүхдийг хүүхэдтэй нь өрсөлдүүлж, сургуулийг сургуультай нь өрсөлдүүлэх гэж энэ

үнэлгээг хийгээгүй. Энэ шалгалт биш, энэ оношилгоо энэ оношилгоо. Тийм учраас бид нар цаашидаа ингээд ахиц дэвшилийн үнэлгээг ингээд яг энэ энэ жилийнхээ хийсэн энэ суурь дээр үргэлжлүүлээд сайжруулаад явна гэж бодож байгаа. Бид нар удахгүй яг энэ хийсэн, үнэлгээ, оношилгооныхоо хэлэлцүүлгийг бүх сургуулиуд дээр хэлэлцүүлэг хийнэ. Тэгээд ирэх жилийн үнэлгээ оношилгоо болбол арай нэг тийм алдаа дутагдлаа зассан, ийм оношилгоо болгоод Монгол Улс боловсролын үндэсний үнэлгээний тогтолцоонд шилжиж байгаа ийм шинэ алхам хийж байгаа ийм шинэ зүйл болох болов уу л гэж бас харж хүлээж байна.

Б.Пүрэвдорж: Тэгээд наадах үнэлгээгээр чинь бас нэг тийм нэг ажлаа хийдэг нь биш, аргалж хуурдаг нь л бас урд гараад байгаа ийм тохиолдлууд бас гараад байгаа шүү гэдгийг хэлье. Багш нарын цалин нэмэгдсэн гэдэг нь ар маш их явуулж байгаа, яг угтаа бол нэмэгдээгүй шүү дээ, угтаа бол үр дүнгийн урамшууллыг л цалин руу шилжүүлээд л тэр нь тухайн сардаа авч байгаа цалин нь өндөр мэт харагдаад ингээд яваад байгаа. Тэгээд энэ дээр чинь яах вэ, залуу багш нарыг бол татах сайн талтай гэж ярьж байгаа. Гэхдээ ахмад багш нар бас нэг жоохон сэтгэл дундуур байгаад байгаа ийм тал байгаад байгаа юм. Үүнийг яаж шийдэх вэ? Багш тэр ахмад багш нарын асуудлыг

Л.Энх-Амгалан: 2-уулаа энэ дээр энэ танхимд цалин нэмэгдсэн нь нэмэгдээгүйг 2-уулаа хэрэлдэж маргалдаж суух нь утгагүй байх аа. Сумын төвийн багш нартай уулзалт хийгээд үзээрэй, та цалин нэмэгдсэн үү, нэмэгдээгүй юу гээд асуугаад үзээрэй. Ингээд цалин гэхээсээ илүү бид нар энэ багш нарынхаа цалин хөдөлмөрийн үнэлэмжийн тогтолцоог л зөв болгоё л гэж оролдсон оролдлого юм байгаа юм л даа. Манай багш нар чинь өөрсдөө нөгөө нэг суурь цалин жаахан өндөр байх ёстой гэж хэлдэг байхгүй юу. Яагаад гэвэл мэдээж нөгөө ипотекийн зээл авахад гэдэг юм уу, ингээд энэ чинь хамгийн чухал хүний амьдралд чухал юм чинь болбол суурь цалин нь өөрөө их өндөр байх ёстой юм байна лээ. Тэндээс нөгөө суурь цалингаас бүх нөгөө урамшуулууд нь бодогддог учраас суурь цалин бид нар аль болохоор л боломж гарвал дээш нь ингээд өсгөөд байх нэг ийм л оролдлогуудыг бид нар хийсэн юм байгаа юм. Тийм учраас мэдээж үр дүнгийн нөгөө үр дүн тооцогддоггүй, үр дүнгийн тайлангаа гаргаж өгдөггүй хавтгайрсан байсан энэ үр дүнгийн урамшуулуудыг бид нар цалингийн нэг хэсэг болгосон нь үнэн, энэ үнэн. Гэхдээ үр дүнгийн урамшуулал олгоно гээд сургуульд нь мөнгө хуваарилаад, зарим нь сургуульд нь энэ мөнгө хуваарилагдаж очдоггүй байсан, очдоггүй байсан. Олон зуун мянган багш нар хохирч үлддэг байсан. Энэ дээр ингээд тэр үр дүнгийн урамшууллыг суурь цалингийн нэг хэсэг болгоод дахиад дээрээс нь бид нар 5 шатлалтай

байсан шатлалыг хамгийн дээд талынх нь шатлал дээр нэг шатлалтай тогтолцоотой бид нар шилжүүлсэн. Энэ болбол залуу багш нар болбол маш том итгэл үнэмшил болсон.

Олон жил ажиллаж байгаа багш нар буюу манай нийт багш нарын 40 хувь болбол дандаа олон жил ажилласны буюу мэргэжлийн зэргийн нэмэгдлүүд авдаг, энэ багш нар. Гэлээ гэхдээ бид нар энэ тодорхой гомдол үүссэн учраас энэ дээр бид нар тодорхой цалингийн индекс хийсэн шүү дээ, Пүрэвдорж гишүүн ээ. Тийм учраас энэ болбол нэг 10 хүрэхгүй мянган багш нарын хүрээнд гарсан асуудал, одоо энэ дээр бол бүгд сэтгэл өндөр үлдсэн болов уу гэж бодож байна. Ямар нэгэн тийм ялгаварлал энэ дээр үүсээгүй ээ гэдгийг бас хариуцлагатайгаар би хэлье.

Б.Пүрэвдорж: Ер нь бол бараа бүтээгдэхүүний үнэ бараг 40 хувиар өсчихсөн, зарим бараа бүтээгдэхүүн нэг дахин өсчихсөн. Тэгэхээр 2023 онд багшийн цалин хэдэн хувиар нэмэх вэ, яаж нэмэх вэ гэдгээ асуулт.

Л.Энх-Амгалан: Сайн багшийн цалин нэмэгдэнэ ээ, чадварлаг багшийн цалин нэмэгдэнэ. Тэгэхээр энэ үр дүнд суурилсан санхүүжилтийн хамгийн гол хөшүүрэг болбол ерөөсөө гүйцэтгэл өндөртэй багш нар өндөр цалин руу өндөр, урамшуулал авах энэ тогтолцоо руу л орж байгаа. Тийм учраас цөмөөрөө нийтээр нь ингээд нэг цалингийн нэмэгдэл ярьдаг биш, үр дүн, гүйцэтгэлд суурилсан, бүтээмж өндөртэй ийм төрийн албан хаагч нар байж байж л төрийн бүтээмж би дээшлэх болов уу л гэж боддог шүү дээ. Энэ ч аль ч салбар дээр бас нэг ийм цалин нэмэх гэдэг цалингийн нэмэгдэл гэдэг бол Ганбаатар гишүүн байх шиг байна. Бүх улс орон цалингийн нэмэгдлийг хөдөлмөрийн бүтээмжтэй шууд уялдуулдаг, хөдөлмөрийн бүтээмжтэй шууд уялдуулдаг. Тийм учраас бид нар энэ үр дүнд суурилсан санхүүжилт гэдэг бол энэ хэлбэр лүү орж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Багшийн хангалтын асуудал байна, багшийн хангалтын асуудал. Өөрөөр хэлбэл өнөөдөр бол химийн багш, математикийн багш, цэцэрлэгийн багш нар маш хангалт муутай байгаа, түүн дээр Боловсролын яамны хувьд ямар ямар арга хэмжээгээр авах гэж байгаа вэ? Богинохон асуугаарай надад дөрөвхөн минут үлдээд байна, хариулаарай.

Л.Энх-Амгалан: Улсын хэмжээнд 1171 багшийн хомсдол үүсэж байгаа гэдгийг бас би түрүүн хэлсэн. Бид нар ерөнхийдөө энэ байгалийн ухааны багш нараа, бид нар энэ МУИС дээр физик, хими, математикаар төгссөн багш нарыгаа дүйцүүлсэн хэлбэрээр сургалтууд явуулж энэ багшийнхаа хангалтуудыг нэгдүгээрт нөхье.

2 дугаар асуудал болбол танхимын болон танхимын бус сургалт хийж байгаа энэ цахим мэдлээ.мн гэдэг энэ сургуульд сонгоны хичээлийг нөхөж хийж байгаа Монголын хамгийн сайн багш нарын хичээлийг хамгийн сайн багш нараар хичээл заалгаж байгаа энэ цахим сургуулийн хэлбэрээр л бид нар энэ тэгш боломжуудыг л хүүхэд бүрд хангая л гэсэн ийм шийдлүүдийг дунд болон урт хугацаанд харж байна.

Б.Пүрэвдорж: Манай ээж багш хийж байгаад тэтгэвэрт гарсан юм, жаран настай. Тэгээд тэтгэвэрт гарангуут Энх-Амгалан сайд аа, манай ээж багш хийж байгаад тэтгэвэрт гарсан юм, тэгээд тэтгэвэрт гарангуут маш хурдан хөгширсөн, тэгээд яадаг гэхээр тэр хүүхэд шуугьсан тэр танхимаасаа гараад л тэгээд тэр чинь маш хурдан хөгширч байна гэсэн үг шүү дээ. Тийм учраас багш тэр хүүхдүүдтэйгээ зааж байгаа хүүхдүүдтэйгээ бол тийм сэтгэл зүрхнээсээ холбоотой байдаг байхгүй юу. Тийм учраас тэр зүрхэндээ тангарагтай тэр багш нарт та нар ингээд дарга нарын өмнө та өмнө нь тангараг тавиулаад яадаг юм бэ? Тэр ямар ач холбогдолтой юм бэ? Ийм хачин коммунист юмаа хэзээ болих юм бэ?

Л.Энх-Амгалан: Энэ тангараг биш л дээ, Пүрэвдорж гишүүн ээ, та буруу ойлгоод байх шиг байна. Энэ андгай юм тийм, Монголын андгай, андгай буйзаа гэж их сайхан үг байдаг. Тэгээд энэ сургуулийн орчинд үүсэж байгаа, энэ сургуулийн нэг үеийнхний дээрлэхэлт, гадуурхалт, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа энэ олон асуудлууд ёс зүйн асуудлууд үүсэж байгаа учраас энэ дээр ингээд нийгмээрээ энэ хэлэлцүүлгүүдийг хийчихсэн шүү дээ. Магадгүй энэ андгай өргөж байгаа асуудал болбол манай Монголын багш нарын нэр хүндийг нийгэмд маш их өсгөж байгаа, маш их өсгөж байгаа. Үүнийг бид нар зөв талаас нь, эерэг талаас нь харж тайлбарлах ёстой болов уу гэж би бодож байна.

Б.Пүрэвдорж: Манай Мөнххайрхан сумын Хаг багийн иргэн Мөнхтуул асуусан, би бага насны 3 хүүхэдтэй, тэр 3 хүүхэд маань сумын төв рүү айлд өгөх дээр 3 эрэгтэй хүүхэд учраас сахилгагүйтэйд болдоггүй, байранд өгөх дээр бас асуудалтай. Тэгэнгүүт бид нар ингээд өвөл малаа хүнд хөлсөөр өгчхөөд хүүхдээ дагаад сум руу ордог оо. Гэтэл 12 сарын 25-нд хүүхдийн амралт аваад 2 сарын 1 хүртэл амардаг, бид нар сумын төв дээр хий эргэсээр байгаад таарч байна. Тийм учраас энэ хот хөдөөгөөр нь ялгаад хотын хүүхэд нь тэр түгжрэлтэй, хүйтэн, утаатай үедээ амардаг юм байгаа биз. Харин малчдын сумын төвийн хүүхдүүдийг 3 сарын 1-нээс 4 сарын 10 хүртэл амрааж өгөөч ээ гэдэг ийм хүсэлтийг тавиад байна. Та энэ дээр ямар хариулт өгөх вэ. Ялгаатай амрааж болох уу?

Л.Энх-Амгалан: Бид нар бүгдээрээ боловсрол ярьдаг, бүгдээрээ боловсролын тухай бид нарын ойлголт бас их өөр өөр байдаг. Сая ковид гэж нэг айхтар юм гараад бүтэн 2 жилийн хугацаанд бид нар хичээл сургуулиа хаасан. Үүнээс болж хамгийн том хохирол үзсэн салбар бол боловсролын салбар. Ковидын хоцрогдол нөхөгдөж эхлээгүй байхад яг малчдын хүүхэд дээр тохирсон, дахиад ингээд ийм богино хугацаанд сургалт хийх нэг ийм хувилбар сургалтыг эхлэх юм болбол дахиад л та түрүүн өөрөө өөрөө өөртэйгөө зөрчилтэй зүйл хэлчих шиг боллоо л доо. Малчны хүүхэд малчин байж болохгүй шүү дээ тийм ээ, насаараа тийм, тэр тийм учраас ингээд бид нарын улс төрчдийн нэг ийм хичээлийн хөтөлбөрт нэг өөрчлөлт хийх гэдэг ингээд хичээлийн хуваарьт өөрчлөлт хийх гэдэг нэг ийм зоргоороо асуудлуудыг бий байж болохгүй юм байна л гэж бодож байгаа юм. Одоо ерөөсөө энэ нэг хүүхдэд оногдож байгаа цагийн ачааллууд үзэх ёстой хичээлүүд, энэ чинь бас ингээд энэ тооцоо судалгаа нотолгоо дээр хийгдэж байгаа зүйлүүд шүү дээ.

Энэ Монгол Улс чинь Боловсролын үндэсний хүрээлэн гэж бас нэг юм байдаг шүү дээ. Монгол хүүхдийн насны онцлогт тохирсон, энэ үзэх ёстой хичээлүүд, унших ёстой номууд гэдэг нэг ийм асуудлуудыг цөмөөрөө нэг ийм, хөнгөн гоомой хандаж болохгүй юм байна л гэж би ойлгоод байгаа юм. Би ч гэсэн яах вэ, Боловсролын сайд болоогүй байхдаа бас нэг ийм хөнгөн гоомой бас бодолтой байсан, байсан, тийм.

Г.Занданишатар: Асуулт, хариултын цаг дууссан.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Таных 20 секунд хэтэрчихсэн байна.

Б.Пүрэвдорж: 20 секунд дутуу байна шүү дээ, дарга аа.

Г.Занданишатар: Цаг дууссан. Одоо хариултын цаг байхгүй.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

16.18 цаг

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл/Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэл/

14 цагийн мэдээллийн цаг, асуулт хариултын цаг сая мэдээ сонсож дууссан.

Одоо илтгэл, дүгнэлттэй болон төсвийн төсөлтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нараас үргэлжлүүлэн асуулт асууна. Асуултаа сэргээе.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Миний хувьд бол 23 оны төсвийн хуулиас бол асуух асуулт байхгүй ээ. Яагаад гэхээр 2019 онд орсон Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд Засгийн газраас оруулж ирсэн бодлогыг Улсын Их Хурал бол ер нь ёсчлох би үүрэг хүлээж байгаа гэж үзэж байгаа. Тийм учраас бол Үндсэн хуулийнхаа энэ үзэл санаанд байж, төсвийн хуулийг бол ЗГ-ын өргөн барьсан хэмжээнд нь би батлах ёстой гэж бодож байгаа. Харин төсвийн хуулийг дагалдуулж орж ирсэн хуулиудтай холбоотой бол асуулт байна. Яагаад гэхээр ер нь энэ хуулийн хулгай гэж би ч их ярьдаг хүн. Энэ дагасан хуулиудыг л нэлээн сайн үзлээ.

Г.Занданиатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн ээ, Энхбаяр гишүүн ээ, уучлаарай. Энэ дагасан хуулиуд бол ирэх 7 хоногоос Байнгын хороо дээр тус тусдаа бүх хуулиуд дээр хэлэлцэнэ шүү дээ.

Б.Энхбаяр: Энэ нөгөө төсвийн хууль дээр төсөв нь яваад байгаа юм, тэгвэл төсвийн хуулиас асуучихъя.

Г.Занданиатар: Төсвийн хуулиас асууж болно.

Б.Энхбаяр: Төсвийн хуулиар, нэгдүгээрт Нэгдүгээрх асуулт, Эдийн засгийн хөгжлийн сайдаас. Тэгэхээр эдийн засгийн хөгжил нэлээн асуудалтай байна гэж үзэж бид Эдийн засгийн хөгжлийн яамтай болсон. Ингээд давхар дээл өмсөж, бас нэлээн туршилагатай хүнээ тавьсан. Гэтэл нөгөө давхар дээл дээр дахиад нэг цол чимэг тэрлэг нэмж Шадар сайд болох гэж байгаа юм байна. Тэгэхээр заавал Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд болж байж ажиллах гээд байгаагийн учир бас юу юм бэ. Энэ ямар чиг үүрэг, төсөв нэмэгдэж байгаа юм бэ гэсэн эхний асуулт байна.

2 дахь асуулт нь энэ манайх чинь гол орон нутгийн орлого бол энэ газрын төлбөрөөс олдог орлого байгаад байгаа юм. Тэгтэл жишээлбэл, Улаанбаатар хотын тухайд гэхэд газрын төлбөрөөс бол 120-130 тэрбум төгрөг олдог, ингээд төвлөрүүлдэг, ингээд эргээд санхүүжилтээ явдаг. Тэгтэл энэ газрын хууль болон газар өмчлөлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад хотоос гаднах бүх орон нутгийн газрыг

үнэгүй эзэмшүүлж, үнэгүй өмчлүүлэх тухай агуулгатай ийм асуудал байгаад байна. Тэгэхээр энэ хэдэн төгрөгийн ямар хэмжээний үнэтэй газрыг өмчлүүлээд, үнэгүй өмчлүүлээд, тэгээд ямар хэмжээний төсөвт орлого олох боломжийг бид хаах гээд байна вэ гэсэн ийм асуулт байгаад байгаа юм.

3 дугаарх асуулт нь энэ гүйцэтгэх эрх мэдлийн хяналтын тухай хууль гэж орж ирж байгаа, энэ хуулийг бол би дэмжиж байгаа. Ер нь бол ЗГ, Улсын Их Хурлын өмнө хуулийн хэрэгжилтийг гол хариуцдагийн хувьд бол энэ дотоод хяналт, мониторинг гэдэг юм бол ЗГХЭГ дээр төвлөрч байх энэ үзэл санааг бол би дэмжиж байгаа юм. Энэ дээр энэ байгууллага нь болохоор шинээр нэг агентлаг байгаад байгаа байхгүй юу, нэг агентлаг, хяналтын агентлаг гээд. Энэ агентлаг нь болохоор ЗГХЭГ-ын жишигээр цалинжинга гээд байгаа юм. Тэгээд энэ бодохдоо болохоор энэ магадгүй Хэрэг эрхлэх газрынхны цалин арай илүү өндөр, агентлагийнхны цалин арай бага учраас ингээд орчхов уу, яачхав. Ер нь бол жишиг нь бол буруу байгаад байгаа юм. Яагаад гэхээр Монголд манайд чинь 48 агентлаг байгаа. Ганц агентлагийг нь сугалж аваад тусдаа цалингаар явна гэхих юм бол энэ бол бусад ЗГ-ын агентлагууд бол үүнтэй барьцах асуудал үүсэх вий дээ гэдэг ийм болгоомжлол надад бол байна. Тэгээд сүүлийн 30 жилд бид нар энэ ЗГ-ын яамдын тухай хууль, Агентлагийн тухай хууль гээд эрх зүйн байдлын тухай хууль гаргасан. Энэ юутай холбоотой вэ гэхээр энэ өөрөө бас тодорхой ... /минут дуусах/

Г.Занданиатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуултад хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Миний хувьд энэ эхний буюу Эдийн засгийн хөгжлийн яамыг яагаад байгуулсан юм, яагаад энэ яамны статус чухал байгаа юм бэ гэдэг тал дээр бодлоо хэлчихье ээ гэж бодож байна. Ер нь 2019 онд бид нар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийгдсэн. Тэр бүгд протоколоороо байгаа. Нэг яригдсан асуудал бол өнгөрсөн 30 жил, ер нь гүйцэтгэх засаглал нэгдүгээрт гэхэд тогтворгүй байлаа, дундаж нас 1,5-1,6 орчим жил үүнээс болоод хариуцлага нэлээдгүй түвшинд алдагдлаа. Эхлүүлсэн олон ажил байдаг байсан боловч дуусгасан ажил туйлын цөөхөн байна.

Хоёрдугаарт, хөгжлийн бодлого төлөвлөлт туйлын тогтворгүй явж ирснээс болж байгаа боломжоо бид нар бүтэн ашиглаж чадсангүй ээ. Энэ хугацаанд төлөвлөлтгүй явснаас болж өнөөдрийн нийслэл Улаанбаатар хотын түгжрэлээс эхлээд олон олон асуудал дээр бодлогын залгамж чанарын алдаа гарчээ гэдэг ийм дүгнэлт, эрдэмтэн судлаачид хийсэн. Ингээд

2019 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж Үндсэн хуульдаа оруулсан. Үүний дараа Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсан. Ингээд Эдийн засгийн хөгжлийн яам төлөвлөж, Сангийн яам санхүүжүүлнэ, Сангийн яам хөгжлийн бодлого төлөвлөлтийг давхар авч явах нь бол буруу юм гэдэг ийм концепц яригдсан. Ингээд тэр үед л яригдаж байснаар, ер нь бол Эдийн засгийн хөгжлийн яам бол бусад яамны уялдаа холбоог хангана, нэгдсэн төлөвлөлтийг хийнэ, тооцоо судалгааг хийнэ. Тийм учраас аж ахуйн яамнууд болон эдийн засагтай холбоотой хөгжилтэй холбоотой бүх яамдыг нэгдсэн координатаар хангана гэдэг энэ жишиг рүү явах нь зүйтэй гээд ингээд бид нар хуулиа баталчихсан.

Тэгэхээр тухайн үед яригдаж байсан зүйлээ л хийж байгаа энэ нэг тийм шинэ агуулга биш, яагаад гэхээр бусад улсуудын жишиг бас тийм л байгаа юм. Жишээлбэл, манай 2 хөри гэхэд гол түни, манай БНХАУ гэхэд Хөгжил, шинэтгэлийн хороо гээд бүх яамнуудынхаа дээр байдаг бүтэц. Хөгжил, шинэтгэлийн хороо нэгдсэн төлөвлөлт хийнэ, түүнтэй уялдаж Сангийн яам санхүүжүүлнэ. ОХУ-д бас адилхан, бусад улсууд ч гэсэн адилхан. Тийм учраас бидний хувьд илүү, энэ бол яам нэмэгдээгүй учраас энэ бол зүгээр статусыг нь өргөж өгч байгаа л гэж ойлгох ёстой. Олон улсын нийтлэг жишигт ингээд уялдуулаад явах нь зүйтэй юм гэж бодож байгаа юм.

Тэгэхээрээ цаашидаа энэ бодлогын хүрээнд энэ 2023 оны бараг төсөв анх удаа ингэж орж ирж байгаа. Цаашидаа 3 сард юм уу, 4 сард Эдийн засгийн хөгжлийн яаман дээр яамд мэтгэлцэж төсвөө зангидна. Түүн дээр Их Хурал орж ирж үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг батална. Батлагдсан зураг төсөвтэй үйл ажиллагааг л Сангийн яам санхүүжүүлнэ. Энэ бол шинэ 30 жилийг бас эхлүүлэхэд өнгөрсөн хугацааны алдаа оноог дэнслэхэд туйлын чухал гэдэг агуулгаараа хандаж байгаа юм. Тийм учраас үүнийг бол тухайн үеийн 2019 оны Үндсэн хуулийн концепцын дагуу яригдаж байсан протоколынхоо дагуу оруулж ирж байгаа. Түүнээс Хүрэлбаатар сайдтай өөртэй нь бол холбоотой асуудал биш юм гэдгийг тайлбарлах нь зүйтэй болов уу.

Бусад асуудлаа Хүрэлбаатар сайд өөрөө хариулах нь зүйтэй байх.

Г.Занданишатар: Амарбаясгалан дарга хариулах уу. 91. Дагасан хуулиуд, төрийн үйлчилгээний агентлагийн талаар

Д.Амарбаясгалан: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Шинээр өргөн баригдаж байгаа энэ төсөв дагаж өргөн баригдсан хууль

дотор байгаа энэ гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулийн төслөөс асуулаа. Ерөнхий сайд Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлээр төрийн хуулийн хэрэгжилтийг Улсын Их Хурлын өмнө хариуцна гэсэн ийм заалт байдаг. Энэ утгаараа ЗГХЭГ дотор энэ төрийн гүйцэтгэх засаглалын дотоод хяналт шалгалтын агентлагийн дарга нь дэд даргын статустайгаар ажиллах нь зөв юм гэсэн энэ үндэснээс энэ хуулийг болбол оруулж ирж байгаа.

Цалингийн зэрэглэлийн хувьд болбол бусад яамдтайгаа цалингийн зэрэглэл болбол жигд байдаг. Энэ дээр ямар нэгэн байдлаар илүү байдаг гэсэн ойлголт болбол байж болохгүй ээ гэж ингэж хариулмаар байна.

Төсөвт дарамт ирэх, эс үгүй бол орон тоо нэмэгдэх цалин төгрөг, төсөв нэмэгдэх гэдэг ойлголт болбол байж болохгүй. Учир нь МХЕГ 1400 байцаагчтай, үүнээс харьяа мэргэжлийн яамдад мэргэжлийнхээ чиг үүргийн дагуу байцаагч нар болбол шилжин ажиллана. Мөн 200 гаруй төрийн албан хаагч нь энэ төрийн гүйцэтгэх засаглалын дотоод хяналт шалгалтын агентлагт ирж ажиллахаар болбол зохицуулалт хийгдэж байгаа гэдгийг энэ дайрам хэлье.

Г.Занданишатар: Бэгзжавын Мөнхбаатар Барилга, хот байгуулалтын сайд. Яамнаас хэн байгаа билээ.

Зочид танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Жамъянгийн Мөнхбат, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг нарын урилгаар Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ИТХ-ын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Архангайчууд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Газрын хуулиар хэн хариулах юм бэ. Мөнхбаатар бол нь өглөөнөөс хойш суусан Магнайсүрэн дарга байж байна. нэг номер. Магнайсүрэн дараг хариулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Яг дагасан хуультай холбоотой асуудал л даа. Дагасан хууль Газрын хууль дээр яг энэ асуудал байгаа юм. Ер нь Энхбаяр гишүүн ээ, үүнийг их томоор нь бид "шинэ сэргэлтийн бодлого", хот хөдөөгийн хөгжил, тэнцвэртэй хөгжил гээд энэ бодлоготой байгаа уяж үүнийг хараарай, энэ цонхоор нэг хараарай.

3,3 сая хун амтай, тал нь нийт газар нутгийнхаа 0,3 хувь дээр нь бид ингэж бөөгнөрч

амьдарч байгаа. Бид дэлхийд дээгүүр ордог нэг том л үзүүлэлт байдаг, энэ нь нэг хүнд ноогдох газар нутгаараа. Гэтэл энэ хөгжлийн юу гэдэг юм бэ дээ, гажуудал гэх үү, юу гэх үү. Ингээд ерөөсөө нэг хувьд нь ч хүрэхгүй газар нутаг дээрээ тал хүн ам маань оришиж байгаа нь бас хөгжлийн тэнцвэрт бус байдал энд хүчтэй нөлөөлж байгаа маш том хүчин зүйл болсон. Тийм учраас үүнийг бид “шинэ сэргэлтийн бодлого”-ын нэг гол тулгуур гэж үзэж байгаа юм, үзэж байгаа юм. Тэгээд ер нь яагаад ийм байна. Яагаад нүүдэл ер нь орон нутгаас Улаанбаатар руугаа яваад байна, яагаад Улаанбаатараас орон нутаг руу нүүдэл бий болгохгүй байна, яагаад тэнд хүн амын маань аз жаргалын индекс муу байна вэ гээд ингээд судалгаа үзэхээр Улаанбаатараас хот хөдөө рүү чиглэхгүй байгаа хамгийн нэгдүгээр шалтгаан энэ ерөөсөө газрын асуудал болж ирж байна лээ, судалгаагаар. Тийшээ очно, яг өмчийн харилцааны асуудал гэсэн үг. Хүн одоо Монголын иргэн хүн бүр нэг удаа үнэгүй газар эзэмших, өмчлөх эрх үүссэн байгаа юм, эрх үүссэн байгаа. Энэ нь Улаанбаатартаа Улаанбаатарын энэ бүсдээ ишгдээд байх бас нэг ийм шалтгаан болоод байна. Тийм учраас хөдөө рүү чиглэж очиход тэнд оршин суухад энэ эрхийг дахин нэг удаа эдлэх ийм боломжийг нь олгоё оо гэсэн ийм бодлого ийм шийдлийг санал болгож оруулж ирж байгаа юм. Түүнээс биш энэ дотор төсөв дээр төсвийн орлогод нөлөөлөх хэмжээнд, эсвэл төсвийн орлогоо алдах эсвэл төсвийн орлогоо орон нутаг руу шилжүүлэх ч гэдэг юм уу, төсвийн тийм, орлого зарлагын бодлогоосоо илүүтэйгээр яг энэ хөгжлийн бодлогын асуудлаа бид нэгд тавьж, ингэж оруулж ирж байгаа юм шүү.

Тэгээд яг дагасан хуулиудыг нэг бүрчлэн яриад эхлэхээр яг энэ Газрын харилцааны тухай хуулийг ажлын хэсэг дээр юу Байнгын хороод дээр ярина, тэр үед яг энэ хуулийг ярья.

Та өнөөдөр яг төсөвтэй холбож асуусан учраас төсөв дээр болбол орлого зарлага дээр нөлөөлөх зүйл онцын зүйл бол тийм зүйл бол байхгүй.

Г.Занданишатар: Баттөмөр Энхбаяр гишүүн тодруулж асууна, 1 минут.

Б.Энхбаяр: Нэгдүгээрт, хэдхэн сарын өмнө Засгийн газраас өргөн барьсан Газрын багц хуулийн үзэл санаанаас энэ огт өөр концепц оруулж ирсэн.

Хоёрдугаарт, газар өмчлүүлэх асуудал бол төсөв дагуулж шийддэг асуудал биш, энэ их суурь асуудал. Бид нар 20 жил угаасаа үнэгүй өмчлүүлээд явж байгаа, угаасаа. Тэгээд Улаанбаатар хотынхон үнэгүй газар авах

боломж одоо ч байгаа, тэгээд явахгүй л байгаа шүү дээ. Угаасаа одоо Засгийн газраас газрын төлбөрийн 95-98 хувийг төлбөрөөс чөлөөлж байгаа, угаасаа. Одоо нэмэх нь 2, 3 хувийн чөлөөлөлт үзүүлэхээр хотоос гараад явчихна гэж би итгэхгүй байна, итгэхгүй байна. Тийм учраас энэ бол газрын хуулийн асуудлыг дахиж ярих ёстой байх гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт энэ ЗГХЭГ-ын дэд дарга нь агентлагийн даргыг давхар хавсардаг ийм бүтэц бол байдаггүй шүү. Ийм хууль орж ирсэн байна гэдгийг хэлмээр байгаа юм.

Г.Занданишатар: Хэн хариулах уу. 91. Ганбат дарга хариулъя. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга хариулна.

Энхбаяр гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Ганбат. Тэгээд өргөн барьсан хуулийн төсөл дээр дагаад ер нь бол ЗГ-ын дотоод хяналт буюу хяналт шалгалттай холбогдолтой ийм анхдагч хуулийн төсөл орж ирж байгаа. Энэ анхдагч хуулийн төсөл дээр ЗГ-ын хяналтын асуудлыг хариуцах энэ агентлагийн дарга нь статусын хувьд бол ЗГХЭГ-ын дэд дарга бөгөөд энэ агентлагийн дарга байна гэдэг ийм зохицуулалтаар орж ирж байгаа, орж ирж байгаа. Ингээд ер нь бол түвшин түвшингээр нь харах юм болбол ийм зохицуулалт болбол бусад хууль тогтоомжуудын хүрээнд бол явж байгаа практик явж байгаа ийм зохицуулалт бас явж байгаа л даа. Жишээлбэл агентлагийн түвшинд гээд ингэх юм болбол түвшинээр нь харахад бол агентлагийн түвшинд бол ... /минут дуусав/

Г.Занданишатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Нэгдүгээрт, энэ нөгөө ЗГХЭГ чинь бүх яамд, агентлагийнхаа ЗГ-ын түвшинд мониторингоо хариуцаж байгаа байхгүй юу. Түүнийх нь дэд дарга нь өөрийнхөө хариуцааг агентлагийн дарга хийдэггүй байхгүй юу. Ийм бүтэц байдаггүй юм, Улсын Их Хурлын дэд дарга бөгөөд сайд гэж явдаггүй байхгүй юу. Нэг нь нөгөөгөө хянадаг алба, институц. Тэгээд энэ бүтцийн хувьд болохгүй байна гэж хэлэх гээд байгаа юм.

Хоёрдугаарт, энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль төрийн үйлчилгээний нэг байгууллага байгаа юм. Энэ байгууллагын 32.5-д эрх хэмжээн дээр энэ Улсын Их Хурлын удирдлага нь томилогддог байгууллагын үйлчилгээг энэ байгууллага хариуцна гээд биччихсэн байгаа юм. Жишээлбэл, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллага чинь АТГ байж байна, Авлигатай тэмцэх газар. Тэгэхээр энэ төрийн үйлчилгээний газар энэ АТГ-ийн үйлчилгээг хариуцна гэж унишгдаад байгаа байхгүй юу. Энэ

яг юу хариуцах гээд байгаа юм, энэ төрийн. Их Хурлын бүтцийн байгууллагуудын үйлчилгээг энэ байгууллага хариуцна гэдгийг би энэ ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа байхгүй юу. Энэ ямар учиртай байгууллага ... /минут дуусав/

Г.Занданишатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тэгэхээр ер нь болбол өнгөрсөн хугацаанд төрийн үйлчилгээ иргэдэд хүнд суртал үүсгээд байгаа ажлууд дээр болбол бас тодорхой үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байгаа. Төрийн үйлчилгээ цахимжиж байгаа хэдий ч анхан шатанд болбол бас хүнд суртал үүссээр байна гэдэг гомдлыг болбол иргэд илэрхийлж байгаа юм. Тэгэхээр үүн дээр болбол хэд хэдэн саад тоггор учирч байгаа юм. Үүнд болбол нэг тийм маш олон дүрэм журмууд нь хуультайгаа нийцэхгүй байдал болбол их байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар бид нар цахим баримт бичгийг цаасан баримт бичиг байна гээд хуульчилчихсан байтал яг бас холбогдох хуулиудаар заавал бичгээр шаардаад байгаа. Ингээд хуулийг нь судлаад үзэхээр нийтдээ бараг 110 орчим хууль дээр энэ бичгээр гэдэг үг байгаа. Тийм учраас ялангуяа хууль шүүхийн практик дээр хараад үзэхэд процессын хуульдаа заавал бичгээр шаардаад байгаа учраас бид нар бичгээр бичиг баримтыг боловсруулаад ингээд шаардлага үүсээд байна гэж ярьдаг. Тэгэхээр эдгээр хуулиудын дүрэм журмуудыг бас энэ түгжрэлээс гаргах шаардлага бол зайлигүй үүсэж байгаа. Тийм учраас өнөөдөр төрийн үйлчилгээ хаана их хүнд суртал үүсээд байна гээд харахаар нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нэг цэгийн үйлчилгээнүүд, аймгуудад байгаа нэг цэгийн үйлчилгээнүүд гэдэг нэг ийм яг хаана, хэн хамаараад байгаа нь ойлгомжгүй, ийм олон байгууллагуудтай болчихсон. Шууд цахимжъя гэхээр нэг цэгийн үйлчилгээнүүдээс шууд халах бас бололцоогүй. Тэгэхээр бид нар энэ нийслэлийн нэг цэгийн үйлчилгээнүүд, аймаг орон нутагт байгаа нэг цэгийн үйлчилгээнүүдийг менежментийн хувьд зөв зохион байгуулалтад оруулах ёстой юм байна гэдэг үүднээс нь болбол ямар нэгэн төсөв мөнгө нэмэхгүйгээр, ямар нэгэн хүн нэмж томилохгүйгээр, цалинтай нь урсгал зардалтай нь шилжүүлээд энэ төрийн үйлчилгээний агентлаг үйл ажиллагаагаа явуулах буюу ... /минут дуусав/

Г.Занданишатар: Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Би товч тодорхой 2 асуулт асууя. Нэгдүгээрт, нэгэнт л төгрөг, долларын хани сулраад, энэ их том асуудал болж байгаа болохоор яалт ч үгүй төлбөрийн тэнцлийн

алдагдалтай холбоотой, мэдээж хэрэг бид нар экспортоо дэмжих, энэ төсөв дээр бас энэ талаар санаа санаачилга орсон байна. Импортыг бас хязгаарлах нь бас тодорхой хэмжээгээр авах ёстой арга хэмжээ гэж бодож байна. Яагаад гэвэл ингэснээр бид нар бас валютын гадагшлах урсгалаа барих юм байна. Түүнтэй холбоотой энэ төсөв орж ирэхээс өмнө уул нь тансаг хэрэглээний татварыг оруулж ирнэ гэж ярьж байсан юм, энэ маань тэгээд ер нь орж ирэхгүй хаягдчих шиг боллоо л доо. Жишээлбэл, өндөр үнэтэй том оврын суудлын авто машины импорт одоо онцгой албан татварыг нэмж оруулах тийм эдийн засгийн хөшүүрэг оруулж ирнэ гэсэн тийм хүлээлт байсан. Одоо зуун сая, зуун саяын үнэтэй автомашины импорт, зуун саяас дээш үнэтэй автомашины импорт нийт автомашины импортын 35 хувийг нь эзэлж байна л даа, үнийн дүнгээрээ. Тэгэхээр энэ болбол нэлээн том бас хөшүүрэг болно гэж хараад байгаа юм.

Хоёрдугаарт, энэ бас түгжрэлтэй холбоотой асуудал. Тансаг хэрэглээний татвар бол нэг их олон нийтийг хамарсан тийм бол татвар болохгүй гэж би харж байгаа юм. Уул нь бол үүнийг оруулаад ирсэн байвал бас зөв байхаар байсан юм.

Хоёрдугаарт түгжрэл. Нийслэлийнхэн түгжрэл ингээд л өдөр болгон ярьж байна. Нийслэлийн 23 онд бол нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр төсөв мөнгөө батлуулж байгаа нь бол зөв. Үүнийг бол дэмжиж байгаа. Гэхдээ үүнийг дагаад бас буруу талдаа хүртэй автомашины тоог хязгаарлах нь бол тэгээд энэ асуудлыг бид нар ярих цаг нь ирчихсэн шүү дээ. Мэдээж хэрэг бид нар, гишүүд бол энэ аягүй эмзэг асуудал болохоор үүнийг ярихаас айж эмээдэг. Гэхдээ үүнийг бол бид нар ярих хэрэгтэй. Автомашины тоогоо бид нар хязгаарлахгүй гэвэл хэчнээн зам гүүр бариад бид нар бол энэ түгжрэлийн асуудлаа шийдэхгүй. Тэгэхээр энэ эдийн, би бол одоо хөдөлгөөнд оролцоод улсын дугаараа аваад явж байгаа машинуудын тоог бол огт яриагүй, шинээр импортоор орж ирэх машины тоог ярьж байна. Эдийн засгийн хөшүүргээр нь татварыг нь нэмээд энэ тоог нь шат дараатай жилээс жилд ингээд хязгаарлаад хэзээ нэгэн цагт бид нар буруу талдаа хүртэй автомашиныг импортлохыг нь зогсоох хэрэгтэй гэж бодож байна. Тэгэхээр энэ одоо хүртэл хос хөдөлгүүртэй хайбрид машинууд импортын татварын хөнгөлөлт эдэлсээр ирж байгаа шүү дээ, тийм ээ, Жавхлан сайд аа, тэгэхээр үүнийг бол эргээж харах цаг нь ирсэн юм бииш үү гэдгийг би дахин дурдмаар байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг, Дуламдоржийн Тогтохсүрэн, Гочоогийн Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Баянгол сумын ЗДТГ-ын албан хаагчид

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Тэгээд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь түгжэрэл ихтэй газар авто тээврийн хэрэгслийн хэрэглээг хязгаарлана гэдэг энэ маань бас түгжэрэлийг бууруулах нэг суваг мөн л дөө. Тэгэхдээ бид үүнийг бас яаж зохицуулах вэ гэдэг дээр маш сайн тооцоолж сайн судлах хэрэгтэй. Тэгэхээр Сүхбаатар сайд маань байсан бол бас нэлээн тайлбар хэлэх байх аа. Зүгээр яах вэ, тийм тэгээд бид нар ярилцаад ингэж шийдсэн юм байгаа юм шүү. Хүний машин худалдаж авах, гаднаас импортлож авчрах энэ эрхэн дээр нь бид нар юу юугүй хязгаарлахгүйгээр тэр эрх нь нээлттэй байг, харин авчирсан хойноо Улаанбаатар хотод түгжэрэл ихтэй газар хэрэглэхэд илүү үнэтэй байх ёстой. Улаанбаатарын номер авахад, Улаанбаатарын түгжэрэл ихтэй энэ бүсүүдэд унаж давихад тэндээ илүү төлбөрт илүү төлбөртэй байх ийм зохицуулалт нь зөв юм. Тэгэхгүй жишээ нь хайбрид тэргүүд гэхээр үнэхээр олон нийтийн хэрэглээ болчихоод байгаа Приус машин дээр жишээ нь энэ чинь ороод л явчхаж байгаа юм. Тэгэхээр тэр импортын татварыг нь тавьж, энэ машиныг үнэтэй болгож байхаар яг хэрэглэдэг, түгжэрэл ихтэй байгаа энэ бүсүүд дээрээ илүү үнэтэй унаж давихдаг л ийм л зохицуулалт нь илүү оновчтой юм болов уу гэж байгаа юм. Одоо энэ цаг хугацаан дээр.

Эдийн засгийн өсөлттэй хүн амын дундаж орлогын түвшин, өрхийн орлогын түвшин өсөлттэй байх он жилүүдэд бол бас болох юм. Гэхдээ тэр цаг үе маань биш учраас яг импортын худалдаж авах тэр хэрэглээн дээр нь бид татварын зохицуулалт хийх нь цаг үе нь биш байна гэж ингэж харсан байгаа юм.

Үнэтэй машин гэж байна, үнэтэй хэрэглээ, тансаг хэрэглээн дээр мөн л одоо илүү татвар тавигдах нь бол бас л татварын сонгодог хэлбэр л дээ. Бид эхний ээлжид ямар ч байсан цалингийн шаталсан татварынхаа орлого дээр орлогын татвар дээрээ өөрчлөлт хийхээр орж ирж байна. Автомашин дээр бол бас судлах хэрэгтэй, цаг хугацаа нь бас биш байна гэж ингэж харсан. Одоо жишээ нь та зуун сая төгрөг гэж байна, зуун сая төгрөгөөс хоёр зуун сая төгрөгийн хооронд байдаг тээврийн хэрэгслүүд том тээврийн хэрэгслүүд өрхийн орлого нэмэгдэж өгөхгүй ер нь буураад байгаа ийм эдийн засгийн хүнд үед тэр авто тээврийн хэрэгслүүд маань бас орлого авчирдаг тээврийн хэрэгслүүд болоод байна, орлого олдог, хөдөө явдаг, тэнд бизнес эрхэлдэг, аж ахуй эрхэлдэг ийм тээврийн хэрэгслүүд их байна. Бүр үнэтэй тансаг

хэрэглээний, үнэхээр яг зөвхөн тансаг хэрэглээний гэж харах юм бол бараг дөрөв, таван зуун сая төгрөгөөс дээш ийм тээврийн хэрэгслүүд болж ийм байгаад байгаа юм. Тэр тээврийн хэрэгслүүд нь нийт орж байгаа тээврийн хэрэгслүүддээ маш цөөхөн, маш бага тоо, хувь хэмжээ эзэлж байна. Тэгэхээр орлогод ажиллах талдаа бол ямар нөлөө байхгүй ийм болоод байгаа юм. Тэгэхээр үнэхээр яг орлого авчирдаг биш, үнэхээр яг тансаг хэрэглээ гэдгийгээ их сайн судалж, тэрийгээ их зөв ангилж ингэж тавих нь болбол оновчтой. Тэгэхээр тэр дүн маань өөрөө яг нөгөө төлбөрийн тэнцлийн импортоор авч ирж байгаа, тэр суваг тэр дарамтыг багасгах хэмжээний татвар болж чадахгүй байгаа юм.

Тийм учраас бид энэ удаа зөвхөн цалин дээрээ шаталсан татварынхаа шинэчлэлийг оруулж ирсэн юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Сүхбаатар сайд нэмж хариулъя.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр яах вэ, Амартүвшин гишүүний тэр асуулт чухал л даа. Сангийн сайд бол сая бол ЗГ-ынхаа оруулж ирсэн бодлогыг ирж ярьж байна, би ч гэсэн үүнийгээ бас баримталж байна. Гэхдээ Засгийн газар юу хийж байгаа юм бэ гэдгийг бас жоохон тодруулаад хэлчих ёстой. Үндэсний хороог даргалж байгаа хүний хувьд бол, сайдын түвшинд бол бас бэлтгэж байгаа юмнууд бол байгаа. Төсвийн бодлогын асуудал бол ингээд ороод ирсэн, ер нь аль аль талаа бодоод ингээд нэлээн тийм зөөлөн мөртөө төсвийн алдагдал, зарлагын асуудлууд эд нарын анхаараад ингээд явсан. Зүгээр ер нь бол түгжэрэлийг бууруулах асуудал дээр бол гарцаагүй машины ухаалаг хэрэглээ, зохистой хэрэглээ рүү шахах бодлого бол явна. Тэгэхээр Үндэсний хороо энэ дээр яагаад ажиллаж байна вэ гэхээр түгжэрэлийн багц хуулийн төслийг ЗГ-т болбол энэ 11 сарын сүүлээр танилцуулах болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр энэ үедээ болбол татвар, төлбөртэй холбоотой асуудлуудыг болбол гаргаж тавьж таарах байх. Яг таны хэлдэг асуудлаар бол бэлтгэгдсэн асуудлууд бол байгаа, жишээлбэл, 65 хувь нь өнөөдөр тэр буруу хүрдтэй гэж байна, ийм машин явж байна шүү дээ, тэгэхэд дүрмийн асуудал үүсэж байна гээд л ярьж байна, иргэд ч гэсэн энийг шаардаж байгаа юм.

Тэгэхээр бид бол яах вэ, ямар асуудал бодож байна вэ гэхээр хуучин насжилттай холбоотой машинуудын асуудал 16 жилээс дээш, машин орж байгаа юм чинь бараг 50 хувьд нь хүрчхээд байгаа юм, 7 жилээс дээш гэвэл бараг ер хэдэн хувьтай байгаа. Ингээд хуучин машинууд их орж ирж байгааг нэг талдаа дэмжээд байх уу, үгүй юу.

Улаанбаатар хотын тухайд бол агаарын бохирдол, түгжрэлийн асуудал бол гамшиг болчихсон. Тэгэхээр яах вэ, энэ удаадаа бол яах вэ, аль болохоор Улаанбаатар бол хуулиар бусад хуулиараа өөрт нь боломж зохицуулах боломжийг олгоё, шууд энэ төсвөөрөө ингээд хязгаарлахгүй ээ гэж байгаа юм. Гэхдээ тэр хос тэжээлтэй тэр машинуудын татварын хөнгөлөлт, татварыг хөнгөлж чөлөөлсөн явдал бол 17 онд Их Хурал шийдвэр гаргаснаас хойш машины импорт даблдаж 2 дахин нэмэгдсэн юм байна лээ. Тэгэхээр энэ асуудлыг бас бид бодмоор, хэрвээ бид энэ хөнгөлөлт чөлөөлөлтийг нь болиулчих юм бол нөгөө талдаа хуучин машиныг ч хязгаарла, нөгөө талаас нь жаран тэрбум төгрөгийн орлого орж ирэх гээд асуудлууд бол байгаа. Гэхдээ яг өнөөдрийн тухайд бол төсвийн бодлого маань ингээд явж байгаа учраас манай Үндэсний хороо бол дахиж нэг судалгаа тооцоо юмнуудаа нягтлаад, тэгээд бас иргэддээ тодорхой хэмжээнд тайлбар юмаа бэлдвэл энэ асуудлыг бол бид зүгээр ЗГ-таа ямар ч байсан танилцуулна гэдэг чиглэлээр манайхан бол ажиллаж байгаа гэдгээ бас хэлмээр байна. Яг тийм, юу ч хийхгүй сууж байгаа юм байхгүй, энэ чиглэлээрх асуудал бол яг ширээн дээр сонголт болоод байж байгаа. Яг өнөөдөр болбол энэ төсвийн бодлого дээр болбол бид бас бусад юмаа тооцож үзээд ингээд оруулчихсан.

Сайдын хувьд бол би зүгээр ЗГ-таа энэ асуудлыг болбол бас гаргаж танилцуулах болно оо гэдгийг л хэлэх гэсэн юм. Тэгээд ер нь энэ бол гарцаагүй бусад улс орон тэгж л шийдэж байгаа, татвар төлбөрийг. Хэдийгээр бид иргэдээ бодож байгаа зарим улсууд маань эсэргүүцэх ч гэсэн, бодит үнэн бол энэ. Олон иргэд үүнийг бас шаардаж байгаа. Ер нь агаарын бохирдол, ухаалаг хэрэглээ, валютынхаа урсгалыг ч бодсон бид 375 сая долларыг суудлын автомашинд зарцуулчихсан байна гэж байна. Том машинаа тооцох юм бол 700 гаруй сая долларыг бид машинд ингээд л тавиад туучхаж байгаа шүү дээ. Тэгээд хуучин машинууд орж ирж байна, тэгээд тансаг хэрэглээний гэдэг юм уу энэ асуудлууд бол анхаарлын гадна манай Үндэсний хорооны анхаарлын гадна байгаа юм биш, энэ бол бэлтгэгдэж яригдах асуудал мөн гэж. Гэхдээ үүнийг ЖУУ-ын Их Хурал, Засгийн газар бол тусад нь нэг аваад үзэх ёстой байх гэсэн ийм байр суурьтай байгаа.

Г.Занданишатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улс бас шинэ сэрээлтийн төсвөө хэлэлцэж байгаа. Төрийн хэмнэлтийн хууль цахим шилжилтийн хүрээнд бас нэг их наяд төгрөгөөр хэмнэгдэх тооцоолол гаргасанд бас талархлаа илэрхийлье. Тэгээд гишүүн болсноосоо хойш ер нь аливаа хөрөнгө

оруулалтыг нэг мөсөн гүйцэд хөрөнгө оруулалтаа хийгээд дуусгаач ээ, царцаасан байдлаар битгий яваач ээ гэдэг энэ саналыг удаа дараа хэлж байсан. Тэгээд энэ удаагийн төсөв маань бас тойрог шүтсэн тэгшитгэн хуваах зарчмаар биш улсаа нэг тойрогт үзэж, улсын хөгжилд бас анхааран төсвөө оруулж ирж байгаад бас Сангийн сайдад талархлаа илэрхийлье.

Би нэр цохоод шууд асуучихъя. Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Энхболд, Хөдөлмөр нийгмийн хамгаалах сайд Зулхар, Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, Цахим бодлогын сайд Учрал нараас шууд асууя.

Засгийн газар 6 сарын 15-ны өдөр тэмдэглэл гаргасан байгаа. Тэмдэглэлийн 4-ийн тав дахь хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийг сургалтад хамруулах, цаашид мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, мөн манай улс хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг байгаа гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Энэ заалттай холбогдуулан 2023 оны төсөвт ер нь юу суулгасан юм бэ?

АШУИС-ийн Сувилахуйн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 21 эцэг эх өнөөдөр хүүхдүүдээ асрах, цаашидаа хүүхдүүдийг асрах зорилгоор өөрсдөө сургуульд сурч байна. Эдгээр эцэг эхчүүдийг сургалтын төлбөрийг нь төлж өгөх тэр боломж нь ер нь Боловсролын сайдад хэр байдаг юм бэ. Ер нь болбол бидэнд ирүүлсэн мэдээллээр суралцагч хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эсвэл эцэг эх нь 2-уулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагчийн сургалтын төлбөрийг тэтгэлгийг буцалтгүй тусламжаар олгоно оо гэсэн байдаг. Тэгвэл эцэг эхчүүд маань өөрсдөө хүүхдүүдээ асрахын тулд олон хүүхдийг асрахын тулд сурч байна, эдгээр хүүхдүүдийн сургалтын төлбөрийг төр харуцаж болдоггүй юм уу, ердөө хэдхэн хүн байгаа шүү дээ.

ЗГ-ын тэмдэглэлийн 4-ийн 1 дэх хэсэгт заасанчлан ажил хөдөлмөр эрхлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдийн эрүүл мэндийн болоод тэтгэвэр, нийгмийн даатгалыг улсын төсвөөс төлөх энэ зорилгыг 2023 оны төсөвтөө суулгаж өгч чадсан уу, үгүй юу. Цаг бага учраас шуурч ярьж байгаа шүү. Өмнөговь аймагт, Дархан аймагт сайн жишиг байна. 2019 оноос орон нутгийн төсвөөс эдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ижий, аав нарын нийгмийн даатгал болон ЭМД-ыг харуцаж төлдөг бас ийм сайн жишиг байна. Тэгвэл яг энэ жишигээр улсын төсөвтөө тусгах боломж нь хэр байгаа вэ гэдэг зүйлийг асууя. Мөн олгож байгаа 288000 төгрөгийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх

боломж ер нь хэр байгаа бол, үүнийг хэр судалсан бэ гэдэг зүйлийг асууя.

Хоёрдугаарт, миний жил болгон төсөв дээр ярьдаг Геронтологийн үндэсний төвийн барилгын асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэхээр болсон бэ, Энхболд сайд аа, 2011 оноос эхэлсэн барилга нь өнөөдрийг хүртэл ашиглах боломжгүй, аудитын дүгнэлтээр ашиглах боломжгүй гэдэг дүгнэлт гарсан. Улсын 6,8 тэрбум төгрөг үргүй царцаагдаж байгаа заалт тийм ээ, цацагдаж байна, үүнийг хэн хариуцах вэ?

Соёлын сайд Номингоос асууя. Хүүхэд залуучуудын театрын маань ажил явахгүй байна. Соёлын яаманд 5, 6 удаа гүйцэтгэгч компанид бичиг өгсөн ямар ч хариу байхгүй, өнөөдрийг хүртэл тийм ээ, ажил нь гүйцэтгээгүй, би сонгогчдодоо соёл урлагт шүтсэн олон түмэндээ дандаа худлаа хэлж байгаа юм. Энэ амлалтыг маань биелүүлж өгөөч ээ гэдэг зүйлийг ярья.

Чойжилсүрэн сайд аа, тоггүй байсаар байна. Тавинбэх сайдыг ирүүлсээр байгаад би 480 айлдаа л тог тавиулж чадсан, 7000 айл маань тоггүй байгаа. Энэ асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ?

Мөн Хүүхэд залуучуудын театртэй холбогдуулан номын сангийн асуудал, нөгөө эзэмшигчийн асуудал нь шийдэгдэхийг хүлээнэ ээ гээд, нас барсан учраас үр хүүхдүүд нь эзэмших үү, үгүй юу гэдэг асуудал хүлээгдэж байгаа. Төр байна даа, энэ асуудлыг шийдэж болдоггүй юм уу?

Яг Геронтологийн үндэсний төвийн барилга шиг энэ барилга чинь ашиглагдах боломжгүй болчихвол яах юм, хэн хариуцах юм бэ гэдэг зүйл.

Учрал сайд аа. Цхим яамтай болсон бид нар. Нэг цэгийн үйлчилгээ цахим Монгол болно гэдэг. Нэг цэгийн үйлчилгээний ажил чинь явахгүй байна аа. Драгон дээр очоод тийм ээ, гадаад паспортын зураг авхуулах, бүртгэл хийлгэх гээд ажил чинь явахгүй байна. Улаанбаатар хот руу орж гарахдаа бид нар тийм ээ, нэг галын хайчаар нэг мөнгө төлдөг ... /минут дуусав/

Г.Занданишатар: *Ням-Осорын Учрал сайд хариулъя.*

Н.Учрал: *Нэг цэгийн үйлчилгээнүүдийн дээр үүсэж байгаа хүнд суртал маш их байгаа. Тэгэхээр нэг цэгийн үйлчилгээ бид нар өнгөрсөн хугацаанд их буруу ойлгоод ирчихсэн юм байна. Нийслэл дээр 4 цэгийн үйлчилгээ байдаг, тэгээд очихоор маш олон цонхтой, нэг цонхон дээр нь асар их очертой. Зарим цонхнууд нь хов хоосон сууж байдаг. Тэгээд тэр өөрөө нэг цэгийн*

үйлчилгээ биш олон цэгийн үйлчилгээ болчихсон. Нэг цэг дээр нь очоод үйлчилгээ авах гэхээр би мэдэхгүй ээ, чи халамж руу оч, нөгөө цэг дээр нь очихоор би чи банк дээр очоод төлбөрөө төлчихөөд ир, нэг дээр нь очихоор би мэдэхгүй ээ, чи нийгмийн даатгал руу, нийгмийн даатгал дээр нь очихоор бүртгэл рүү гээд ингээд бие бие рүүгээ шидээд байдгаас болоод нэг цэгийн үйлчилгээ дээр бүтэн өдөр алдаж байна гэдэг чинь энэ өөрөө концепц нь буруу явж ирсний л хар гай.

Тийм учраас үүнийг цэгцлэхийн тулд бид нар энэ нэг цэгийн үйлчилгээг операторын горимд шилжүүлж ээ л гэж байгаа юм. Операторын горим гэдэг нь юу вэ гэхээр банкин дээр очоод үйлчилгээ авахаар тэр теллер санхүүгийн бүх үйлчилгээг үзүүлдэг шиг аль ч цэг дээр нь дугаараа аваад очиход тэр нь нийгмийн даатгалаа ч үзүүлдэг, халамж ч үзүүлдэг, бүртгэлээ ч үзүүлдэг, ААН-ээ ч бүртгэдэг, төлбөр тооцооныхоо асуудлаа шийддэг байх юм болбол нэг цэгээс нөгөө цэг рүү явж болоод шаардлагагүй. Нэг ёсондоо мэдээлэл солилцооны систем гээд байгаа хур системээс энэ төрийн байгууллагууд бүгд мэдээлэл татаж байгаа мөртөө төр өөрт байгаа мэдээллээ иргэнээсээ нэхээд байхаар энд хүнд суртал үүсээд байгаа юм. Тийм учраас энэ эзэнгүй байгууллагуудыг илүү операторын горимд шилжүүлсэн, шинэчилсэн менежментийн хувьд өөрчлөх шаардлага байна гэж үзээд нэг ч төсөв мөнгө нэмэхгүйгээр байгаа, тэр хүмүүсийг нь урсгал зардал, цалинтай нь төрийн үйлчилгээг зохицуулах газар болгож байгаа. Энэ болбол түрүүний Энхбаяр гишүүний асуултад бас гарч байсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр энэ төсөв дагуулж орж ирсэн энэ 32-ын итрих нэгийн 3 дахь заалт. Энэ юу вэ гэхээр бид нар тэр операторууд бол асуудлыг шийдвэрлэхгүй, нэг ёсондоо тэр болбол бүртгэлийн байцаагчийн эрхийг эдлэхгүй, тэр хүн бол зөвхөн оператор. Цаанаа болбол тэр бүртгэлтэй холбоотойг нь бүртгэл шийднэ, нийгмийн даатгалтай холбоотойг нийгмийн даатгал шийдэх, халамжтай холбоотой бол халамж шийднэ, гол нь тэр яг төрийн үйлчилгээ үзүүлж байгаа оператор. Тэгэхээр орон нутагт хандсан ийм зохицуулалт юм. Энэ ялангуяа.

Нэг ёсондоо аймагт байгаа хүн яагаад өөрийнхөө оюуны бүтээлийг зохиогчийн эрхийн гэрчилгээг бүртгүүлж болохгүй байгаа юм. Заавал хотод ирж оюуны өмчийн газар ирдэг. Өнөөдөр СЗХ-ны үйлчилгээнүүдийг яагаад аймаг орон нутагт үйлчилгээ авч болдоггүй юм, яагаад аймаг орон нутагт ажиллаж байгаа хүн ББСБ байгуулах зөвшөөрлийг хүсэж болохгүй байгаа юм, яагаад өнөөдөр ҮСХ гэдэг байгууллагын тэр дата мэдээлэл, дээрээс нь тэднийхээс гарч байгаа биг датаг одоо тэр шийдвэр гаргалтдаа ашиглаж болохгүй байгаа юм бэ гэдэг ийм

асуудал хөндөгдөөд байгаа юм. Тэгэхээр цахим шилжилт гэхээр зөвхөн хотын асуудал биш, хөдөө орон нутагт байгаа иргэд хотод эмчилгээнд хамрагдаж байгаа болбол цагийнхаа бүртгэлийг аваад эмчээ сонгоод ирдэг, нэг ёсондоо хүлээлтэд ордоггүй. Дээрээс нь орон нутагт аль ч алс хязгаар аймагт байгаа хүмүүс нэг цэг дээрээ очиход тэр оюуны өмчөө ч бүртгүүлж болдог, статистикийн хорооны үйлчилгээ ч авч болдог, СЗХ-ны үйлчилгээг ч авч болдог болох ёстой учраас энэ 32-ын штрих нэг 3 дээр болбол Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын үйлчилгээг хариуцна гэж байгаа. Үйлчилгээг хариуцна гэдэг бол тэр байгууллагын эрх мэдлийг авах гэж байгаа биш, зөвхөн тэр нүүрэн дээрээ операторууд ажиллана. Ингэснээрээ болбол энэ шилжилтийн үед болбол бид нар энэ төрийн үйлчилгээг зохицуулах шинэ менежментийг хийгээд цахимжилттай зэрэг явсан тохиолдолд бол бид судалгаа гаргахад бол 5 жилийн дараа Монгол Улсыг нэг цэгийн үйлчилгээгүй болгоод ингээд шат шатаар нь болбол яваандаа бол Киоскгүй болох асуудлыг шийдэхгүй болбол шууд цахимжуулна гэхээр ахмад настнууд байна, хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна, бүгдээрээ ухаалаг утас байхгүй байна. Манай ахмад настнууд бол дандаа л нэг цэг дээрээ очдог.

Тэгэхээр цаашидаа болбол энэ төрийн үйлчилгээний зохицуулалтын газар бол операторын горимд шилжинэ. Тэгэхээр нөгөө Драгон дээр, Дунжингарав дээр, Мишээл экспо дээр, Чингэлтэй дээр бөөгнөрөл үүсээд байгаа асуудал болбол шийдэгдэнэ ээ л гэдэг ийм зорилгоор энэ бүтцийг хийсэн.

Г.Занданишатар: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Жаргалмаа гишүүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах эрхийн талаар бас тодруулга хийж асуулт асууж байна. Тэгэхээр яах вэ, үндсэндээ бол өнөөдрийн байдлаар яг ЕБС-д сурч байгаа нэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо нэг 6300 орчим хүүхдүүд байна. Жаргалмаа гишүүн ээ. Тэгээд яг юутай, эндээс 6300 хүүхдээс яг 6 тусгай сургуульд 1600 хүүхэд байгаа, тэгээд яах вэ, ерөнхийдөө дэмжлэг яг энэ 23 оны төсөв дээр яг эд нар руу чиглэсэн бодитой дэмжлэг өнөөдөр яг юу байна вэ гэж. Бид нар илүү нөгөө нэг хүүхдээ сургаж байгаа хувьсах зардал гэж байгаа шүү дээ, тэр хувьсах зардала бид нар ямар ч байсан тийм ээ, тэгээд яах вэ, би тэгээд орох гэж байна, тийм, тэгээд хувьсах зардал өгч байгаа, нэгдүгээрт.

2 дугаар асуудал болбол ерөнхийдөө бид нар, энэ нэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагч нар, тийм ээ, эцэг эхчүүдийг, ингээд цаашид нь бид нар ингээд энэ Анагаахын их сургуульд богино хугацааны сургалтад

хамруулаад тодорхой энэ хөдөлгөөн засал, хэл засал гэдэг юм уу, тэгээд энэ чиглэлээр бас суралцуулах ийм тусдаа нэг богино хугацааны хөтөлбөрийг энэ Ариунзаяа сайдыг байхад хамтарч бас нэг ийм хөтөлбөрүүдийг эхлүүлж байгаа. Одоо энэ дээр яах вэ, бид нар бүртгэл хийгээд бас нийт нэг 300 гаруй эцэг эх, асран хамгаалагч нар санал өгч байгаад 100 орчим хүмүүс санал өгч байгаа юм, тэгээд тодорхой эхний хөтөлбөрүүд. Тэгэхээр үүний хөтөлбөрүүдийн нөгөө нэг зардлуудыг нь төрөөс дааж болохгүй юу л гэж хэлээд байна шүү дээ, тийм ээ, энэ бол би боломжтой гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ боловсролын зээлийн сангаас үүнийгээ бол зохицуулаад явчих энэ боломжууд нь байгаа. Гэхдээ бид нар нэг зүйлийг нэг сайн ойлгомоор байна. Жаргалмаа гишүүн ээ. Нэг удаагийн ийм гал унтраасан арга хэмжээ биш, энэ намар Ерөнхий сайд, бас энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд, асран хамгаалагч нар, гэр бүлийн төлөөллүүдтэй уулзсан. Бид нар энэ асуудлыг нэлээн цогцоор нь харах ёстой юм байна гэж бодож байгаа юм. Эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, нийгмийн хамгааллын үйлчилгээ. Тэгэхээр гол асуудал болбол ерөөсөө энэ эрт илрүүлгийн л асуудал юм байна лээ. Аль болохоор эрт илрүүлэх. Тэгэхгүй бол нэгэнт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гараад ирэх юм бол энэ чинь бараг үндсэндээ насан туридаа хөгжлийн бэрхшээлтэй болчихож байгаа учраас СӨБ ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол, насан туршийн боловсролынх нь энэ хэлбэрүүд рүү яах, тэр нөгөө хувилбар сургалтуудын асуудлууд нь тодорхой, бэлэн байх ийм хэлбэр рүү бид нар бодож харахгүй болбол нэлээн бас бид нар энэ жил бүхэн энэ тоо өсөж байгаа. Одоо 12000 орчим болж байна, энэ чинь маш их том тоо шүү дээ, тийм ээ, тийм. Тэгэхээр ингэхээр энэ асуудлуудыг бид нар ер нь цогцоор нь харж байж асуудалд хандах ёстой юм байна л гэж бодож байгаа.

Г.Занданишатар: Сэрээжавын Энхболд. 95.

С.Энхболд: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Энэ Геронтологийн төвийн барилга бол бас 10 хэдэн жил болсон. Энэ барилгын асуудал бас нэлээн хүндрэлтэй, ялангуяа аудит орсон байгаа, хэсэгчилсэн аудит энэ барилга дээр дүн шинжилгээ хийхэд бол нягтаршил нь бол хангалтгүй байна гэсэн дүгнэлт гарсан. Энэ жилийн төсөвт оруулах гэсэн боловч хамгийн гол нь аудитын газраас энэ барилгыг бүхэлд нь нягтарилгыг нь үзэх шаардлагатай, тэгжэ байж энэ дараагийн төсөв оруулах тийм асуудал яригдсан учраас бид нар энэ жилийн төсөвт бол оруулаагүй. Гэхдээ Геронтологийн төвийн барилгыг яг геронтологийн төв баригдаж байгаа Хан-Уул дүүргийн 10 дугаар хороон дээр бид нар өөр

зохицуулалт хийсэн байгаа. Шинээр баригдаж байгаа 36 ортой 5 давхар барилгыг бид нар 23 онд ашиглалтад оруулахаар Геронтологийн төвийг тийшээ нүүлгэн шилжүүлэх байдлаар зохион байгуулалтуудыг бол хийсэн. Тэгэхээр 23 онд Геронтологийн төв маань Хан-Уул дүүрэгт шинэ байранд орно гэсэн үг. Тэнд үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой.

Дээрээс нь төрөөс ЭМД-ын шимтгэлийг хариуцах иргэдийн юун дээр хуульд бол тусгагдсан байдаг, энэ дээр бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд бас хамрагддаг. Бид нар энэ жилийн төсөв дээр 226 тэрбум болгож өсгөж оруулсан байгаа. Өмнө нь бол 163 тэрбум байдаг байсан бол энэ эдгээр иргэдийн төрөөс ЭМД-ын шимтгэлийг хариуцах төсөв нь бол нэмэгдэж орсон. Ингэснээрээ бол энэ иргэд маань эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах бүрэн боломжтой гэсэн үг.

Ч.Номин: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт болбол би бол бас юу гэж харж байгаа вэ гэхээр Соёлын яамтай болсноор соёлын салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтыг бол бас эрчимжиж байгаа бөгөөд сайжирч байгаа гэж бодож байгаа. Хүүхэд залуучуудын театрын хувьд болбол анхнаасаа 2019 онд, ер нь бол 19 онд төсөвт суусан хөрөнгө оруулалт. Анхнаасаа хөрөнгө оруулалтын төсөвт суухдаа ажлын тоо хэмжээгээ бүрэн оруулаагүй, дутуу оруулж ирсэн, өнөөдрийн байдлаар болбол үйл ажиллагааны хувьд гүйцэтгэлийн хувьд бол ер хувьтай явж байгаа, 2023 оны 6 сар гэхэд ашиглалтад өгөхөөр ажиллаж байгаа. 23 оны төсөвт болбол энэхүү барилгын тоног төхөөрөмж нь мөн интерьер нь орсон байгаа, энэ интерьер зураггүй, ямар нэгэн интерьерийн ажил нь тооцогдож ороогүй байсан учраас үүнийг бид нар нэмж оруулж байгаа. Тэгэхээр энэ 2023 онд бол бүрэн ашиглалтад орно гэж үзэж байгаа.

Үндэсний төв номын сангийн хувьд болбол яах аргагүй гүйцэтгэж байгаа байгууллагын хувьд бол асуудалтай байгаа. Гэхдээ үүнийг мөн Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, мэргэжлийн хяналтын байгууллагуудтайгаа хамтарч ажиллаад, Соёлын яамны зүгээс бол сүүлийн бүтэн жилийн хугацаанд энэ барилгыг ашиглалтад оруулах гэж ажиллаж байгаа. Одоо яах аргагүй өмчлөлийн асуудалтай болсон учраас бид нарын хувьд болбол гэрээг цуцлах ажил руу орж байгаа, тэгээд цаашилаад 2023 онд шинэ гүйцэтгэгч дахиж тендер зарлаж байж оруулахаас өөр аргагүй болсон, яагаад вэ гэхээр эзэмшиж байсан гүйцэтгэл хийж байсан байгууллагын эзэмшигч нь нас барчихсан. Тэгээд цаашилаад хүүхдүүдийнх нь хооронд өвийн асуудал үүссэнээс болоод гүйцэтгэгч байгууллага чадамжгүй болж байгаа асуудал үүссэн учраас энэ гэрээг цуцалж шинэ гүйцэтгэгч оруулахаас өөр аргагүй болж байгаа.

Г.Занданиатар: Жаргалмаа гишүүн 1 минут.

Б.Жаргалмаа: Монголын төр бас татвар төлөгчийнхөө мөнгийг үргүй зарцуулах ёсгүй гэдгийг би дахиад хэлье. Тийм ээ, зарлага гарсан бол тэр зарлагаа хариуцагчийг тооцож бид нар мөнгөө олж авах ёстой шүү гэдгийг хэлье. Өвөл болж байна, хүйтэн болно гэдэг шиг Чойжоо сайд аа, сайжруулсан түлиний асуудлаа хэрхэн яаж шийдвэрлэх юм. Манай тойрог дээр 20 дугаар хороон дээр сайжруулсан төлсний үйлдвэр байдаг. Энэ жил болохоороо зүгээр хадгалалт юу билээ, агуулах хөлбөрөө ашиглана гэсэн. Иргэд маань амьдрахад маш хэцүү байдаг шүү. Энэ асуудал дээр ер нь ямар шийдвэр гарч байгаа вэ? Тог цахилгааны асуудлыг яах ёстой юм бэ.

Жавхлан сайд аа, би хүүхдийн төлөө фондын мөнгө хааччихав гэдгийг асуумаар байна. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам энэ дээр хариулах уу.

Г.Занданиатар: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, эсвэл хүчдэлийн уналттай айл өрхүүдийн судалгааг манай яам хэдэн удаа хийсэн. Хийх тоолонд өөр өөр тоо гарч байгаа. Би танд хамгийн сүүлд хийсэн 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Улаанбаатар хотод цахилгаан юу хүчдэлийн уналттай буюу цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айлын тоо 13102 байна. Үүнээс 9061-ийг нь болбол 2024 он хүртэл төсөлд суусан Улаанбаатар хотын 41 хороон дээр эдгээр айлуудыг цахилгаан эрчим хүчинд холбоно. Цаана нь 4041 айлд цахилгаан эрчим хүчинд холбогдохгүй үлдэж байгаа. 2023 оны төсвийн төсөлд ЭХЯ-наас Сангийн яам руу санал явуулсан болов чиг санхүүгийн нөхцөл байдал, эх үүсвэрийн хүндрэлтэй байдлаас шалтгаалаад ... /минут дуусав/

Г.Занданиатар: 1 минутдаа л хариулна, цагаараа явахгүй бол энэ.

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Баярлалаа. Энэ удаагийн төсөв бол би нэг ийм 3 том зохицуулалтын хүрээнд орж байгаа болов уу гэж бодож байна, тэгж орж ирлээ гэж харж байна. Хөөе Жавхлан чимээгүй байгаарай. Урт, дунд хугацааны тогтвортой хөгжлийн бодлого гэж бид нар яриад Үндсэн хуульдаа хүртэл санааг нь тусгаад ингээд явж байгаа. Үүнийгээ барьж байна гэж бодож байна. 19 оны Үндсэн хуулиар нэлээд нэмэлт, өөрчлөлт оруулаад, ялангуяа

төсөвтэй холбоотой ЗГ-ын эрх үүрэг, хариуцлагын тал дээр шинэ зохицуулалтууд хийсэн. Үүнийгээ барьсан байна гэж харж байгаа.

Гуравдугаарт нь, энэ тухайн төсвийн жилийн хугацаанд хийх хөгжлийн том зорилтуудынхаа асуудлыг ингээд эрэмбэлээд ерөнхийдөө энэ том зарчмуудынхаа хүрээнд оруулж ирж гэж бодож байна, тийм, хэлэлцэхийг нь дэмжинэ гэж бодож байгаа. Тэгээд энэ удаа бас Засгийн газраас оруулж ирсэн төсвийн энэ алдагдлыг нь бууруулсан эрэмбээ бас олон оновчтой тогтоох гэсэн, тэр оновчтой тогтоосон эрэмбэдээ хөрөнгөө яаж төвлөрүүлэх вэ байсан энэ агуулгыг нь бас зөв байна гэж харж байна. Гэхдээ энэ зорилтуудыг төр дангаараа хэрэгжүүлж чадахгүй л дээ, маш том зорилтууд байгаа. Зөвхөн нийгмийнхээ бүхэлд нь хөдөлгөж байж, сэтгэлгээг нь өөрчилж байж, нийгэмд ойлгуулж, зөв хүлээж, зөв хүлээлт үүсгэж, дэмжлэг авч байж л энэ зорилтуудыг хэрэгжүүлнэ. Түүнээс зүгээр ингээд төсөл дээр биччихсэн гээд хэрэгжих юм нэг ч байхгүй байгаа энд, бүгд их том төслүүд.

Тэгээд энэ төслийн хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааг дэмжих хэсэгт нь ийм заалт байна. Хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрийн салбарыг онцгойлон дэмжинэ гэсэн байна. Тэгээд үүнтэй бас бүрэн санал нэгдэж байгаа, нэгдэж байгаа. Эхний ээлжид хүнсний үйлдвэрлэлийн асуудал байна, энэ бол өөрөө ХАА, газар тариалан, эрчимжсэн МАА-н асуудал бидний тэргүүн зорилтод ба нэг яах аргагүй мөн. Яг энэ үүднээс нь харвал үүнийг тойргийн асуудал гэж битгий бодоорой манай гишүүд улсын хэмжээний нэг том асуудал байгаа. Энэ Төв аймаг, Сэлэнгэ аймгийн хүнсний хангалт, аюулгүй байдлын баталгаатай байлгах, хөөе Тогтохсүрэн дарга аа, та битгий хүний яриа үймүүлээд тэр амьтны анхаарал байгаад байна л даа.

Хүнсний аюулгүй байдал, цаашидын экспортыг нэмэгдүүлэх энэ бодитой валютын нөөцийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах том төсөл энэ дотор явж байгаа юм. Энэ нь юу вэ гэхээр энэ Төв аймгийн Угтаал, Заамар, Цээл, цаашидаа Сэлэнгийн Сэлэнгэ, Эрдэнэт, Дарханыг холбосон ийм том замын сүлжээний асуудал явагдаж байгаа. Цээл, Угтаал, Заамарынх баригдаж байгаа, нийтдээ 117 сая тэрбум байсан, өнгөрсөн онд 25 барьсан энэ хэмнэлтийн хууль энэ тэр гэж байгаад бид нар 15-хан болгосон, энэ жил 25-ыг тавьсан байна, энэ хаана ч хүрэхгүй, хэрэв 25-аар нь тавивал цаана нь 77 үлдэнэ. Тэр 24 онд хэрэгжихгүй, тийм их мөнгө нэг дор гаргаж чадахгүй, энэ худлаа болох гээд байна. Тэгээд энэ замын ач холбогдлыг яагаад ярьж байгаа юм бэ гэхээр зөвхөн энэ Төв аймаг, Сэлэнгийн газар

тариалан, эрчимжсэн МАА-н бүсийг хамарсан ийм тойрог зам үүсэх төдий биш, манайхан заримдаа хөгжлийн алтан гурвалжин гэж ярьдаг, энэ Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт, Улаанбаатарыг холбосон энэ том гурвалжингийн логикийн асуудлыг их зөв шийдэхэд маш том ийм арга хэмжээ болох гээд байгаа юм. Тэгээд энэ дээр бид нар ач холбогдол өгөөд ЗГ энэ оруулж ирсэн төсөлдөө бичсэн ХАА-г хөгжүүлэх, хүнсний хангамжийг ахиулах энэ зүйлүүдээ харж үзээд энэ жил ядаж энэ замын төсвийг нэг 50 тэрбумд хүргэх хэрэгтэй байгаа юм. Тэгвэл цаана нь нэг 50 үлдэнэ, тэгээд 24 он гэхэд энэ яг зорилт хэрэгжих юм байгаа юм.

Тэгээд үүнтэй уялдаад миний асуулт юу вэ гэхээр би ер нь зөв асуулт тавиад байна уу, буруу асуулт тавиад байна уу л гэж асуух гэж байгаа. Уг нь Ерөнхий сайдаас юм уу, Эдийн засгийн хөгжлийн сайдаас асууя гэж бодсон, аль нь ч алга байна, энэ өнцгөөс нь харах ёстой юу? Бид нар жижиг юм руугаа тал талд байсан чирэх ёстой юу? Том ... /минут дуусав/

Г.Занданишатар: Хариулт хангалтгүй л бол. Хариулт хангалтгүй л бол 1 минут сунгаж байгаа. Бүгдэд нь адил дээ үйлчилж байгаа учраас.

Ярьсан юмнууд нь Жавхлан сайд хариулах уу.

Б.Жавхлан: Энхболд гишүүний асуултад хариулъя. Таны асуултын зөв бурууг би яаж шүүх вэ. Та зөв л асуусан байх. Та бол ер нь байнга л зөв асуудаг учраас эргэлзэх юмгүй байна. Ер нь байгаа төсвөөрөө болбол төсөвт өртгөөрөө 115 тэрбум төгрөгийн ийм төсөвт өртөгтэй Төв аймгийн Угтаал, Цайдам, Цээл, Заамарын сумдыг холбох хатуу хучилттай авто зам юм байгаа юм. Ингээд эхлүүлсэн, эхлүүлсэн анхныхаа хуульд зааснаараа тэр төсөвт өртгөөр явж байгаа. Гэтэл 115 тэрбум төгрөгийг 185 болгоно оо гээд ороод ирсэн байгаа, 185 болгоно гээд яамнаас нь ийм хүсэлт ирсэн байгаа, битгий эргэлзээрэй. Энэ дээр аудит хийгдэх шаардлагатай байгаа, тийм, тэгж байж энэ төсөл цаашаагаа энэ 185-аар явах уу, 115-аар явах уу гэж байгаа юм. Энэ чинь бараг ингээд 75 гэдэг чинь бараг 70 хувиар төсөвт өртөг нь нэмэгдээд ороод ирчихсэн байгаа юм 70 хувиар. Өөрөөр хэлбэл төсөвт өртөг нэмэгдэж байна гэж орж ирсэн төслүүдээс нэлээн дээгүүр цохиж яваа ийм төсөл өө. Гэхдээ ямар ч байсан ирэх жил болбол бид энэ замыг бол үргэлжлүүлж байгаа, ач холбогдлын хувьд таны хэлж байгаатай би бол зуун хувь санал нийлж байна. Мөн манай ЗГ-ын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ч бас энэ бас энэ зам дэд бүтэц бол орсон байгаа. Тэгээд цаашаа бол ямар ч байсан амжилттай үргэлжлээд явна. Төсөвт өртгийн асуудлыг бол ирэх жил бүгд

аудит орж нягтална аа. Ингээд үргэлжлээд явах юм байгаа юм.

Г.Занданишатар: Нямаагийн Энхболд гишүүн 1 минут.

Н.Энхболд: Өнөөдөр төсөвт өртөг нь нэмэгдсэн тухай яамнаас оруулсан тухай мэдээ алга, дөнгөж сая бид нар газар дээр нь явж үзсэн. 4 компанид хуваагаад өгчихсөн ажил нь маш сайн явж байгаа юм байна лээ, хүмүүс их урамтай байгаа. Хойтон бид нар нэг ядаж тавин сая тавин тэрбум төгрөг авчихвал ер нь хугацаанаасаа өмнө ашиглалтад оруулах тал дээр компанийн зүгээс ч гэсэн илүү их анхаарал тавих ийм боломж бол бидэнд байна гэж байгаа юм. Тэгэхээр үүнийг үнэхээр тэр зөвхөн нэг 3 сумын асуудал гэж үзэлгүй би дахиад хэлэхэд энэ бол эрчимжсэн МАА, газар тариалангийн бүс нутгийг бүхэлд нь хамарсан ийм тойрог байгаа.

Дээр нь дахиад хэлэхэд Дархан, Сэлэнгэ, Улаанбаатар гээд манай аж үйлдвэрийн гол төвүүдийг холбосон энэ замын нэвтрүүлэх чадвар, зардал хэмнэх боломж, цаг хугацаа хэмнэх боломж бол үлэмж дээшлэх нэг ийм том хөтөлбөр шүү. Тэгэхээр үүнийг энэ зүгээр 110 хэдэн километр зам гэж бодолгүйгээр их том, логистикийн сүлжээний эх үүсвэр гэж ... /минут дуусав/

Г.Занданишатар: Жавхлан сайд. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр 2023 оны төсвийн төсөлд өндөр хэрэглээ бүхий боломжийн айл өрхийн гээд их хүн амын 9 хувийнх нь хүүхдийн мөнгийг танах руу оруулж ирж байна. Үүнтэй бол санал нийлэхгүй байна. Хүүхдийн мөнгө бол халамжийн мөнгө биш ээ, хүүхдийн мөнгө бол ирээдүйд хийж байгаа хөрөнгө оруулалт, тэгээд тэр дундаа нийгмийн тэгш байдал, нийгмийн шударга ёс, эв санааны нэгдлийг гол үнэт зүйл болгодог, МАН-ын ЗГ-аас ийм бодлого хэрэгжүүлэх нь нийгмийн шударга ёсонд нийцэхгүй ээ. Улс орнуудын жишгээр болбол хүүхдийн мөнгийг эцэг эхийн болон бусад ямар нэгэн нийгмийн статусаас үл хамааруулж ижилхэн олгодог оо. Ингэж байж тухайн хүүхдийн ирээдүйн хөрөнгө оруулалт, мөн ямар гэр бүлээс гаралтайгаас үл хамаараад ирээдүйд тухайн хүн нийгмийн давхарга хооронд чөлөөтэй хөгжих, ажил амьдралаа дээшлүүлэх ийм боломжийг бий болгодог. Тэгэхээр бид нарын гол үлгэрлэн дуурайж байгаа Скандиновын орнууд, баруун Европын орнууд бол бүгд хүүхдийн мөнгөтэй, тэр дотроо тэн дээр болбол шатлал харгалзсан гэдэг юм уу, эцэг эхийн орлогоос үл хамаарч байгаа. Тийм учраас энэ нийгмийн шударга ёсны зарчмын дагуу бид нар энэ хүүхдийн мөнгийг болбол эн тэнцүү олгох ёстой. Мэдээж Орос, Украйны хямрал, цар тахлын

хямралаас үүдэлтэйгээр төсөв бол танагдсан. Тэгэхээр одоо байгаа төсвийнхөө энэ танагдсан дүн дээрээ буюу бид нар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас бас тооцоо авсан. Хэрэв энэ танасан дүнгээрээ болбол нийт хүүхдэдээ өгөхөөр болбол нэг 80000 орчим төгрөг болохоор байна. Тэгэхээр нийт хүүхэд болгондоо өгөх нь зүйтэй байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь хүүхдэд оруулж байгаа хөрөнгө оруулалтыг бид нар улс орны стратегийн том хөрөнгө оруулалт гэж үзэх ёстой юм. Ерөөсөө улс орнуудын хөгжлийн гол бодлого маань энэ хүн рүү чиглэсэн хөрөнгө оруулалтууд хамгийн чухалд тооцогддог. Бид нар бол өмнөх бүх жилүүдэд дэд бүтэц, эрчим хүч гээд энэ хэдийг стратегийн гол салбар гэж ойлгож байсан. Гэтэл улс орноо хөгжүүлсэн, хүн амаа хөгжүүлсэн, хүний нөөцийн бодлогыг маш амжилттай хөгжүүлсэн, бүх улс орнууд бол хүн рүү чиглэсэн хөрөнгө оруулалт, тэр дотроо хүүхдийн хөрөнгө оруулалтыг асар чухалчилдаг. Тэр Нобелийн шагнальтай эдийн засагч нарын судалгаа байгаа шүү дээ. Ер нь бага насны хүүхдийн хөгжилд оруулсан доллар тутам бол нэг 12,9 доллар болгож өсдөг, ирээдүйдээ хийж байгаа хөрөнгө оруулалт байгаа. Тийм учраас энэ асуудал дээр манай МАН-ын гишүүд нийгмийн шударга ёсны үзэл баримтлалыг дэмждэг хүн болгон, өөр намын гишүүд ч гэсэн бас дэмжих байх. Энэ асуудлыг бол манай Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам болон Сангийн яам ямар байр суурьтай байна. 91 хувьтай 100000 биш, бүх хүүхэдтэй ижил тэнцүүгээр нэг 80 орчим мянган тооцоогоор олгохыг юу гэж бодож байна гэж.

2 дугаар асуулт нь мөн Сангийн яамнаас, төсвийн төсөлд хүн амын орлогын албан татварыг орлогоос шалтгаалсан буюу шаталсан татвар байдлаар оруулж ирэхийг бол дэмжиж байна. Энэ болбол нийгмийн цөөнхийн гарт баялаг төвлөрөх хэт баян хоосны ялгааг тэгшитгэх нэг томоохон хэрэгсэл байдаг. Японоос авхуулаад Европын ихэнх улс орнууд орлогын шаталсан татвартай, тэр дотор татварын шатлал нь болбол бараг 7, 8, 10 хүртэл ийм юутай байдаг. Тэгэхээр манай энэ төсөл дээр бол ийм 3 шаталтай орж ирж байна. Шатлал нь арай хол юм уу, ер нь 3-аас илүү болох боломж байхгүй юу.

Хоёрдугаарт нь, ингээд татвар нэмж байгаа энэ тохиолдолд татварын ерөнхий бааз сууриа яаж нэмэгдүүлэх юм бэ? Тэгээд 2020 оны дүнгээр и-баримтад бүртгүүлсэн 2063000 иргэн байгаа юм. Гэтэл үүнээс яг нөгөө хүн амын орлогын татвар төлдөг нэг 800 орчим мянга байх шиг байна. Тэгэхээр ер нь бол далд эдийн засаг Монголд байна, татвар төлдөггүй тодорхой ажил мэргэжлийн бүлгүүд байна, тэгэхээр эдгээрийн татварыг хэрхэн төлүүлдэг болох вэ. Татварын бүртгэл, тэгээд татварын суурин өр

чиглэлээр ямар тодорхой арга хэмжээ ер нь авахаар байна. Ингэж чадах юм бол бид нар улсын эдийн засгийн хөгжүүлэх, тэгээд төсөв бүрдүүлэлт болон далд эдийн засгийг хязгаарлах ийм боломжтой болно. Ийм 2 асуулт дээр Сангийн яамнаас хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданишатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Би сүүлийн хэсгээс нь эхэлбэ. Шаталсан татвар болбол ер нь олон улсад нийтлэг байдаг ийм сонгодог татварын хэлбэр юм байгаа юм. Бид нар ямар ч байсан, хожуу ч гэсэн энэ татварынхаа реформыг хийж орж ийм алхам хийж байгаа юм. Өмнө нь 2 ч удаа ороод гарч байсан, энэ систем байсан. Энэ удаа бол босгыг нь нэлээн өндөр тавиад ингээд орж байгаа юм. Тэгээд 2 ингээд 10, 15, 15-аас дээш гээд ийм шатлалтай орж байгаа нь одоо 817000 ХХОАТ-ын мэдүүлэгч нараас 0,1 буюу 1300 хүнд хамрагдах ийм шатлалын систем байгаа юм. Хэт өндөр тавих нь бас эдийн засгийн яг мөчлөгтэйгөө бол бас таарахгүй, өндөр босго тавья ямар ч байсан татвараа шинэчлэлээ хийгээд авъя, эдийн засаг өснө, цаашидаа ХХОАТ-ууд өснө, энэ шатлалд орж ирэх хүн амын тоо маань цаашидаа бид нэмэгдэх байх гэсэн, өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлтөө дагаад ийм хүлээлттэй байгаа гэсэн үг.

Хүүхдийн мөнгийг таны томьёолж байгаа болбол бид нарын томьёолж байгаа, таны хэлж байгаа энэ зүйл болбол яг энэ шаталсан татварын яг нөгөө талынх нь проекц байхгүй юу. Бид яг эдийн засгийн ийм хүнд үед өндөр орлоготой эсэх нь илүү төлдөг болооч ээ, янз бүрийн халамж төрөөс авч байгаа энэ мөнгөн тэтгэмжээс мөнгөн халамжаас татгалзаад ч энэ байж, яг агуулга бол нэг юм байгаа юм, агуулга нэг. Хүүхдийн мөнгө бол анх 100000 болсныг бол та санаж байгаа байх, энэ болбол яг ковидын хүнд нөхцөл байдалтай ийм үед хүүхдийн мөнгөөр дамжуулж өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх, дэмжих ийм бодлого бас дагаж явсан давхар. Тэгэхээр ковидын хүнд нөхцөл байдлынхаа үеийг бас бид өнгөрөөж байна, өнгөрөөж байна, гэсэн хэдий ч энэ геополитик, дайн тулааны асуудал гээд бид эдийн засгийн хүндрэл маань цаашаа үргэлжлэх төлөвтэй байна, үргэлжлэх төлөвтэй байна. Тийм учраас үүнийг бид халамжийн хууль руу оруулж, өөрөөр хэлбэл нийгмийн халамжийн нэг хэлбэр юм. Өндөр орлоготой хэсэг нь багахан хэсэг нь 8, 9 хувь энэ хэсэг нь үүнээсээ татгалзаач ээ, нөгөө шаталсан татварт байгаа агуулгыг ижилхэн байхгүй юу, нөгөө талынх нь л тайлбар. Ингээд илүү их зорилгод бүлэг рүү нь үүнийгээ чиглүүлэх нь зүйтэй юм гэж ингэж харсан байгаа. Энэ нь манай ЗГ-ын төсвөөрөө дамжуулж тавьж байгаа энэ бодлого энэ санал юм байгаа юм.

Макро талаас нь харах юм болбол бид ирэх жилээ эдийн засгаа тогтворжуулах, цаашид илүү эрсдэлд орох энэ байдлаас урьдчилж сэргийлье ээ, макро эдийн засаг энэ төсвийн тогтвортой байдлаа эхэлж хангая гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл алдагдлаа бууруулна, зарлагаа хумина, орлогоо бүрэн дайчилъя гэж байгаа юм. Энэ бодлогодоо ч гэсэн бас ийм тодорхой хэмжээнд бол нийцнэ ээ, нийцэх юм байгаа юм. Ийм л бид бодлогын хүрээнд уялдуулж ингэж оруулж ирсэн юм байгаа юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Мөнхцэцэг гишүүн нэг минут.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Сангийн яам болбол хүүхдийн мөнгө гэдгийг халамж гэдэг утгаар үзэж концепцын ийм ялгаа байгаа болбол гэтэл улс орнууд бол хүүхдийн мөнгө гэдэг болбол халамж биш ээ, энэ хүүхдэд хийж байгаа хөгжлийн хөрөнгө оруулалт гэж үздэг. Орлогоос үл хамаараад, тэгээд дээрээс нь социал демократ баримттай улс орнууд бол хүн болгонд төрөөс тэгш боломж олгох, тэгш нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх энэ бодлогын үүднээс тухайн хүүхдийн эцэг эхийн орлогоос үл хамаараад төрийн үйлчилгээ адил хүртээмжтэй байх ёстой гэдэг зарчмаа барьж бид нар энэ асуудалд хандмаар байна.

Г.Занданишатар: Жавхлан сайд хариулъя. Санал байна даа.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Энэ миний асуух гэж байгаа 3 гол асуулт байна. Нэгд нь Эрчим хүчний сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Эрүүл мэндийн сайдад ийм асуулт байна.

Хамгийн сүүлийн статистик мэдээллийг аваад хагас сайн, бүтэн сайн өдөр би бас яг ирсэн хүсэлтийн дагуу Эх нялхас гээд хүүхдийн эмнэлгээр явлаа. Дуудлага бол бүр өдөрт 300 хүнээр дуудлага ирж байна. Түүний 40-50 хувь нь л эмнэлгийн тусламж авч, эмнэлэгт хэвтээд бусад нь хоног хүлээгээд гэр лүүгээ буцаж байна, нэг тодорхой хэмжээний эм бичээд явж байна. Бүр дэндэж байна гэж бид нарт хүсэлт ирж байгаа.

Өнөөдөр харин Ерөнхий сайд, Эрүүл мэндийн сайд энэ Хүрээ Эх нялхсын эмнэлэг дээр бас очоод ямар ч байсан шав тавих ажилд орсон байна. Тэгэхээр 2023 оны төсөвт нэг 19 орчим тэрбум төгрөг сууж байгаа гэж би сая сонслоо. Тэгэхээр энэ санхүүжилт яг 23 ондоо багтаж бүрэн ороод, тэгээд 23 ондоо энэ Хүрээ амаржих газар маань ашиглалтад орох уу, эсвэл энэ маань бас ингээд хугацаатай ингээд явах уу? Энэ асуулт. Үүнийг асууж байгаа шалтгаан нь би бас

Сангийн сайд маань хэлэх байх. Энэ эрүүл мэндийн багц ингээд сайд нь оруулж ирсэн төсвийг нь би бас Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар 2 жил ажиллахдаа хүртэл анзаарч байсан, эд нар оруулж ирэхдээ төсөвлөхдөө нарийн төсөвлөөд хамгийн боломжит, бүр бараг хасуулж байгаад л нэг 1,5 их наяд ч юм уу оруулдаг, тэгээд ороод хасагдаад явчихдаг. Одоо л ингээд харахад 1,4 болоод бас хасагдчихсан. Өмнө нь төсвийн тодотгол дээр яаж хасагдаад энд хөөрхий сайд нь ч энд нэмээд өгөөч гээд л орилоод л байсан. Бид нар энд бүр Ерөнхий сайд аа, Эх нялхас дээр ийм байна гээд Ерөнхий сайд Эх нялхст өөрөө очиж үзэж байгаад тэр өргөтгөлийн асуудал дээр нь нэмэлтээр ороод ингээд шийдэгдээд явж байсан л даа. Тэгээд бас ингээд эрүүл мэндийн багц багасаад л ороод ирчихсэн байна, түрүүний бас зарим гишүүдийн яриад байгаа. Тэгэхээр энэ ЭМЯ-ныхан маань өөрсдөө цаг хугацаандаа нөгөө ТЭЗҮ-гээ гаргаад, тендерээ зарлаж чадахгүй хугацаа алдаад байна уу, эсвэл засаг дээр энэ Эрүүл мэндийн сайдын багцыг ингээд буулгаад байгаа юм уу? Энд нэг хариулт өгөөч ээ, нэгдүгээрт.

2-т нь, энэ өвчлөл ингэж нэмэгдээд байгаа шалтгаан нь юу гээч, агаар, хөрсний бохирдол, нийгмийн эрүүл мэнд чинь өөрөө доройтолд орчихсон байгаад байгаа нь ийм өөрчлөлд хүргээд байна. Ганц ЭМЯ-ны асуудал биш, тэгэхээр Чойжилсүрэн сайд аа, Коксжих нүүрсний үйлдвэр маань хэзээ ашиглалтад орох вэ, энэ өвөл нөгөө түлшний үйлдвэр маань асуудалгүйгээр явчих уу. Улаанбаатар хотын утааг, жишээлбэл, Ерөнхий сайд Хүрэлсүх дарга байхдаа бид бүгд хамтраад 50 хувь бууруулсан нь өвчлөл тэр хэмжээгээр буурах, тэр хэмжээгээр эмнэлгийн ачаалал буурахад маш чухал нөлөө үзүүлсэн. Энэ өвөл хэдэн хувиар буурах вэ, өнгөрсөн өвөл юу боллоо, бид бүгдээрээ мэдэж байгаа. Эцэст нь нэг Байгаль орчны сайд суудлаасаа огцроод л үлдсэн, асуудал шийдэгдэх үү. Энэ дээр Байгаль орчны сайдаас бас яг тодруулан хариулт өгчхөөрэй.

Байгаль орчны сайд аа, энэ агаарын бохирдол, хөрсний бохирдлыг бууруулахад 2023 оны төсөвт хэдий хэмжээний хөрөнгө мөнгө сууж байна, юу хийх гэж байна, утааны бууралт дээр би ингээд харахад нэг ч зардал байхгүй байна, ялангуяа барилга хот байгуулалтаар ингээд харахад тэр хэсэгчилсэн инженер, дэд бүтэц дээр тодотгол болгоноор хасагдсаар байгаад эхлээд наян тэрбум байсан, дараа нь далан тэрбум болсон, 21 оны 2 удаагийн төсвийн тодотголоор бүр 21 тэрбум болтлоо буураад өнөөдөр нэг төгрөг ч тавигдаагүй гээд хотынхон ч яриад, барилга хот байгуулалт нь ч яриад сүүлдээ ер нь Улаанбаатар хотын гэр хорооллыг яах юм бэ. Энэ агаар хөрсний бохирдлоо яах вэ. Энэ зүгээр нэг гэр хорооллын юм уу, тэр жорлон

юм уу, утаа яриад байгаа юм биш шүү дээ. Энэ чинь өөрөө энэ их өвчлөл үүсэхэд, Монгол хүмүүс хорт хавдраараа дэлхийд нэгд ороход хүргээд байгаа учраас бид нар ул суурьтай нь шийдье ээ гээд агаар, хөрсний бохирдол гээд орилоод байгаа юм шүү дээ уг нь, тийм. Үүнийг 23 оны төсөвт яаж суусан юм бол доо? Албаны хүмүүсээс нь сонсоход нэг төгрөг ч дахин төлөвлөлт дээр ороогүй ээ гээд хэлж байна. Тэгээд эхлээд би эд нартай нэг тодорхой хариултыг саяын сайд нараасаа авчихъя гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданишатар: зочид танилцуулъя.

УИХ-ын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Батсүхийн Саранчимэг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Энхтайваны Бат-Амгалан, Баттөмөрийн Энхбаяр нарын урилгаар БЗД-ийн Нийгмийн ардчилал Монголын эмэгтэйчүүдийн холбооны гишүүд УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ УИХ-ын гишүүдийн өмнөөс ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Асуултад Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Оюунчимэг гишүүн сайд нараас нэр зоож асуух шиг болсон тийм ээ. Тэгэхдээ ямар ч байсан би хариулъя, нэмж хариулъя.

ЭМЯ, ЭМД-ын сангийн асуудлыг хэд хэдэн гишүүд асуугаад байна. Энэ дээр би нэгдсэн байдлаар тодорхой хариулт өгье гэж ингэж бодож байна Ирэх жил ЭМД-ын сангийн нийт орлого 1 их наяд 481 тэрбум байгаа. ЭМД-ын сангаас 1,6 их наядар санал ирж байсан юм. Ингээд бид нар хамтарч суугаад 1 их наяд 481 тэрбум төгрөг ирэх жил яг таарах юм байна. Ингэснээр ЭМД-ын сангийн зардлаа бүрэн санхүүжүүлээд ямар нэг доголдол үүсэхгүй явж болох нь ээ гэдгийг тогтоосон.

Түрүүн хэлээд байсан, Чинбүрэн гишүүн бас хэлнэ лээ, доголдол үүсэх вий гэж. Үгүй ээ, тийм зүйл байхгүй. Бид яг үүнээс бага хэмжээтэй бүр 1,02 их наяд байхад 20 он, 21 оны ковидын үеийн хүндрэлүүдийг ажрахгүй даваад гараад ирсэн юм. Тэр үед бид зөвхөн ковидын тарифтай 400 тэрбум, 500 тэрбум төгрөгийг зарцуулж байсан. Ирэх жил энэ суларна, энэ орон зай байхгүй болно оо гэсэн үг. Ингэхээр бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээнүүд энгийн үед байдаг тэр ачааллаараа ингээд явахад ямар ч асуудалгүй бүрэн санхүүжүүлээд явах боломжтой гэсэн ийм судалгаа гаргаж, ЭМЯ, ЭМДҮЗ-тэй бид хамтарч энэ тоогоо баталсан дүн юм байгаа юм.

Тэгэхээр ирэх жил энэ дээр ямар нэгэн эрсдэл гарахгүй, нэгд.

2-т, Монгол Улс маань өөрөө нэг л төсөвтэй, нэг л орлоготой, түүндээ багтааж бид бүх салбарынхаа энэ зарлагыг ямар нэгэн эрсдэлгүйгээр хуваарилж, нөөцөө зөв хуваарилах нь хамгийн зөв төлөвлөлт юм. Эрүүл мэндийн салбар хэдийгээр том төсөвтэй хэдий ч цаана нь энэ чинь боловсролын салбар, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар гээд өсөн нэмэгдэж байгаа маш том олон нийгмийн суурь салбаруудын урсгал зардал, хөрөнгийн зардал гээд томоохон зардлууд байна. Энэ бүгдийг бид хязгаарлагдмал орлогынхоо хүрээнд оновчтой хуваарилалтын дараа энэ дүн гарч ирж байгаа юм. Харьцангуй ЭМД-ын сангийн зардал болбол бусад томоохон нийгмийн салбаруудын зардалтай харьцуулах юм бол харин ч бага танагдсан байгаа, бага танагдсан байгаа. Энэ яг нөгөө бодит өртөгт суурилсан ийм санхүүжилтийн системд ороод 3 дахь жил рүүгээ орж байгаа учраас төлөвлөхөд бас харьцангуй их тодорхой хялбар байдаг. Тийм учраас энэ хэмжээндээ хойтон явахад ЭМД-ын сангийн зарцуулалтад ямар нэгэн эрсдэл гарахгүй ээ гэдгийг хариуцлагатай хэлье.

Г.Занданиатар: Эрүүл мэндийн сайд 95.

С.Энхболд: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын ЗГ эрүүл мэндийн салбарт бол бодитой хөрөнгө оруулалтуудыг хийж байгаа. Үүний нэг нь бол ялангуяа эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж үйлчилгээ дээр бол илүү онцгой анхаарч, хөрөнгө оруулалтуудыг бол нэмэгдүүлсэн, өнөөдөр ч гэсэн бид нар бас Ерөнхий сайд өөрөө 21 оны 6 сарын 1-нд Хүрээ амаржих газар ажиллахдаа энэ тухайн барилгын үйл ажиллагаатай танилцаж, эмнэлгийн бас дотоод зохион байгуулалтыг судалсны үндсэн дээр 10 жил гацаад байсан шинэ өргөтгөлийн барилгын ажлыг судалж, 22 орны төсөвт суулга гэсэн ийм үүрэг чиглэл өгсөн. Энэ үүрэг чиглэлийн дагуу бид нар 22 онд энэ төсвийг суулгаж магадлан хийлгэж, барилгын төсөв бол нийтдээ 46 тэрбум төгрөгийн өртөгтэй. 23 оны төсөв дээр 19 тэрбум төгрөгийн санхүүжилт суусан байгаа. Энэ маань энэ барилга маань 22 оноос 24 онд хооронд бол хэрэгжиж дуусах ийм хугацаатай. Тэгээд үлдсэн санхүүжилт нь бол 24 ондоо хийгдээд 24 оны 3, 4 дүгээр улиралд бол хүлээлгэж өгнө өө гэсэн тийм товлолт, хугацаатай энэ маань санхүүжээд явж байгаа.

Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг 20 оны 8 сарын ЭМД-ын тухай хуульд тусгаж өгч, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн ажил эхэлсэн байгаа. Бид нар 21 оны 3 сараас эхлэн энэ албан ёсоор энэ гүйцэтгэлийн санхүүжилтийг бол явуулсан. Тэр үед бол цар тахалтай хэцүү байсан ч гэсэн бид нар энэ ажлыг бол эхлүүлсэн, энэ хугацаанд бол жил гаран жил 6 сарын хугацаанд бас бодитой үр дүнгүүд гарсан гэж үзэж байгаа юм. Тэгэхдээ

энэ бас шинэчлэлийн ажил маань бас өшөө цаашид эрчимжүүлэх, сайжруулах зөндөө ажлууд байгаа. Өчигдөр бас Чинбүрэн гишүүн асуусан, энэ дээр би нэг тодотгол хэлэх гээд 21 оны хамгийн гол нь улсын төсөвт ЭМД-ын сан дээр ковидын тусламж үйлчилгээний зардал гэж нэг ч зардал тавигдаагүй байсан. Энэ маань өөрөө бид нар ковидын тусламж үйлчилгээ үзүүлээд ирэх дээр нийт 500 гаран тэрбум төгрөгийн ийм тусламж үйлчилгээ зөвхөн ковидын тусламж үйлчилгээнд зарцуулсан байгаа.

Бид нар 22 оны төсөв дээр энэ бас тусламж үйлчилгээний 260 орчим тэрбумыг бас дааж гарч байгаа. 22 оны бас төсвөөс 100 тэрбумыг зарцуулсан. Тэгэхээр бид нар энэ 23 онд энэ ковидын эффект буюу энэ санхүүгийн тусламж үйлчилгээний тарифын нөлөөлөл орж ирэхгүй гэж үзэж байгаа юм. Тийм учраас бид нарын энэ батлагдаж байгаа төсөв маань бол ямар ч гэсэн энэ баталсан төсвийнхөө хүрээнд тусламж үйлчилгээ явуулахад бололцоотой гэж харж байгаа. Тэгэхдээ өчигдөр бас асуусан, бид нар энэ шинэчлэлийн ажлаас хэзээ ч ухрахгүй. Бид нар 21 оны намрын чуулган, 22 оны хаврын чуулган дээр ч бас Байнгын хороо дээр маш их асуусан. Салбарын шинэчлэлийн ажлыг цаашид үргэлжлүүлэх боломжтой юу гэж асууж байсан. Бид нар бол энэ санхүүжилт, гүйцэтгэлийн санхүүжилтээс бол цаашид ухрахгүй, үүнийг өшөө сайн сайжруулахын төлөө ажиллана гэдгийг бас хэлье.

Г.Занданиатар: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хагас коксын үйлдвэр энэ галлагааны улиралд амжиж ашиглалтад орохгүй ээ, орох бололцоогүй, хүндрэлтэй байгаа. Эхний ээлжид бид нар 2 зорилго байгаа юм. Айлуудыг түлшээр хангах, дулаан байлгах.

Хоёрдугаарт, утааг бууруулах. Ямар ч байсан эхний зорилгыг биелүүлэхийн төлөө ажиллаж байгаа. Энэ Таван толгой түлшний чанарын тухайд болбол бас хүссэн хэмжээ нь Монгол Улсын стандарт батлагдсан болов чиг яг хүссэн хэмжээнд хүрэхгүй байгаа нь үнэн, хүндрэлүүд бий. Гэхдээ энэ өвөл ямар ч байсан утаа бууруулж чадахгүй гэхэд айлуудыг түлшээр тасалдуулахгүйн төлөө ажиллаж байгаа.

Г.Занданиатар: Товч тодорхой хариулчих. 94. Мөнхбаатар сайд.

Б.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын сайдын багцад ер нь Улаанбаатар хотод тодорхой 4, 5 чиглэлээр төсөв тавигдаж байгаа. Усан хангамжийг, тухайлбал Зайсан орчмын хороолол руу хотхонуудын усан хангамжийг

хангах, гэр хорооллын дахин төлөвлөлтөд инженерийн дэд бүтэц, ус зайлуулах суваг, эко жорлон гэх мэтчилэн. Ингээд янз бүрийн чиглэлээр энэ дотор бас их гол төсөл бол энэ нэгдүгээр хороололос баруун 4 зам хүртэл дулааны 11-ийн г, д 800 шугамыг мянга болгох шугам гээд энэ олон төслүүд бол тавигдаж байгаа, тавигдаж бол хэрэгжиж байгаа. Тэгэхээр ганц энэ дотор магистрал шугам, түүний салбар шугамууд, тохижилтууд, орон сууцны фасад дээвэр, тийм ээ, лифт ингээд бол төрөл бүрийн чиглэлээр бол төсвүүд тавигдаад тэгж байгаа юм. Харамсалтай нь 23 онд бол бид нар бас шинэ төсөл арга хэмжээг бол тавиагүй байгаа, мэдэж байгаа. Тэгэхээр бид нар бол энэ хугацаанд хотод хийгдэж байгаа энэ ажлуудыг бол дуусгая гэсэн байдлаар дуусгах байдлаар бол төслүүдийг хөрөнгийг нь тавиад бол хийгдээд явж байгаа.

Улаанбаатар хотод бас гэр хорооллын шугам сүлжээнээс гадна бол салбарын сайдын багцад маш олон чиглэлийн ажлуудыг хийгдээд явж байгаа гэдгийг бас давхар хэлмээр байна.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя.

УИХ-ын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Батсүхийн Саранчимэг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Энхтайваны Бат-Амгалан, Баттөмөрийн Энхбаяр нарын урилгаар БЗД-ийн Нийгмийн ардчилал Монголын эмэгтэйчүүдийн холбооны гишүүд УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд УИХ-ын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Оюунчимэг гишүүн нэг минут.

М.Оюунчимэг: Эрчим хүчний сайд бол шулуухан л хэлчихлээ дээ, утаатайгаа байна, хамгийн гол нь түлшиндээ иргэд анхаараарай гээд. Гааль дээр жишээ нь түлш орж ирж чадахгүй маш их удаж байгаа гэсэн. Тэгэхдээ бидний үүрэг бол Улаанбаатар хотын агаар утааг 50 хувь бууруулсан, түүнээс бууруулж, иргэдээ л хамгаалах чухал. Иргэд эрүүл байвал ажил хөдөлмөр эрхлэх боломжтой болно ажил хөдөлмөр эрхэлбэл бид нарын энд яриад байгаа нөгөө орлоготой байж чадна. Тиймээс иргэдийнхээ эрүүл мэнд дээр бүгд анхаарч, энэ Улаанбаатар хотынхоо утаа, хөрсний асуудал дээр бол үнэхээр онцгой анхаарах хэрэгтэй байна. Тэгээд мэдээж худлаа хэлж тэр нээгдэнэ энэ тэрээ гэж хэлэхгүй бодит үнэн байна, тэгэхдээ үүнийг яаж шийдэх вэ. 23 оны төсөв дээр бас Мөнхбаатар сайд ч гэсэн яг үнэнээ л хэлж байна, нэг төгрөг ч суухгүй 23 онд нийслэл нь болохоор Барилга, хот байгуулалтын яам мэдэж байгаа гээд, Барилга, хот байгуулалт юм болохоор нийслэл дээр гээд яг үнэнийг хэлэхэд энэ агаар

хөрсний бохирдлыг бууруулахтай холбоотой асуудал орхигдоод байна шүү. Үүнийг бодохгүй бол бид нар энд нөгөө шинэ төсөв гэж яриад байдаг, гэтэл энэ чинь эргээд олон мянга хүүхэд маань энэ өвдөж, тэр ... /минут дуусаа/

Г.Занданишатар: Дамбын Батлут гишүүн асуулт асууна.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсөв хэлэлцэж байгаатай холбоотой хэд хэдэн асуулт байна.

УИХ-ын даргын чуулганы нээлт дээр хэлсэн итгэлийн зээл олгох, иргэдээ орлоготой болгох саналыг бол би бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын эдийн засаг бол төр, хувийн хэвшлийн томоохон ААН-үүдийн нуруун дээр л явж байгаа. Тэгэхдээ бид нарт өөр ахиад гарц, боломжууд байгаа юм. Тухайлах юм бол бичил бизнес эрхлэгчдийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, цаашидад үүнд чиглэсэн төрийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх явдал гэж ойлгож байна. Өөрөөр хэлэх юм бол өөрөө өөртөө ажлын байр гаргаж, өөрөө л нэг хэн 1-нийг ажлын байраар хангачих санаатай зорилготой, маш олон бизнес эрхлэгчид байгаа, маш олон бизнес эрхлэхийг хүссэн иргэд байгаа юм. Тэд банкны шалгуур үзүүлэлтийг хангадаггүй, банкны шалгуур үзүүлэлт хангаж чадахгүй учраас бизнес эрхлэх боломж олддоггүй ийм хүмүүс. Тэгэхээр эд нарт бид нар энэ хүнд цаг хугацаанд жишээлбэл ковид гээд дараа нь энэ геополитикийн эдрээтэй нөхцөл байдал үүсчихсэн, иргэдийн орлого багасчихсан, амьжиргааны өртөг нэмэгдчихсэн, эдийн засгийн уналтад орчихсон энэ цаг хугацаанд иргэдээ орлоготой болгох тал дээр үүн дээр анхаарч ажиллах зайлигүй шаардлагатай гэж харж байгаа юм.

Тэгэхээр энэхүү итгэлийн зээл олгох асуудлыг ЗГ ер нь цаашидаа хэрхэн бодож, боловсруулж, ямар шийдэл гаргана гэж үзэж байгаа вэ. энэ тал дээр нь энд харцалт өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёрдугаарт нь, ЭМД-ын сантай холбоотой асуудал ярья. 1,4 их наяд төгрөг батлагдсан байна. Өнөөдөр инфляц 14,4 хувьтай байгаа. Эрүүл мэндийн салбарын хэрэглэгдэхүүний үнэ 50-60 хувь нэмэгдсэн байна. Тэгээд энэ зардал маань хүрэх үү, нэмэх боломжтой юу, 2021 онд ковидын зардал гээд 264,4 тэрбум төгрөгийг 22 оны ЭМД-ын төлбөрөөс шилжүүлж тооцсон байгаа шүү. Ингээд бүх зардлаа тооцох юм бол үндсэндээ өнөөдөр ЭМД-ын сан 880 гаруй тэрбум төгрөг л болж байгаа, гүйцэтгэлийн санхүүжилтээр. Энэ мөнгө өнөөдөр яг хүрэлцэж байгаа юм уу. Өнөөдөр нэг асуудал ярьж байхад эмнэлгүүд тухайлах юм бол 2 дахь шатлалын эмнэлгүүд

дээр бинт хүртэл байхгүй хэмжээнд оччихсон байна гэж байна шүү дээ, Иргэдээсээ авдаг болчихсон. Үгүй ээ, ингэж бид нар цаг аргацаасаар байгаад иргэдээсээ баахан тэр эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг авхуулсаар байгаад энэ оноо дуусгах гэж бодож байгаа юм биш биз дээ, нөхөд өө. Үгүй байлтай. Үүнийгээ анхаарч үзэж надад хариулт хэлж өгөөч ээ гэж хүсэж байна. Энэ зардлыг нэмэгдүүлж болохгүй юм уу.

Гуравдугаарт нь, төрийн өмчийн ААН-үүдийн санхүүжилттэй холбоотой асуудал. Төсвөөс гадуур маш том, хөрөнгө оруулалтууд маш том мөнгөнүүдийг зарцуулж байгаа. Үүнийг яагаад энэ улсын төсөв дээр хэлж болохгүй байгаа юм бэ, Технологийн зардлуудыг нь бид үлдээгээд бусад зардлуудаа УИХ дээрээ татаж аваад, батлаад, орон нутагт хэрэгтэй шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг хийж болохгүй юм уу. Энэ дээр нэг хариулт авъя.

Эрчим хүчний салбар үнэхээр хүнд байгаа. Гэхдээ бид нарт бас боломжууд байгаа. Өнөөдөр сэргээгдэх эрчим хүч гээд нэг 9 төсөл Монгол Улсад хэрэгжиж байна, 20 жилийн хугацаатай. Тэгэхдээ энэ компаниуд өнөөдөр эрчим хүчний нэгдсэн системд 300-575 төгрөгөөр нэг киловатт цахилгаан эрчим хүчээ нийлүүлж байгаа. Бидний үйлдвэрлэдэг үнээс даруй 3-5 дахин илүү, төрийн үйлдвэрлэдэг гээд. Тэгээд жилдээ тэр компаниуд нь 60-70 тэрбум төгрөгийн ашигтай ажилладаг. Тэгээд тариф нэмэх асуудал яриад байна л даа, тариф нэмбэл иргэдийн нуруун дээрх ачаа л нэмэгдэнэ, энэ гэрээг эргэж харж дүгнэх боломж бололцоо байхгүй юу.

Төрийн захиргааны албан тушаалтнуудын цалинг нэмэгдүүлэх гэж байна. Төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг бодож үзэх боломж байгаа юу? Нэмэгдүүлэх боломж байгаа юу, Сангийн сайд аа.

Г.Занданиатар: Жавхлан сайд, эхлээд Боловсролын сайд хариулъя. Эхлээд Жавхлан сайд хариулчих. Мэргэжлийн боловсролын асуудал

Б.Жавхлан: Батлут гишүүнийхээ асуултад хариулъя. Тэр итгэлцлийн зээлийн асуудлыг хууль нь ямар төсөл явж байна, ямар концепц өргөн баригдах уу, яг шийдлүүд нь байна, энэ яг тодорхой концепц албан ёсоор ирэхээр би албан ёсоор саналаа хэлье ээ гэж ингэж бодож байна. Ер нь бол яах вэ, итгэлцлийн зээл, ногоон зээл гэдэг бол бас дэвшилтэт ер нь улс орнуудад ийм практикууд болбол байдаг. Итгэлцлийн зээл гэдэг маань үндсэндээ барьцаа хөрөнгө байхгүй, түүний оронд итгэлцэл л гэсэн үг шүү дээ. Төр нь иргэндээ итгээд, ийм зээлийн хэлбэр байж болно оо л гэдэг ийм санаа. Тухайн үед нь тодорхой саналаа хэлье ээ гэж ингэж бодож байна.

Эрүүл мэндийн хэсгийг сайд хариулах байх.

Төсвөөс гадна хөрөнгө оруулалт гэдэг маань та төрийн өмчийн үйлдвэрийн газруудын хөрөнгө оруулалтыг ярьж байх шиг байна. Энэ удаа мөн л яг төсөв дагасан тогтоолууд дотор үүн дээр нэлээн том тийм концепцын шинжтэй заалт орж ирж байгаа шүү. Тэрийг ер нь та дэмжинэ байх гэж бодож байна. Таны үгнээс би тэгж ойлголоо. Тэнд юу гэж байгаа вэ гэхээр төрийн өмчийн үйлдвэрийн газрууд стратегийн гэж байгаа тэр жагсаалтад орсон томоохон үйлдвэрүүд, Эрдэнэт, Эрдэнэс таван толгой гээд Эрдэнэс Монгол гээд эдгээр үйлдвэрийн газрууд нь зөвхөн “шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд УИХ-аас баталсан тэр жагсаалтад байгаа, жишээ нь, Эрдэнэт үйлдвэрийн газар гээд катодын зэс үйлдвэрлэх, Эрдэнэс таван толгой дээр нүүрс боловсруулах үйлдвэр гээд эдгээр хөрөнгө оруулалтуудаа л хийнэ. Үүнээс гадна хөрөнгө оруулалтуудыг бол ирэх жил бол ингээд зогсооно, 1 жил ямар ч байсан ингээд завсарлага авна. Тэгэхээр энэ бол нэлээн ийм бодлогын шилжилтийн ийм жил болно оо гэж ингэж харж байгаа. Цаашидаа мөн яаж явах вэ гэдгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар дамжуулж ЗГ дээр үүнийг хэлэлцдэг төсвийг хэлэлцдэг, ЗГ дээр хэлэлцэж байгаа төсөв бол мэдээж Их Хурал дээр эцсийн шийдвэрээ гаргадаг ийм байдлаар цаашидаа явна.

Үнэхээр цалингийн энэ томоохон шинэчлэлийн хүрээнд орон нутагт энэ ТЗ-ийн ажилтнуудын цалинг дор хаяж 20 хувиар нэмж байгаа, ингэж шийдэл бүр гарч байгаа. Энэ бол томоохон цалингийн зөвхөн цалингийн гэлгүй, ер нь тогтолцооны шинэчлэлийн хувьд ингэж багт явж байгаа гэдгийг дахин тодруулж хэлье. Би энэ талаар нэлээн. Тэгээд ТҮ-ийн ажилтнуудын мөн асуудлыг бас шийдэх боломжтой, ингээд оруулж ирсэн хэлбэр болон Их Хурал дээр энэ төсвийг хэлэлцэх явцад энэ дээр бас засаж янзлах зүйлүүд байгаа. Ингээд төрийн үйлчилгээний ажилтнуудыг бол хамрагдуулах бүрэн боломжтой.

Г.Занданиатар: Энхболд сайд 95.

С.Энхболд: Батлут гишүүний асуултад хариулъя. ЭМД-ын сангийн энэ жилийн төсөв ирэх жил яаж батлагдаж байгаа талаар асууж байх шиг байна. ЭМД-ын сан 21 онд бол улсын төсөв болон ЭМД-ын шимтгэлийн төсөв нийлж нэг сан болж 1,2 их наядаар батлагдаж байсан. 23 он, 22 оны төсөв бол 1 их наяд 450 тэрбумаар батлагдаж байсан. Энэ бол энэ үед бид нар 21 онд би түрүүн бас Оюунчимэг гишүүний асуултад харуу хэлсэн. Ковидын тусламж үйлчилгээнд бид нар 560 гаруй тэрбум төгрөгийг зарцуулсан, түүний 264 тэрбумыг 22 оны даатгалын сангаас нэмж санхүүжсэн, мөн

дээрээс нь 1, 2 сарын бас энэ ковидын давлагааны үед бид нар нэмж 100 тэрбумыг бас энэ даатгалын сангаас санхүүжүүлсэн. Ингээд нийтдээ 22 онд ЭМД-ын сангаас 360 гаруй тэрбумыг бол бид нарт зарцуулсан байгаа, бусад санхүүжилт нь бол ерөөсөө эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулсан төсөв гэсэн үг. Тэгэхээр бид нар Сангийн яамтайгаа бол ярьж тохирсон байгаа, энэ 260 тэрбум төгрөгийг бид нар энэ онд багтааж тэнцлийг хангаж дуусгана. Тэгэх дээр 23 онд ямар нэгэн даатгалын сан дээр нэмэлт өмнөх оны үлдэгдлийг санхүүжүүлнэ гэсэн юм бол байхгүй. Тэгэхээр 23 онд 1 их наяд 481 тэрбум төгрөг бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээндээ хангалттай гэж үзэж байгаа.

Бид нар хамгийн гол нь энд 705 оношийн бүлгээр санхүүжилтийг олгодог, энэ бол санхүүжилтийг олгоход тухайн улсын бүлэгт тухайн эм, эмнэлгийн хэрэгслийн материал, тухайн байгууллагын урсгал зардал, цалин бүх юу орчихсон байдаг, жигнэсэн өртгийн жигнээр бид нар тооцож энэ тооцооллыг гаргадаг байгаа. Тэгэхээр бид нар энэ тооцооллуудыг бас хийсэн, бас сүүлийн 2 сарын хугацаанд ам. долларын хани бас нэлээн өсөж байна. Гэхдээ бид нар бол энэ 1,4 их наяд 481 тэрбумдаа энэ 23 оны төсвийг бол хангалттай гэж үзэж байгаа. Үүгээр бол бид нар цаашаа санхүүжилтээ хийгээд явах боломж бололцоо байна гэж харж байгаа.

Дээрээс нь бид нар 8 сард энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнг бол бас эхнээсээ харсан байгаа. Цаашид ч гэсэн биднүүс боломж бололцоо байвал энэ эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг шийдэхэд энэ бас эрүүл мэндийн байгууллагуудын давсан санхүүжилтийг бас зарцуулах бүрэн бололцоотой гэж үзэж байгаа юм. Энэ мэтчилэн бид нар бас эмийн энэ өсөлт болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ дээр энэ ЭМД-ын сангийн 23 оны төсвийн баталсан энэ юу бол бид нар засаг дээр бас нэлээн ярьсан, 2 яам ч гэсэн бас нэлээн ярилцаж тохирсон. Тийм учраас энэ бол маш олон хүчин зүйлээс нөлөөлж байгаа. Тээвэр ложистикийн асуудлууд бас их энд шалтгаалж байгаа. Мэдээж эм ханган нийлүүлэх 400 гаран байгууллагууд байдаг, энэ байгууллагуудын бас тээвэр ложистиктой асуудлуудтай холбоотой, энд бас хомсдол үүсэж байгаа юм. Хамгийн гол нь бид нар энд тендерт шалгарсан эрүүл мэндийн байгууллага юу ханган нийлүүлэх байгууллагуудад бол энэ санхүүжилтийг олгоод явж байгаа. Тэгэхээр ямар нэгэн бол эм ханган нийлүүлэх байгууллагууд дээр санхүүжилтийн асуудал байхгүй. Бид нар энэ сард бас нэлээн шахаж, үлдэгдэл санхүүжилтүүдийг бол гаргахаар шийдвэрлэсэн байгаа. Тэгэхээр тээвэр ложистикийн асуудал энэ үнийн өсөлтэй зарим нэг юмнууд бол холбоотой байгаа. Энэ дээр бол бид нар бол байнга уулзаж ханган нийлүүлэх

байгууллагуудтайгаа бол энэ харилцан зөвлөлдсөний үндсэн дээр бол энэ тусламж үйлчилгээний юунууд зохицоод явж байгаа гэдгийг хэлбэ.

Г.Занданишатар: Чойжилсүрэн гишүүн, сайд.

Б.Чойжилсүрэн: Батлут гишүүний асуултад харуулья. Таны сая ярьсан мэдээллүүд үнэн байна. Салхины эрчим хүчний 3 компани ажиллаж байна, 9,4 центийн өртөгтэй, сүлжээ нийлүүлэх үнэ нь 9,5, 9,5 гэсэн ийм 3 компани байна. Нарны станцууд бол бүр өндөр үнэтэй байгаа 14,2 цент байгаа. 1 киловатт цаг нь 15,3 байна, 16,5 байна, 17,3 гэсэн ийм өндөр үнээр явж байгаа юм. Тэгэхээр энэ цахилгаан эрчим хүчнийхээ хэрэглээнд эд нар маань өнгөрсөн жил маш тогтворгүй нийлүүлсэн горим, тохиргоонд хүндрэл учруулж байгаа. Нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлдээ бол 10,3 хувийг нийлүүлсэн. Эрчим хүчнийхээ борлуулалтынхаа орлогод болбол энэ 27,3 хувиа авч байгаа юм. Тэгэхээр энэ ийм өндөр үнэтэй сэргээгдэх эрчим хүчний төслүүд цаашид манай төвийн эрчим хүчний системд нэмж эх үүсвэр залгах бололцоо байхгүй болсон, өртгөө дийлэхгүй байгаа. Энэ ингээд үйл ажиллагаа явуулж байгаа 9 сэргээгдэх эрчим хүчний төсөл байна. Дээрээс нь нэмээд 11 төсөл ирээдүйд нэмж орохоор тусгай зөвшөөрлүүдээ сунгуулчихсан байгаа юм байна.

Би хувьдаа сайд болоод энэ нэг ч сэргээгдэх эрчим хүчний төслийг болбол шинээр зөвшөөрөл өгөх, ашиглалтад авах энэ асуудлыг шийдээгүй байгаа. Үүнийг бол нэг талд нь яаралтай шийдэж гаргахгүй болбол эрчим хүчний систем өөрийнхөө өртгийг дийлэхээ болино, тийм учраас бүгдийг нь ямар ч байсан эхлээд зогсооно, шинээр нэг ч эх үүсвэр юу зөвшөөрөл нэмж олгохгүй, ийм л байна. Одоо яг бодитой, үнэнээрээ ярихгүй болбол ийм өндөр үнэтэй цахилгаан эрчим хүчийг Монголын хэрэглэгчид төлж хүч хүрэхгүй ээ.

Хоёрдугаарт, энэ үйл ажиллагаа явуулж байгаа 9 ААН байгаа, эд нар болбол нөгөө хуучин, бас одоогоос хэдэн жилийн өмнө нэлээн тийм анхны болхидуу технологиор барьчихсан юм байна лээ. Тэгээд ямар ч байсан үнийг нь, үнээ бууруулах шаардлагыг болбол хүргүүлж байгаа.

Г.Занданишатар: Батлут гишүүн 1 минут асууя.

Д.Батлут: Тээвэр ложистикийн асуудлаа бид нар зохицуулж чадахгүй байдаг бол энэ төрийн буруу гэж харж байна. Тийм учраас энэ иргэдийг хохироож болохгүй, нөхөн төлбөртэй холбоотой асуудлыг эргэж тавих хэрэгтэй, үүнийг бас олох эрх нь төрд байх ёстой шүү. Тэгээд авах ёстой үйлчилгээгээ авч чадахгүй

өөрсдөө л тэгээд мөнгө гаргаад л аваад байж болохгүй биз дээ.

Хоёрдугаарт нь, энэ ЭМД-ын сан хангалттай гэж ёстой мэдэхгүй шүү. Одоо саяын тэр 100 гаран тэрбумыг чинь тооцоогүй байсан юм байна. Гүйцэтгэлийн санхүүжилт нь 700 гаран тэрбум л байгаа юм байна даа, наадах чинь хүрэхгүй дээ нөхөд өө. Тэгээд наадах чинь 23 он руугаа шилжинэ, сайн тооцоорой доо. Энэ инфляцтайгаа уялдуулж нэмэгдүүлэх ёстой шүү. Энэ дээр бас анхаарах ёстой гэж хэлмээр байна.

Нэг зүйл байна. Боловсролын сайдаас, манай орон нутагт 3 дугаар сургууль гээд шинээр барьж байгуулахаар буулгаж шинээр барьж байгуулахаар болсон, 8,4 тэрбум төгрөгийн өртөгтэй, 1 тэрбум төгрөг өнгөрсөн жил тавигдсан, одоо 2,7 тэрбум ... /минут дуусав/

Г.Занданишатар: Пүрэв- Очирын Анужин гишүүн. Хариулт хангалтгүй бол.

П.Анужин: Баярлалаа. Бид үнэхээр өнөөдөр халамжаас хөдөлмөрт гэж ярьж байна, бид нар үнэхээр халамжаас хөдөлмөрт шилжиж чадах уу. Монгол Улс төрөөс хүүхдийн мөнгийг оролцуулаад нийгмийн халамжид 2 их наяд гаруй төгрөг зарцуулж байгаа, 2020 оны байдлаар ДНБ-ий 4,3 хувь, нэгдсэн төсвийн 11,3 хувийг зарцуулж байгаа. Бид ийм мөнгийг зарцуулж байгаа хэдий ч ядуурлын түвшин огт буурахгүй 27,8 хувьтай байна.

Нөгөө талдаа халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа иргэдийг амьдралын нийт иргэдийг 100 хувь гэж авч үзвэл амьдралын баталгаажих түвшинээс доогуур орлоготой иргэд нь 34,5 хувь, дундаж, түүнээс дээш орлоготой нь 65,6 хувийг эзэлж байгаа. Өнөөдөр статистик ийм байна. Тэгэхээр үүний нөгөө талд бид энэ халамжийг бууруулахын тулд халамжаас гаргах иргэддээ зориулах төсөв огт байхгүй байна. Бид нар одоогийн нийгмийн халамжийн тогтолцоонд бол бэлэн мөнгөний үйлчилгээ давамгайлсан хувь хүн, гэр бүлийг чадавхжуулах, дэмжих үйлчилгээнд огт мөнгө тавигддаггүй. Өнгөрсөн 2021 оны статистикаар энэ халамжаас хүмүүсийг гаргахын төлөө зарцуулсан мөнгө нь нийт халамжийн нэг хувьд хүрэхгүй байгаа. Энэ жил энэ нь огт өсөж орж ирээгүй байна. Тэгэхээр яаж ч тэр нийгэмтэй харилцахгүй халамжид түшиглэж амьдарсан хүмүүс чинь нийгэмшиж ажил хийх вэ? Бид нар энэ зорилтдоо үнэхээр хүрч чадах уу?

Хоёрдугаарт нь бид нар давхардсан халамжийн талаар маш их ярьж байна, энэ халамжийг бид нар бууруулъя гэж. Тэгвэл энэ халамжийг бууруулахын тулд бид халамжийг хувь хүнээр, хувь хүний энэ статистикт түшиглэсэн ийм, тооцооллоор бид нар нэг иргэн

бүр дээр тооцооллоо хийж энэ халамжийг гаргаж байгаа юм. Тэгэхээр эндээс аваад үзэх юм болбол нэг гэр бүлд халамж давхарддаг. Нэг өрхийн олон гишүүд давхардсан халамж ингээд аваад эхэлдэг. Тэгэхээр бид нар үүнийгээ бууруулъя гэвэл гэр бүлээ, гэр бүлд түшиглэсэн ийм нэгдсэн сан бидэнд хэрэгтэй, мэдээллийн сан. Тэгэхээр энэ сангийн тухай ойлголт ч алга, энэ санд зарцуулах мөнгө, ойлголт нь байхгүй юм чинь мөнгө төгрөг юу ч алга. Тэгэхээр бид нарын энэ яриад байгаа халамжаас хөдөлмөрт гэдэг энэ зүйл маань хэрэгжих боломжтой юу? Төсөвт ч нэг ч төгрөг суугаагүй байна.

Энэ Монгол Улсын төсвийн баримт бичигт үүнийгээ томъёолж оруулж ирэхдээ халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хүрээнд нийгмийн хамгааллыг зорилтот бүлгүүдэд чиглүүлэх зэргээр төсвийн тэнцлийг сайжруулна гэж байгаа юм. Үүндээ бараг ганцхан зүйлийг яриад байна гэж хэлж байгаа ард түмний шүүмж бол зөв өө. Хүүхдийн мөнгийг бууруулна тэгэхээр миний түрүүний хэлсэн нөгөө талд нь яах э вэ. Халамжаас гаргах стратеги нь юу юм, энэ аргаа хэрэгжүүлэх арга нь юу юм бэ гэдэг нь огт туссаагүй.

2 дахь асуудал нь хэрвээ бид хүүхдийн энэ хүүхдэд өгч байгаа мөнгийг 91, 9 гэж ингэж багасгах юм бол энэ 9 хувийн мөнгө яг юунд зарцуулагдах вэ? Сангийн сайд аа. Яг юунд зарцуулагдах вэ? Би энэ дээр бас нэг зүйлийг хэлэхийг хүсэж байна. Өнөөдөр бид нар хүүхдийн Үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Би хотын хүүхдүүдийг ярихаа больё. Өөрийнхөө гэрээс явж байгаа учраас. Хөдөө орон нутагт дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүд маань нэг удаагийн хоол нь мянган төгрөгөөр төсөвлөгдөж байгаа. Өнөөдөр энэ үнийн өсөлт, инфляцтай бид нар нэг хүүхдэд мянган төгрөгөөр ямар хоол өгөх юм. Тэгэхээр энэ 9 хувийн энэ хэмнэж байгаа хэмнэлтээс ядаж энэ хөдөө орон нутагт байгаа дотуур байранд байгаа хүүхдүүдийн энэ хоолонд нэмэгдэл төлөвлөж байна уу. Үнэхээрийн бид нар энэ хөдөлмөрөөс халамжид чиглүүлэх бодлого чинь энэ халамжийн бодлого нь хүүхдийн мөнгөтэй л уялдаад байгаа юм бол ... /минут дуусав/

Г.Занданишатар: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Анужин гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн мөнгөн дээр өндөр орлоготой айл өрхүүд маань хүүхдийн мөнгөнөөс татгалзаад, илүү зорилтот бүлэг рүүгээ түлхүү явах, зориулах энэ хүнд үеийг ингэж бид нар давах, дээрээс нь ковидын үед өрхийн бодит орлогыг дэмжиж ирсэн энэ хүүхдийн мөнгөний орлого маань онцгой, нийгмийн үүргээ бол гүйцэтгэсэн. Цаашидаа төсвийн зөв хуваарилалт, энэ бидний тавьж байгаа том макро зорилгууд гээд энэ бүгдтэйгээ бас нийцтэй явах ёстой.

Тэгэхээр цаашидаа Нийгмийн халамжийн тухай хуульд орж, хүүхдийн мөнгө маань халамжийн нэг хэсэг болж байгаа учраас илүү зорилтот хэсэг рүүгээ илүү хүртээмжтэй, илүү үр дүнтэйгээр ингэж зарцуулагдах нь зөв юм гэж ингэж харж байгаа юм.

Хэмнэгдэж байгаа эсэх нь болбол 67 тэрбум төгрөг. Энэ нь ирээдүйн өв сан дээрээ үлдэнэ ээ гэсэн үг. Өөрөөр хэлбэл хойч ирээдүйдээ бид зарцуулагдах энэ сандаа хуримтлагдаж үлдэнэ ээ гэсэн үг.

Бусад тэр халамжаас хөдөлмөр лүү явах энэ бодлого юмнуудыг тэнд сайд гараа өргөөд байна, дэд сайд хариулах байх.

Г.Занданиатар: 1. Зулхар сайд. Дэд сайд Зулхар хариулъя.

С.Зулхар: Анужин гишүүний асуултад хариулъя. Халамж бол нийгмийн хамгааллын 3 арга хэрэгслийн нэг нь. 3 аргачлалын нөгөө 2 нь болбол нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт. Өнгөрсөн хугацаанд бол бид халамжаас хөдөлмөрт шилжих ийм уриа дэвшүүлсэн. Үүний хүрээнд тодорхой, жишээ нь бодлогын зохицуулалтууд хийгээд явж байгаа нэг үндсэн арга нь бол халамжийн хуулийг шинэчилж байгаа, зорилтот бүлэг рүү чиглүүлсэн байдлаар илүү хүртээмжтэй, илүү одоо түүнээс гадна үүнтэй бүр ашигтай болох ийм чиглэл рүү явж байгаа гэдгийг илэрхийлье.

2 дахь зүйл бол хөдөлмөр эрхлэлтэй холбоотой асуудал байгаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр, ялангуяа гарцаа байхгүй, жишээ нь дэмжлэг шаардлагатай бүлгүүд рүү чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөвт суусан 90,4 тэрбум төгрөг байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар. Энэ дотроос бид болбол энэ жил арга хэмжээнүүдийг тухайлсан байдлаар авч хэрэгжүүлнэ гэсэн байгаа, та бүхэн мэдэж байгаа, хэвлэлээр ч гэсэн яригдсан. Зорилтот бүлгийн 5270 өрх рүү чиглэсэн тухайлсан хөтөлбөр хэрэгжинэ. Түүнээс гадна 50000 жишээ нь ажилгүй иргэдэд чиглэсэн профайлын хөтөлбөр хэрэгжинэ. Үүнээс гадна болбол хувиараа болон бичил бизнес эрхлэгчид рүү чиглэсэн зээл болон мөнгөн дэмжлэгийн ийм үйл ажиллагаанууд хэрэгжинэ. Үүнтэй холбоотойгоор бол бас тооцоолол хийгдсэн байгаа. Баярлалаа.

Г.Занданиатар: Анужин гишүүн тодруулж асууя, 1 минут.

П.Анужин: Төсөв Байнгын хороо дээр хэлэлцэгдэх үед Зулхар сайд аа, би энэ талаар танаас өшөө дэлгэрэнгүй асууна. Ингэж тойрсон, авах ч юм байхгүй, сонсчих ч юм

байхгүй ийм хариулт өгөхөөс та боль оо. Ийм том зорилт тавьчихаад яг яаж хэрэгжүүлэх юм гэхээр тодорхой юм хэлэхгүй наад улиг болсон хариултаа та өөрчил өв.

Энэ халамжийг зорилтот бүлэг рүү чиглүүлнэ гэдэг нь туйлын зөв. Тэгээд энэ хэмнэгдэж байгаа мөнгөнөөс ирээдүйн өв сан руу орно оо гэж байна. Үгүй ээ, тэгээд энэ хөдөө орон нутагт байгаа хүүхдүүдээ жоохныг өгчхөж болохгүй юм уу? Үр хүүхдүүдээ мянган төгрөгөөр өнөөдөр хооллох тухай яриад байна шүү дээ. Юун эрүүл Монгол хүн, юун хүнсний хувьсгал вэ? Зөв хооллож байгаа хүнд эмч хэрэггүй, зөв хооллохгүй болбол эмч хэрэггүй гэж үг байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүүхдүүд чинь 50 хувь нь тэжээлийн хомсдолд ороод байна. Тэгэхээр наад ирээдүйн өв сангаасаа жоохон ч гэсэн мөнгө ядаж хөдөө орон нутаг руу нь болохгүй юм уу? Мянган төгрөгийг нэмж, бүр хотоо байя л даа, орон гэрээсээ явж байгаа хүүхдүүд. Би үүнийг л асууж байгаа юм.

Г.Занданиатар: Зулхар сайд, дэд сайд Зулхар.

С.Зулхар: Анужин гишүүний асуултад хариулъя. Би халамжтай холбоотой, бас зарим зүйлийг танд дахин мэдээлэл болгож өгье. Өнгөрсөн Байнгын хорооны хуралдаан дээр та бүхэн давхацсан байдлаар халамж авч байгаа иргэдийн талаарх мэдээллийг өгөөрэй гэсэн, бид үүнийг бэлэн болгосон байгаа.

Халамж авч байгаа иргэдийн давхцал бол ихэвчлэн тухайлбал тухайн кейсээсээ шалтгаалаад 1-5 хүртэл байгаа гэдгийг энд дахин тэмдэглэе. Тэр нь тухайлбал ахмад настай хүн болбол эмэгтэй хүн байх юм бол нэг талаар одонтой ээж нэг талаар, жишээ нь насны хишиг гэсэн ийм хөтөлбөрт хамрагддаг. Цаашидаа шаардлагатай болбол ороо портез, ортопедийн үйлчилгээнд хамардаг, энэ нь явсаар байгаад зарим тохиолдолд болбол жилдээ 3 болдог, заримдаа жишээ нь 5 болдог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүү чиглэсэн үйлчилгээ болбол заримдаа 5 болдог, зарим жил бол 7 болдог, ийм байгаа. Энэ нь явсаар байгаа тоо их өндөр байгаа юм шиг харагдуулдаг, ийм байгаа гэдгийг хэлье. Гэхдээ бол халамж болбол хүрэх ёстой эзэндээ хүрэх ёстой, яагаад гэвэл нийгмийн хамгааллын энэ хөтөлбөр хэрэгжихгүй бол үүнээс гарах нийгэм, эдийн засгийн үр дагавар нь өөрөө улам хүнд байна гэдгийг хэлье.

Г.Занданиатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Эдийн засаг, төсвийнхөө асуудлыг яриад л байгаа. Байдал, нөхцөл амаргүй

байна. Тэгэхдээ энэ нь яг нарийндаа ЗГ-ын буруу энэ тэр гэж хэлэх янзгүй, дэлхий нийтээрээ хүндхэн сорилтыг давж байна. Энэ хүнд цагийн үеийг бас аль болохоор эрсдэл багатай, үндэснийхээ эдийн засгийн систем, иргэдийнхээ аж амьдралд аль болохоор хохирол багатай давах энэ л арга ажиллагааг авч хэрэгжүүлээд яваад байгаа. Энэ жилийн төсвийн бодлого, зарчмыг бол би ерөнхий агуулгаар нь бол дэмжиж байгаа. Гэхдээ ярих зүйлүүд дотор нь олон байгаад байгаа.

Төсөвтэйгөө дүйсэн шахуу хөрөнгө оруулалтуудыг хийгээд байдаг энэ төрийн өмчтэй компаниудынхаа асуудлыг бид цэгцлэхгүйгээр явахгүй ээ, явахгүй. Тийм учраас энэ төрийн өмчийн компаниудыг олон нийтийн болгох тухай ярьж байгаа, олон нийтийн болгох тухай асуудал ярихдаа бид нэмэлт хувьцаа гаргаж дүрмийн сан гэдэг юм уу, юуг нь санхүүгийн чадамжийг нь нэмэгдүүлэх тухай асуудал яриад байгаа юм шиг байгаа юм. Биш, энэ хүнд цаг үед тодорхой хэсгийг нь төсөв рүүгээ татаж авах ёстой юм, тэр үнэт цаасаар орж ирж байгаа орлогын тодорхой хэсгийг татаж авах ёстой, бид. Тэгж эх үүсвэр болгож ашиглах ёстой гэж нэг.

2 дахь зүйл, ерөөсөө энэ төрийн өмчтэй компаниудад хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай асуудал байгаа юм. Энэ зардал юмнуудыг нь хянаж, хязгаарлалтын асуудал хийх ёстой. Энэ бол хүмүүсийн хувийн өмч биш ээ, ерөнхий захирлууд биш, энэ ард түмний баялаг дээр гүйцэтгэх захирал хийж байгаа улсууд байхгүй юу. Тэгэхээр энэ нөхдүүд энэ ажил асуудалдаа зөв ханддаг байх ёстой. Үүн дээр нь тавьдаг хяналт, эрх зүйн зохицуулалтаа боловсронгуй болгох ёстой. Манай Эдийн засгийн сайд өчигдөр хариулж байгаа нь бол энэ компаниуд өөрийнхөө үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, хөрөнгө оруулалтаа тэндээсээ хийх нь зөв маягийн юм ярьж байна лээ. Улаан буруу юм байхгүй юу энэ чинь. Яг нарийндаа мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёртоо тооцогдоогүй баахан хөрөнгө оруулалт хийгээд наад инфляц бүх юмыг чинь хөөрөгдөөд, энэ ард түмний аж амьдралыг хүндрүүлээд байгаа асуудал чинь энд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг бид орох ёстой газар нь оруулж, хийх ёстой хөрөнгө оруулалтыг нь буцааж хуваарилалтын зарчмаараа хийх ёстой. Ийм асуудлыг яаж тооцож байгаа юм бэ, энэ төсвийн үзэл санаан дотор орж ирсэн юм байна уу гэж.

2 дахь зүйл, хүнд байна, хийх юм их байна. Төр, хувийн хэвилийн түншлэлийн зарчмаар юу хийх юм, бид юу хийнэ гэж бодоод байгаа юм бэ? Далд эдийн засаг их байна тухай яриад байгаа юм. Би магад ч үгүй байх гэж санаад байгаа, энэ их олон том тэрэг, эд нарыг нь харахаар далд эдийн засаг байж мэдэхээр юм

шиг байгаад байгаа юм. Тэгвэл тэр далд эдийн засгийг энэ бодит эдийн засаг руу оруулж ирэхийн тулд төр, хувийн хэвилийн түншлэлийн хүрээнд жосоохон юм хийлгэвэл яасан юм. Дотоод эх үүсвэрээ жосоохон дайчлах гэж оролдье л доо, энэ талаар юу хийх вэ, хэдүүлээ.

Дараагийн нэг асуудал, өмнө нь энэ ард түмний баялгаас бартер маягаар хийчихсэн том хөрөнгө оруулалтууд эцсийн байдлаараа үр өгөөжөө өгөхгүй байгаа, төмөр замууд. Тэрийг яаж холболтыг нь дуусгаж, үр өгөөжийг нь хүртэх юм бэ? 23 онд үүнийг хангах талаар ер нь ямар хөрөнгө хаана тусчхаад байна. Үүнийг нэг бодмоор байна.

Дараагийн нэг асуудал баялаг бүтээгч нарыг яаж дэмжих юм. Энэ бол зүгээр нэг үг биш шүү. Эдийн засгийг идэвхжүүлэх тухай асуудал, ажлын байраа тогтвортой хадгалах, нэмэгдүүлэх тухай асуудал, нөгөө ядуурлыг бууруулах тухай асуудал, өнөө халамжаас хөдөлмөрт шилжих тухай асуудал бүгдээрээ яг энэ дээр ирээд төвлөрч байгаа. Үүн дээр ямар хөрөнгө юу байгаа юм? Үүнийг нэг тодорхой анхаармаар ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ийм юм байгаа юм шүү, Батжаргал гишүүн ээ, төрийн өмчит үйлдвэрийн газруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн хүрээнд энэ засаглалыг нь сайжруулна гэж байгаа юм. Ялангуяа бирж рүү гаргаж, олон нийтийн ХК болгоё, компанийн тухай хуулиар олон нийтээс тавих хяналтыг нь сайжруулъя гэдэг ийм зарчмаар. Хэрвээ бид хувьцаа гаргаад хувьцааны орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлнэ ээ гэх юм бол ганц ч хувьцаа зарагдахгүй, ганц ч хувьцаа хөрөнгийн зах зээл дээр үнэд хүрэхгүй. Хувьцааны орлогоороо тухайн компанийн үйл ажиллагааг нь сайжруулах, үйл ажиллагааг нь тэлэх, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нь дээшлүүлэхэд энэ иргэд зарцуулагдаж байж тэндээс өгөөж гарч байж энэ хувьцаанд хөрөнгө оруулагч нар мөнгөө хийнэ. Төсөв аваад явчихна гэвэл ямар ч хөрөнгө оруулагч сонирхохгүй. Компанийн тухай хуулиар энэ бол ашиг биш, бид ашгийн татвар ашгийн дараах ногдол ашгаар төр өөрийнхөө хувь эзэмшлийнхээ өгөөжийг авч төсвийн орлого руу татдаг юм байгаа юм. Тэгэхээр одоогоор бид ийм зохицуулалт хийх нь болбол зохимжгүй ээ гэж хариулмаар байна.

Зардал хязгаарлалт бол тантай би 100 хувь санал нийлж байна. Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу энэ бол төсөвт байгууллагууд болон төсвөөс гадуурх төрийн өмчийн үйлдвэрийн газрууд бүгдээрэнд нь хамааралтай, жижиг том гэлтгүй орон нутгийн, мөн төрийн төвлөрсөн гэлтгүй бүх ААН-үүдэд хамааралтай юм. Тийм ч

учраас энэ жил болбол энэ хуулийн үр дүн их сайн гарах, гүйцэтгэлд нэлээн эерэг нөлөөлөх шинжтэй байна. 23 онд ч гэсэн цаашиагаа ингээд хэвшил болоод ингээд явна.

Төрийн өмчийн үйлдвэрийн газруудын хөрөнгө оруулалт дээр мөн л тантай би санал нийлж байна. Үүнийхээ хүрээнд ч тэр энэ удаагийн төсөв дагасан хэд хэдэн тогтоолууд дээр энэ зохицуулалтууд орж ирж байгаа. Ирэх жил зөвхөн УИХ-аар баталсан ЗГ-аас дэвшүүлж байгаа “шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд батлагдсан хөрөнгө оруулалтын жагсаалтад л орсон зүйлүүд дээр хөрөнгө оруулалт хийнэ. Бусад зүйлүүдийг бол ирэх жил болбол хийгдэхгүй. Цаашиа ч мөн энэ хөрөнгө оруулалт дээр эрэмбэ дараалал тавьж, ЗГ үүнийг бүрэн хянаж, ЗГ хянана гэдэг маань УИХ-аас эцсийн байдлаар үүнийг тогтооно оо гэсэн үг, ийм байдлаар явна. Тийм учраас төр зөвхөн төсвөөр биш, төрийн өмч, үйлдвэрийн газрууд дээрээ ч гэсэн энэ хөрөнгө оруулалтын бодлогыг нэгдсэн байдлаар удирдаж явах энэ концепц руугаа бид шилжснэ байгаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэр лүүгээ бид ер нь том салбаруудаасаа эхлээд бид шилжээд эхэлсэн. Нэгд, маш том, жишээ, үр дүн бол энэ эрүүл мэндийн салбар байгаа. Эрүүл мэндийн салбарын зөвхөн улсын эмнэлгүүд дээр иргэдэд үзүүлдэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гадна хувийн эмнэлгүүдээр дамжуулж энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болъё, тэр үйлчилгээг нь улс худалдаж авдаг болъё оо. Энэ бол төр, хувийн хэвшлийн түншлэлийн маш том, сонгодог жишээ нь энэ байгаа. ЭМД-ын сангаас хувийн эмнэлэг гэлтгүй улсын эмнэлэг гэлтгүй нэгдсэн нэг өртгөөр нэг тарифаар явж байгаа бүх эрүүл мэндийн үйлчилгээг төр худалдаж авч байгаа нь бол маш том, ийм шилжилт маш том, сайн үр дүн өгч байгаа ийм үлгэр жишээ юм.

Мөн цаашиа ч бид нэгжсийн тухай хуулиар ч тэр ийм төрийн өмчийн боломжит үйлчилгээнүүдийг хувийн хэвшилээр хийлгүүлэх, энэ төсөв болбол нээлттэй болсон эрх зүйн зохицуулалт нь. Харин үүнийг цаашиа бид төр, хувийн хэвшлийн түншлэлийг гаргаснаар төгс хийх бүрэн боломж нээгдэнэ ээ. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг ЗГ, УИХ-д өргөн бариад одоо яг хэлэлцээд явж байгаа. Энэ хуулийг ирэх жилийн төсөвтөө батлагдахтай зэрэгцээд гарчих юм бол ирэх онд ч гэсэн тэр энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн ... /минут дуусав/

Г.Занданиатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Дараагийн нэг тодруулмаар байгаа юм, энэ “шинэ хөдөө” төсөл дээр ер нь ямар хөрөнгө тавьж байна? Хүнд цаг

уеийг энэ ХАА-н салбар чинь авч гарч байна шүү, амь амьжиргаа болж. Энэ салбарын хөгжлийг хангах талаар ер нь ямар хөрөнгө мөнгө хаана байна?

Дараагийн нэг зүйл. Зуун мод дээр 2 том хөрөнгө оруулалт байсан, 23 онд дуусахаар байсан. Нэг нь 110-ын агаарын дамжуулах шугам, 110, 35, 10-ын дэд станцын асуудал. Нөгөөдөх нь инженерийн шугам сүлжээний асуудал байсан. Тэгэнгүүт 24 он болгоод 23 онд санхүүжих дүнг нь багасгачихсан байна. Энэ хаанаас Их Хурлын баталчихсан шийдвэрийг өөрчлөөд байна вэ? 23 ондоо л дуусах ёстой. Гэтэл энэ хөрөнгө оруулалтын жагсаалт дотор 24 он болгоод үлдэгдэл хөрөнгийг нь 2 хуваагаад тавьчихаж байгаа байхгүй юу. Энэ бол Улаанбаатар хотын төвлөрөл түгжрэлийн ... /минут дуусав/

Г.Занданиатар: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Санал хэлэх шиг боллоо. Тэгэхдээ яах вэ, нэмж хариулъя. “шинэ хөдөө” дээр бол ийм байгаа шүү. 14 аймаг дээр энэ “шинэ хөдөө” төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа, ер нь ингээд багц багцаараа явдаг. Гэрээ нь хийгдээд явж байгаа бүх төслүүд үргэлжилнэ, гэрээ нь хийгдээгүй энэ жил үлдсэн хугацаанд хэрэгжих магадлал муутай, ингэснээсээ болоод хойтон үргэлжлэх эсэх нь тодорхойгүй байгаа ийм зөвхөн “шинэ хөдөө” биш. Бусад өөр олон төсөл хөтөлбөрүүдээр ч гэсэн нэг ийм ижил зарчим барьж хязгаарлалт хийсэн байгаа юм. Энэ нь ч гэсэн ер нь 23 онд дахиад дуусахгүй, энэ нь ахиад 24, 25 оноор үргэлжлэх ийм эрсдэлүүдийг ч гэсэн бас хааж байгаа гэж ингэж харж байгаа.

Зуун мод 2 төслийн талаар энэ Чимидээ дарга хариулагдах уу. Тухайлан 2 төсөл дээр.

Г.Занданиатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ажлын хэсэг 84 хариулъя.

Сангийн яам Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга Чимидсүрэн гишүүний асуултад хариулъя. Шинэ нисэх Зуунмод сумыг холбох 110 киловаттын цахилгаан шугам дээр Саруул өргөө, Илч хангай гэсэн энэ компаниудын түншлэл бол ажиллаж байгаа. 22 онд 1,5 тэрбумын санхүүжилт батлагдсан, одоогоор бол гүйцэтгэлээр санхүүжилт нь болбол гараагүй байна.

23 оны төсвийн төсөлд болбол санхүүжих дүнг нь болбол 1,3 тэрбум төгрөгөөр болбол өргөн барьж байгаа. 24 он руу гүйцэтгэлийнх нь явцтай уялдуулаад дуусах

хугацааг нь бол 2024 он болгож төсвийнхөө орон зайнд тааруулж өөрчилсөн байгаа.

Г.Занданишатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Зуун мод хотын энэ тов тодорхой 2 төсөл дээр хэрэгжилт нь удааширч байгаа тов тодорхой шалтгаан байгаа юм. Төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлдэг үндсэн чиглэл бүхий яамны хувьд хэрэгжилтийнх нь явцаас нь шалтгаалж үргэлжлэх хугацааг оруулах санал бүрэн эрхийнхээ хүрээнд энэ ЗГ ингэж саналаа оруулж байгаа юм. Энэ төслүүд 23 онд хэрэгжиж дуусахгүй байх ийм эрсдэлтэй байгаа, одоо явж байгаа, энэ жилийнх нь явцыг нь харахад. Харин ч энэ эрсдэлээс хамгаалж, энэ 23, 24 онд ингэж жигд тавьж өгч байгаа юм шүү.

Г.Занданишатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 2023 оны Монгол Улсын нэгдсэн төсөв орж хэлэлцэгдэж, Батжаргал гишүүн ээ. Үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаа, дэмжих олон үндэслэл байгаа гэж ингэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт бол энэ төсвийн алдагдлыг бууруулна гэдэг бол ирээдүйд төлөх өрөө л багасгаж байна гэсэн үг. Мөн 30 жил яригдсан энэ төсвийн төрийн хэмнэлтийн асуудлууд, энэ дарга, ангийн гэж яригдаад байгаа энэ олон зардлууд хэмнэгдэж байна. Гол нэг том зүйл бол тойрог биш, улс орноо бодъё гэдэг энэ том бас үзэл баримтлал орж ирж байна гэж ингэж бодож байгаа юм.

Өнөөдөр эрчим хүчний салбар гал алдахад ойрхон байна гэж салбарын сайдыг нь л хэлээд байгаа болохоос биш 30 жилд бас энэ эрчим хүчний салбартаа ямар хөрөнгө оруулалтууд хийх вэ гэдгээ бас яриагүй л жишээ, өнөөдөр бас би нэг зөв голдирол руугаа орох юм руугаа орж байгаа юм болов уу гэж ингэж бодоод байгаа юм.

2023 онд нөгөө олон гадаад бондын өрүүдээ бас Монгол Улсад төлнө. Үүний бас бэлтгэл ажлууд энэ хангагдаж байгаа юм байна гэж ингэж ойлгож байгаа. Шинэ юм хийхгүй гэдэг нэг том зүйл орж ирж байгаа юм. Гэхдээ үүний цаана бол шинэ юм хийдэг мянган компанийн маань өнөөдөр хүндрэлд орчихсон энэ санхүүгийн хүндрэлүүд, энэ олон гацсан үнийн хөөрөгдөлд орсон энэ барилгууд 2023 онд дуусаж, төрийн үйлчилгээ бүх юмнууд бас явах нь ээ гэж ингэж бас бодож байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлэн тавьсан энэ хүнсний аюулгүй байдлын асуудал энэ төсөв дээр бас тусгайлан ингэж орж

ирж байгаад бас туйлын талархалтай байгаа. Баялаг бүтээгч нар энэ зүйлийг маш их хүлээж байгаа, маш их хүлээлт байгаа, үүний бас хариулт энэ дээр тусгагдаж байна, хүнсний аюулгүй байдлын асуудал гэж ингэж бас бодож байна.

Тэгээд хэдэн асуулт байгаа юм. Нэгдүгээрт, Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүний хувьд энэ эрүүл мэндийн санхүүжилт дээр салбарын санхүүжилт дээр Чинбүрэн гишүүнээс авхуулаад бас нэлээдгүй шүүмжлэлтэй хандаад байна. Тэгээд энэ яг ирэх онд, 2023 онд эрүүл мэндийн салбар дээр ямархуу хүндрэлүүд үүсэх үү, үүсэхгүй юу гэдгийг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд 2 тодорхой хариулаад өгөөч ээ. Яагаад гэвэл энэ чинь өөрөө том салбар, үүнийг надаар хэлүүлэлтгүй та бүхэн мэдэх байх.

2-т нь, миний бас нэлээн ярьдаг асуудлуудын нэг. Энэ төрийн албан хаагчдын цалингийн асуудал. Энэ дээр бас 2023 онд энэ замбараагүй явж байгаа цалингийн сүлжээ нэг чигтээ гарах нь ээ гэж ингэж бас би ойлгож байгаа. Энэ дээр гишүүдийн ярьж байгаа энэ төрийн үйлчилгээний албан хаагч нар бас орох уу гэдгийг бас нэг тов тодорхой хариулж өгөөрэй гэж ингэж бодож байна.

3 дахь асуудал юу вэ гэхээр энэ эдийн засгийн төрөлжилт гэдэг ийм зүйлүүд бас нэлээн яригддаг. Тэгээд энэ эдийн засгийн төрөлжилт дээр уул уурхайн салбар бол нэлээн ДНБ-д эзлэх жингийн хувьд бол байнга өсөлттэй явж ирсэн байна. 1996-2022 оны хугацаанд уул уурхайн салбар 11 хувь байсан бол өнөөдөр 27 хувь болтлоо өссөн байна. Гэтэл харамсалтай нь ХАА-н салбар маань 41 хувь байсан бол 17 хувь болтлоо буурсан байна, ДНБ-д үзүүлж байгаа хувь. Тэгэхээр энэ дээр энэ малчдын гол ярьдаг, энэ түүхий эдийн үнийн асуудал, энэ мал махны экспортын асуудал, энэ малын вакцин, энэ эрүүлжүүлэх асуудлууд ер нь 2023 онд ер нь ямархуу асуудлууд байгаа юм бэ. Шинэ хөрөнгө оруулалт юу ч байхгүй байгаа. Тэгэхээр энэ Био комбинат энэ асуудлууд яах юм.

Тойрогтоо ажиллаад 10 гаруй мянган малчидтай уулзахад энэ л асуудлыг ярьж байна. Улсын хэмжээнд 250000 гаруй малчин өрхийн асуудал энд бас би давхар яригдаж байна гэж ингэж бодож байгаа. Саяхан Заригийнхан Вьетнамд очоод сурвалжилга хийхэд бидний ад үзээд байдаг ямааны нэг килограмм мах 10-15 доллар байна гэж ингэж яригдаад байдаг. Тэгэхээр энэ эдийн засгаа төрөлжүүлэхэд доллар орж ирэхэд гол нөлөө үзүүлэх боломжтой энэ салбар маань 2024 оны үед ямархуу өнгө төрхтэй байгаа юм бэ, ямархуу зорилго юм байгаа юм бэ, энд би хэн хариулахыг нь сайн хэн хэлж мэдэхгүй байна, энэ ХААЯ-ныхан байхгүй байна гээд ингээд

байгаа шүү дээ. Ийм асуултауддаа хариулт авъя гэж ингэж бодож байна.

Г.Занданиатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Идэрээ гишүүний асуултад хариулъя. ХАА-н салбар маань манай улсын эдийн засгийн голлох бүгд уламжлалт ийм томоохон эдийн засгийн бүтэц ээ. Цаашидаа ч энэ байр суурь нь хэвээр явна гэдэгт огт эргэлзэхгүй байгаа. Гагцхүү сүүлийн 10 гаруй жил энэ уул уурхайн салбар нэлээн хүчтэй тэлж байгаа учраас ДНБ-д эзэлж байгаа хувь хэмжээ нь багасаж байгаа юм. Түүнээс биш тухайн өөрийнх нь салбарынх нь өсөлт болбол жигд, жил бүр өсөөд л, үүрэг нь илүү нэмэгдээд л ингээд явж байгаа. Тэгсэн хэдий ч манай ХАА-н салбар болбол хамгийн их ажил олгодог, ажлын байрыг шингээдэг ийм салбар. Уул уурхайн салбар хэчнээн том дүнтэй боловч ажлын байр шингээдэг тоо нь бол харьцангуй бүр хэд дахин бага ийм байдаг. Тэгэхээр энэ том ажил олгогч, том салбараа бид үргэлж анхааралдаа байлгаж, энэ бодлогын төвд байх болно оо.

Ирэх жил хүнсний аюулгүй байдал гээд бид Ерөнхийлөгчийн санаачилсан УИХ-ын тогтоолоор батлагдсан энэ хөтөлбөрийг ЗГ бүрэн дэмжиж, ирэх жилээс онцгой анхаарч төсөв дээрээ суулгаж явж байгаа. Зөвхөн хүнсний аюулгүй байдал, хангамж энэ дээр зориулж нийтдээ 228 тэрбум төгрөг тавьсан байгаа. Үйл ажиллагааны урсгал зардал дээр нэмэлт 90 тэрбум, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, зээлийн хөнгөлөлт, яг ХАА-н салбарын боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдийг маш тодорхой нэг шат ахиулах энэ хөтөлбөрт нийтдээ 138 тэрбум төгрөгийг нэмэлт зарцуулж байгаа, өмнөх жилүүдээсээ.

Дээрээс нь татварын бодлогын хүрээнд ч тэр тухайн энэ ХАА-н салбарын боловсруулах үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийг 2027 он хүртэл гаалийн татвараас нь бүрэн чөлөөлж байгаа. Энэ олон бодлогуудын үр дүнд энэ салбар дээр тодорхой хэмжээний ахиц гарна гэж бид ингэж харж байгаа. Мөн УИХ-аас баталсан, үндэсний аюулгүй байдлын энэ хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг харах жил болно оо гэж харж байна.

ТҮ дээр бол бид орхихгүй ээ, орхиж болохгүй, орхиж болохгүй. Тэгэхээр ЗГ-аас оруулсан төсвийн хүрээнд, мөн төсвийг УИХ дээр хэлэлцэх явцад үүнийг бас өшөө их илүү оновчтой болгох хувилбар, боломжууд бол байгаа. Гэхдээ Энхболд сайд ч гэсэн бас хэлэх болов уу, энэ энгийн ТҮ-ийн ажилтнуудтай, манай эрүүл мэндийн салбарын ТҮ-ийн ажилтнууд, мөн боловсролын салбарын ТҮ-ийн ажилтнууд бол барьцахгүй байх гэж ингэж найдаж байна. Энэ 2 салбар бол түрүүлээд, төсвийн шинэчлэлийн

хүрээнд энэ цалингийн тогтолцоо нь бол өөр болоод явчихсан. Манай Энх-Амгалан сайд салбарынхаа багш, ажилтнуудын суурь цалинг ингээд тогтоочихсон, ЭМЯ дээр ч мөн энэ шийдвэрүүд мөн ЗГ дээр гараад, ингээд суурь цалин нь тогтчихсон байгаа учраас бусад үлдсэн энгийн ТҮ-ийн ажилтнуудыг болбол бид ирэх оны төсвөөс цалингийн тогтолцоо дээр нь өөрчлөлт хийгээд суурь шатлалыг нь нэг түвшинд аваачаад явахад бол болохгүй зүйл байхгүй. Энэ дээр харин орон нутаг, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар маш харьцангуйтай байх хэрэгтэй. Энэ эрх мэдэл, үүрэг харьцангуй нь орон нутаг руу шилжиж очно, өөрөөр хэлбэл орон нутагт байгаа ТЗ, ТҮ-ийн ажилтнуудын цалин хөлсний асуудал, эрх мэдлийнхээ хамт үүрэг харьцангуй нь ч бас тэндээ очно. Тийм учраас орон нутаг маань татаас авдаг биш, илүү их орлоготой, илүү их баялаг бүтээгч нарыгаа орон нутагтаа илүү дэмжиж, татварын суурь орлогоо өсгөж, ингэж цалингийнхаа энэ тогтолцооны шинэчлэлд зарцуулах ийм боломжууд нь, өөрөөр хэлбэл эдийн засгийн тэр өдөөгч хүчин зүйл, энэ бүх зүйл орон нутаг руу ... /минут дуусае/

Г.Занданиатар: Энхболд сайд 95.

С.Энхболд: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Маш олон гишүүн ЭМД-ын сантай холбоотой асуудлыг асууж байна. Идэрбат гишүүн 23 онд ЭМД-ын сан ямар нэгэн алдагдалгүй ажиллаж байж чадах уу гэж асууж байна. Энэ дээр би нэг хэд хэдэн тоо баримтыг бас дахиад хэлье.

Бид нар энэ гүйцэтгэлийн санхүүжилтэд 21 оны 3 сараас эхлэн шилжиж ороход ЭМД-ын сангийн дээд хязгаар хэд байх вэ гэдэг нь аль ч яам дээр бас тодорхойлох боломжгүй байсан. Энэ маань өөрөө шинэчлэлийн ажил эхэлж байсан үе, 21 он бол бас өөрөө ковидтой бас хэцүү цаг үе байсан. Гэсэн хэдий ч гэсэн энэ бид нар энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн ажлыг бол эхлүүлсэн байгаа.

22 онд бол бид нар бас эхний 8 сарын бас мониторинг хийж үзсэн, энэ дээр бас нэлээн эерэг үр дүнтэй үр дүнгүүд бол гарсан байгаа. Тэгээд мэдээж 21 оны ковидын үлдэгдэл ковидын эффектгүйг биднүүсийн 22 орныхоо 4 дүгээр улиралд энэ даатгалын сангийн тэнцлийг хангаад гарчихна. Тэгэхээр 23 онд бол энэ маань өөрөө 22 онд зарцуулагдаж байсан 300 гаран тэрбум төгрөг бол цэвэр тусламж үйлчилгээ рүүгээ санхүүжих ийм боломж бололцоо байна гэж харж байгаа. Ингээд ирэх дээр ЭМД-ын сан 23 ондоо бол ямар ч гэсэн энэ хэмжээнд бид нар зохицуулалт хийгээд энэ төсвийн хязгаартай ажиллахад бол боломжтой гэж үзэж байгаа. Мэдээж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бол хязгааргүй, түрүүн бас Жавхлан сайд хэллээ.

Бид нар энэ гүйцэтгэлийн санхүүжилтээр нэг хийсэн томоохон ажил бол энэ төр, хувийн хэвшил адилхан даатгалын сангаас санхүүжилт авч сонгон шалгаруулалтад ордог болсон байгаа. Тийм учраас мэдээж энэ хэрэгцээ шаардлагыг бол бид нар 100 хувь болгон хангаж дийлэхгүй, тэгэхдээ зарим юман дээр зохицуулалт хийж явна. Мэдээж нэхэмжлэлийн хяналтуудыг маш сайн хийнэ, ингэсний хүчинд бол бид нар 23 ондоо энэ даатгалын сангийнхаа энэ хязгаарт бол баригдаж зарцуулалтаа хийгээд явахад бол боломжтой гэж урьдчилсан байдлаар дүгнэлтээ гаргачихсан байгаа.

Г.Занданишатар: Идэрбат гишүүн асууя, 1 минут.

Ц.Идэрбат: Би энэ ХАА-н салбар дээр ямар ч хариулт авч чадсангүй ээ. Үнэхээр энэ Хэнтий аймгийн 10 гаруй мянган малчин, Монгол Улсын 250000 малчин өрх үүнийг хараад байж байгаа байх. Тэгээд би Их Хурлын гишүүнээр сонгогдоод 1 жилийн хугацаа өнгөрлөө. Ингээд нэг асуугаад хагас дутуу, ингээд нэг хариулт аваад л ингээд хариулах ч хүнгүй болчихсон ийм байдалтай байгаад туйлын харамсалтай байна. Тийм учраас Монгол УИХ-ын тухай, Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль гэж гарсан, энэ мөрдөгдөж эхэлж байгаа. Үүнийхээ дагуу энэ хуульд заагдсан эрхийнхээ дагуу энэ ХАА-н салбарын энэ экспортын энэ түүхий эдийн энэ малын өвчин, хуучин үүнтэй холбоотойгоор Хяналт шалгалтын Хяналтын түр хороо байгуулах ийм бичгийг Их Хурлын даргад бас ирэх 7 хоногоос өргөн барья. Энэ хууль дээр УИХ-ын 19 буюу түүнээс дээш гишүүд дэмжиж гарын үсэг зурсан тохиолдолд түр хороо байгуулагдах ийм хуулийн зохицуулалттай, тийм учраас ... /минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Төсөв батлах гэж гурилдаж байна даа. 76-гаа аргалаад л, тэгээд л нэг эрх баригчид нэг ингээд л аргалдаг л болж. Яг бид өөрсдөө 76 бид тойрогтоо очоод ард иргэдэд яаж юу хэлэх бол оо. Ажилгүйдэл, ядуурал, энэ орлогогүй үнийн хөөргөдөл, энэ орлогогүй байдлыг бид аргалж чадахгүй шүү дээ. Оюун-Эрдэнээр ахлуулсан энэ эрх баригчид сүүлийн 6 жил 60,2 их наяд төгрөгийг зарцуулж эрхээ авлаа, төсөвт зарцуулсан. Энэ жил 20,5 их наяд төгрөг орж ирж байна. Сүүлийн 2 жил 24 их наяд төгрөг орж ирлээ. Энэ мөнгийг зүгээр нэг, 76 хүнийг нэг хуурч батлаад, тэгээд нэг баясаад зарцуулаад явдаг юм биш, ард иргэдэд сонгогчдод яг Монгол айлд яаж ажил болгох вэ, орлого болгох вэ гэж л оруулах гэж бид өнөөдөр энд сууж байгаа. Үр дүн нь та нарын эрх баригчид аа, Та нарын үр дүн инфляц 16,2 хувьд хүрчихлээ. Монголбанкны мөнгөний бодлого дээр байгаа

шүү, төгрөг 3500-аас даваад явчихлаа, доллартой харьцуулбал. Зарим бараа бүтээгдэхүүний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ 40 хувиас хэтрээд явчихлаа, нэг хүнд ногдох өр 30 сая төгрөг гараад явчихлаа, 3 хүүхэдтэй 5 ам бүл 150 сая төгрөгийн өртэй гэсэн үг. Амьдарч байгаа байр, хааша байшин болгон гадаадын барьцаанд байна гэсэн санаа. Ийм байдлыг бид бий болгосон. Өнгөрсөн 6 жилийн энэ балай найр хийснээс болж. Тэгээд энэ дээр хариуцлагатай байя, хариуцлагатай байя, хэнтэй ч хуваалцахгүйгээр энэ эрх баригчид МАН үүнийг хариуцна.

Тэгэхээр миний асуулт. Энэ 20,5 их наяд төгрөгийг та нар хүмүүсээс цуглуулж авсан, хүмүүсээс авсан. Хүмүүсийн мөнгө, та нарын энэ баян баян сайд нарын гэрээсээ авчирсан мөнгө биш, энэ хүмүүсийн мөнгийг хүмүүстэй нь зөвлөлдөж хэлэлцэж, хүмүүст яаж зарцуулах тухай хэлэлцээр хийсэн үү? Баялаг бүтээгчдийн төлөөллийн байгууллагуудтай та нар хэлэлцээрт орох ёстой, 3 үүрэгтэй. Тэд нар зөвшөөрсөн үү, өө болж байна гэсэн үү. Үйлдвэрчний эвлэл болон тэр хөдөлмөр хийж байгаа хүмүүсийн төлөөллийн байгууллагатай зөвшилцсөн үү? Энэ хуулиараа зөвшилцөх ёстой. Та нар төрийн үйлчилгээний төрийн албаны энэ цалингийн нэмэгдлүүдээ яг тэр сургуулийн тогооч, багш, цэцэрлэгийн багш нар маш бага цалинтай, суманд ажиллах хүнгүй болсон шүү, тэд нартай зөвшилцөөд за, зуу болж орж ирсэн үү? Нэгдүгээр асуулт.

2 дугаар асуулт. Өнөөдөр цалин нэмэх тухай би одоо ярих гээгүй. Та нарын буруутайгаас болж юмны үнэ хөөргөдөөд, төгрөгийн худалдан авах чадвараа алдсанаас болж тэтгэврийн хүний карманд байгаа тэтгэврийн мөнгө 40 хувь нь хулгайлагдчихлаа. Тэдний буруутай биш, буруугүй ямар ч буруугүй, бага орлоготой 500000 төгрөг, 515000 төгрөг энэ багийн нийгмийн ажилтан, байгаль хамгаалагч 548000 төгрөг, энэ бүгд жагсаалт нь байна. Энэ хүмүүсийн цалингийн 30-40 хувь нь кармандаа та нарын буруугаас болоод алга болчихлоо. Цалин нэмэгдсэнгүй. Жилийн өмнөх энэ 515000 төгрөг бол жилийн өмнөх 300000 төгрөгтэйгөө адилхан болчихлоо. Зөрүү 200000 төгрөгийг нь хэзээ өгөх вэ, яаж өгөх вэ? Үг нь социализмын үед энэ байсан шүү дээ. Өргөн хэрэглээний барааны сагсны аргачлалаар үүнийг заавал англи нэрээр нь хэлүүлэх гээд, энэ байна уу? Та нарт, 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт. Өнөөдөр төрийн өмчийн компаниуд мафжсан. Энэ улс төрийн бүлэглэлүүдийн санхүүгийн дэмждэг ийм бүлэглэл болчихсон. Төсвөөс том төсөв тэнд эргэлдэж байгаа. Тэд нарыг төсөвт ингэж оруулж ирж хянах нөгөө хууль орж ирнэ гэж яриад байгаа шүү дээ. ... /минут дуусав/

Г.Занданишатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Бид ирэх оныхоо төсвийг өргөн барихдаа бүх яг хуулийн хүрээнд ажилласан байгаа, хэлэлцүүлэг хийх ийм зохицуулалт ч байдаг. Үйлдвэрчний эвлэлд бид бүх шат шатанд нь танилцуулсан байгаа. Эндээс Сангийн яамны манай төсөв боож байгаа Төсвийн бодлогын газрынхан бусад харьяа байгууллагууд оролцоод хэлэлцүүлэг хийгээд тэндээс санал авсан байдаг юм. Жил бүр бид нар ингэдэг, ингэж явдаг. Сэтгүүлч нарт сэтгүүлч нараар дамжуулж, мөн олон нийтэд мэдээлэл хүргэх, санал авах ийм ажлуудыг ч хийсэн байгаа. Бид төсвийн ерөнхийлөн захирагч нар, төсвийн шууд захирагч нар нийтдээ бид 300 гаруй ийм төсөв рүү шууд оролцдог захирагч нар байдаг. Эдгээрээрээ дамжуулаад мөн шат шатны төсвийн бүрдүүлэлт, төсвийн орлого, төсвийн зарлага, төсвийн хөрөнгө оруулалт, бүх төрлүүд, эдийн засгийн ангиллууд дээрээ саналуудаа авч ингэж төсвөө боодог юм байгаа юм.

11 сарын 15-нд төсөв батлагдмагц, дараа жилийнхээ төсвийн бэлтгэл ажлыг хангаж ингэж ажилладаг. Тийм учраас энэ бүх шат шатны бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ингэж төсвөө өргөн барьж байгаа.

Инфляцын хувьд Ганбаатар гишүүн ээ, энэ удаагийн инфляц бол жирийн инфляц биш шүү, энэ Монгол Улсын ганц инфляц биш, энэ дэлхий нийтийн ийм, глобал ийм асуудал болчихоод байгаа. Манайх зорилтот төвшинөөс 2 дахин илүү инфляцтай явж байна. Томоохон эдийн засгууд, тухайлбал АНУ, Их Британи, Европын бүс гээд зорилтот төвшинөөсөө 4, 5 дахин илүү ийм инфляцтай явж байна. Манай улс харамсалтай л юм, гэхдээ үнэн гэвэл бид хэрэглээнийхээ 60, 70 хувийг нь гаднаас худалдаж авчирдаг. Өөрөөр хэлбэл гадна талд 4, 5 дахин илүү ийм инфляцтай явж байгаа тэр бүтээгдэхүүнүүдийг бид худалдаж авчраад хэрэглээд байгаа юм, хэрэглээд байгаа юм. Төлбөрийн тэнцлийн шок гээд байгаа асуудал маань өөрөө энэ юм байгаа юм.

Харин бид энэ удаа оруулж ирж байгаа төсөв маань энэ бүх байдлыг ирэх жил тогтворжуулъя гэж байгаа юм, тогтворжуулъя гэж байгаа юм. Төсвөө хумья гэж байгаа, төсвийнхөө зардлыг таная гэж байгаа, шинэ хөрөнгө оруулалтаа зогсооё гэж байгаа юм, тэнцлийнхээ алдагдлыг эрс бууруулъя гэж байгаа юм, халамж тэтгэврүүдийг илүү зорилтот бүлэг рүү нь илүү чиглүүлж, өндөр орлоготой хэсгүүд дээрээ шаталсан татвараа төлье, мөн хүүхдийн мөнгө болон бусад тэтгэвэр энэ тэтгэмжээс бас ингэж татгалзаж эхэлье гээд байгаа нөөцийнхөө энэ зөв хуваарилалтыг оновчтой хэлбэр лүү явуулъя гэдэг ийм төсвийн шинэчлэлүүдийг бид санал болгож оруулж ирж байгаа. Олон жил явж

ирсэн энэ төсвийн тэнцвэрт байдал алдагдсан энэ зүйлүүдийг бид нар 1 жилийн дотор 2 жилийн дотор бид засаж амжихгүй ээ. Дунд, урт хугацаанд энэ үр дүнгээ өгнө, хэцүү боловч хүнд боловч энэ шийдвэрүүдийг бид төсвийн ирэх оныхоо төсөвтөө тусгаж ингэж оруулж ирж байгаа. Үүнийг Ганбаатар гишүүн бол өөрөө эдийн засагч хүн олж харж байгаа байх гэж би ингэж найдаж байна.

Инфляцын хувьд болбол яах аргагүй төрийн мөнгөний бодлого, төсвийн бодлогын уялдаж, бие биедээ бодлогын шийдлүүд дээр дэмжлэг болж ингэж явахаас өөр бодлогын сонголт байхгүй ийм он жилүүд юм байгаа юм. Тийм учраас төсөв ийм хумьсан бодлого оруулж ирж Их Хуралдаа бид танилцуулж байна.

Төрийн өмчийн үйлдвэрийн газар дээр бол би тантай 100 хувь санал нийлж байна. Энэ төсвөөс гадуур төсвөөсөө бараг 2 дахин илүү гэж хэлж болохоор том эдийн засаг тэнд явж байгаа. Манайх Оюутолгойгоо оруулаад ... /минут дуусав/

Г.Занданишатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууна.

С.Ганбаатар: Үнэн. Үүссэн энэ нөхцөл байдлыг ганцхан Сангийн яам энэ төсөв дээр би тохоогүй. Нөхцөл байдал ийм байна. Бас ганцхан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамыг туг дахиад, энэ уурссан ард түмнээ нэг аргалаад өнгөрнө гэж бас байхгүй шүү. Хамгийн гол нь бид гарц гаргалгаа хэрэгтэй байна. Түрүүний яриад байгаа ЗГ, Ерөнхий сайдын түвшинд баялаг бүтээгч нар, бизнес эрхлэгч нартайгаа уулзаж яаж гадаад зах зээлд хамтдаа гарах вэ? Яаж бид гаднаас валют оруулж ирдэг тогтолцоо руу орох уу? Ганцхан уул уурхай, ганцхан ОТ-г хараад бухын доодохыг хараад үнэг турж үхэх болчихоод байна аа. Энэ зүгээр нэг тэр нийгмийн түншилэгч байгууллагуудаас зүгээр нэг саналыг нь аваад нэг дүр эсгээд салах биш ээ, өнөөдөр муу эзэнд учирсан албат иргэд сайн эзний нохой шувуунд үл хүрнэ ээ гээд алтан товч дээр бичсэн байна. Түүн шиг манай Ерөнхий сайд, Солонгосын Ерөнхий сайдаас 10 дахин муу байна аа. Манай залуучууд Солонгос руу мөрөөдөж явах гээд байна. Үүнээс болж л бид энэ гадаад зах зээлээ эдийн засагжуулах ... /минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: 2, 3 зүйл тодруулъя. Яах вэ, 23 оны төсөв бас сайжруулсан юм байна л даа, бас төсвийн алдагдлыг 900 тэрбум төгрөгөөр бууруулж байгаа юм байна, шинэ хөрөнгө оруулалт 23 онд байхгүй гэж байгаа юм байна. Энэ нь бол сайн хэрэг. Гэхдээ бас өндөр төсөв байна л даа. 20,4 их наядын төсвийг бид

хэлэлцэж байна. Урсгал зардал 2,5 тэрбум 2,5 их наядаар нэмэгдэж байгаа юм байна.

Шинэ хөрөнгө оруулалт төсвийн хөрөнгөөр хийхгүй явуулахгүй гэж байгаа боловч өмнөх онуудад эхэлсэн хөрөнгө оруулалтынхаа ажлыг дуусгана гэхээр чинь шинэ хөрөнгө оруулалтаасаа давсан хэмжээний 27 их наядын хөрөнгө оруулалтын асуудал 23 онд чинь бас л байж л байна л даа. Тэгээд ингээд ийм их тэлсэн төсөв тэгээд дээр нь 2,7 их наядын хөрөнгө оруулалт хийнэ гэхээр чинь нөгөө мөнгөнийхөө бодлоготой уялдах уу. Бид чинь мөнгөний бодлогын чинь бодлогын хүүгээ 12 болгосон, цаашидаа ч нэмэх хэрэгтэй, бүсээ чангалахаас өөр арга алга гээд Монголбанкийг баахан л шахсан, мөнгөний бодлого дээр.

Нөгөө талдаа төсөв дээр ингээд хэт бас тэлсэн төсөв ороод ирэхээр энэ нөгөө мөнгөний бодлоготой уялдах нь инфляц чинь буурах юм уу, Сангийн сайд аа. Нөгөө валютын гадагшлах урсгал чинь саарах юм уу, валютын нөөц чинь нэмэгдэх юм уу.

36,5 сая тонн нүүрс экспортолно гэж л байна. Энэ хил, гааль ийм боломж байна уу, олон улсын нөхцөл байдал, ковидын нөхцөл байдлаа яаж тооцож байгаа юм. Өнгөрсөн 22 оны төсөв батлахдаа энэ 36 сая тонн нүүрс гэж оруулж ирээд тэгээд дараахан төсвийн тодотголоор 18 болгож бууруулж байсан. УУЯ-наас авч байгаа мэдээллээр болбол 19 сая тонн нүүрс л гарсан байна гэсэн мэдээ байна. Тэгэхээр 23 онд бид 36,5-ыг гаргаж чадах уу, үгүй юу гэдэг энэ асуудал байна.

3 дахь асуудал. Нийгмийн даатгалын сангийн орлогыг та бүхэн нэлээн их нэмэгдүүлчихэж ээ, Сангийн сайд. 811 тэрбумаар нэмэгдүүлээд татаасыг нь 375 тэрбумаар бууруулчихаж. Яах вэ, 375-ыг чинь 150 нөгөө буцаан олголт байгаа байх, тэрийг хасах юм бол 200 гаруй тэрбум төгрөгөөр татаасанд буулгачхаж. Гэтэл энэ онд чинь 3Г тэтгэвэр нэмээд сангийн алдааг тэр 600 тэрбумаар нэмэгдүүлчихсэн шүү дээ. Тэгээд ийм нөхцөлд ингээд татаасыг орлогыг 811 тэрбумаар нэмэгдүүлээд, татаасыг нь 300 гаруй тэрбум төгрөгөөр бууруулахаар чинь энэ боломж байгаа юм уу. Сүүлийн хагас жилдээ бид тэтгэврээ хугацаанд нь тавьж чадахгүй болчих вий дээ гэсэн ийм болгоомжлол байх юм.

Хүүхдийн мөнгөтэй холбоотой асуудлыг бид уг нь ер нь төрийн бодлого тогтвортой баймаар байгаа юм. Өнгөрсөн жил бид 22 оны төсөв баталж, хүүхдийн мөнгө бол халамжийн мөнгө биш ээ, хүүхдийн ирээдүйд хийж байгаа хуримтлал, хөрөнгө оруулалт гээд л халамжийн сангаас гаргаад л Ирээдүйн өв сангийн хуульд өөрчлөлт оруулаад л тийш нь оруулаад л, тэгээд

л нэг хэсгийг нь сүүлийн хагас жилээс дансанд нь хуримтлал хийсгээж үүсгэнэ гээд л Хуримтлалтай хүүхэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо гээд л баахан ярьсан шүү дээ. Одоо болохоор гэв гэнэтхэн үүнээс ухраад энэ болбол хуримтлал биш юм аа, халамж юм гээд халамжийн хууль руу буцааж оруулаад, ингээд Монгол төрийн бодлого ингээд тогтворгүй байгаад байж боломгүй байх юм. Би болбол энэ бол халамжийн хүүхдийн мөнгө бол халамжийн мөнгө биш юм, хүүхдийн ирээдүйд хийж байгаа хөрөнгө оруулалт, хуримтлал гэдэг ийм байр суурьтай л байдаг. Энэ хүүхдийн ирээдүйд хийж байгаа хөрөнгө оруулалт, хуримтлал гэсэн энэ байр сууриа бас өөрчилж боломгүй байх юм. Үүнийг бас юу гэж үзэж байгаа юм.

Орон нутгийн тэр цалин хөлстэй холбоотой юман дээр нэг эргэлзээ байна, Сангийн сайд. Монгол Улс чинь нэгдмэл улс, орон нутгийн цалинг орон нутгийн удирдлагууд орлогоосоо хамаараад өөрсдөө тогтоо гэдэг юм руу явж болохгүй. Тухайлбал, Өмнөговь, Эрдэнэт, Дорноговь гэсэн аймгууд цалингаа өндөр нэмээд бусад аймгууд нэмж чадахгүй. ... /минут дуусав/

Г.Занданишатар: Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Төсвийн бодлого, мөнгөний бодлого ирэх онд нийцтэй явна. Ингэх ч шаардлага нөхцөл туйлын байна гэж ойлгоорой. Гэхдээ төсвийн бодлого, мөнгөний бодлоготой нийцтэй байхад бас их хязгаар байгаа, хязгаар байгаа. Тэр хязгаар нь юу вэ гэхээр төсвийн өөрийнх нь эрсдэлийн түвшин. Дараа, дараа жилийнхээ бид эрсдэлийн түвшинд тооцоолохгүйгээр хэт их хумих нь өөрөө төсөв дээрээ эрсдэл авчирна. Одоо бид ирэх онд шинэ хөрөнгө оруулалт байхгүй гэж байгаа, өөрөөр хэлбэл тэр орон зайн дээрээ бид хуримтлагдсан шилжиж ирсэн энэ олон хөрөнгө оруулалтуудаа ирэх жил дуусгахгүй болбол энэ үнийн өсөлттэй жилүүд дээр дараа дараагийн эрсдлүүд маань нэмэгдээд энэ хуримтлагдсан маань хэзээ ч дуусахгүй, хэзээ ч дуусахгүй. Хэрвээ мөнгөний бодлоготойгоо илүү нийцтэй явж байна гээд үүнийгээ таначихвал төсөв энэ эрсдэлээс ойрын хэдэн жил өөрөө гаргахгүй. Энэ нь эргээд мөнгөний бодлого битгий хэл макро төвшин нь макро тэнцвэрийг алдагдуулах дараагийн эрсдэлийг бий болгоно оо. Тийм учраас чадах хэмжээнд урсгал зардлаа ч тэр хөрөнгийн зардлаа танасан ийм бодлого хязгаар маань энэ юм.

Тэгээд та экспорт ярьсан. Экспорт дээр ирэх онд 36,5 сая тонн нүүрс гаргана, гаргана. Энэ удаагийн энэ жилийн 5 сард хийсэн тодотголоор бид жилийн эцэс гэхэд 18 сая тонн нүүрс гаргахаар боллоо гэж тодотгол хийсэн. Тэгвэл тэндээс хойш нөхцөл байдал сайжирсан

шүү, сайжирсан. Таны авсан тэр мэдээлэл 19 сая тонн гэдэг маань 8 сарын мэдээ юм. Өөрөөр хэлбэл бид жилийн эцэст 18 хүргэж байсан бол аль 8 сард 19 сая буюу жилийн эцсийнхээсээ 1 сая тонноор давчихсан явж байгаа юм. Энэ хурдаараа бол энэ жилдээ жилийн эцэс рүү нэг 23 сая тонн нүүрс гаргах ийм бүрэн боломжтой болж ирсэн. Яг энэ хурдаараа экспортоор тооцох юм болбол бид хойтон бараг 50 сая тонн нүүрс гарах ийм хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадамж, боломж бий болсон. Гэхдээ ямар ч байсан эрсдэл болзошгүй энэ бүх байдлыг тооцож 19 оны түвшинд буюу 36,5 сая тонн дээр бид тооцоолж орж ирсэн байгаа юм шүү.

Нийгмийн даатгалын сан дээр та санаа зовох зүйлгүй ээ. Ер нь нийгмийн даатгалын сангийн орлогыг тооцдог суурь цалингийн бааз ХХОАТ, ААНОАТ тооцдог цалингийн суурь бааз 2 их зөрүүтэй явж ирсэн. Таны үед ч бас ингэж ирсэн. Тэр хандлага хэвээрээ яваад байгаа юм. Би танд хэдхэн тоо хэлье. 21онд 2,3 их наядаар орлогоо төлөвлөөд гүйцэтгэл нь 2,7 их наяд буюу 13 хувиар давж гарч байсан. Тэгвэл энэ 2,7-оос багаар энэ онд төлөвлөсөн байдаг 2022онд 2,3 их наяд гэж. Гэтэл одоо явж байгаа гүйцэтгэлийн явцыг харахад жилийн эцэс рүү 2,8 их наяд гарахаар байгаа. Тэгэхээр ирэх оны шимтгэлийн орлогыг 3,1 их наядаар тооцсон нь энэ жилийн бодит гүйцэтгэлээс хүлээгдэж байгаа бодит гүйцэтгэлээс 9 хувиар л давна, 9 хувиар л давна. Тэгэхээр энэ болбол бодит орж болох орлого гэж ингэж харж байгаа. Тийм учраас нийгмийн даатгалын сангийн орлого зардал ямар нэгэн эрсдэл гарахгүй ээ гэж харж байгаа юм.

Татаасны хувьд болбол бид төрөөс өгөх ёстой НДШ орлогоо 560 тэрбум төгрөгөөр өгдөг ёстой, энэ ном журмаар нь татаасаа тавьсан байгаа. Тийм учраас нийгмийн даатгалын сангууд хийж байгаа татаас бага байна, тэтгэврээ тавьж чадахгүй шүү гэж ийм байдлаар тулгаж татаасаа нэмдэг ийм хандлагыг бол бид өөрчлөх хэрэгтэй. Нийгмийн даатгалынхаа шимтгэлийн орлогыг бодитойгоор төсөвлөж, бодитойгоор бааз сууриа тооцдог энэ бас л төсвийн шинэчлэлийн хүрээнд ... /минут дуусав/

Г.Занданиатар: Жамбалын Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Сангийн сайд бас хэллээ. Чинзориг гишүүний асуултад гүйцээгээд хариулъя. Уул уурхайн салбар бол нүүрсийг бол тэр 36-аас 2 даблдаж гаргах бол хүчин чадал, боломж байгаа. Хамгийн гол нь та маш сайн мэдэж байгаа, боомтын асуудал байна, тээвэр ложистикийн асуудал бол байна. Үүнийг хариуцаж байгаа хүмүүс, тэр урд хөрштэйгөө ч гэсэн бид нар асуудлаа ярих, энэ талаар хурдлах, үүнийг сайжруулах асуудал байгаа. Түүнээс биш уул уурхайн салбарт бол хүчин чадал, хүн нөөц,

техник технологи, бүх зүйл бол ерөнхийдөө байна. Тэгэхээр боомтынхоо асуудлыг сайжруулах хэрэгтэй байна, ЗГ бид нар. Тээвэр ложистикийнхоо асуудлыг шийдэх хэрэгтэй байна, урд хөрштэйгөө урьдчилж тохирох зайлиггүй шаардлага бол байна. Энэ ажлаа сайжруулах л шаардлагатай. Түүнээс биш үүнийг гаргаж чадах уу гэдэг асуултад бол манай салбар хангалттай чадна гэж хариулъя. Баярлалаа.

Г.Занданиатар: Содномын Чинзориг гишүүн тодруулъя.

С.Чинзориг: Нийгмийн даатгалын сангийн орлого, татаастай холбоотой асуудлыг ажлын хэсгийн хэсэгтээ нэлээн ярих байх. Тэгэхгүй бол ингээд огцом орлогыг нь нэмээд татаасыг нь огцом бууруулж болохгүй шүү дээ Энэ жил гэхэд л та 600 тэрбумаар сангийн алдагдлыг нь нэмэгдүүлээд, тэтгэвэр нэмчхээд ядаж тэрнийхээ нэмэгдлийг өгөхгүй ингээд 540-хөн тэрбум төгрөг өгөөд ингээд байгаад байж болохгүй болж байна шүү дээ. Харин тэгээд өнгөрсөн жил энэ жил бид нар 2 удаа төсвийн тодотгол хийсэн. Он гарав уу үгүй юу дахиад байдал хүндэрчихлээ гээд төсвийн тодотгол хийгээд ороод ирэх юм биш биз дээ? Тэр цагт чинь харин ёстой төсвийн тодотгол хийхгүй гээд суучихна шүү, Сангийн сайд аа.

Орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой эмийг болбол цаашид анхаарна биз дээ, орон нутгийн нэмэгдэл болбол ялгавартай байж болно, баруун аймагт ч гэдэг юм уу, говийн аймгуудад болбол ялгавартай байж болно, нэмэгдэл нь. Үндсэн цалин нь ялгавартай байж болохгүй шүү, Сангийн сайд аа, Өмнөговь аймаг, Дорноговь аймгууд бол чадна, тэгээд наадах чинь аймгууд хоорондоо ... /минут дуусав/

Г.Занданиатар: Үг хэллээ дээ. Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Би эрүүл мэндийн салбартай холбоотой, соёлын салбартай холбоотой асуудал тавья гэж бодож байна. Эрүүл мэндийн салбарын төсвийг нэмэхгүй бол болохгүй нь ээ, эмч нарын байдал нэлээн хүнд байгаа даа. Цалингийн гүйцэтгэлээр санхүүжээд нэмэгдсэн гэдэг нь ерөнхий ойлголт болохоос биш цалингийн сүлжээг нь 2 дахин нэмж байж дараа нь гүйцэтгэлээр санхүүжихэд урамшуулал авдаг болохоос биш одоо цалин хүрэхгүй байна, эмч, сувилагч нарын. Өчигдөр гэхэд би энэ 2 дугаар эмнэлэг дээр очсон гучаад сувилагч ажлаас гараад явчихсан байна шүү дээ, цалингаа голоод. Ихэнх нь нөгөө хүүхдээ сургаж байна, цалингийн зээлтэй, хүрэлцээ муутай байна. Тийм учраас энэ цалинг нь нэмэх боломж байна уу, Сангийн сайд аа, Эрүүл мэнд сайд аа.

Эрүүл мэндийн сайд та эрүүл мэндийн төсөв хангалттай гэж ерөөсөө ярьж болохгүй, хүрэлцээ муу байна, одоо эмнэлэг бүхэн дээр квот тавьж эхэлж байна шүү дээ. Зарим эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ өндөр, өртөг ихтэй болохоор чинь квот тавиад тогтоочихсон. Очер дараалал ихэссэн. Хөдөө сумуудын гүйцэтгэлээр санхүүжихэд оношилгооны тоног төхөөрөмж байхгүй, сая сумуудаар явсан, зарим сумд ерөөсөө оношилгооны тоног төхөөрөмж байхгүй. Цус, шээс, биохими, ЭКГ, экогийн аппарат заавал байх ёстой. Тэгж байж аймгийн нэгдсэн эмнэлгийн ачаалал ба төвийн эмнэлгүүдийн ачаалал буурдаг болохоос биш бүгд оношилгооны юм байхгүй юм чинь аймаг руу явж байна шүү дээ. Энэ дээр 1 онцгой анхаараад юуг нь нэмэх боломж байна уу, ер нь, хөрөнгө оруулалт оруулах боломж байна уу гэдгийг асууя.

Хоёрдугаарт, эмийн үнийн асуудал байна. Үүнийг бууруулахгүй бол ерөөсөө үйлдвэрлэгчээс хэрэглэгчид хүрэхэд ер нь тээврийн даатгал гээд 5-8 хувь, гаалийн Нөат гээд 15,5 хувь, ханган нийлүүлэх байгууллага гээд 15-45 хувь, үүний борлуулалтын Нөат гэхэд 10 хувь байгаа дахиад. Эмийн сангийн нэмэгдэл 25-35 хувь, эмийн борлуулалтын Нөат гээд 10 хувь байгаа, 3 Нөат төлж байгаа байхгүй юу. Тэгээд хэрэглэгчид нь ийм өндөр үнээр хүрч байгаа.

ДЭМБ-ын жишгээр Монголын эм бол 5-6 дахин өндөр үнэтэй хэрэглэгчид авч байгаа. Энэ дээр анхаарахгүй бол ерөөсөө болохгүй нь ээ. Үүнийг бууруулах ямар арга байна? Энэ Сангийн сайд, энэ Нөат-үүдийн давхар дараалсан эмийн 3 Нөат байна шүү дээ. Үүнийг хасах чөлөөлөх боломж байдаггүй юм уу?

Дараагийн асуудал энэ эмийн үнэ зарим 60-238 хувь нэмэгдсэн байна, үүнийг бас анхаарахгүй бол үнэхээр зарим эм импортоос орж ирж байгаа юм дээр чинь авч чадахгүй байна. Долларын төслийн эмийг Аз фарм, Монос, Монгол импекс 3-аас л авдаг. Гэтэл үүний хөдөө сум дээр аптекууд нь байхгүй, заавал аймгийн төвд орж ирэх ийм юм байж байна л даа. Энэ дээр анх харахгүй бол болохгүй байна, үүнийг бууруулах ямар арга байна?

Соёлын сайдаас асуух. Соёлын төв төвд 3 сум дээр Баян-Өлгийн Дэлүүн, Буга, Улаан хус сум дээр Соёлын төв баригдсан. Дотор ерөөсөө ямар ч тоног төхөөрөмж, тавилга нь байхгүй, энэ дээр анхаарахгүй бол болохгүй байна. Энэ бид нарт өгсөн зузаан ном дээр чинь Соёлын сайдын хөрөнгө оруулалт гэхэд нар 136 тэрбум 790 сая байна л даа. Энэ чинь нөгөө барилгын төсөв нийлээд тийм байна уу, үгүй юу? Нөгөө талаар дээд талд нь Соёлын сайдын шууд гэдэг дээр чинь 18 тэрбум байх юм. Тэр энэ юуны төсөв в. Үүнийг нэмэх боломж байна уу, одоо.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Бейсен гишүүн ээ, хэдүүлээ энэ эрүүл мэндийн салбарын төсвийн шинэчлэлийг маш их ярьсан даа, та ухрах юм яриада байх юм. Бид тухайн эмнэлгийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг ийм томоохон төсвийн шинэчлэл рүү реформ руу орсон. Одоо эргэж буцах зүйл байхгүй. Гүйцэтгэлээр нь өртгөөр нь тарифаар нь ЭМДҮЗ-ээс гаргасан жагсаалт бүрээр ингэж санхүүжүүлээд явдаг байгаа. Харин эмнэлэгт очсон нийт санхүүжилтийг хийсэн гүйцэтгэлээр нь эмч, сувилагч ямар тусламж үйлчилгээг ямар хэмжээнд үзүүлсэн гэдгээр нь олгоод ингээд явна, хийснээрээ авна гэсэн үг. Түүнээс биш эмч, эмнэлгийн ажилтан, сувилагч бүрээр нь тооцдог хуучин систем рүүгээ бид ухарч орохгүй ээ. Энэ шинэчлэл маань маш сайн үр дүнгээ өгч байгаа. Гажуудал байгаа, гэхдээ энэ бүгдийг цааш нь засаад янзлаад явах ийм шийдлүүд дээр л ажиллах хэрэгтэй юм байгаа юм.

Тэр Нөат дээр та арай л буруу тайлбарлаад байх шиг байна. Тэр давхардсан Нөат гэж байдаггүй юм. Нөат чинь өөрөө ийм шилждэг татвар, эцсийн дүндээ хэрэглэгч төлдөг л ийм л систем. Гааль дээр орж ирээд Нөат төлнө, дараа нь үйлдвэрлэгч дээр очоод шингээд явна, бүтээгдэхүүнээ өртөө шингээд явна, ингээд эцсийн хэрэглэгч дээр очдог тийм юм байгаа юм. Энэ бүгд бараа бүтээгдэхүүн дээр ижил гэдэг юм байгаа юм. Түүнээс биш эм дээр 3 Нөат давхардаад төлөгддөг ийм ямар ч ойлголт, зарчим байхгүй ээ.

Тэр соёлын төвүүдийг Номин сайд хариулчих уу. Танд мэдээлэл байна уу. Байхгүй бол манайхан эндээс хариулж болно шүү.

Бусад тэр эм, эмийн хүртээмж, хүргэлттэй холбоотой асуудал дээр Энхболд сайд хариулчих байх.

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн. Бейсен гишүүн тодруулъя 1 минут, товч тодорхой.

Б.Бейсен: Жавхаа сайд аа, Би энэ буруу мэдээлэл өгөөгүй, өчигдөр бид нар эм, эмнэлгийн хэрэгслийн газартай бас хэлэлцээ хийсэн, тэгэхэд энэ эм, эмнэлгийн хэрэгслийн агентлаг нь гаргаж өгсөн юм шүү, энэ дараалсан 3 Нөат ын юутай ингэж хүрч байна, эмийн үнэ гээд тэд нарын гаргаж өгснийг би ярьж байна. Тийм учраас үүнийг бас анхааралдаа авч үзэхгүй бол болохгүй нь ээ.

Нөгөө талаар бодит байдал дээрээ энэ эмч нарын цалин үнэхээр хүрэлцэхгүй байна. Тэгээд ажлаас гарч байна. Яг эмнэлгүүдээр яваад үз л дээ. Одоо энэ юмны өргөн хэрэглээний

барааны үнийн өсөлт, бензин шатахууны өсөлтийг нь даахгүй байна шүү дээ, хүрэхгүй байна. Харин эмнэлгүүд хэл дээр нь босохын тулд тэр гүйцэтгэлээр санхүүжээд тоног төхөөрөмж авахад тэр сүлжээг нь эмч нарын цалингийн сүлжээг нэг дахин нэмж байж дараа нь гүйцэтгэлээр санхүүжиж, эмнэлгүүд чинь босож ирэх боломж байгаа, тэрийг би мэдэж байна. Эмнэлэг ажиллаж байгааг нь сайн мэдэж байна, үүнийг. Энэ дээр бас анхаарах боломж бий ... /минут дуусав/

Г.Занданиатар: Үг хэллээ.
Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ жилийн төсөвтэй танилцсан, нэлээн уншиж дуусгаж үзлээ. Тэгээд анх удаагаа 20 их наяд давсан ийм төсөв орж ирж байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаа энэ үед тэгээд тодруулж тодорхой хэдэн асуултыг асууя.

Энэ төрийн захиргааны албан хаагчдын ер нь тэгээд цалин, энэ хавар бол би нэлээн олон удаа ярьсан, тэгээд энэ 23 оны төсөв дээр нэмнэ ээ гэсэн, нэмсэн байдлыг аваад нэмэх гэж байгаа төсөөллийг аваад үзсэн. Төрийн захиргааны албан хаагчид бол орон нутгийн нэмэгдэл авдаггүй байсан, үүнийг 20 хувиар нэмэгдүүлж улсын төсөв дээр сөхөхөөр ингэж орж ирж байгаа юм байна гэж ойлгосон. Орон нутгийн төсөв рүү төсөв дээрээс орлого бүрдүүлэх юм бол 80 хувиар нэмэгдүүлээд, ингээд нийлээд нэг дахин нэмэгдүүлэх боломжтой гээд үүнийг би ойлгохгүй байгаа, үүнийг тайлбарлаж өгнө үү, нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, энэ ТҮ-ийн ажилчдын төрийн үйлчилгээний ажилчдын цалин нэмэгдэх үү? Хоёрдугаарт нь, энэ эрүүл мэндийн салбарын төсөв яамнаас бол 1,5 их наядар төсөвлөж Сангийн яам руу хянуулсан юм байна лээ, батлагдсан орж ирчихсэн бол 1,4. Өнгөрсөн оныхтой ер нь бараг ялгаагүй шахуу 30 тэрбум төгрөгөөр л нэмэгдэж орж ирсэн. Инфляц үнийн өсөлт байгаа энэ үед энэ мөнгө хүрэхгүй гээд олон хүн яриад байгаа, энэ ортой, тэгэхээр энэ дээр ямар бодлогоор ингэж оруулж ирсэн юм бэ гэдэг асуулт.

Сангийн яамнаас энэ 1 иргэнээр тооцох санхүүжилтийг 2 дахин нэмсэн шийдвэрийг Байнгын хорооноос шийдвэр гаргаад засаг руу оруулаад үүнийг нэмсэн. Эхний 3, 4 сарыг нь төрийн байгууллагуудын уялдаа хангамжгүй байдлаас болоод алдчихсан, үүнээс хойш нэмчихсэн явж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Ирэх онд энэ байдлаараа явна биз дээ, ядаж. Үүнийг нэг батлаад нэг хариулаад өгөөрэй.

Ямар сайдууд нь суугаад ямрууд нь суудаггүй юм бэ. Би энэ дээр бас гайхаж байна.

Тааллаараа гэдэг шиг бас энэ ХАА-н салбар энэ чухал, бид нар ямар ч байсан хүнстэй хоолтойгоо байх асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр төсвийг нь ингээд харахаар дүнгээрээ маш их нэмэгдчихсэн харагдаж байгаа юм. Задлаад харахаар энэ хүнсний хангамж, аюулгүй байдал, Ерөнхийлөгчийн санаачилгатай энэ юм зүйл дээр 228 тэрбум төгрөг, үүний яг задаргааг нь нэг хэлээд өгөөч. Юунд энэ 228 төгрөг гарах гээд байгаа юм.

Буцаагаад ХАА-гаа дэмжинэ ээ гэж хэлчээд нэг зүйл харагдаж байгаа нь энэ 66-аар яваад байсан урамшуулал хасагдчихсан байна. 44 рүү ороод ирчхэж, энэ ямар бодлого юм бэ, ХАА-гаа дэмжинэ гэж нэг амаараа хэлчээд нөгөө амаараа яагаад энэ урамшууллын бодлого ХАА-д хамгийн гол амин чухал энэ бодлогыг ингээд бууруулж тооцсон бэ? Энэ дээр нэг хариулт авъя.

Эрүүл мэндээ дэмжиж, эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөр татаац одоо энэ хэрэгжих жил нь явж байгаа байх гэж бодож байна. 3 дахь жил рүүгээ ч юм уу, 2 дахь жил нь ч билүү. Энэ дээр хүүгийн татаац энэ жилийн төсөв дээр хэдэн төгрөг тавигдаж орж ирж байгаа вэ.

Хүүхдийн мөнгө бол АН-ын үед бодлого болж гарч ирсэн, баялгийн тэгш хуваарилалт аа. Ялгавартай олгох нь энэ хүүхдээ ялгаварласан Үндсэн хууль зөрчихгүй юу? Үүнийг Одонтуяа гишүүн их ярьж байгаа, энэ дээр яаж тойрч гарах юм бэ? Энэ дээр хариулт авъя.

Төв аймаг бол төв цэг ээ, бид нар энэ Төв цуудангийн урд талд Монгол Улсын авто замын төв цэг гээд 1 цагдаа зогсдог төв цэг байгаа. Бид нар бүгдээрээ Төв аймаг дотор амьдарч байгаа. Төсөв тавьсан байдлыг хараад үзэхээр бараг сүүлээсээ нэг 4, 5 дээр яваад. Энэ төв цэг рүүгээ бас анхаарсан ийм бодлогыг ядаж авч болохгүй, энэ чинь Улаанбаатарын хүмүүсийн хүнсний хангамж, тэр гол үүрэг гүйцэтгэж байгаа ... /минут дуусав/

Г.Занданиатар: Жавхлан сайд, Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Манай ХАА-н сайд маань гадаадад томилолтоор яваа шүү, Төрийн нарийн нь цуг яваа юм байна лээ. Тэнд нэг хүн байгаа байгаа, тийм. Тэр хүн маань бас чухал хүн байх шиг байгаа юм аа, хариулъя гээд л гараа өргөөд л байгаа юм, тэгээд нэмэх зүйл байвал нэмээрэй, би чадлаараа хариулъя.

Би тэр сүүлийн хэсгээс нь хариулаад эхэлбэ. 10 их наяд үргэлжилж байгаа, Энэ 10 их наядын хөтөлбөр маань 2024 он хүртэл дунд хугацааны хөтөлбөр шүү дээ. 10 их наяд гэхээр бид зөвхөн нөгөө нэг ажлын байрыг дэмжих 3

хувийн зээл гэж ойлгоод байдаг, гэтэл энэ чинь өөрөө 50 гаран жагсаалттай батлагдсан ийм хөтөлбөр байгаа. Ажлын байрыг дэмжих зээлийн хүүгийн татаасны жилүүд үргэлжилнэ. Энэ жил хамгийн өндөр, ачаалалтай жил нь хойтон эргэн төлөлттэйгөө холбогдоод ингээд буураад ирэх юм байгаа юм. Тэгэхээр энэ хүүгийн зөрүү, татааснууд нь явж байгаа. Дээрээс нь репо санхүүжилтийн юмнууд Төв банкаар дамжаад ингээд явж байгаа. Ипотекийн зээлүүд мөн үргэлжлээд ингээд амжилттай явж байгаа. Ер нь бол 10 их наядын энэ хөтөлбөр ажлын байрыг хамгаалах, эдийн засгаа ч, эрүүл мэндээ ч хамгаалах түүхэн үүргээ хамгийн хүнд үед болбол гүйцэтгэсэн гэж үзэж байгаа.

Хүүхдийн мөнгө Үндсэн хууль зөрчихгүй ээ. Энэ Нийгмийн халамжийн тухай хуульд хүүхдийн мөнгө халамж юм гэж ингэж төсөв дагасан хуулиуд дотор орж ирж байгаа. Тэгэхээр Үндсэн хууль болбол зөрчигдөхгүй ээ гэж ингэж үзэж байна.

ХАА-н 228 тэрбум төгрөгийг, би танд бол нэг бүрчлэн хэлье ээ, та нэг бүрчлэн нь сонсох гээд байх шиг байна. Үндэсний үйлдвэрийг хөгжүүлэхэд 175 сая, МАА-н салбарыг хөгжүүлэхэд 4 тэрбум, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ 41 тэрбум, газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд 40 тэрбум, жижиж дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хориоог хөгжүүлэхэд 2 тэрбум, ХАА, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ 2,1 тэрбум, ингээд урсгал зардал дээр нийтдээ 920 тэрбум, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 67 тэрбум, МАА-н салбарыг хөгжүүлэхэд 17,5 тэрбум, газар тариалангийн салбар хөгжүүлэхэд 53,4 тэрбум, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэхэд 110 сая гээд, ингээд ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлт нь нийтдээ 140 тэрбумаар үргэлжилнэ ээ гэсэн үг.

Дээрээс нь татварын бодлогоор бид ХАА-н салбарт боловсруулах шатанд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн гаалийн татварыг 27 хүртэл тэглэж байгаа, энэ болбол нэлээн том дэмжлэг болно. Энэ 138 тэрбум, 90 тэрбум чинь нийлээд 228 тэрбум болж байгаа юм. Энэ нь УИХ-ын батлагдсан Хүнсний аюулгүй байдлын хөтөлбөр. Та өөрөө үүнийг дэмжиж оролцож баталсан энэ хөтөлбөрийн ЗГ дээр бодит хэрэгжилт болж ингэж төсөвт сууж байгаа нь энэ ээ. Бусдыг нь өөр сайд нар.

Г.Занданишатар: 82. Мижиддоржийн Санжаадорж. Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга.

Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр орон нутгийн нэмэгдэл болбол үндсэн цалин болбол

суурь цалин бол ижилхэн байгаа, тухайн хүнийх нь ажил мэргэжил хүлээж байгаа үүрэгтэй холбоотой. Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны ажилчдад бол ирэх 2023 оны төсвийн төсөл дээр бол 20 хувийн нэмэгдэл бол бид тооцож орж ирсэн байгаа. Тэгэхээр суурь зардал дээр нь бид нар хянаад өгчихсөн гэсэн үг. Орон нутгийн. Үүн дээрээсээ нэмээд орон нутаг маань өөрөө аймаг маань бол төсвөө батлах эрхтэй байгаа, аймаг. Тэгэхээр төсвөө батлахдаа болбол хэрвээ орон зай гаргаад орлогоо нэмэгдүүлээд, эдийн засгаа сайжруулаад, бүтээмжээ сайжруулаад орон нутаг маань өөрөө ингээд сайн ажиллах юм болбол тэр нэмэгдлийг өшөө нэмэгдүүлж олгох тэр эрх зүйн орчныг нь бид нар ЗГ-ын тогтоолоор бол бүрдүүлж өгнө өө гэсэн ийм юутай байгаа, төлөвлөгөөтэй байгаа.

Нөгөө эрүүл мэндийн тариф болбол сумдын эмнэлгийн тарифыг бол 2 дахин нэмэгдүүлэх шийдвэр маань бол ирэх онд бол үргэлжилнэ. Түүнтэй холбоотой зардлыг бол тусгасан байгаа.

Г.Занданишатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Төв аймаг төсөв багатай байгаа, зарим аймгууд төсөв их тавьчихсан гээд бас энэ хэдэн өдрүүдэд хэлэлцүүлэг бас болж байна. Яг үнэндээ бол Төв аймаг хамгийн их төсөвт тавигдаж байгаа аймгуудын нэг болчихож байгаа юм. Яагаад гэхээр Хөшгийн хөндийн дэд бүтцийн асуудлыг бүтэн шийдэхээр оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ агуулгаараа яг энэ дэд бүтцийн асуудлын хөрөнгө оруулалт шилжихтэйгээ нийлээд харагдвал бараг энэ жилийн хөрөнгө оруулалтын эхний бараг хэдэн аймгийн нэг нь бол Төв аймаг болох байх. Тэгэхээр бид нар нэг ийм улс төрждөг хандлагаа л болимоор байгаа, яагаад гэхээр Хөшгийн хөндийг хөгжих нь чухал. Тэр Туваан гишүүний тойрог байна уу, өөр гишүүний тойрог байна уу, хэдүүлээ нэг ийм жалганы сэтгэлгээнээсээ гармаар байгаа юм. Хөшгийн хөндий рүү Богд хаан төмөр зам явна, тэнд тээвэр логистикийн төв хийгдэнэ гэдэг агуулгаар нь л хэдүүлээ Монголын Их Хурлын гишүүн гэдэг өнцгөөсөө харж сурмаар байгаа юм.

Зарим аймгуудад яах вэ, зам тавигдчихдаг зам нь 1, 2 жил төсөв нь өндөр л болчихдог, Дорноговь аймгийн төсөв өндөр явж байгаа тэнд, яагаад гэхээр нөгөө бүтээн байгуулалтын 2 ч том төмөр зам явж байх шиг байна. Тэгээд л энэ аймаг, аймгууд дээрээ шилжээд л ингээд явж л таарна. Одоо хэдүүлээ энэ жил энэ 30 жилийн хугацаанд анх удаа тойргоос үндэсний хэмжээний бодлогыг эхэнд нь тавьж байгаа ийм л төсөв орж ирж байгаа юм. Мэдээж зарим аймгууд нь бага байгаа, зарим

аймгууд нь өндөр байж магадгүй. Тэгэхээр бүх аймагууд үндэсний хэмжээнд том хэмжээний төслөө хэрэгжүүлдэг байх соёл руу л орох ёстой. 5, 6 аймагаас бусад нь бол төрөөс татаас авч байгаа.

Цаашидаа би Ерөнхий сайдаар ажиллаж байх хугацаандаа том төслүүд хэрэгжиж байгаа аймагуудыг л илүү дэмжинэ. Зарим аймагууд нь уул уурхайгаа илүү ашиглуулаад, зарим аймагууд нь ямар нэгэн байдлаар тийм лоббидож мөнгө авдаг, энэ бол бас шударга биш. Тийм учраас цаашидаа бүх аймаг бие дааж төсвөө бүрдүүлдэг зүйл рүү л хэдүүлээ явна. Төв аймаг бол удахгүй бие даагаад төсвөө бүрдүүлдэг, бас илүү ашигтай юмнуудын нэг болж чадна. Яагаад гэхээр Хөшигийн хөндийн чөлөөт бүс нь маш том хэмжээний хөрөнгө оруулалтын асуудал бол шийдэгдэнэ ээ. Тэгэхээр ийм зүйлүүд дээр хэдүүлээ ярьж байгаад бас нөгөө юу яах вэ, бас нэг ийм талцсан, хуваагдсан асуудал гарч ирээд нөгөө Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудлаа царцаах улс төрийн бойкот руу орчих вий. Одоо манайх чинь нөгөө юм хийхээсээ илүү гацаагаад сурчихсан нэг ийм асуудалтай бас зүйлүүд байна.

Дээрээс нь, ер нь бол миний бодлоор иргэд маань их мэдээлэж байгаа юм. Тойргийн хөрөнгө оруулалт гэхээс илүүтэйгээр төсвийн зардлыг танаад төсвөө сайжруулаад ороод ирэхэд илүү баяртай хүлээж авч байгаа. Юмыг илүү тийм том зургаар нь хараасай гэж иргэд маань бас хүсдэг, ийм зөв чиг хандлага руу явж байна.

Өр тавиад Хөгжлийн банкаар хуваагаад дуусгачихсан хүн энд өрөнд нэг санаа зовж яриад хэрэггүй байхгүй юу. Би зүгээр улс төржихгүй л байгаа, яг үнэнийг хэлэхэд. Хэдүүлээ улс төржиж ханалаа, зүгээр ингээд хэдүүлээ урагшлаад юмаа шийдээд л, чиг хандлагаа гаргаад л явчихмаар байгаа юм. Зарим нь бүр нүүр улаймаар, зарим нь бүр ингээд төрөл арилжчихсан юм шиг юм ярих юм, тэгэхгүй л баймаар байгаа юм. Үүнийг тэгээд иргэд мэдэж л байгаа шүү дээ. Ойлгож л байгаа юм. Олон юмнуудыг цэгцлэх гээд л явж байна.

Геополитикийн нөхцөл байдал ямар байгаа билээ, мэдсээр байж мэдэхгүй юм шиг, нөгөө муу бол сайн гэдэг өнцгөөс ярих гээд л оролдох байна, ойлгож байна. Гэхдээ хэдүүлээ том асуудлуудаа барьж аваад шийдээд л явах нь зүйтэй. Нэг ЗГ бүх зүйлийг шийдэхгүй нь ойлгомжтой, том төслүүд гэдэг бол өөрөө ТЭЗҮ-ээсээ авхуулаад олон жил хэрэгтэй нь чухал, олон жилийн хугацаанд үргэлжлээд явчихсан төслүүдээ наяс дээш хувьтай энэ жил дуусгачих л гэж байгаа юм, энэ Монгол Улсад л хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй тэгээд л 100 тэрбумын төсөв оруулж ирчхэд л 1 тэрбумыг тавьчхаад л,

нөгөөдхөө 10 жилд шилжих, шилжих, шилжих, шилжих, шилжих, шилжих гээд л явдаг энэ жишгээ тасалчихъя л гэж байгаа юм. Тэр агуулгаараа 2023 оны төсөв бол реформын зөв гэж би хэлээд байгаа юм.

Энэ дээр харин Их Хурлын гишүүд маань бас их том агуулгаараа хамт байж чадвал ирэх жилээс авхуулаад л төсөв эрүүлжээд явчихна. Бид нар зарим нэг зүйл дээр өвдөлт өгч зарим нэг зүйл дээр, бас бидний хувьд жосоохон тийм хатуу шийдвэрүүд гаргаж энэ асуудлуудаа засахгүй бол болохгүй ээ.

Хүүхдийн мөнгө, халамж хаанаас гарлаа. Одоо бид нар ингээд нэг их тийм мэдэхгүй юм шиг, гэнэт нэг тийм эвэртэй туулай үзсэн юм шиг ийм асуудлыг яриад бас хэрэггүй. Одоо байгаа энэ асуудлуудаа засаад халамжит зорилтот бүлэг рүүгээ чиглэх ёстой. Халамжаас хөдөлмөр рүү шилжих ёстой. Гэхдээ алхмаар ... /минут дуусав/

Г.Занданишатар: Туваан гишүүн 1 минут тодруулъя.

Ц.Туваан: Хөшигийн хөндийн бүтээн байгуулалт дээр бол харсан, дэмжиж байгаа, Төв аймагчууд бүгд дэмжиж байгаа. Төр ард түмний холбоос гүүр гэдэг утгаараа тэнд ард түмний хэлж байгаа зүйлийг энд хэлж шахаж шаардаж явах нь бид нарын үүрэг ээ гэж ингэж бодсоны үндсэн дээр хэлж байгаа гэдгийг бас ойлгоно биз. Тэр саяын түүрүүний асуултууд дунд тэр ХАА-гаа дэмжинэ ээ, хоолоо л гэсэн үг шүү дээ, тэгээд нэг ярьчихсан. Өмнөх жилүүдэд 66 тэрбум төгрөг явж байсан, энэ жил 44 болчихсон байна, энэ яагаад. Хүнсний ногооны урамшуулал гээд тавигдчихсан, энэ бас боломжийн энэ дээр бол бас 10-аар орж ирээд 8-аар төсөвлөгдчихсөн явж байна лээ, энэ бол бас энэ жилийн нөгөө хүнсний ногооны хангамж, хувь энэ тэр нэмэгдээд явж байгаа чинь энэ зөв бодлоготой бас уялдаж ингэж явж байгаа байх гэж байна гэж бодож байна. Тэгэхээр энэ асуултад тодруулаад хариулт авчихъя.

Г.Занданишатар: Хөдөө аж ах, ахуйн яамнаас Санхүү, бодлогын газрын дарга. Индрийн I.

ХХААХҮЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонцэцэг. ХАА-н дэмжих урамшуулалд бол бид нар улаан буудай, сүүний урамшуул, арьс шир, ноосны урамшуулал, хүнсний ногоо гээд нийтдээ 90,6 тэрбум төгрөгийн төсвийн саналыг хүргүүлсэн. Төсвөөр болбол нийтдээ 44,5 тэрбум төгрөгийн төсвийг болбол хянасан байгаа, Сангийн яам.

Г.Занданишатар: Жавхлан сайд, Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Туваан гишүүний асуултад нэмж хариулъя. ХАА-н салбар маань манай уламжлалт салбар аа, хамгийн их татаас авдаг, хамгийн их дэмжлэг авдаг салбар байсаар байгаа. Ер нь цаашидаа аажим аажмаар яг бизнест суурилсан бизнесийн зарчмаар нь явуулдаг энэ хэлбэр лүүгээ бид шилжих ёстой. Төсөв дээрээс аль болох ачааллыг нь багасгаад бизнесийн зарчим дээр суурилуулаад явах хэрэгтэй. Энэ жилийн татаас өмнөх жилүүдийн татаасныхаа түвшинд л энэ байгаа. Харин хүнсний аюулгүй байдлын тухай цогц арга хэмжээ авахаар УИХ-аас томоохон ач холбогдол өгч энэ тогтоол гарсан байгаа. Санаачлагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ хөтөлбөрүүдийн хүрээнд. Энэ дээр бол харин бид нэлээдгүй том төсөв тавьсан, нэмэлтээр тавьсан байгаа. Түүрүүн би танд нэг бүрчлэн уншиж танилцууллаа. Тэр 228 тэрбум төгрөг болбол энэ сал ... /минут дуусав/

Г.Занданишатар: Амгалангийн Адьясүрэн гишүүн. 3 минутад л багтаавал сайн байна.

А.Адьяасүрэн: Тэгээд цаг орой болсон учраас нэлээд хэд хэдэн асуудал байсан боловч бас саналаа товч хэлье. Ингээд 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын талаар бас 1, 2 санал байна. 23 онд улсын төсвөөс 6,9 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,7 их наядын санхүүжилттэй 1061 хөрөнгө оруулалтыг бол тусгасан байна. Бид жил бүр бололцооныхоо хэрээр тодорхой хэмжээний зардлыг төсөвлөгддөг ч хамгийн харамсалтай нь зарим аймаг, яам, газрын бодлогын болон зохион байгуулалтын хариуцлагагүй байдал, алдаанаас шалтгаалж төсөвлөгдсөн санхүүжилтийг ашиглаж чадахгүй байдал бол зөндөө байна. Сая Ерөнхий сайд хэллээ, улс төржихөө больё оо, цөмөөрөө бас ажлаа хийе, сахилга хариуцлагатай байя гэж би бас энэ дээр нэмээд бас хэлчихмээр байна. Ингээд би нэг тодорхой жишээ яримаар байгаа юм. Тухайлах юм бол өнгөрсөн онд баталсан 2022 оны улсын төсөвт Баянхонгор аймгийн 7 сумын 7 цэгт үүрэн телефоны дэд станц байгуулж өгөөч гэсэн малчид ард иргэдийн удаа дараа тавьсан саналуудыг үндэслээд 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсөв дээр бол төсөвлөгдсөн. Гэтэл Баянхонгор аймгийн Засаг дарга дүр мэдээд төсвийн хуулийг зөрчиж, ажлын даалгаврыг өөрчлөөд 7 сумд биш 10 сумд дэд бүтэц байгуулахаар аймгийнхаа худалдан авалтын ажиллагаанд шууд оролцож, нөлөөлснөөс болоод 2 удаагийн тендер зарлагдаж, уг дэд бүтцийг барих компани олдоогүй ээ. Ингээд уг төсөл маань 2022 оны 4 сард хийгдсэн төсвийн тодотголоороо гэрээ нь хийгдээгүй гэдэг шалтгаанаар хасагдсан. Мөн бас энэ 2023 оны төсөвт ч бас тусгагдсангүй ээ. Ингээд мэргэжлийн яам нь тооцоо судалгаандаа үндэслэн ажлын даалгаврыг нь баталчхаад байхад төсвийн хууль зөрчиж, тендерийн нөхцөлд

нь өөрчлөлт оруулсны улмаас энэ ажил ингээд гагцхиаад байна. Энэ мэт ганц нэг хүний, буруутай үйл ажиллагаанаас болоод хуулиар батлагдсан төсөв биелэгдэхгүйд хүрснийг би Баянхонгорынхоо иргэдэд юу гэж тайлбарлах вэ? Үүнээс болоод ард иргэд, малчид маань хохирч байна. Мэдээж бид төсвийн хуулийг заавал биелүүлэх ёстой хууль гээд одоо хүртэл ингээд л шөнө болтол бидэнд хэлэлцээд сууж байна. Тэгвэл ийм үйлдэлд хэрхэн яаж хариуцлага тооцох юм бэ? Энэ дээр бас би Ерөнхий сайдыг тодорхой хариулт өгөөч ээ гэж бас хүсэх гэсэн юм.

2 дахь асуудал гэх юм бол мөн л 2022 оны төсөв түүний тодотголоор бас Баянхонгор аймагт хийгдсэн 2,5 тэрбум төгрөгийн “шинэ хөдөө” төслийн тухай. Энэ “шинэ хөдөө” төсөл болох дээр зэрэг 2022 онд 200 сая, 2023 онд 2,3 тэрбум төгрөгийн санхүүжилт бол тус тус батлагдсан байдаг юм. Гэтэл 2023 оны төсвийн тодотголд батлагдсан 2,3 тэрбум төгрөгөөс зөвхөн 775 сая төгрөг нь тусгагдаад 1,5 тэрбум төгрөг нь бол хасагдсан байгаа. Тэгээд яагаад энэ хуулиар батлагдсан энэ 23 онд шилжих төсөл арга хэмжээ 23 оны төсөлд суулгасангүй вэ? гээд нэлээд ингээд тодруулаад явахад ХХААЯ, Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авалт зохион байгуулж гэрээ хийгдээгүйгээс 3 багц төсөл болбол ингээд хасагдчихсан байгаа. Тэгээд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Ерөнхий сайд. Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Дахиад л энд би реформ ярья. Яагаад төсөвлөгдсөн батлагдсан үйл ажиллагаа хэрэгждээгүй вэ. Нэг хоёрхон шалтгаан байгаа. Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад зүгээр нэрийг нь батлаад, зураг төсөвгүй учраас хэрэгждээгүй. Эсвэл хэрэгжих явцад төсөвт өртөг нь хэт нэмэгдээд хэрэгждээгүй. Хоёрдугаарт бүх л улс орон, ер нь бол нэг л гүйцэтгэх засаглалтай байдаг. Манайх бол өнгөрсөн 30 жил 76 Ерөнхий сайдтай яваад ирчихсэн байхгүй юу.

Их Хурлын гишүүн тойрогтоо очоод гүйцэтгэх засаглалаасаа гадуур төсөвлөөд, тэгээд төсөвт оруулж ирээд нөгөө гишүүнийхээ мөнгө гээд гурван тэрбум ч юм уу, дөрвөн тэрбум дээр зүгээр нэр тавиад төсөөлчихдөг. “шинэ хөдөө”, тэгээд нөгөөдөх нь улсын төсөв дээр шууд орж ирээд батлагдчихдаг, батлагдсаных нь дараа сайд нь хурааж авдаг, хурааж аваад ойлгох гэж байтал эхний улирал өнгөрчихнө, хүйтэн болчихно. Хавар болон зураг төсөл байхгүй, намар болно, дуусчихна. Ийм байдалтай л ер нь бид нар явж ирсэн, одоо үүнийг нуугаад яах вэ. Тийм учраас Адьяасүрэн гишүүн та Баянхонгорынхоо иргэдэд маш энгийнээр

тайлбарлах. Хэдүүлээ зураг төсөв дээрээ маш сайн хамтдаа ажиллаж л гээд л.

Ирэх жил зураг төсөв дээр нэлээдгүй их санхүүжилт тавигдсан байгаа, энэ дээр үнэхээр шаардлагатай төслүүдээ Эдийн засгийн хөгжлийн яамтайгаа уялдуулаад хэдүүлээ хамтдаа төлөвлөөд л явъя. Түүн дээр ЗГ биечлэн ажиллана, тэгээд зураг төсвөө гаргая. 3000-ас доош хүнтэй сум нь яах юм, дээш хүнтэй суманд яах юм, цэцэрлэг ямар стандарттай байх юм, дотуур байр ямар стандарттай байх юм, Соёлын төв ямар стандарттай байх юм, зарим газар нь дотуур байр байхгүй байхад зарим газар нь дотуур байрны дүүргэлт 30 хувь хүрэхгүй байгаа. Энэ бүх асуудал нэгдсэн төлөвлөлтгүй явснаас болсон. Тийм учраас үүнийг л хэдүүлээ энэ жил ингээд л өөрчилж байгаа юм, мэдээж яах вэ, одоохондоо энэ бол ингээд хүнд эвлэрэхэд төвөгтэй шинэ соёл учраас. Гэхдээ цаашид ингээд явчихвал ийм маргаан байхгүй болно. Төлөвлөгдсөн бүх ажил 2 жилийн дотор шууд дуусах ёстой гэдэг зорилт хэдүүлээ тавих ёстой, нэг үгээр хэлбэл төсвийн мөнгийг 2 жилээс дээш хувааж тавимааргүй байгаа юм. 10 жил хувааж тавьж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар сая ингээд аудитын юу хийж үзсэн, ажлын хэсэг дээр, зарим төсөл 12 жил, зарим төсөл 13, 4 жил ингээд шилжих, шилжих гээд л ингээд явж байгаа юм. Ингээд дунд нь ач холбогдол нь байхгүй болчихож байгаа, нөгөө 11 жилийн өмнө эхэлсэн төсөл. Баригдсан төслүүд нь дундуур нь зураг төсөв нь байхгүй болоод компани нь дампуураад өөр компани орчихсон. Ингээд л татвар төлөгчдийн мөнгө үр ашиггүй өнгөрч байгаа юм.

Тийм учраас бид нар өнгөрснөө буруутгаад яах вэ, бид нар ирээдүй рүү шинэ соёлоор явах цаг болсон. Үүнийг бид нар хийчихвэл ийм маргаан ч байхгүй болно, ер нь тэгээд цаашид парламентын гишүүд, өдөр тутмын жалга довын түмпэн шанаганы ажилд ордог энэ байдлаас хэдүүлээ ер нь татгалзаж, илүү бодлого ярьдаг, илүү улс орныхоо хөгжлийн томоохон реформуудыг ярьдаг болохгүй бол энэ ингээд олон сонгуультай бас явж ирсний их төвөгтэй зүйл болж байгаа юм, энэ буруутгах арга байхгүй. Гэхдээ яг ийм соёлоор бид нар яваад удахгүй. Тийм учраас үүнийгээ бид нар өөрчлөөд л парламент илүү бодлогоо ярьдаг, орон нутаг нь төлөвлөлтөө хийдэг, ЗГ нь үйл ажиллагаагаа хийдэг, УИХ хянадаг, энэ бүтэц рүүгээ л бид нарын хувьд орж чадвал илүү их тийм чухал.

Тэгээд ирэх жил 2024 он нэлээдгүй тийм шинэ байх болно. Яагаад гэхээр бид нар ингээд 80 орчим хувийг нь дуусгачхаж байна гэдэг бол нэлээдгүй их бүтээн байгуулалтын орон зайнууд гараад ирж байгаа юм. Одоо гагцхүү бид нар төлөвлөлт, зураг, төсөв, ТЭЗҮ маш чухал. Тийм учраас энэ дээр л бид нар ирэх жил маш сайн төвлөрч чадвал ажил эхэлнэ, 2 жилийн дотор

заавал дуусна, ийм зарчим руу л хамтдаа явбал илүү бодит үр дүн ... /минут дуусав/

Г.Занданишатар: Амгалангийн Адьясүрэн гишүүн 1 минут.

А.Адьяасүрэн: Би 2 асуудал тавьсан Ерөнхий сайд аа. Эхнийх нь болохоор нөгөө зураг төсөл нь бэлэн байсан 7 цэгт тендер зарлагдах юу байтал яг 10-аар тендер маань орж ирээд тэгээд энэ гол нь нөгөө Засаг даргын буруутай үйл ажиллагаанаас хэд хэдэн удаа би удаа дараа шаардлага тавьж байсан. Энэ төсөв нь батлагдчихсан, тендер нь ингээд зарлагдчихсан 7 гэж байхад 10, Гэхдээ би Засаг даргыг бас буруутгахгүй байгаа юм л даа. Мэдээж манай Баянхонгор аймагт 10, 20 тийм үүрэн телефоны юу хэрэгцээтэй байгаа, үе шаттайгаар тендерийг зарлана гээд 7 суманд тендер зарлана гэж байхад тэрийг 10 болгочихсон байхгүй юу? Ийм учраас тендерт оролцох тендерийг гүйцэтгэх компаниуд шалгараагүй учраас энэ Баянхонгор аймгийн нэгэнт цахим үндэстэн болно гээд байгаа юм. Гэтэл бид нарын нөгөө үүрэн телефоны энэ станцууд маань баригдахгүй байдал бол хурчихсэн юм аа, энэ талаар би бас хариуцлага яриад байгаа юм.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Сая Ерөнхий сайд хөрөнгө оруулалтын бодлого, зарчмыг маш тодорхой хэллээ. Та яг тодорхой хөрөнгө оруулалтууд ярьж байгаа учраас энэ дээр тодруулж хэлье. Хэрвээ аймгийн удирдлагууд, өөрөөр хэлбэл төсвийн ерөнхийлөн захирагч нар гэсэн үг. Төсөв дээр нь тавьж өгөөд эрхийг нь шилжүүлсээр байтал үүнийг цаг хугацаандаа хийж чадаагүй болбол Иргэдийн хурлаараа та бүхэн орон нутагт өөрсдөө энэ дээр хариуцлага тооцох асуудал бүрэн нээлттэй ийм асуудал. Бид төсвийнхөө хөрөнгө оруулалтын зарчмыг бариад хугацаа тавьсан байгаа, ингээд хассан. Ирэх онд үргэлжлэх боломжгүй ээ гэсэн үг.

“шинэ хөдөө” нийтдээ 14 аймагт хэрэгжиж байгаа юм. 5 аймаг дээр нь багц багц дээр нь асуудлууд байгаа, хэрэгжүүлж чадахгүй, хойшилсон, удааширсан, мөн гэрээ байгуулагдаагүй гээд ийм нийтлэг зарчмаар энэ удаагийн төсөв хөрөнгө оруулалтыг барьж байгаа. Энэ нийтлэг зарчмаар хасагдсан байгаа шүү. Гэхдээ Баянхонгор дээр хасагдсан зүйл ч байгаа, үргэлжилж байгаа, “шинэ хөдөө”-ийн багцууд ч байгаа. Тэр үргэлж ... /минут дуусав/

Г.Занданишатар: Балжиннямын Баярсайхан гишүүн. 3 минутад багтаагаарай.

Б.Баярсайхан: Монгол Улсын Ерөнхий сайд, ЗГ-ын оруулж ирж байгаа улсынхаа том

мега төслийг урагшлуулаад, улсын хөгжлөө урдаа тавиад, тойргийн асуудлуудыг бас энэ жилдээ ингээд хөрөнгө оруулалтыг ардаа тавиад ингээд явъя гэж байгаа энэ бодлогыг бол энэ дэмжиж байгаа. Гэхдээ бидний хэрэгжүүлж байгаа “шинэ сэргэлтийн бодлого”-д хот хөдөөгийн ялгааг арилгах, хөдөөгөө хөгжүүлж, төвлөрлийг сааруулах гээд бас чухал зорилтууд байгаа. Тэгэхээр би бол байшин барилгыг хөгжил гэж хардаггүй, хүний хөгжлийг, хүний эрхийн асуудлыг, хүн нь аз жаргалтай байхыг илүү хөгжил тийшээ зөв зорьж байна гэж харж байгаа. Тийм учраас хүн, мал хоёроо ярьсан нэг хэд хэдэн асуудлыг бас би заавал асуухгүй бол болохгүй нь ээ.

Эхний асуудал болбол манай аймаг 73802 хүн амтай, аймгийн хэмжээнд нийтдээ зургаахан шүдний эмч байна. Тэгэхээр энэ шүдний эрүүл мэндийн асуудал, хүний эрүүл мэндийн асуудал өнөөдөр хамгийн гол чухал асуудал. Тэгээд энэ Эрүүл мэндийн сайд Энхболд сайдаас би асууж байна. Манай аймагт сум болгонд байшин барилга биш энэ эмчийн орон тоог баталж өгч шүдний эмчээр хангаж өгөөч ээ, энэ ямар боломж байна аа? Үүнийг 2 жилийн төсвийн хууль дээр ингэж ярьж байна.

Дээрээс нь Завхан аймгийн хэмжээнд 12 сум, 1 өрхийн эмнэлэг, ингээд Тосонцэнгэл, Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг нийт 15 эмнэлэгт 22 хүүхдийн эм эмч байж байгаа. Тэгэхээр хүүхдийн эмчгүй сумуудад бас үнэхээр асуудал хэцүү байна. Сүүлийн үед хүүхдийн хорт хавдар ихсэж байна, хүүхдийн эрүүл мэндийн асуудал бас хэцүү байж байна. Тэгэхээр энэ орон тоог батлаад явах боломж байхгүй юм уу.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдаас бас асуух асуудал байна. Өнөөдөр сум болгонд мал эмнэлгийн тасагтай, ХАА-н хэлтэс гээд мал хариуцсан 5 орон тоонд мэргэжилтэн ажилладаг. Гэтэл суманд хүүхэд хариуцсан нэг ч орон тоо байхгүй. Тэгэхээр өнөөдөр хөдөө орон нутагт хүүхдийн хүчирхийлэл маш өндөр байгаа, улсын хэмжээнд өнөөдөр 35000 хүүхэд өөрийнхөө гэрт гэмтэж, бэртэж, хүчирхийлүүлж нас барж байна. 12-17 насны өсвөр насны хүүхдүүд Энхболд сайд аа та мэдэж байгаа, жилдээ 564 хүүхэд абортот орж байна. Тэгэхээр энэ хүүхэд хариуцсан мэргэжилтэн үнэхээр энэ сум орон нутагт байхгүй бол бид нар хот хөдөөгийн хөгжил, хүүхдийн эрх, хүний эрх бол ярих ийм боломжгүй ийм цаг үед ирчхээд байна.

Гуравдугаарт, тулгамдсан асуудал болбол ганцхан манай Завхан аймаг биш, баруун 5 аймаг, өшөө ч аймгууд өвөлжилтийн нөхцөл байдал нэлээн хүндрэх, төлөвтэй байна. Тэгэхээр улсын маань эдийн засгийн гол тулгуур болсон энэ МАА-г энэ өвөлжилтийн бэлтгэлийг сайн хангаж ингэж ... /минут дуусав/

Г.Занданишатар: Энхболд сайд хариулна, 95.

С.Энхболд: Баярсайхан гишүүний асуултад хариулъя, Бид нар 21 онд 330 сумын бас судалгаа аваад 214 суманд шүдний кабинет шаардлагатай юм байна гэдэг судалгааг гаргасан. Бид нар бас төсөв дээр тодорхой хөрөнгийг тавьж, эхнээсээ бас энэ сумуудад шүдний кабинетуудыг байгуулсан. Харамсалтай нь ер нь манай улсын хүн амын төвлөрөл Улаанбаатарт дийлэнх хувь нь байдаг учраас бүх шүдний чиглэлээр төгссөн эмч нар Улаанбаатарт төвлөрчихсөн, хувийн эмнэлэг нээчихсэн байдаг юм байна. Энэ дээр бид нар Боловсролын яамтай ярьсан, АШУИС-тай ярьж, бас зохих түвшинд нь бид нар бүсчилсэн байдлаар энэ үзлэг оношилгоонуудыг бол хийж явуулсан.

Ноднин 10 сард бол энэ баруун 5 аймагт бол бид нар шүдний эмч юуг бол хийсэн байгаа. Дээрээс нь нарийн мэргэжил эзэмших шаардлагатай хүний судалгаануудыг гаргаж, энэ хүмүүсээ наашаа бэлдэж өгөөч ээ гэдэг бид нар эрүүл мэндийн газрууд руу албан бичгээр хандсан. Харамсалтай нь орон нутгаас бол эмчийн юун дээр сургалтад хамрагдах тийм квот ирээгүй. Тэгэхээр бид нар үүнийг бас АШУИС-тай ярьж байж энэ зохион байгуулалтад орж ирж тийшээ хуваарилах ажлыг бол хийхгүй бол тэр болгон төгссөн эмч нар маань шууд орон нутагт очдоггүй юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бид нар бас зохицуулалтуудыг хийж, цаашид ялангуяа энэ хүүхдийн эмч, шүдний эмч өөр бусад, ялангуяа сумдад ажиллаж байгаа эмч нарын судалгааг авч үзэхэд дийлэнх нь уламжлалтын эмч байдаг. Тийм учраас яг нарийн мэргэжлийн, тэр стандартад нийцсэн эмч нарыг бэлтгэх тал дээр бол бид нар онцгой анхаарч, энэ жилээс эхлэн бид нар бас хэд хэдэн үе шаттай ажлуудыг хийж байгаа. Энэ жилийн реседентийн сургалт дээр бол бид нар аль болох орон нутгаас бүх квотуудыг олгосон, нийтдээ 415 эмчийг бид нар орон нутгаас сургаж гэсэн боловч харамсалтай нь 50 хувьд нь 264 хүн шалгалтад орсон. Бусад юун дээр бол ямар нэгэн квот дээр бол ирээгүй, бид нар шүдний эмч, хүүхдийн эмчийг суралцъя гэсэн эмч нарыг бол ер нь бүгдийг нь энэ жилийн сургалт нь реседенттэй төрийн сангаар суралцуулах ийм боломж бол бололцоо байгаа. Энэ дээр бол бид нар ирсэн хүмүүсийг нэмж авч байгаа. Тэгэхдээ цаашид энэ шүдний кабинет, ялангуяа энэ хүүхдийн эмч дээр бид нар бас бодлогоор ажлуудыг хийнэ ээ гэдгийг бас танд хэлье.

Г.Занданишатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна, гүйцээж хариулна.

Л.Оюун-Эрдэнэ: Нэгдүгээрт, бас би Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлэх ёстой.

Яагаад гэхээр өнгөрсөн 2022 оны төсвийн болон бусад хөрөнгө оруулалт нийлээд 1,5 их наяд тийм ээ, Энхболд гишүүн, 1,2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг бид нар эрүүл мэндийн салбар дээр 3, 4 багц асуудал дээр тавьсан. Нэг нь бол Эх үрсийн эрүүл мэндийг шийдье, төрөх ороос авхуулаад стандартыг нь хангая гээд өнөөдөр дөнгөж бид нар 2 дугаар төрөхийн бас өргөтгөлийн нээлт ажлынх нь бүтээн байгуулалтын нээлт болсон. Эх нялхас хуучнаар би ярьж байна, бас нэлээдгүй том түвшинд засагдаж байгаа. Аймгуудын төрхүүд засагдаж байгаа. Тэгэхээр бид нар ингээд асуудлыг ингээд бөөнөөр нь тавивал ингээд шийдэж болчихож байгаа юм.

Тэгэхээр хэрвээ үнэхээр шүдний эмнэлгийн асуудал чухал байна гэвэл бид нар энэ жилдээ маш сайн судлаад л ирэх жил бид нар энэ дээр тогтолцооны том реформ хийгдэж байж л үүнийг шийднэ. Түүнээс Эрүүл мэндийн сайд дангаараа үүнийг шийдээд, өөрөө орон тоогоо эд нар нэмэх тийм боломж бол байдаггүй шүү дээ, бид нар үүнийг мэднэ. Энэ бас нэгдсэн байдлаар Сангийн яаман дээр төлөвлөлт хийгдээд л явна.

Хүүхдийн сугалааны асуудлыг бид нар тодотголоор нийслэлтэй хамтраад сая нэлээн том түвшинд шийдчихэж байгаа юм. Тэгэхээр энэ бүгдээрээ л ингээд бид нар нэг далайлтаар ийм том түвшинд шийдвэл шийдэл гардаг юм байна гэдгийн том жишээ.

Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийн асуудал дээр манай бас орон нутгийн Их Хурлын гишүүд яг төсвийг ингээд аваад үзвэл орон нутаг дээр дандаа хамаагүй давуу талууд нь чиглэсэн байгаа. Зөвхөн нийслэл дээр нийтийн тээврийг шинэчиле л гэдэг л зүйл орж ирж байгаа. Гэхдээ нийтийн тээврийг нэг мөсөн бас ийм нэлээн тийм том далайцтай шийдье. Хотын болон дүүргийн удирдлагуудтай би бас уулзах гэж байгаа, тэр нь юу вэ гэхээр тэд бас төсөв тавь аа, автобусны буудлуудаа нэг мөсөн шинэчил ээ. ЗГ, Их Хурал ингэж анхаарч байгаа. Та нар ч гэсэн хийх ёстой гэж ингэж хэлж байгаа юм. Тэгэхээрээ бидний хувьд энэ асуудлуудыг ингээд том агуулгаар нь шийдчих нь зүйтэй.

Ер нь бол хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийн хүрээнд хотоос хөдөө рүү чиглэж байгаа бүх урсгалыг дэмжье гэж байгаа юм. Одоо энэ төсөв дээр та бүхэн харвал бүгд ийм байгаа юм. Жишээлбэл, ипотекийн зээл хотоос 3 хувь болоод хөдөө хямдхан болж байгаа, орон нутаг руу чиглэсэн, бүх нүүдлийн урсгалыг дэмжиж байгаа. Цаашидаа халамжийн бодлого, цалингийн шатлал тийм болно. Орон нутагт байгаа, төрийн албан хаагчдын цалинг 20-100 хувь нэмэгдүүлэх эрхийг олгож байгаа, нэг үгээр хэлбэл би сайн эмч нар, сайн багш нар, хүүхдийн шүдний эмчээс авхуулаад хөдөө орон нутагт

шаардлагатай байгаа төрийн албан хаагчид өөрсдөө очиж ажиллах энэ тогтолцооны цалингийн, халамжийн, нийгмийн хамгааллын энэ бүх тогтолцоог бид нар хот, хөдөө дээр илүү өөр болох шаардлагатай. Ингэж байж хотоос урсгал нэмэгдэнэ. Түүнээс Улаанбаатар хот хамгийн хямдхан байгаа нөхцөлд хөдөө орон нутаг Улаанбаатар хотод шилжиж ирсээр л байх болно. Хөдөө хотоос үнэтэй байвал яаж тэнд хүмүүс оршин суух уу? Тийм учраас энэ агуулга дээр бид нар бас тогтолцооны том реформ хийж, чиг хандлагыг бид нар Улаанбаатар хотоос орон нутаг руу чиглэдэг байх энэ зүйл рүү л тогтолцооны хувьд бид нар алхам алхмаар орох ийм зүйлийг энэ төсвийн жилээс эхлээд бид нарын хувьд бол хийж байгаа. Үр дүн гарна гэдэгт бол итгэлтэй байгаа. Гэхдээ энэ дээр Их Хурал, ЗГ, орон нутаг маш ойрхон ийм ажиллах боломжтой байгаа.

Цаашидаа Улаанбаатар хотоос илүү хөдөө орон нутагт ажиллах нь ашигтай болох, ингэж байж л бид нар тэр хүмүүсийн урсгалыг бий болгоно. Би бас санал солилцож байсан, гэхдээ эцсийн байдлаар энэ жил орж ирж чадсангүй. Төрийн албан хаагчдын карьерын буюу шатлан дэвших зарчмыг хүртэл хөдөө орон нутагт ажилласан байх гэдэг зарчимтай уялдуулна. Ингэж байж бидний хувьд илүү туршилагатай, тэнцвэртэй хөгжлийн асуудалд туршилагатай боловсон хүчин ажиллах энэ боломжийг бол бас бүрдүүлнэ. ... /минут дуусах/

Г.Занданишатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асууя, 1 минут.

Б.Баярсайхан: Баярлалаа. Ерөнхий сайд аа, энэ бол маш чухал зүйл байгаа, ялангуяа шүдний эмч, хүүхдийн өмч, сум болгонд байсан урьд нь. Одоо энэ хөгжлөөсөө бас бид нар ухарчхаад байгаа.

Баруун аймгийн малчдын энэ өвөлжилтийн байдал бол нэлээн хүнд байгаа учраас энэ жилийн төсөв дээр энэ жил малчид өвөлжилтийг хүндрэлгүй давах тал дээр асуудлыг бол бүрэн шийдэж байгаа гэж найдаж байна. Тэгээд Ерөнхий сайд аа, энэ 2016 онд Монгол Улсын Шадар сайд, бусад аймгуудад оторлоод явж байгаа малчдаа хамгаалах нэг тийм тушаал шийдвэр гаргаж байсан юм байна лээ. Үүнийг энэ жилийн ЗГ тэмдэглэл ч юм уу, гаргаж өгөөч ээ. Өнөөдөр Завхан аймгийн 102 өрхийн 56695 малчин Архангай, Булган, Баянхонгор, Хөвсгөл, Төв аймагт оторлож байна. Тэгээд энэ хүмүүсийг хамгаалах очсон газарт нь хөөж туухгүй байх бас нөхцөлийг бүрдүүлэхэд та анхаарч өгөөч ээ гэж би танаас хүсэж байна.

Г.Занданишатар: Үг хэллээ. Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэнд хүргэе. Би маш товчхон нэг асуулт асууя. Уг нь нэлээн хэдэн асуултууд байлаа. Бид нар өнөөдөр мөнгөний бодлого болон төсвийн төслийг хэлэлцэж байна. Тэгээд дараа дараагийн хурлууд дээр асуултуудаа асуучихъя. Зүгээр нэгхэн асуулт байгаа юм, тэр нь юу вэ гэхээр урсгал зарлага сүүлийн 4 жилийн хугацаанд тогтмол өсөж ирсэн байгаа. Ерөөсөө 2-3 их наяд төгрөгөөр тогтмол. Тэгээд 23 онд бас дахиад 2 их наяд төгрөгөөр 1,6 их наяд төгрөг өссөн дүнтэй харагдаж л байна л даа. Тэгээд би энэ дээр ганцхан санал юу хэлэх гээд байна гэхээр 22 оных нь түвшинд энэ урсгал зардлыг хадгалж болохгүй юу? Хөрөнгө оруулалтын асуудлыг бол маш сайн ойлголоо, төсвийн хууль дээр бол нэлээн том өөрчлөлт орж байгаа юм байна, үндэсний хэмжээний төслүүд дээр эрэмбэлж, ЗГ нэмж оруулж ирдэггүй, энэ бол маш том сайн өөрчлөлт, эерэг өөрчлөлт гэж харж байна. Яах вэ, энэ төсвийн төсөл энэ тэрийг хараад Дэлхийн банкны судалгаа эд нарыг харлаа л даа. Тэгээд яах вэ, яагаад би энэ урсгал зардлыг яриад байна гэхээр бид нар мөнгөний бодлого ингээд цаашид ирэх жилийн мөнгөний бодлого яаж гарах вэ гэхээр хатуу мөнгөний бодлого явагдана. Тэгээд тэр нь юу гэсэн үг вэ гэхээр зээлийн хүү нэлээн өндөр болно, аль эсвэл зээл олдохоо болино гэсэн үг. Тэгэхээр энэ нь бол үндсэндээ бол сүүлийн 2 жил яг ковидын нөхцөл байдлаас болоод энэ хувийн хэвшил чинь бол үндсэндээ бол яг ингээд байдаг бүх ингээд бүсээ чангалчихсан байж байгаа байхгүй юу. Тэгээд илүү л чангална гэсэн үг. Тэгэхээр энэ талдаа бас засаг буюу бид нар ч гэсэн бас танаж болохоор зардал байвал танахгүй бол яг ингээд явах юм болбол нэг талаасаа бид нар хувийн хэвилээ нэлээн хүнд байдалд оруулна.

2 дугаар асуудал болохоор орлого талаа нэлээн өөдрөг төсөөлчихсөн байгаа байхгүй юу. 19 оны экспортын хэмжээгээр төсөөлсөн байна гэдэг маань бид нар сүүлийн 20 он, 21 он, 22 он одоо 3 жилийн хугацаанд хэзээ ч тийм хэмжээний экспорт хийж чадаагүй. 23 онд дайны нөхцөл байдал үргэлжлэх эсэхийг бид нар мэдэхгүй байгаа, ковидын нөхцөл байдал үргэлжлэх эсэхийг мэдэхгүй байгаа. Тэгэхээр бид нар бол яг 32 сая тонн нөөц, тэр нүүрсээ гаргаж чадна гэдэг дээр би бол хувьдаа итгэхгүй байна л даа, аягүй хүндрэлтэй л байх болов уу? Тэгээд тийм учраас орлого талдаа бид нар нэлээн хүндрэлтэй, том том, нөгөө бэрхшээлүүдтэй тулгарахаар байгаа байхгүй юу. Тэгэнгүүт яах вэ гэхээр бид нар чинь нэг ёсонд ханих унах байдаг юм уу? Эсвэл инфляц хэд юм уу? Энэ яг инфляц, ханийн асуудлыг бол 21 онд бас Жавхлан сайд бас хэлж байсан, тийм ээ, тэгээд энэ асуудал дахиад л дараа жил ингээд л гарч ирэхээр байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө энэ асуудлууд чинь дахиад л хүндрээд л явахаар харагдаад байгаа байхгүй юу. Тэгээд дараа жил ядаж байхад бид нар чинь 600 сая долларын бонд төлнө гэж

байгаа юм. Тэгээд дотоодын зээлийн эх үүсвэрийн өртөг нэлээн өндөр болчихно оо гэж байгаа юм, тэгээд дотоодод бонд гаргана гэхээр чинь нөгөө хувийн хэвшил чинь бүр мөнгө олдохоо болино. Нэг иймэрхүү бэрхшээл хүндрэл харагдахаар байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ тал дээр л би асуух гэсэн юм л даа. Ер нь бол яах вэ, Энэ урсгал зардлаа зарлагаа 22 оных нь түвшиндээ хадгалаад ... /минут дуусав/

Г.Занданишатар: Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ асуултад харуулна.

Л.Оюун-Эрдэнэ: Мэдээж бид нар амаргүй цаг үе бол байгаа, гэхдээ бид нар шалтаг тооцоод суугаад байж болохгүй, хариу үйлдэл үзүүлэх ёстой. 2022 оны төсөв буюу өнгөрсөн жилийн төсөв хэлэлцэж байхад бол эдийн засаг маань хасах 5,3 хувиар уначихсан байсан. Энэ оны төсгөл гэхэд бол 3 хувийн өсөлттэй гарах ийм урьдчилсан тооцоо гарч байгаа юм, 2,7-3 орчим хувьтай байх нь ээ гээд.

2023 оны төсвийн хэрэгжээд дуусах үед Монгол Улсын эдийн засаг 5 хувийн өсөлттэй байна гэж яах вэ, мэдээж өөдрөг төсөөлөл гэж бас шүүмжлүүлж байгаа зүйл байгаа. Гэхдээ бид нарт бол бүрэн боломж байна гэж үзэж байгаа.

Нүүрсний экспортыг мэдээж бид нар багаар төлөвлөөд оруулаад ирж болно, нөгөө хэрэгжихгүй байж магадгүй, шүүмжлэлд өртөөд яах вэ гэдэг өнцгөөс харвал. Гэхдээ нэг ялгаатай зүйл байгаа. Одоо бид нар шинээр экспортын 3-4 шинэ гарц хийгдэж байгаа юм. Саяхан бид нар Гашиун сухайтын төмөр замыг ашиглалтад авлаа, мэдээж тэнд холбох гүүрэн байгууламж туйлын чухал нэг, 30-40 орчим хоногийн дараа Ханги мандалын төмөр зам ашиглалтад орно, Шивээ хүрэнгийн төмөр замын экспортоор бидний хувьд гаргах байдлаар ажиллаж байна. Хил холболтын цэг тохирсон. Тийм учраас бид нар урд нь нүүрс зөөхдөө зөвхөн машинаар зөөдөг байсантай харьцуулахад бол энэ жилийн хувьд бол харьцангуй өөдрөг төсөөлөх боломж бас бүрдэж байгаа юм. Тийм учраас л бидний хувьд мэдээж бүсээ чангална, хоёрдугаарт бүх зүйлийг экспортод. Энэ агуулга руу, бидний хувьд бас нэлээн их харах нь бол чухал юм гээд.

Ер нь бид нар, хувийн хэвшлийнхний хувьд бол Монгол Улсын төр засаг, УИХ, ЗГ ганцхан зүйлийг л бид нар хийж чадах ёстой. Энэ бол макро тэнцвэр тогтвортой байх, бодлого савлахгүй байх, тодорхой байх, өөр өөр юм яриад, улс төржөөд байхгүй байх энэ зүйлийг л хийж чадвал бусдыг нь хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийнхэн өөрсдөө хийнэ. Тэгэхээр хэдүүлээ энэ зүйлийг л хийхийн тулд энэ 2023 оны төсвийг бас нэлээн чангалж, ингэж оруулж ирж байгаа нь чухал юм. Ер нь бидний хувьд ингээд тогтворгүй, хэт савлуулдаг, мессеж тодорхойгүй, яах гээд

байгаа нь ойлгомжгүй, ийм байдлыг л бид нар гадна талдаа ч засах ёстой, дотор талдаа засах ёстой, хөрөнгө оруулагчдад бид нар тодорхой байх ёстой, төлөвлөх боломжтой байлгах ёстой, хувийн хэвшил тодорхой байх ёстой, төлөвлөж чадах ёстой. Тийм учраас энэ жилийн төсөв бол гол агуулгаараа бол энэ юм.

Тийм учраас 2022 оны төсөв бол цар тахлыг даван туулах төсөв байсан бол 2023 оны төсөв бол эдийн засгийн макро тэнцвэрийг хадгалах ийм төсөв байна гэж бид нар оруулж ирж байгаа. Тэгээд ЗГ-аас өргөн баригдсан энэ хувилбараар батлагдвал энэ макро тэнцвэрийг хангаж чадна гэдэгт ЗГ бүрэн итгэлтэй байгаа. Тэгээд бас үүнийг орж ирсэн энэ хувилбараар нь аль болохоор их өөрчлөхгүйгээр баталж өгөхийг бас УИХ-ын эрхэм гишүүд та бүхнээс хүсье.

Мэдээж геополитик амаргүй байна, гэхдээ үүнийг бол бид нар Монгол Улсын хил дотроос шийдэж чадахгүй зүйл, давагдашгүй хүчин зүйл гэсэн үг. Тийм учраас мэдээж бид нар хүнс болон бусад асуудлууд дээр нөөц төлөвлөгөөнүүд бол гаргаж байгаа. Гэхдээ л бидний хувьд энгийн амьдралаа үргэлжлүүлэх ийм л төлөвлөлтийг хийх ёстой. Цар тахлын үед хүнд байсан, гэхдээ эрүүл мэнд, эдийн засаг хамтдаа гэдэг концепцыг бид нар дэвшүүлсэн. Цаг хугацаа өдрөөс өдөрт түүнийг зөв байсан гэдгийг бас нотолж байгаа. Тийм учраас ирэх ... /минут дуусав/

Г.Занданиатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Ц.Цэрэнпунцаг: Ерөөсөө товчхон 2 асуулт, 2 санал байна.

Нэгдүгээр асуулт. Өвөлжилт хүндрэх нь ээ, Ерөнхий сайд аа, баруун аймгууд хүндэрч байгаа. Тэгэхээр зэрэг энэ өвөлжилт хүндэрсэн тохиолдолд яг нэг бол энэ гарч ирэх энэ өвөл, хавар маань хүнд болох тохиолдолд өвс тэжээлийн асуудал гарч ирнэ, хавар ингээд хүнд өнгөрөх юм бол малчдаа бас нэг малжуулах ийм ажил гарч магадгүй. Энэ дээр төлөвлөж хэдэн төгрөг дээр тавигдаж байгаа вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёр дугаар асуулт. Жавхлан сайдаас. ЗГ үнэт цаас гаргах нь ээ, энэ үнэт цаас гаргах нь, яг хэдэн төгрөгийн үнэт цаас, дотооддоо гаргах гэж байгаа ЗГ-ын үнэт цаас. Энэ маань нэг сөрөг үр дагавар байж магадгүй юм, энэ дотоод мөнгөний эх үүсвэр ховордоод байна, зээл олдохоо болиод байна, зээл гарахгүй байна гээд энэ бизнесийнхэн маань их санаа зовж байна, ААН-үүд. Тэгэхээр зэрэг үүнтэйгээ өрсөлдөөд энэ

дотооддоо байгаа жосохон мөнгөний, одоо мөнгөний нийлүүлэлт багасаад яваад байгаа ийм тоон мэдээ байна. Эндээс мөнгийг нь зэрэгцээж татах нь ээ, энэ дээр гарах энэ сөрөг үр дагаврыг энэ үр нөлөөг багасгах чиглэлд ЗГ-аас ямар үйл ажиллагаа явуулах юм.

2 санал. Төсөв алдагдалгүй байвал маш сайн байна. Төсөв алдагдалгүй байх, төсвөө ашигааж төсвөө батлах эд нар бол бас үргэлж муу нөлөө байдаггүй юм байна. Жишээлбэл, Дани улс бол 1982, 86 онд төсвөө ДНБ-ийхээ 10 хувьтай хэмжих хэмжээгээр ашигааж, төсвөө батлаад дараа жилүүдэд нь 4, 5 хувийн эдийн засгийн бодит өсөлт үзүүлж байсан жишээнүүд байдаг юм байна. Тэгэхээр бас энэ дээр бас ажиллавал их зүгээр байх. Зүгээр санал.

2 дахь юм бол ерөөсөө нэг төгрөгийн ч асуудал яригдахгүй нэг асуудал байна. Өнөөдөр эрчим хүчний эх үүсвэр болон үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл гаргахад энэ олон улсын санхүүгийн байгууллагын судалгаагаар дунджаар 280 хоног орж байна, бараг 1 жил нэг зөвшөөрөлтэй нь осолдож байна шүү дээ. Тэгэхээр үүнийг бид нар нэг ч төгрөгийн зардал гаргахгүйгээр шийдэж болохоор байна шүү дээ. Энэ дээр энэ тусгай эрчим хүчний зөвшөөрөл, ялангуяа нөгөө Эрдэнэбүрэнг бүгд ярисаар байгаад л мэдэж байгаа, Эрдэнэбүрэнгийн УЦС гэхэд л өнөөдөр ингээд л бас тодорхой бус, ингээд л байж байгаа. Тэгтэл бид нарт баруун бүс ямар их хэмжээний их эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай билээ, ямар их валют зарж Оросоос өвөл авдаг билээ, заримдаа дизель станц хүртэл асаадаг шүү дээ. Тэгэхээр ийм нэг ийм тусгай зөвшөөрөл, лиценз, ийм дүрэм журамтай холбогдоод ингээд ийм хүнд суртал засгийн энэ манай төрийн л хүнд суртлын улмаас ингэж удааширчихсан байгаа энэ төслүүд дээрээ бас хурдавчлах ийм ямар арга хэмжээн дээр авах юм бэ? Ийм бас нэг, энэ дээр нэг арга хэмжээ авч өгөөч ээ л гэдэг ийм хүсэлт байгаа юм.

Г.Занданиатар: Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ харуулна.

Л.Оюун-Эрдэнэ: Өвөлжилт баруун аймгуудад хүндэрч болзошгүй гэсэн ийм төлөв байдал байна гэдгийг бол надад мэргэжлийн хүмүүс хэлсэн. Бид нар уулзсан, хэд хэдэн удаа уулзсан. Мэдээж, ЗГ бүх зүйлийг дангаараа шийдвэрлэх боломжгүй, гэхдээ ЗГ-ын нөөц дээр бол энэ зудтай холбоотой амаргүй нөхцөл байдлыг яаж даван туулах вэ гэдгийг бол тооцож нэлээн ярилцсан. Энэ дээр, бас аймаг орон нутгууд, манай ард ирээд маань ч гэсэн дотроо нэгийг тооцож суугаа байх, ер нь бол. Цаашидаа бид нар, ер нь ХАА, орон нутгийнхаа түвшинд нэг зүйлийг бас зарчмын нэг тийм, бас бодитой л үнэнийг ярих бас цаг болсон байж болзошгүй гэж би зүгээр дотроо бодож байгаа.

ЗГ дээр бас ярилцаж байгаа. Энэ бол бид нар бэлчээрийн хувьд бас төвөгтэй байдал руу орж байна, энэ бол бодитой. Малынхаа бид нар илүү чанарт илүү их тийм анхаарах, ямар ч өвлийн хүйтэнд ажрахгүй гардаг байх, ийм бас нэг ийм тогтолцоо маягийн ийм шинэчлэл бол бас зайлшгүй ер нь хэрэгтэй л болж байх шиг байна. Энэ шагнал урамшилаас авхуулаад ч гэсэн бид нар бас нөгөө зөвхөн ийм тоо тал дээр нь илүү их анхаараад явчихсан, мянгат малчин гээд л. Ингээд л яах вэ, энэ мэдээж чухал, мал сүрэг өсөх нь сайхан зүйл. Гэхдээ бид нар бас багтаамж байна, бодитой асуудлууд байна, энэ бүх зүйлээ, бас бидний хувьд бодвол илүү чанарт шилжих, ийм агуулга руу, бас энэ ХАА-г дэмжих бодлогын хүрээнд бол нэлээн их явах нь бол чухал юм гэж бас бодож байгаа юм.

Эрдэнэбүрэнгийн УЦС бол явна, үүнийг би дахиад хэлье, ямар ч төсөл зогсох ёсгүй. Яагаад гэхээр бидний хувьд улс орны Засгийн газруудтай Монгол Улс гэдэг нэрийн өмнөөс гэрээ хийгээд бүхэл бүтэн төр засгаараа ард түмнээрээ бид нар Монгол улс гэдэг нэг л ийм усан онгоц дээрээс хэлцэл хийчхэж байгаа юм. Тэгээд бид нар ингээд гадаад ертөнцөд Монголчууд нэг тийм худалч юм хэлээд хийдэггүй, жоохон байж байгаад өөрчлөгдчихдөг гэдэг ийм нэр хүндтэй улс болчихож болохгүй, ингэх юм бол цаашидаа бид нарт хэн ч итгэхгүй болно. Мэдээж тэнд олон асуудлууд байгаа, тэрийг ойлгож байгаа, ойлгож, ярилцаж, зөвшилцөж, энэ бүх асуудал дээр хүндэтгэлтэй хандана.

Гэхдээ нэгэнтээ олон улсын түвшинд хэлцэл болчихсон ЗГ-ын ийм, тодорхой бодлого бол зогсож болохгүй, би үгэндээ хэлсэн, дахиад хэлье. Ямар ч улс төржилт, ямар ч эсэргүүцэл бай би Ерөнхий сайдын хувьд энэ бодлогоос сөөм ч ухрахгүй, урагшилна. Бусад олон жилийн хугацаанд гацсан төслүүдээ ч гэсэн 2023 онд дийлэнхийг нь хийнэ, дийлэнхийг нь хийж дуусгана, эхлүүлнэ. Бид нар шинэ зүйл эхлүүлнэ гэхээс илүүтэйгээр төлөвлөөд явчихсан, нэгэнтээ мөнгө гаргачихсан, зураг төсөвтэй ажлуудаа дуусгахын төлөө ажиллана, ингэж байж бодитой үр дүн гарна гэдгийг бас танд хэлье.

Тэгээд та бас Эдийн засгийн байнгын хорооны даргын хувьд, бас ЗГ-ын томоохон бодлогуудад бодлогын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана гэдэгт бол итгэлтэй байна.

Дээр нь орон нутгуудад бас очиж ажилласан. Орон нутагтаа очиж ажиллаад бид нар төслүүдийг эрэмбэлсэн, 70 орчим хувь нь зураг төсөвгүй байсан, дахиад л гарч ирж байгаа юм, Тийм учраас зураг төсөв, бэлтгэл ажлаа хэдүүлээ маш сайн хангая, ингэж чадвал манай ард иргэд маань ойлгоно, илүү ойлголцол өндөртэй болно. Ингээд л бага багаар асуудлуудаа урагшлуулаад зогсолтгүй ингээд

явбал Монгол Улс бас богино хугацаанд хөгжин дэвжих ийм боломж бол байгаа. Мэдээж амаргүй цаг үе байгаа ч гэсэн.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт явуулдаг болсон байна.

Дэмжсэн, дэмжээгүй үг байхгүй. Энэ хуучин санал хураалтгүй байсан энэ хяналт шалгалтын тухай хуулиар нэг санал хураалт явуулахаар болсон. Ингээд саналаа хураачих уу, тийм ээ. Тогтохоо дарга тэгье гэж байна.

Ингээд төсвийн төсөл Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан шаардлага хангасан талаар санал хураалт явуулна. Энэ хангасан гэсэн дүгнэлтийг нөгөө аудитын болон төсвийн бодлого шинжилгээний албаны санал, дүгнэлтийг тараасан байгаа.

Төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан шаардлага хангасан талаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Өнөөдрийн анхны санал хураалт учраас энэ бүртгэлийн санал хураалт явуулна.

Бүртгэлд ороогүй энэ 18 гишүүн байна, бүртгэлдээ ороорой.

Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 62,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн шаардлагуудыг хангасан байна.

Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороод, мөн Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлж байна.

Энэ төсвийн хууль бол Монгол хүн бүрийн амьдралд нөлөөлж байдаг олон нийтийн хяналт, оролцоо чухал ийм хуулийн төсөл. Ийм учраас манай Төсвийн байнгын хорооноос санаачилж олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийн төсөв дэх оролцоо, хяналтыг сайжруулахын тулд анх удаа олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулах гэж байна. Төсвийн байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг 10 дугаар сарын 19-нд энэ нээлттэй

хэлэлцүүлгийг зохион байгуулна. Иргэд, олон нийтийг идэвхтэй оролцохыг уриалж, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, судлаачдын саналыг өнөөдрөөс эхлээд 17-ны өдрийг хүртэл энэ нээлттэй хэлэлцүүлэгт ирүүлэх саналыг авч байна.

Ингээд төслийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээс хийхээс өмнө иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжилтэн, судлаачдын саналыг авна, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын саналыг авна. Энэ хувийн хэвшил, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авснаараа иргэдийг мэдээллээр хангах, иргэн бүрийн амьдралд нөлөөлж байдаг Улсын төсвийн хуульд иргэн бүрийн оролцоо, санал бодлыг тусгах боломжийг нээх, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулснаар улсын төсөвт тулгардаг хамгийн том бэрхшээл, үр ашиггүй зардлуудыг урьдчилан хянах, хэлэлцэх, өөрчлөх, төсвийн хяналт, төсвийн хэмнэлтийг бодитой хэрэгжүүлэхэд төсвийн бодлого төлөвлөлт, төсвийн ил тод байдлыг бэхжүүлэх, төсвийн хяналт, төсвийн сахилга батыг сайжруулахад чиглэгдэж байна.

Төсөв батлагдсаны дараа тийм зүйл орчхож, ийм зүйл орчхож гээд хэл ам, хэрүүл маргаан гардаг биш, нөгөө тайван цагт хөлс их гарвал дараа нь дайны цагт цус бага гарна гэдэг үг байдаг шиг энэ хэлэлцүүлгийн шатанд олон нийтийн хэлэлцүүлэг, мэргэжилтэн, судлаачдын хэлэлцүүлгийг бол хийх нь чухал гэж үзсэн байна. Ер нь бол энэ ирэх жилийн төсөв бол маш хариуцлагатай төсөв. Ийм ч учраас энэ 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлэн “цахим төсөв” төслийг хэрэгжүүлж, Ди парламент цахим аппликэйшнд улсын төсвийг байршуулсан байгаа. Энэ дээр олон нийтийн хэлэлцүүлэг хийдэг процессыг бол цаашид ингэж улс төрийн соёл болж нутагшуулахаар төлөвлөж байна. Ийм учраас энэ хэлэлцүүлэг 20 хоногийн хугацаанд байршина. Тэгэхээр энэ цахим төсвийн хэлэлцүүлгийг цаашид иргэний нийгмийн байгууллага, аудит, УИХ хамтран хийдэг болно. Энэ олон нийтийн саналыг авах ажлыг 2 7 хоногийн хугацаанд зохион байгуулах юм байна. Өнөөдөр 10 сарын 07-ны өдрөөс эхлэн өнөөдөр 1 цагаас эхлэн байришиж санал авч эхэлсэн. 17-ныг хүртэл цахим хуудас, шуурхай утас, ди парламент ашиглан саналуудыг авна. Утас нь бол 262727 гэсэн утсаар санал санаачилгыг бас бодлогод тусгадаг, энэ төсвийн хяналтын талаар нэн ялангуяа өнөөдөр 1 цагт тавьснаас хойш бас нэлээн олон санал ирсэн дотор бол улсын өрийн дарамтыг бууруулах, үргүй зардлуудыг хэмнэх, хүүхдийн мөнгө, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар бол бас олон саналууд, санаачилгууд ирсэн байна.

Санал цуглуулах, ирүүлсэн саналыг эрэмбэлэх, нэгтгэх, хариу өгөх ажлыг Төсвийн байнгын хороо хариуцаж, эргэж танилцуулна. Байнгын хороодын хэлэлцүүлэгт танилцуулна, Төсвийн байнгын хороогоор хэлэлцэх нь байна.

Ингээд улсын төсвөө анх удаа УИХ нээлттэй хэлэлцүүлэх гэж хийх гэж байна. Олон нийтийн иргэдийн оролцоо, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын оролцоо маш чухал. Ингээд та бүхнийг идэвхтэй оролцохыг уриалж байна.

Одоо төсөв орлогоо яаж нэмэгдүүлэх бололцоо байна гэдэг маань бол төр бизнес хийж орлого олох гээд байгаа хэрэг биш, ер нь бизнес гэдэг бол ажил хэрэг л гэсэн үг шүү дээ. Төрийн бизнес өнөөдөр ч гэсэн ажил хэрэг явж л байгаа. Тийм учраас суманд орлого олох р эрхийг нь өгье, бүгдийг нь татан төвлөрүүлчихдэг учраас орлого олох сонирхолгүй байна. Газар тариалан, ХАА, уул уурхай шинээр оруулж ирээд шинэ орлого олох юм бол түүнийг орон нутагт нь үлдээе. Ингэх юм бол сумын, орон нутгийн орлогоо олох хүсэл сонирхол нэмэгдэнэ. Ийм учраас энэ зорилгоор төрийн үйлчилгээний байгууллагуудыг, эрүүл мэндийн салбарыг энэ орлого орлого олох, нэмэлт орлого олох эрхийг нээсэн тогтолцоонд шилжүүлсэн.

Төсвийн байгууллага, удирдлага, санхүүжилтийн хуулийг Шинэ Зеландын загвараар ийм нэмэлт орлого олбол өөрөө зарцуулах, урамшуулал олгох эрхийг нь нээдэг, ажилчдынхаа нийгмийн асуудал, цалинг нэмэгдүүлэх, зардлын хэмнэлтийг тодорхой хувийг урамшуулалд олгодог ийм тогтолцоо байсныг энэ 13 онд халсан. Үүнийг бүрэн хэрэгжүүлж чадаагүй. Ийм учраас энэ орлого олох механизм бол сум, орон нутгийн байгууллагууд орон нутгийг орлого олох боломжийг нь урамшуулах, идэвхжүүлэх, сая Дархан, Сэлэнгийн харьяанд ажиллаж байхад ч гэсэн төрийн байгууллагууд, Ургамал хамгааллын хүрээлэн, Малын удмын сангийн хүрээлэн бол орлого олох маш их боломж байгаа боловч энэ Төрийн өмчийн хороо төсөвт төвлөрүүлээд хураагаад авчихдаг учраас бидэнд сонирхол байхгүй байна гэж байгаа юм. Тэгээд энэ ажлуудыг их, дээд сургуулиуд ч гэсэн тэгж байгаа, судалгаа, ТЭЗҮ хийе, үүнийг алга байна, МУИС-ийнхан сая ойдоо оролцсон ингэж байна. Хувийн хэвшилээ дэмжих, ингэж хамтран ажиллах бололцоог бас энэ төсвийн реформын орлогын реформын нэг том болгож хэрэгжүүлэх гэсэн зорилгыг дэвшүүлж байгаа. Зарлагын реформ ч гэсэн үүнтэйгээ хамтран хэрэгжих ёстой. Үүнийг бас энэ хэлэлцүүлгүүд дээр идэвхтэй хэлэлцүүлж хэрэгжүүлнэ ээ.

Ингээд сая Байнгын хороонд шилжүүлсэн.

19.59 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Дараагийн асуудал өнөөдөр Даргын дэр зөвлөлөөр хуралдаад 2 асуудал нэмсэн. Эхний ээлжид “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Гурав. “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг уншиж танилцуулъя.

Монгол УИХ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26-гийн 1 дэх хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26-дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн МАН-ын бүлэг, АН-ын бүлгээс ирүүлсэн саналуудыг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Төмөртөгтоогийн Энхтүвшин нарыг УИХ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулууныг Эдийн засгийн байнгын хорооны, Улсын Их Хурлын УИХ-ын гишүүн Чинбатын Ундрамыг Нийгмийн бодлогын байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэнг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг Эдийн засгийн байнгын хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбатыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Ингээд МАН-ын бүлгийн саналын дагуу бол Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

Тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж 75,5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.03 цаг

Дараагийн асуудалд орно.

Дөрөв. “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Коронавируст халдварт ковид 19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Монгол Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай заасан бөгөөд мөн хуулийн 6.2 дахь хэсэгт Монгол УИХ энэ хуулийн биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий Түр хороог Монгол УИХ-ын бүх Байнгын хорооны болон УИХ дахь цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулна гэж заасны дагуу Монгол УИХ-ын Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэнцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтэд сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан билээ.

Уг түр хороог Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар ажиллаж байсан, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр ахалж, гишүүдэд УИХ-ын гишүүн, Байнгын хорооны дарга Х. Болорчулуун, Б.Бат-Эрдэнэ, Н.Учрал, Ж.Мөнхбат, М.Оюунчимэг, Л.Энх-Амгалан, Б.Жавхлан, Б.Чойжилсүрэн, С.Бямбацогт, Ж.Ганбаатар нар болон УИХ дахь АН-ын бүлгийг төлөөлж Б.Бейсен, УИХ дахь Зөв хүн Электрат эвслийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, бие даагч Н.Алтанхуяг нар ажиллаж ирсэн болно.

Уг түр хороо нь өнгөрсөн хугацаанд нийт 13 удаа хуралдаж, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар УОК, Нийслэлийн Онцгой комисс, ЭМЯ, БШУЯ, Монголбанк болон СЗХ, НБГ зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтны

танилцуулга, мэдээллийг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан сонсож, Түр хорооны хуралдаанаас ЗГ болон бусад байгууллагад тухай бүр үүрэг чиглэл өгч ажиллаж ирсэн болно.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолоор Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Б.Энх-Амгаланг, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Б.Саранчимэгийг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны спорт, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Г.Мөнхцэцэгийг, Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны даргаар Б.Баттөмөрийг, Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Э.Батшугарыг, Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар П.Анужинг, Төсвийн байнгын хорооны даргаар Г.Тэмүүлэнг, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Т.Энхтүвшинг, Хууль зүйн байнгын хорооны даргаар Л.Мөнхбаатарыг, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Ц.Цэрэнпунцагийг нарыг сонгосон тул Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах шаардлага гарсан болно.

Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталснаар Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих үүрэгтэй түр хорооны үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдэх болно.

Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн тавдугаар зүйлийн тавын нэгд, УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд Улсын Их Хурлын бусад шийдвэр, тогтоолын хэлбэртэй байна гэж заасны дагуу болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д, УИХ шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан болно.

“Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданишатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна.

Байнгын хорооны саналаар “Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, 77,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Түрүүний “Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

20.08 цаг

Тав.Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Даваажанцангийн Сарангэрэлийг Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын үүрэгт ажлаас огцруулах асуудлыг танилцуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Бямбажавын Ганбат ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Чулуунбаатарын Дондогмаа ЗГХЭГ-ын ахлах референт.

Ерөнхий сайдын танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

20.09 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.ОЮУНГЭРЭЛ*